



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

**СОЁЛЫН ЯАМ**



**unesco**

International Institute  
for the Study of  
Nomadic Civilizations  
under the auspices  
of UNESCO

**Тайлангийн дугаар: 220018**

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ МЭДЛЭГ, ТУРШЛАГЫН ТОЙМ  
СУДАЛГАА

Knowledge and Experience of Mongolian Traditional Medicine

Захиалагч: Соёлын яам

Гүйцэтгэгч: ЮНЕСКО-ийн ивээл дор НСИСОУХ

Улаанбаатар хот  
2022 он

**Энэхүү тайланг Монгол Улсын Соёлын Яамны захиалгаар ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн “МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ МЭДЛЭГ, ТУРШЛАГЫН ТОЙМ СУДАЛГАА” сэдэвт тойм судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.**

Хянасан: И.Бямбабаатар (Доктор, НСИСОУХ)

Судалгааны багийн ахлагч: Г.Зулбаатар (НСИСОУХ)

Судалгааны багийн гишүүд: Ч.Мөнхтуул (доктор, НСИСОУХ), Б.Бумбаяр (НСИСОУХ), С.Мөнх-очир (НСИСОУХ), М.Пагмадулам (НСИСОУХ), Г.Мөнх-Эрдэнэ (МУИС)

Улаанбаатар хот  
2022 он

## Талархал

Уг төслийг 2022 оны 01сарын 01-ээс 07 дугаар сарын 04 хугацаанд ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн хийж гүйцэтгэсэн болно. Төслийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээлэл дээр үндэслэн 9 аймгийн 20 суманд ажилласан бөгөөд нийт 22 ардын уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагчдын дуу, дүрс бичлэгийг баримтжуулж, судалгаандаа ашигласан юм. Уг төслийг хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн Соёлын Яам, Соёлын Өвийн үндэсний төв, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн Соёл урлагийн газар, Аймгуудын Соёл урлагийн газар, сумдын Соёлын төв, судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нартаа талархал илэрхийлье.

## Агуулга

<b>УДИРТГАЛ</b> .....	<b>5</b>
Судалгааны үндэслэл .....	5
Судлагдсан байдал.....	6
Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол .....	11
Судалгааны арга зүй, хамрах хүрээ.....	12
Судалгааны ач холбогдол .....	13
Судалгааны ажлын бүтэц .....	13
<b>1. ТҮҮХ БА АРГА УХААН</b> .....	<b>15</b>
Монголын “УЛАМЖЛАЛТ” АНАГААХ УХААНЫ ТҮҮХЭН ТОЙМ.....	15
Монголын “УЛАМЖЛАЛТ” АНАГААХ УХААНЫ 8 АРГА УХААН.....	15
ХАНАХ ЗАСЛЫН ТУХАЙ.....	16
ТӨӨНӨХ АРГЫН ТУХАЙ .....	18
МАЛ АМЬТНЫ ЭД ЭРХТНЭЭР АНАГААХ УХААН .....	19
УРГАМЛЫН ЗҮЙЛЭЭР АНАГААХ УХААН .....	23
ТАНГААР ЭМЧЛЭХ АРГА УХААН.....	26
ДОМЫН АРГААР АРГА УХААН.....	28
БАРИА ЗАСЛААР АНАГААХ АРГА УХААН.....	32
ЗҮҮ ЭМЧИЛГЭЭНИЙ АРГА УХААН.....	33
<b>2. АРДЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ӨВҮҮД БА ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИД</b> .....	<b>33</b>
УРГАМЛЫН ЗҮЙЛЭЭР АНАГААХ .....	35
АМЬТНЫ ЭД ЭРХТНЭЭР АНАГААХ.....	39
БАРИА ЗАСЛЫН АРГААР АНАГААХ .....	43
ДОМ ЗАСЛААР АНАГААХ .....	45
ТАН ЭМЭЭР АНАГААХ АРГА УХААН .....	47
ХАНАХ ЗАСЛААР АНАГААХ АРГА УХААН.....	50
ЗҮҮ, ТӨӨНҮҮРИЙН АРГААР АНАГААХ АРГА УХААН .....	53
<b>3. “УЛАМЖЛАЛТ” АНАГААХ УХААН БА СОЁЛЫН ӨВ</b> .....	<b>54</b>
ЮНЕСКО-д бүртгэгдсэн Уламжлалт анагаах ухааны олон улсын туршлага .....	54
“ЮНЕСКО-д бүртгүүлэх Нүүдэлчдийн анагаах ухааны төрөл” .....	59
Өвлөн уламжлагч нарт тулгамдаж буй асуудал, хэтийн төлөв .....	63
<b>4. ДҮГНЭЛТ</b> .....	<b>65</b>
<b>5. НОМ ЗҮЙ</b> .....	<b>67</b>
<b>6. ХАВСРАЛТ</b> .....	<b>70</b>
Хавсралт 1. Монголын уламжлалт анагаах ухааны экспертүүдийн ярилцлага зөвлөмж .....	70
Хавсралт 2. Хээрийн судалгааны ажил 1 .....	73
Хавсралт 4. Нутагшил, байршлын хүснэгт.....	75
Хавсралт 5. Өвлөн уламжлагч нартай хийсэн ярилцлагууд.....	79
Хавсралт 6. Өвлөн уламжлагч нарын зураг.....	193

## Удиртгал

### Судалгааны үндэслэл

Монголын анагаах ухаан бол монголын нийгэм- соёлын нэгэн чухал бүрэлдэхүүн төдийгүй төр-нийгмийн өөрчлөлтийг харуулах сонгодог жишээ билээ. Тус ухаан уламжлалт эсвэл нүүдэлчдийн, барууны гэх мэт олон зүйлийн бүрдэлтэй. Гэвч уламжлалт хэсэг нь улам бүр хумигдсаар байна. Учир нь Европ анагаах ухааны мэдлэг Монгол Улсад нэвтэрснээр монголчуудын амьдралын туршлагаар буй болсон уламжлалт анагаах ухааны мэдлэгийн хүрээ ихээхэн хумигдах болжээ. Энэ нь Монгол улсад орчин цагийн эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөн цаг үетэй хамааралтай юм. Орчин цагийн эрүүл мэндийн салбарын хөгжлийг:

- 1921-1940 оны үе буюу БНМАУ-д орчин цагийн анагаах ухаанд суурилсан эрүүл мэндийн албыг бүрдүүлж эхэлсэн үе;
- 1941-1990 оны үе буюу Социалист эрүүлийг хамгаалах номлолоор замнасан үе;
- 1991 оноос одоог хүртэлх үе буюу Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үеийн олон талт(multi-medical system) эрүүл мэндийн албаны хөгжил гэсэн гурван томоохон үе болгон авч үзэж болох юм.<sup>1</sup>

Үүнээс үзэхэд Европ зүгийн анагаах ухаан нь Монгол улсад үүсэж хөгжөөд удаагүй бөгөөд түүнээс өмнөх үед нийт ард иргэдийн эрүүл мэнд, өвчин зовлонг уламжлалт анагаах ухаан олон зуун жилийн туршид нуруун дээрээ үүрч явсан нь илт юм. Уламжлалт анагаах ухаан монгол оронд цаг хугацааны байдлаас хамааран түүхэн олон нөхцөл байдлаар уламжлагдан хөгжиж байсан бөгөөд энэхүү мэдлэгийг эрүүл мэндийн шинжлэх ухааны үүднээс, түүхэн хөгжил, үечлэл, уламжлал, шинэчлэл, онол арга зүй гэх олон талаас нь нарийвчлан судалсан судалгааны бүтээл ихээхэн байдаг. Харин уламжлалт анагаах ухааны хэрэглээ болон нийтийг хамарсан ардын анагаах ухааны уламжлал, эмнэх домнох арга хийгээд энэхүү арга ухааны өвлөн тээгчдийн талаарх судалгаа хомс байна. Тиймээс тус судалгаа нь энэхүү орон зайг нөхөх гэсэн нэгэн зорилготой юм.

Үүнээс гадна тус судалгааг хийх болсон бас нэг шалтгаан бол монголын анагаах ухааны түүхээс харахад XV-XIX зуун хүртэл олон алдартай эмч домч, маарамба төрөн гарч, олон ч дацан байгуулагдан хөгжсөн ч эдгээр нь Мин улс, Эртний Энэтхэг, Төвөдийн гэх олон соёл, анагаах ухаантай ихээхэн нийлэгжсэн нь анзаарагддаг (Болд 2006). Тиймээс уг төслийн судалгааны гол үндэслэл, шаардлага нь монголчуудын язгуур буюу үндэстний (ethnic medicine) анагаах ухааныг ялган тодруулах, одоо хэрэглэгдэж байгаа анагаах ухааны арга ухаануудаас алийг нь илүүтэй хэрэглэж байгаа, нүүдлийн соёлд уусан шингэсэн уламжлалт анагаах ухааны арга ухааныг нарийвчлан судалж тодруулах, тухайн анагаах ухааны арга барилыг өнөө цагт өвлөн тээж, сурган уламжлуулж байгаа өвлөн уламжлагчдыг баримтжуулахад чиглэж буй юм.

---

<sup>1</sup> <https://moh.gov.mn/p/5>

## Судлагдсан байдал

Бид тус сэдэвтэй холбоотой судлагдсан байдлыг хоёр хэсэг болгон үзэж байна. Тэр нь *нэгд*, Ардын “уламжлалт” анагаах ухааны тухай дотоодын судалгаа, *хоёрт*, энэ тухай хийгдсэн гадаад хэл дээрх судалгаа гэсэн хоёр хэсэг болгон авч үзэж байгаа юм.

### Ардын “уламжлалт” анагаах ухааны тухай дотоодын судалгаа

Тус сэдэвтэй холбоотой өмнөх үеийн судалгаа ч бага биш байгаа юм. Ялангуяа монголын уламжлалт анагаах ухааны түүхэн хөгжил, онолын сэтгэлгээний дэвшил, эргэлтийн үе, ном судар, сурвалж бичгүүдээс эрэн сурвалжилж, нарийвчлан судалсан судалгаа бүтээлүүд чамлалтгүй байна (Хайдав 1997; Нацагдорж 2001; Цагаанхүү; Дэмбэрэл 1996). Учир нь Монгол ардын анагаах ухаан нь дорнын анагаах ухааны олон арга барил, онол арга зүйтэй нийлэгжиж, түүнийг хөгжүүлэн сайжруулсан гээд цаг хугацаа, түүхийн хувьд олон зуун жилийг туулсан шинжлэх ухааны чухал салбар юм. Дорнын анагаах ухаан нь Энэтхэг, Хятад, Төвөд гэх улсуудын өөр өөрийн өвөрмөц анагаах ухааны онцлог, арга барил түүхтэй улсуудын цогц бүтээл билээ. Дээрхийн нэгэн адил монголчууд ч гэсэн байгаль цаг уур, амьдралын нөхцөл байдал зэргээс хамаарч, өөрсдийн уламжлалт анагаах ухааны өвөрмөц арга барилыг бий болгосон байдаг ба түүний түүхэн үечлэл, хөгжлийн олон шатыг судалсан судлаачид (Хайдав 1997; Нацагдорж 2003; Болдбаатар 2002) цөөнгүй бий. Нүүдэлчдийн эртний анагаах ухааны багаж хэрэгсэл нь археологийн олдвор болон түүхийн сурвалж бичгийн дурсгалаар олон илэрсэн байдаг (Төрбат ба бусад 2003; Наран 2003). Мөн монгол нутагт бурхны шашин дэлгэрсэн цагаас монгол анагаах ухааны дэг сургуулиуд уламжлалт болоод дорнын анагаах ухааныг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулсан бөгөөд дорнын анагаах ухааны талаар Ч.Баавгай болон Б.Болдсайхан (1990), Ш.Болд (1998) нар судалж, дорвитой бүтээл туурвижээ. Монгол анагаах ухааны эмч, эрдэмтэд төвөд хэл дээр өөрсдийнхөө бүтээлийг туурвиж байсан талаар Ш.Бира (1960), Д.Цэрэнсодном (1997) нар нарийвчлан судалсан байдаг. Гэвч дурдан буй эдгээр судалгаануудаас харахад өмнө дурдсанчлан уламжлалт анагаах ухаан монгол оронд цаг хугацааны байдлаас хамааран түүхэн олон нөхцөл байдлаар уламжлагдан хөгжиж байсан бөгөөд энэхүү мэдлэгийг эрүүл мэндийн шинжлэх ухааны үүднээс, түүхэн хөгжил, үечлэл, уламжлал, шинэчлэл, онол арга зүй гэх олон талаас нь нарийвчлан судалсан судалгааны бүтээл ихээхэн ч уламжлалт анагаах ухааны хэрэглээ болон нийтийг хамарсан ардын анагаах ухааны уламжлал, эмнэх домнох арга хийгээд энэхүү арга ухааны өвлөн тээгчдийн талаарх судалгаа хомс байна. Тийм учраас бид энэхүү судалгаагаараа дамжуулан энэхүү орон зайг нөхөхийг шаардлага байна гэж үзсэн болно.

## Ардын уламжлалт анагаах ухааны арга ухааны англи хэл дээрх судалгаа

Судлаач Питшман (2013) бусад долоон судлаачтай хамтран бичсэн өгүүлэлдээ монголын уламжлалт анагаах ухааны товч түүхийг өгүүлжээ. Тэдний үзэж буйгаар тус улсын уламжлалт анагаах ухаанд зөвхөн монголын уламжлал ахуй байдал төдийгүй, хятадын, төвөдийн анагаах ухааны нөлөө их байдаг байна. Өнөөдөр ч энэ төрлийн анагаах ухааны хэрэглээ, цар хүрээ их байдаг бөгөөд нийт хүн амын 20 гаруй хувь нь одоо ч өвчин хуучдаа уламжлалт анагаахын мэдлэгээ ашигласаар байгаа ажээ. Түүнчлэн социализмын үед дарагдаж байсан ч 1990-ээд оноос ихэд дэлгэрч, өнөөдөр олон эмнэлэгт европ болон уламжлалт анагаах ухааны хослуулан хүн ардаа эмчилж буй нь сонирхолтой жишээ болдог байна. Монголын олон эрдэмтэн уламжлалт анагаах ухааны арга барил, эм танг барууны шинжлэх ухааны судалгааны аргаар судалж, тэр бүхэнд шинжлэх ухааны үндэс байгааг нээн илрүүлсээр байгааг онцолсон байна. Түүнчлэн өнөөдөр уламжлалт анагаах ухааны сургалт их сэргэж, олон сургууль, сургалтын төв үйл ажиллагааг идэвхжүүлж буй ажээ. Энэ талын судалгаа монгол хэлээр улам их хэвлэгдэх болсон ч мөн дурдсан байна.

Мөн судлаач Ганбаяр, Төмөрбаатар нар (2007) энэтхэгийн анагаах ухааны (ayurveda) нөлөө монголын анагаах ухаанд хэрхэн нөлөөлсөн Хүннү гүрний үеэс түүнчлэн үзсэн судалгаа хийжээ. Одоогоор мэдэгдэж буй баримтаар бол эртний нүүдэлчид аль Хүннү гүрний үеэс л Буддизмаар дамжуулах энэтхэгийн нөлөөтэй анагаах ухаантай танилцсан бөгөөд энэ арга барил Их Нирун, Уйгур улсын үед ч үргэлжлэн, Согд зэргээр дамжуулан тус ухааны олон мэдлэг өнөөгийн монгол нутагт улам дэлгэрчээ. Харин Их монгол улсын үеэс энэ уламжлал дээр нэмэгдэн төвөдийн анагаах ухааны мэдлэг түрэн тэлж, анагаах ухааны олон судар номыг орчуулах болтлоо дэлгэрсэн байна. Улмаар Их юань улсын дараах монголчууд энэ уламжлалын улам бүр хөгжүүлэн төвөдөөр дамжуулан уг анагаах ухааны олон судар номыг монгол хэлнээ буулгах, өөрсдөө ч төвөд хэлээр бүтээл ном туурвих болжээ. Монгол дахь төвөдийн уламжлал дагасан анагаах ухааны сургууль 1662 онд байгуулагдсан бол 1937 он хүртэл ийм төрлийн 40 гаруй сургууль нэмж байгуулагджээ. Энэ мэтээр анхлан Буддизмаар дамжуулан энэтхэгийн нөлөөтэй, улмаар төвөдийн нөлөөтэй анагаах ухааны мэдлэг уламжлал монгол нутагт дэлгэрэн монголын уламжлалт анагаах ухаантай сүлэлдэн хөгжих болсон судлаачид тоймлон судалжээ.

Судлаач Филин (2017) XIX-XX зууны Европын эрүүл мэндийн тогтолцоо, Монгол дахь мал эмнэлгийн, эмчилгээний хувьслын үе шатуудыг судалсан байна. Тэрээр төвөд болон ардын анагаах ухааны зарчимд тулгуурласан Монгол Улсын хүн амд эмнэлгийн тусламж үзүүлэх уламжлалт тогтолцооноос европ хэлбэрт шилжих үйл явцын үндэс суурь, үндсэн мөчүүдийг тоймлон харуулахыг оролджээ. Уг өгүүлэлд үндэсний анагаах ухааны ололт амжилтыг харгалзан хүн амыг эмнэлгийн тусламжаар хангах уламжлалт болон Европын зарчмуудыг хослуулан Монголын эрүүл мэндийн шинэ тогтолцоог бий болгосон гэж дүгнэсэн байна. XX зууны эхний хорин таван жилд Монголын хүн амын дийлэнх нь ямар нэгэн өвчнөөр шаналж байсан нь уугуул хүн амын тоо эрс цөөрч, нийгмийн эрүүл ахуйн нөхцөл байдал муудахад нөлөөлсөн ажээ. Бэлгийн болон бусад онц аюултай халдварт өвчнийг (хотод хүн амын 40-өөс доошгүй хувь нь тэмбүү, 50-аас доошгүй хувь

нь заг хүйтэн өвчнөөр өвчилсөн) эмчлэхэд Монголын уламжлалт анагаах ухааны аргууд үр дүнгүй байжээ. Тиймээс анагаах ухааны хамгийн сүүлийн үеийн ололт амжилтыг ашиглаж байсан Оросын эмч нар Монголын хүн амыг бэлгийн замын өвчин, салхин цэцэг зэрэг өвчнийг анагааж чадсан гэнэ. ОХУ-ын мэргэжилтнүүдтэй үр дүнтэй хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улс төвөдийн анагаах ухааны ололтыг ашиглан Европын эрүүл мэндийн тогтолцоог амжилттай бий болгосон байна. Монгол Улс Европын эрүүл мэндийн тогтолцоог бий болгохын зэрэгцээ хүн амыг малын халдварт өвчнөөс хамгаалах ололт амжилтад хүрсэн орчин үеийн мал эмнэлгийн албыг ч хүртэл бий болгох эхний алхмаа хийсэн байна.

Өөр тун сонирхолтой судалгааг судлаач Гүнбилэг, Боланд нар (2009) хийсэн байна. Монголын уламжлалт анагаах ухаанд шавжны эмчилгээний талаарх мэдлэгийг эрт дээр үеэс өргөн хэрэглэж ирсэн ч өнөөг болтол харьцангуй бага судалсан байдаг ажээ. Цөөхөн судлаач өмхий цохны (Blaps femoralis) хамгаалалтын бодисын эмчилгээний чадавхыг судалсан байдаг. Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг шавжны биологийн идэвхт бодис болох хамгаалалтын шүүрэл, гадаргуугийн липидийн агууламжийн талаар хийсэн судалгааны үр дүнг хоёр судлаач уг өгүүллээрээ танилцуулж байна. Шулуун гинжин хэлхээний нүүрс ус төрөгч болон өөх тосны хүчлүүд дагалддаг хэд хэдэн р-бензокиноны деривативыг тодорхойлохын тулд хийн хроматографи ба масс спектроскопийн хослолыг судалгаандаа ашиглажээ. Эдгээр нэгдлүүдийн аль нь ч өмнө нь энэ зүйлээс бүртгэгдээгүй байсан байна. Энэ судалгаа тус шавжны өөх тосны хүчлийн аналитик шинж чанарыг өндөр нарийвчлалтай харуулах боломжтойг илтгэж байгаагаараа эрдэм шинжилгээний ач холбогдолтой судалгаа болжээ. Энэхүү эмчилгээг бидний судалгааны үед Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын өвлөн уламжлагч Б. Болдбаатар олон жилийн өмнө нарийндаж хоол идэж чадахгүй байх үедээ нэгэн арга хэрэглэсэн тухайгаа хуучилсан юм. (Зураг 1 харна уу) *...унгадаг хар, бингийн хар гэдэг юм л даа. Энэ зүйлийг би ерөнхийдөө түлхүү хэрэглэсэн. Үүнийг цагаан архинд хийгээд түүнээ нэг ундааны саванд хийсэн юм. Би 60 орчим биндээ хар түүж хийсэн. Түүнийгээ үнэрлэхэд л тэр биндээ хар гээч лут үнэр үнэртдэг хэр нь уухад бол архины амт ерөөсөө байдаггүй. Дотор ходоодонд орохоор ходоодыг халуу асгуулаад их л лут болдог юм байна лээ...*(Б.Болдбаатар)





*Зураг:1 Архинд хийсэн шавж*

Мөн судлаач Гүнбилэг, Рэнцэндорж нар (2016) монгол дахь эмийн ургамлын хэрэглээний өнгөрсөн, одоо, ирээдүйн тухай товч тойм судалгаа хийжээ. Тэдний үзэж буйгаар сүүлийн хорин жилийн хугацаанд Монголд эмийн ургамлын хэрэглээ илт ихэссэн байна. Хувьсгалын дараа монголын засгийн газар өвс ургамал эмчилгээнд хэрэглэг явдлыг бүдүүлэг, хоцрогдсон гэж үзэн хориглодог байсан бол одоо уламжлалт анагаах ухааны эмч нар, засгийн газар төдийгүй монголын нийгэм хүртэл энэ арга барилыг ихэд үнэлэх болжээ. Гэвч шинжлэх ухааны салбарынхан Монголын уламжлалт анагаах ухааны энэхүү чухал бүрэлдэхүүн хэсэгт улам илүү анхаарал хандуулах ёстой. Учир нь эмийн ургамлын биологийн идэвхт байдлын талаарх шинжлэх ухааны мэдлэг төдийлөн тодорхойгүй хэвээр байгаа ажээ. Үүний зэрэгцээ ургамлыг хэт их ашигласны улмаас олон төрөл зүйл устаж, түүнтэй холбогдох үнэлж баршгүй уламжлалт мэдлэг алгуур мартагдаж байна. Эдгээр шалтгааны улмаас эмийн ургамлын судалгааны чиглэлээрх судалгааг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа аж. Мөн цаашид хүрээлэн буй орчны нөхцөл байдлын талаарх эмийн ургамлын зан үйлийн судалгааны талбарт анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлага урган гарч байгааг судлаач онцолжээ. Ургамлыг эм болгон ашиглах, ховордсон ургамлын төрөл зүйлийг эм болгон ашиглах/худалдаалах тухай хууль тогтоомж мөн чухал, сонирхол татаж байгаа асуудал гэнэ. Товчдоо уг өгүүлэл нь ургамал ашиглаж эм хийх, ургамлыг эмчилгээнд хэрэглэх арга дадлын тухай эрдэм шинжилгээний чиг хандлага, аналитик технологийн хөгжил, өнгөрсөн, одоо, ирээдүйн ололт амжилтын талаар чухам тойм судалгаа болжээ.

Дээрх судалгааны адил судлаач Клеттер нар (2008) Австри, Монголын хамтарсан судалгааны үр дүн танилцуулжээ. Судалгааны баг элэгний эмгэгийн уламжлалт эмчилгээнд хамгийн их хэрэглэгддэг ургамлуудыг сонгон, уг дээжээ Монголын янз бүрийн бүс нутгаас цуглуулж, Австри улсад ургамал судлал, хими, фармакологийн судалгаа хийсэн байна. Австри улсад ургамлын төрөл бүрийн чанарын хяналтын

протоколыг боловсруулахын тулд ургамлын материалын ботаник-анатомийн болон химийн шинжилгээг хийсэн байна. Ийм протоколд дараа нь цуглуулсан ургамлын дээжийн чанарыг шалгахын тулд жижиглэсэн болон нунтагласан ургамлын дээжээ таних чанар, цэвэр байдлыг шалгах зааврыг мөн багтаажээ. Ингэж судлан үзэхэд эдгээр ургамлын биологийн шинж чанар элэг цэсний тогтолцооны эмгэгийг эмчлэхэд тустай байж болох үр дүн гарсан байна. Мөн эдгээр ургамлыг ходоодны таагүй байдал, гэдэс дүүрэх, хоолны дуршилгүй болох, дотор муухайрах, бага зэргийн суулгалт, өтгөн хатах зэрэг хоол боловсруулах эрхтний янз бүрийн асуудлуудыг цэсний шүүрлийг үр дүнтэй идэвхжүүлдэг холеретик нэгдлүүдтэй хамт хэрэглэн эмчлэх боломж байгаа гэсэн үр дүн гарав. Мөн сонгосон ургамлын хор судлалын шинж чанарыг судлахын тулд *Dianthus versicolor*, *Gentiana barbata*, *Lilium pumilum*, *Myricaria longifolia* зэрэг ургамлын усан хандыг туршилтын хархны элэгний анхдагч эсэд үзүүлэх биологийн нөлөөг судлав. Зөвхөн *Myricaria longifolia*-ийн ханд нь үхжил үүсгэдэг цитотоксик нөлөө үзүүлсэн бол бусад ханднуудын аль нь ч генотоксик нөлөө үзүүлээгүй байна. Эцэст нь судлаачид судалгаа бүрэн дуусаагүй байгаагаа онцлон уг өгүүллээр зөвхөн анхдагч үр дүнгээ танилцуулснаа илэрхийлжээ.

Өвөр монголын судлаач Сайжрах (2008) тус улс дахь ардын эмчилгээний тухай тойм өгүүлэл хэвлүүлжээ. Түүний үзэж буйгаар XXI зууны Өвөр монголд анагаах ухааны олон арга барил нэвтэрч байгааг био анагаах ухаан, Хятадын уламжлалт анагаах ухаан, Төвөдөөс гаралтай монгол анагаах ухаан зэрэг нь эрүүл мэндийн тогтолцоонд адилхан үүрэг оролцоотой байдгаас харж болох гэнэ. Гэвч эдгээр эмнэлгийн эмтэй зэрэгцэн Монголын нийгэмд анагаах ухааны өөр нэг хэлбэр байгааг мартаж болохгүй тэрээр сануулжээ. Өөрөөр хэлбэл, ардын анагаах ухааны арга туршлагын талаар анхаарах хэрэгтэй сануулж байна гэсэн үг. Түүний мэтгэж буйгаар бол ардын анагаах ухааны уугуул уламжлал болох нүүдэлчин амьдралын хэв маяг, бөө мөргөлийн аль алинаас нь үүссэн бөгөөд эдгээр эртний уламжлалын зарим хэсэг нь бусад эмнэлгийн тогтолцооны нөлөөнд автаагүй хэвээр байсаар байгаа ажээ. Нүүдэлчдийн соёлоос айргаар эмчлэх, усан, ургамлын эмчилгээ зэрэг ардын анагаах ухааны зан үйлийг хэрхэн хэрэглэж байсан, яс тогтоох, андай эмчилгээ, бөөгийн өвчин зэргийг анагаах бөөгийн анагаах арга нь монгол ардын анагаах ухааны гол хэсэг болох биеийн зовлон, өвчин эмгэгийг эмчлэхтэй холбоотой талаар уг өгүүлэл судалжээ. Эдгээр нь орчин үеийн нийгэмд амьд хэвээр байгаа эртний шашин шүтлэг болох болох монгол бөө мөргөлийн нэгэн чухал үүрэг нь ардын анагаах ухаантай ч холбогдоно гэдгийг харуулж байгаа ажээ. Мөн уг өгүүллийн нэгэн давуу тал нь ардын анагаах ухаан гэдэг соёлын үзэгдэл болохын хувьд эрт дээр үеэс өнөөг хүртэл оршин тогтнож байгаа, үнэ цэнтэй зүйл гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстойг сануулж байгаад юм. Өмнө дурдсан ардын анагаах ухааны олон жишээгээр ч энэ бүхэн нь батлагдаж байгаа бөгөөд Өвөр Монголын анагаах ухааны олон талт байдлыг баримтжуулахад уугуул иргэдийн мэдлэг чухал үүрэг гүйцэтгэхийг ойлгох хэрэгтэйг онцолжээ.

Гэвч эдгээр дотоод, гадаадын судалгаануудаас харахад өмнө дурдсанчлан уламжлалт анагаах ухаан монгол оронд цаг хугацааны байдлаас хамааран түүхэн олон нөхцөл байдлаар уламжлагдан хөгжиж байсан бөгөөд энэхүү мэдлэгийг эрүүл мэндийн шинжлэх ухааны үүднээс, түүхэн хөгжил, үечлэл, уламжлал, шинэчлэл, онол арга зүй гэх олон талаас нь нарийвчлан судалсан судалгааны бүтээл ихээхэн ч уламжлалт анагаах ухааны хэрэглээ болон нийтийг хамарсан ардын анагаах ухааны уламжлал, эмнэх домнох арга хийгээд энэхүү арга ухааны өвлөн тээгчдийн талаарх судалгаа хомс байна. Тийм учраас бид энэхүү судалгаагаараа дамжуулан энэхүү орон зайг нөхөхийг шаардлага байна гэж үзсэн болно.

### Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол

Монголчууд аливаа өвчнийг урьдчилан сэргийлэх, анагаахдаа байгалийн өвс ургамлыг өргөн ашиглахын сацуу хоол ундаа зохицуулах, сойх, ханах, төөнөх, хатгах, илэх, барих, засах, мэс засал үйлдэх зэрэг өвөрмөц арга барилуудыг хослуулан хэрэглэдэг байсан бөгөөд энэ нь түүхэн хөгжлийнхөө хэр хэмжээгээр улам нарийсан хөгжиж баяжсаар монгол ардын өвөрмөц шинжтэй эмнэлэг үүсэх эх суурь буй болжээ (Володя ба бусад 2008, 19). Тиймээс тус судалгаа нь ЮНЕСКО-ийн биет бус өвийн жагсаалт, түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн БСШУЯ-ны сайдын А/759 дүгээр тушаалаар батлагдсан Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлийн V ай сав болох “Уламжлалт арга ухаан” болон тэрхүү жагсаалтад багтаагүй буюу уламжлалт анагаах ухааны мэдлэг, туршлагыг сурвалжлан баримтжуулах судалгаа хийж, түүн дээр орон нутгийн мэдлэг дээр суурилсан уламжлалт анагаах ухааны арга ухааныг нарийвчлан судлах, олж тогтоох зорилготой юм. Ерөнхийдөө Монгол улсаас уламжлалт анагаах ухааны доорх 8 зүйлийг “Монголын уламжлалт анагаах ухаан” хэмээн тодорхойлсон байдаг бөгөөд тэдгээр нь:

1. Бариа заслын аргаар анагаах ухаан
2. Хануур хийх арга ухаан
3. Төөнүүр хийх арга ухаан
4. Зүү тавих арга ухаан
5. Мал, амьтны эд эрхтнээр анагаах ухаан
6. Ургамлын зүйлээр анагаах ухаан
7. Тан бэлтгэх арга ухаан
8. Гүрэм домын арга ухаан зэрэг юм.

Иймийн учир энэхүү судалгаагаар уламжлалт анагаах ухааны мэдлэгийг өвлөн уламжлуулагч, уламжлагч нартай уулзаж, дуу, дүрс бичлэгт тэдний уламжлалт анагаах ухааны арга ухааныг хадгалан авч үлдэх, хээрийн судалгааны аргаар давхар баримтжуулах, цаашид энэхүү судалгааг үргэлжлүүлэн ЮНЕСКО-ийн биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэх суурь судалгааг бэлтгэх, орчин үеийн нөхцөл байдал болоод өвлөн тээгч нарт тулгарч буй асуудлыг тодруулах нь энэхүү төслийн шинэлэг, дэвшилттэй тал юм. Тэрчлэн бид тус судалгаагаар орон нутгийн мэдлэг дээр суурилсан нүүдэлчдийн

язгуур анагаах ухаан байж болох найман зүйлийг судалж, түүн дотроо шинжлэх ухааны салбартаа бага хэмжээгээр судлагдсан, жишээ нь гүрэм, дом засал, мал амьтны эд эрхтнээр анагаах, ургамлаар анагаах зэрэг ахуй байдлаас урган гарсан эмчлэх, домнох, сэтгэл засах зэрэг аргуудыг илүүтэй нарийвчлан судлан сурвалжилсан юм. Мөн уг судалгаагаар дорнын анагаах ухаанд нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр болоод хэрхэн хөгжүүлсэн бэ, дан ганц монголчуудын гэж ангилж болохуйц мэдлэг ухааныг ялган авч үзсэн нь бас нэг гол шинэлэг тал гэж хэлж болох юм.


Харин тус судалгааны ач холбогдолын хувьд нүүдэлчдийн уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагч нартай биечлэн уулзаж, уламжлалт анагаах ухааны хөгжлийн өөрчлөлт, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэтийн төлөв зэргийг асуун тодруулж, анализ хийхэд оршиж байгааг онцлох хэрэгтэй. Мөн ардын уламжлалт анагаах ухаан, түүний салбар арга ухааныг ЮНЕСКО-ийн биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэхэд урьдчилсан суурь судалгаа хийж, цаашид нүүдэлчдийн болон ардын уламжлалт анагаах ухааны зарим (бага судлагдсан) хэсгийг соёлын биет бус өвд бүртгүүлэхэд суурь мэдээлэл, материал бэлтгэх нь ардын уламжлалт анагаах ухааны арга ухааны үндсэн суурь мэдлэгийг дорнын болоод бусад эм эмнэлэг, анагаах ухаанаас ялган авч үзэх, зөвхөн монголын уламжлалт анагаах ухааныг нарийвчлан судлах ач холбогдолтой юм

#### Судалгааны арга зүй, хамрах хүрээ

Тус судалгааны арга зүйн хувьд бид хоёр зүйлийг онцолж хэлэх хэрэгтэй юм. Юуны өмнө бид судлагдсан байдлыг тоймлож, энэ чиглэлээр хийсэн, хэвлүүлсэн бүтээлүүд болон холбогдох бичиг баримтын судалгааг хийнэ. Харин дараагийн шатанд төслийн үндсэн судалгааны арга болох чанарын судалгааны арга буюу антропологийн оролцон ажиглах (participant observation) арга зүйг ашигласан болно. Мөн судалгааны баг уг үндсэн арга зүйн хамт бусад судалгааны арга болох тухайлбал, бүтэцтэй болон бүтэцгүй ярилцлагын арга, баримт бичгийн судалгаа зэргийг судалгаандаа ашиглав. Мөн 21 аймаг, тэдгээрийн сумдын Соёлын хэлтэстэй утсаар холбогдон мэдээлэл, судалгаа авч, 9 аймгийн 20 суманд нийт 3 удаагийн 30 өдрийн хугацаатай судалгаа хийв. Хээрийн шинжилгээний ажлын нийт хугацааг тооцож үзвэл нийт 1 сар болж байна. Соёлын Өвийн Үндэсний Төвийн өвлөн уламжлагч нарын анхан шатны мэдээлэл дээр үндэслэж, өвлөн уламжлагчид нь идэвхтэй, өөр хоорондоо ойрхон аймгуудыг сонгон судлав. Сум тус бүрийн нэр хүнд бүхий өвлөн уламжлагч нартай уулзаж, дуу, дүрс бичлэг, тэмдэглэл хөтөлж, урьд өмнө эмчлүүлж байсан хүмүүсээс мэдээлэл авав. 9 сумын 30 гаруй өвлөн уламжлагч нараас 50 цагийн уулзалт ярилцлага, дүрс дуу бичлэгийг бичиж авсан болно.

Судалгаа хийх сумдыг өвлөн уламжлагчдын тархалт, газарзүйн байршил, угсаатны бүлгийг харгалзан сонгож авав (Зураг 2-ийг харна уу). Тухайлбал, Соёлын Өвийн Үндэсний Төвийн анхан шатны бүртгэл мэдээлэл дээр нийт нутгийн баруун хэсэгт өвлөн уламжлагчид таран суурьшсан байгаа юм. Мөн халх, дөрвөд, казах, хотон, буриад, баяд гээд олон угсаатны төлөөллийг төлөөлүүлэн баруун 5 аймаг, төвийн 3 аймаг, зүүн бүсийн

1 аймгийг сонгон судалсан нь тус судалгааны төлөөлөх чадвар, түүвэрлэлтийн хэмжээ, мэдээллийн үнэ цэн, чанарыг бүрэн илэрхийлж байгаа юм.



Зураг:2

*Соёлын Өвийн Үндэсний Төвийн анхан шатны бүртгэл мэдээллээс шүүж, өвлөн уламжлагч нарыг судалж судалгаа хийсэн газрууд*

Тус бүртгэлээс Өвөрхангай аймгийн Есөнзүйл, Тарагт, Баянхонгор аймгийн Баянбулаг, Хүрээмарал, Завхан аймгийн Шилүүстэй, Цагаанхайрхан, Идэр, Тэлмэн, Сонгино, Увс аймгийн Завхан, Тариалан, Ховд, Баян-Өлгий аймгийн Өлгий сум, Говь-Алтай аймгийн Бигэр Сум, Архангай аймгийн Цахир, Өндөр-Улаан, Хэнтий аймгийн Биндэр зэрэг суманд ажиллаж, нийт 7000 гаруй км замыг туулан хээрийн судалгаа, шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

### Судалгааны ач холбогдол

Уг төслийн судалгааны ач холбогдол нь нүүдэлчдийн уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагч нартай биечлэн уулзаж, уламжлалт анагаах ухааны хөгжлийн өөрчлөлт, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэтийн төлөв зэргийг асуун тодруулж, анализ хийх юм. Мөн ардын уламжлалт анагаах ухаан, түүний салбар арга ухааныг ЮНЕСКО-ийн биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэхэд урьдчилсан суурь судалгаа хийж, цаашид нүүдэлчдийн болон ардын уламжлалт анагаах ухааны зарим (бага судлагдсан) хэсгийг соёлын биет бус өвд бүртгүүлэхэд суурь мэдээлэл, материал бэлтгэх, ардын уламжлалт анагаах ухааны арга ухааны үндсэн суурь мэдлэгийг дорнын болоод бусад эм эмнэлэг, анагаах ухаанаас ялган авч үзэх, зөвхөн монголын уламжлалт анагаах ухааныг нарийвчлан судлах ач холбогдолтой юм.

### Судалгааны ажлын бүтэц

Тус судалгаа нь удиртгал, үндсэн гурван бүлэг, дүгнэлт хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ. Тус бүлгийн нэгдүгээр хэсэгт бид түүхэн сурвалж болон өмнөх судалгаанууд

дээр үндэслэн Монголчуудын “уламжлалт” анагаах ухааны түүхэн тоймыг өгүүлсэн байгаа харин тус бүлгийн хоёрдугаар хэсэгт бид “уламжлалт” анагаах ухааны үндсэн мэдлэг эсвэл практик гэж хэлж болох найман аргын тухай өмнөх судалгаа болон хээрийн судалгааны зарим баримтууд дээр үндэслэн авч үзсэн болно. Өөрөөр хэлбэл, тус тайлангийн нэг дүгээр бүлэгт бид Монголын “уламжлалт” анагаах ухаан түүний түүх болон практикийг танилцуулсан болно. Харин тус ажлын хоёрдугаар бүлэгт бид энэхүү “уламжлалт” эсвэл түүхэн практик өнөөдөр хэрхэн хувирсаар байгааг гол нь харуулахыг зорьсон. Тэрчлэн тус бүлгийн доторх эмчилгээний арга ухаануудаар жишээлэн өөрчлөлт болоод өнөөгийн хотжиж буй орон зайд хэрхэн өөр соёлын нийгмийн нөлөөнд ямар бэрхшээлүүдтэй энэ орон зай тулгарч буйг авч үзлээ. Харин тус ажлын гуравдугаар бүлэгт Монголын “уламжлалт” анагаах ухааныг нэгэн соёлын өв гэдэг үүднээс нь ЮНЕСКО-д бүртгүүлэх тухайд дотоодын болон олон улсын байдлыг авч үзсэн байгаа. Эцэст нь тус судалгааны ажлын дүгнэлтийг хэсэгт захиалагчийн хүсэлтийн биелэлт болоод судалгааны ерөнхий ерөнхий дүнг тайлагнан, дүгнэж бичсэн байгаа болно.

## 1. Түүх ба арга ухаан

Монголын “уламжлалт” анагаах ухааны түүхэн тойм

Монголын уламжлалт анагаах ухааны түүхэн хөгжлийн үе шатыг эртний сурвалж бичиг, эд өлгийн зүйл, эмч, маарамбуудын бүтээл дээр сайтар тулгуурлан үе шат бүрд хувь нэмрээ оруулсан, түүхийн үечлэл, онол арга зүйн талаарх ном бүтээл, судалгааны ажлууд нэлээд байдаг. Энэ тухай анагаах ухааны “Дөрвөн үндэс болон язгуурын үндэс”-ийн “Анагаах арга”-ын “Монголын төөнөх арга” гэсэн нэрээр алдаршсан, эмчилгээний аргуудын талаар тодорхой дурдсан бүтээлүүд ч байдаг. Тухайлбал, монголчууд төөнөх аргыг дорнын анагаах ухаанд оруулсан хэмээн олон судлаач үзсэн байдаг бөгөөд (Бира 2001) “Монголын түүх соёл, бичлэгийн судалгаа”-ныхаа “Ардын эмнэлэг” гэх хэсэгт монголын уламжлалт анагаах ухааны түүхтэй холбоотой, мөн эрдэм заслын тухай өгүүлэхийн зэрэгцээ Сүмбэ Хамба Ишбалжирыг монгол хүн гэдгийг анх удаа иш баримтаар нотлон, төвөдийн анагаах ухааны эрдэмтэдтэй эн зэрэгцэх бүтээл туурвисан монгол эмч, эрдэмтэн гэж анхлан тодруулжээ.

Үүний дараагаар академич Д.Цэрэнсодном (1997) “Ганжуур, Данжуур” болон монголын нэртэй эмч нарын намтар зэргийг судлан туурвисан байдаг. Мөн профессор Г.Гонгоржавын (2001) хэвлүүлсэн “Монголчуудын эрдэм ухааны уламжлал” номын “Анагаах ухаан” гэх дэд хэсгүүдэд уламжлалт анагаах ухааны онолын товч ойлголт, дан эмийн бус эрдэм заслын талаар судлан өгүүлсэн байна. Уламжлалт анагаах ухааны онол, харьцуулсан судалгаагаар шинжлэх ухааны докторын зэргийг М.Амбага 1994 онд, Б.Дагвацэрэн 1995 онд, Б.Саранцэцэг 1999 онд, Ш.Болд 1998; 2002 онд, Б.Болдсайхан 1996 онд, Д.Цэрэндагва 2000 онд, Д.Сээсрэгдорж 2002 онд гэхчлэн хамгаалсан байдаг.

ОХУ-ын Буриадад, БНХАУ-ын ӨМӨЗО-д уламжлалт анагаах ухааны түүхэн судалгаа ихээхэн хөгжжээ. Мөн уламжлалт анагаах ухааны түүхэн үечлэлийг олон судлаач (Эрхэмбат 1987; Жин Бат 1996; Ёндон 1997; Хайдав 1997) өөр өөрсдийн судалгаан дээр үндэслэн үечилсэн байдаг. Үүнээс гадна уламжлалт дом засал (Галбадраа 2006; 2009), таван хошуу малын эм дом заслын тухай (Цэрэнсодном 2000; Лхагвасүрэн 2000) судалгаанууд бий.

Монголын “уламжлалт” анагаах ухааны 8 арга ухаан

Монгол Улсад ардын “уламжлалт” анагаах ухааны үндсэн найман төрөл буй гэж үздэг. Тэдгээр нь:

- 1) Хануур хийх арга ухаан
- 2) Төөнүүр хийх арга ухаан
- 3) Мал, амьтны эд эрхтнээр анагаах ухаан
- 4) Ургамлын зүйлээр анагаах ухаан
- 5) Тан бэлтгэх арга ухаан
- 6) Гүрэм домын арга ухаан
- 7) Бариа заслын аргаар анагаах ухаан

- 8) Зүү тавих арга ухаан зэрэг юм. Бид энэ хэсэгт уг практикуудын тухай дэлгэрүүлэн авч үзье,

### Ханах заслын тухай

Эртний хүмүүс энгийн хийцтэй чулуу, яс, мод ашиглан ан авлах, юм оёх, хоол ундаа бэлтгэх зэрэг хөдөлмөрийн үйл ажиллагааныхаа явцад гар, хөлөө гэмтээх, амьтанд дайруулах, хад асгаас унаж, бэртэх явдал ихээхэн тохиолддог байжээ. Тэр үеийн хүмүүс эмийн бодис таньж мэдэхгүй учраас гар дороо хэрэглэж байсан чулуу, мод, яс ашиглан өвдсөн хэсэгтээ чулуугаар жин тавих, халаасан модоор төөнөх, хурц үзүүртэй ясаар хатгах зэрэг эмчилгээний анхны арга хэмжээ авдаг байжээ (Бадарчин ба бусад 1989).

Монгол уламжлалт заслыг хатуу засал (огтлох, хагалах, хусах, гаргах) ширүүн засал, зөөлөн засал гэж гурван ангид хуваан үзэж байжээ (Болд 2006). Монгол уламжлалт эмчилгээнд таван заслыг хэрэглэдэг. Үүнд, ханах төөнөх, зүү тавих, түрхэх, илэх, дэвтээх гэж хуваан үздэг.<sup>2</sup> Ханах засал уламжлалт таван заслын эрхэм нь болох бөгөөд цусан өвчнийг анагаахад хамгийн сайн үр дүнтэй байдаг. Ханах заслаар муу цусыг ханаж гаргахаар дамжуулан цусны гүйх сүвнүүдийг нээн, хий цусны гүйдлийг сайжруулан, цусан халууныг бууруулж, махбодыг тэгшитгэж, эцэст өвчнийг анагаадаг. Харин энэ эмчилгээний гол зорилго нь хүний биеийн цусыг учиргүй ханаж цус гаргахдаа биш юм. Ханах засал нь тогтсон жам ёстой, үр дүн өгөхдөө түргэн, өвдөж хатгахыг тэр даруйд нь зогсоож, өвчнийг үндэснээс нь арилгах давуу талтай.<sup>3</sup>

“Монголын уламжлалт анагаах ухааны түүх” (Болд 2006) бүтээлд Уламжлалт анагаах ухааны ханах, төөнөх аргын шинэ чулуун зэвсгийн үеэс нүүдэлчдийн анхны төрт улс үүссэн НТӨ 209 он хүртэлх анагаах ухааны хөгжилтэй холбоотой ном, судрын баримт, нотолгоо ховор тул олдсон баримтуудаа археологийн баримтаар баталгаажуулахыг ихэд хичээсэн байдаг. Мөн энэ тухай Персийн түүхч Рашид-ад-дин “...Нүүдэлчин Сяньби аймгийнхан өвчтөн хүмүүсээ чулуу халааж төөнөх, хатгаж цус гаргах, ус цацах зэрэг эртний хүй нэгдлийн арга хэмжээг хадгалсаар ирсэн” (БНМАУ-ын түүх 1966) гэж бичсэн байдаг.

Ханах аргыг анх мал дээр хэрэглэж байсан нь тодорхой бөгөөд өнөөдөр ч энэ аргийн малчид өдөр тутамдаа өргөн хэрэглэдгээс харж болно. Нүүдэлчид ханах заслын ач тусыг танин мэдэж яваандаа арга хэрэгслийг боловсронгуй болгож, хүний өвчнийг анагаахад хэрэглэж эхэлжээ (Болд 2006, 72). Энэхүү мэдээг “Жаргалын эзэн их Ютог Ёндонгомбын үлэмжийн аврал, нууц тэмдэг зарлиг сүр жавхлантай их эрдэнийн хөмрөг”-т “Далч Монголчууд (Согбу) хануурын үндэс” гэсэн уламжлалт байсан тухай нотлон бичсэн байдаг. Энэ талаар Төвөдийн хоёрдох номын хаан Тисрондэзаны (755-797) үед Төвөдөд анагаах ухааны олон улсын анхдугаар хурал гэж болохуйц цуглаан болжээ. Уг хуралд Энэтхэг, Хятад, Балба, Ли, Төвөд, Монгол зэрэг олон орны эрдэмтэд оролцож, хүлээн

---

<sup>2</sup> Алтанхундага, Н. Уламжлалт анагаахын их эмч ярилцлага

<sup>3</sup> Алтанхундага, Н. Уламжлалт анагаахын их эмч, ярилцлага



авагч орны тэргүүн эмч их Ютог Ёндонгомботой ном хаялцсан байна. Ютог Ёндонгомбо энэ талаар өгүүлэхдээ:

- Энэтхэгийн ёс: Ухааны билиг билгийн ёс
- Хятадын ёс: Ертөнцөөс хэтэрсэн (төрөх, үхэх) зурхай ёс
- Балбын ёс: Үхэх, төрөхийг засах үндэс
- Качийн ёс: Үнэт эд, эрдэнийг найруулах
- Далч Монголын (Согбу) ёс: Өвчнийг гадагш татаж гаргах хануурын үндэс бий хэмээсэн (Болд 2006, 73) байдгаас үзвэл ханах засал он удаан жилийн түүхтэй нь харагдаж байна.

Мөн тус цуглааны үеэр тухайн үеийн улс орон бүрийн анагаах ухааны гол онцлогуудыг дурдсан байх бөгөөд Монголын анагаах ухааны ханах ёс нь 8 дугаар зуунаас өмнөх үеийн анагаах ухааны ном, зохиолын байдалтай холбоотой байгаа юм. Тиймээс Төвөдийн алдарт эмч Ютог Ёндонгомбо нүүдэлчдийн “Өвчнийг гадагш татаж гаргах хануурын үндэс” бүтээлийг сайн мэддэг байсан нь түүний “Жаргалын эзэн их Ютог Ёндонгомбын үлэмжийн аврал, нууц тэмдэгт зарлиг сүр жавхлант их эрдэнийн хөмрөг”-т монгол ёс, өвчнийг ерөнхийд нь гадагш татах хануурын үндсийн тухай өгүүлсэн байдгаас (Болд 2006, 72) харагдана. Өөр нэг баримт бол доктор Ц.Шагдарсүрэн “НТӨ II зууны үед монголчууд өвдөг өвдвөөс агь шатаах буюу чулуугаар төөнөдөг. Мөн өвстэй газар шатаагаад өвчтэй хүнээ хэвтүүлдэг. Хүний өвчтэй газрыг ханаж, цус гаргадаг гэсэн мэдээ эртний Нангиадын түүхнээ тэмдэглэгдэн үлджээ. Энэ нь Монголчуудын дээд өвгийн хүн эмнэлэгтэй холбогдож буй хамгийн эртний баримт бөлгөө” хэмээн өгүүлсэн байдаг. Ханах хатгах заслаар бичсэн судрууд өөр олон бий. Үүнээс эмч Данзанпунцагийн “Дарга-Дамба” сударт өвчтөнд хануурыг хэрэглэх, өвчний байдалд зөв тохируулахын ач холбогдлыг онцгой анхааруулсан байдаг. “Хануураар өвчнийг засах хамгийн зохимжтой үе бол өвчин архагших, бусад өвчинтэй хавсарч хүндрэх төлөвтэй үед цус авах нь тустай” (Бадарчин ба бусад 1989, 139) гэсэн санал ч бий. Ханаж болох 77 судас, арьсан доор үзэгдэх 65 гэж заажээ. Ерөнхийдөө 8 их судас ил харагдах бөгөөд түүнээс салбарласан 16 том судас цаашид салаалж, бүх биеэр тарна гээд хий, цус, хир нийлж лугших улаан судсыг ханаж үл болно.

Түүхийн эх сурвалжийн тулгуур зүйлсийн нэг нь археологийн олдворууд юм. Анагаах ухаантай холбоотой ийм олдвор Өвөр Монгол болоод Монгол Улсын газар нутгаас ихээхэн олдсон байдаг. Тухайлбал, Монгол-Оросын хамтарсан Төв Азийн археологийн шинжилгээний анги 2001 онд Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутагт малтлага хийн 7,6 см урттай, 3 мм зузаантай, дөрвөлжин хэлбэртэй, 4 см орчим урт, бөөрөнхий засаж ишинд суулгаж хэрэглэж байсан хүрэл шөвгийг олж, ханах, хатгах засалд хэрэглэж байсан хүрэл зэвсгийн үеийн багаж байж болох юм (Эрдэнэбаатар, Колалев 2004) хэмээн дүгнэсэн байдаг.

Археологич Д.Наваан “Эртний хүний ул мөр” (1960) бүтээлдээ “Шинэ чулуун, хүрэл зэвсгийн үеийн олдворуудын дотор байгаа цахиур зомголууд гэж нэрлэдэг олон төрлийн хурц дөрвөлжин ирмэгтэй жижиг хэмжээний чулуун багажууд, нарийн, бүдүүн

хурц үзүүртэй хатгуур байгаа нь хатгах засалд хэрэглэж байсан үндэстэй юм” (Болд 2006, 78) гэжээ. Дээрх баримтуудыг үндэслэвэл, монголчуудын өвөг дээдэс хануур заслын аргыг чулуун зэвсгийн үеэс эхлэн хэрэглэж ирсэн төдийгүй улмаар Хүннүгийн үед “Өвчнийг гадагш татаж гаргах хануурын үндэс” ном бичиж, уг бүтээл нь Хятад, Төвөд зэрэг улсуудад нэвтэрч байсан сурвалжийн лавтай мэдээ бидэнд үлджээ.

### Төөнөх аргын тухай

Төөнөх засал нь биеийн гадаргуу дээр байрласан суваг сүвээр дамжуулан утаж засаж анагаах арга юм (Бадарчин ба бусад 1989, 131). Нэг ёсондоо хатаасан уул өвс, сойг, агийн төөнүүрээр биеийн гадаргуу дээрх сувгийн сүв дээр буюу өвдсөн хэсэгт дулааны элчээр халааж, утаж төөнөх үйлчлэлд нь суваг хэрдэсний энерги, цусны гүйдлийг сайжруулан өвчин эмгэгийг засаж анагаана гэсэн үг юм. Үндсэн агуулга нь анх НТ VII зуунд Энэтхэгээс уламжлагдсан Төвөд, Монголын уламжлалт анагаах ухааны гол сурах бичиг “Дөрвөн үндэс”-ийн “Язгуурын үндэс”-ийн анагаах ухааны тавдугаар бүлэгт “Түрхэх, илэх, монгол (Хор-нүүдэлчин) төөнөөр хийг засан үйлд” хэмээн номлосон байдаг. “Дөрвөн үндэс”-т дурдсан Монгол төөнийн тухай бичсэн хамгийн эртний бүтээл бол Байлдаант улсын үеэс (НТӨ 475) уламжлагдсаар Хан улсын үед эмхэтгэгдсэн 2000 гаруй жилийн түүхтэй Хятад эмнэлгийн зохиол “Хуан Ди Нэйжин” юм. Чухамдаа уг зохиолын 12 дугаар бүлэгт Умардын нүүдэлчдийн төөнө эмчилгээний тухай дурдсан байдаг байна.

Төөнөх заслыг монголчуудын өвөг дээдэс хамгийн анх бүтээн бий болгож, анагаах ухааны практикт хэрэглэсэн гэж хэлэх бүрэн үндэстэй (Болд 2006, 88) гэж зарим судлаач үздэг. Энэ талаар (Жигмэд 1985; 2002), (Ш.Болд, М.Амбага 1999; 2002) нар өөрсдийн бүтээлдээ тэмдэглэсэн байна. Мөн Анагаах ухааны “Дөрвөн үндэс”-т тэмдэглэгдсэн “Хоржи мэза буюу Монгол төөнө”-ийг манай алдарт эрдэмтэн, маарамба Лүнриг Дандар (1832-1920) “Ар үрийн эрхсийн үзэсгэлэнт чимэг” зохиолдоо, “Хор Монголын төөнө гэдэг нь зоргодсыг (Гоньд) тосонд зуурч, жонш чулуунд түрхэж, халуун жин тавихыг хэлмүй” гэжээ. Мөн ӨМӨЗО-ы судлаачид Дуван Гомбожав (1992) хуучин монгол бичгээр бичиж тараасан төөнө заслын тухай номыг “Эртний Монголын төөнийн бичиг” нэрээр тайлбар хийн хэвлүүлсэн байна. Уг номын зохиогч тодорхойгүй, нийт 27 хуудастай, төөнийн 177 бэлчрийг багтаасан толгойн 22, гарын 25, өврийн 28, арын 80, хөлийн 22 бэлчир тус тус энэхүү бүтээлд байна. Ц.Хайдав (1975) “Дорно дахины анагаах ухааны судар бичгийн тойм” гэдэг номд хатгах, шивэх, төөнөх заслын бүгд 322 сүв бэлчир судлын талаар бичсэн байдаг. Одоо зүү төөнүүр заслын суваг судалд харьяалсан 360 сүв, бүгд 700 шахам суваг сүв, судлын гадна орших 1500 гаруй сувгийг эмчилгээнд хэрэглэж байна.

Төөнүүрийн бодис нь өвөрмөц үнэртэй, халуун чанартай, олон наст ургамал юм. Умайн өвчин, үргүй болох, биеийн юм хямрах, цээж бүсэлхийгээр өвдөх, аюулхай тэлэгдэх, дөрвөн мөч тамирдах, хоолонд дургүй болох, эмэгтэйчүүдэд цагаан улаан юм буухад нөлөөтэй бөгөөд дотуур хэрэглэдэг. Төөнөх аргын хувьд дээр дурдсан олон бэлчир тус бүр нь маш олон аргаар төөнөх эмчилгээ хийгддэг. Жишээ нь нуруу төөнөх бэлчир 19, цээж болон хэвлийн төөнөх бэлчир 10, толгой төөнөх бэлчир 3, доод мөчний төөнөх

бэлчир 6 байдаг бөгөөд биеийн аль хэсэг юунд сайн талаар дурдсан байдаг. төөнүүрийн талаар бас нэг сонирхолтой зүйл бол Хорхгийн чулуугаар хийн бэлчрүүдийг төөнөж, үнэрийг нь үнэртэх, гарыг алгаараа дарж сайн төөнөх, толгойн орой хэсэг, ходоод зэргийг төөнөх нь ихээхэн ач холбогдолтой хэмээн үздэг байна<sup>4</sup>.

Мал амьтны эд эрхтнээр анагаах ухаан

Монгол уламжлалт анагаах ухаанд амьтны эд, эрхтнийг эм танд ашиглан анагаах арга түгээмэл байдагт гөрөөлөхүй, шавуулахуй, загасчлахуйгаас, мөн таван хошуу малаас бэлтгэн авдаг байна. Өдгөөгөөс 2000 шахам жилийн өмнө үндэс нь тавигдаж, 1500 гаруй жилийн өмнө Төвөдөд Ютог Ёндонгомбын орчуулан гаргасан “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолын “Амарлиулах эмийн товч” хэсэгт **баавгайн донти** буюу цөсийг ямар өвчинд хэрэглэх тухай дурдсан байдаг. Тухайлбал:

- “Шар мод- 3 танд шар модны дурс, цагаан агийг ширгээсэн танд *баавгайн цөсийг* тавьж уулгавал хамраас цэс цувирахыг зогсооно” (АУДҮ 1991, 627).
- “Түргүм- 3 танд гүргүм, *баавгайн цөс*, энгэсэгийг найруулсан танг уулгавал цусаар бөөлжихийг зогсооно” (АУДҮ 1991, 629).
- “Габүр- 9 танд габүр, цагаан зандан, жуган, гүргүм, *баавгайн цөс*, дэгд, мэхээр, хонлэн, энгэсэгийг чихэртэй найруулж уулгавал гэмтсэн халуун, хямарсан халуун, цээж хатгуулах, улаан, шар цэр болон цэртэй ханиах зэргийг дарна” (АУДҮ 1991, 634) зэргээр, цаашлаад Габүр-3, Хатан хайлмал-9, Цөс-7, цус тогтоох шинхун зуурмаг, судлын халууны гүргүм-7 гэх мэт ихэвчлэн судлын сүвийг боож, цус гарахыг зогсоох, шархыг дарах чадалтайг эл номд судлан өгүүлжээ.

Мөн баавгайг ардын эмнэлгийн ном, судруудад “хүн гөрөөс” гэж тэмдэглэн, түүний тархи, гавлын яс, мах, тос зэргийг эмчилгээнд хэрэглэх тухай олонтоо дурдсан байна. Жишээ нь, “гавал-3 буюу додба танд хүн гөрөөсний гавал, луугийн яс, дэгд гурвыг гуравны хоёр хувийг нь ширгээж хөргөөд уулгавал толгойн өвчнийг арилгана” (АУДҮ 1991, 627) гэжээ.

Амьтны эд эрхтнээс манай оронд байдаггүй ч монгол эмийн жорд ихээхэн хэрэглэдэг нэгэн зүйл бол **хирсийн эвэр** юм. “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолд “Габүр-14 танд габүр, зургаан сайн, цагаан зандан, *хирсийн эвэр*, хөх удвал, агару...чихэртэй найруулж уулгавал хижгийн халуун дэлгэрч, бие хүндрэх, дурдал буурах, үхэтгэх, хэлхийрэх зэргийг арилгана” (АУДҮ 1991, 634)... “Хирсийн эвэр (сэру)-ийн зуурмал хэмээхэд *хирсний эвэр*, цөсний зүйлийг чихэр, бурам, шинэ шар тосны аль нэгэнд нь зуурч уулгавал уушгины өгөрийг хатаана” (АУДҮ 1991, 650) зэргээр судлан бичсэн байна. Энэхүү хирсний эвэр хэмээх нь халуун оронд амьдардаг хамар дээрээ нэгээс гурван эвэртэй зэрлэг амьтан мөн үү, эсхүл өөр зүйлийн нэрлэлт үү гэдгийг анагаах ухааны доктор С.Сээсрэгдорж, Б.Авирмэд (2014, 25-32) нарын эрдэмтэд судлан үзжээ. Тэд энэ

---

<sup>4</sup> Отгонцэцэг, Г (2020) Отгонцэцэг эмчийн зөвлөж байна.

тухай “Сэрү гэх эмт бодисыг Гомбожав зохиолдоо төвөдөөр 水牛角 хятадаар (水牛角 shuiniujiao) гэсэн бөгөөд тус хятад нэршлийг хөөн орчуулбал “Усны үхрийн эвэр” гэх утгатай юм.

Тэгвэл Жамбалдорж зохиолдоо төвөдөөр 犀牛 хятадаар (犀牛 xiniu) гэж бичсэнийг хятад нэршлээс орчуулбал “Хирсний эвэр” гэх утгатай юм. Харин төвөдийн судлаачид “Хиргүй болор толь” зохиолдоо 印度犀 хэмээн төвөдөөр тэмдэглэж хятадаар (印度犀 yinduxi), (独角犀 dujiaoxi) хэмээн тэмдэглэн бичсэн байдаг. Тухайн хятад нэршлийг орчуулбал 1.Энэтхэг хирс, 2.Ганц эвэрт хирс гэх утгатай юм. Мөн тус амьтан нь туурайтны баг, хирсийн язгуурт хамаарагдах амьтан бөгөөд түүний эврийг эмд хэрэглэдэг, амт нь чихэрлэг, шингэсний сүүлээр сэрүүн, чадал нь хэнхдэг цээжний идээ, цус, шар усыг хатааж, цусны уурыг шингээж цусан халууныг арилгана, хатгалгааг тасалж, хор хийгээд цанхыг дарна, уушиг зүрхэнд халуун оршсон хийгээд халуунаар сэтгэл хямарч долгисох, дотор чичирч айдас хүрэх, хижгийн халуун, цусаар суулгаж, бөөлжих тэргүүтэн тустай гэсэн байдаг.

Харин Өвөр Монголын монгол эмийн судалгааны ажлын удирдагч, доктор, профессор Бөхбаатар өөрийн 2008 оны судалгааны бүтээлдээ дурдахдаа “Усны үхрийн эвэр” хятадаар (水牛角 shuiniujiao) хэмээн Гүн Гомбожавын зохиолыг баримтлан бичжээ. Тус эмийн түүхий эд бол туурайтны баг үхрийн язгуурын амьтан болох усны үхрийн эвэр бөгөөд амт нь эхүүн давслаг амттай бүлээн чанартай, чадал нь муу цус, шар усыг хатаана. Голдуу уушгины өгөр, усан хаван, уяман өвчин, элэгний өвчнийг засахад хэрэглэнэ гэсэн байна.

Эдгээрээс харахад хирс нь халуун оронд оршдог амьтан бөгөөд түүний эвэр олдоц ховор төдийгүй үнэтэй байх нь дамжиггүй. Дорнын анагаах ухаанд ч хирсний эврийн энэ шинж чанарыг чухалчлан үздэг. Гэтэл усны үхрийн эвэр нь хятадын өмнө орноор гаршуулан тэжээвэр болгосон учир олдоц элбэг байдаг байна. Иймд эртнээс аваад өдийг хүртэл монголын зарим газар оронд хирсийн эврийн оронд усан үхрийн эврийг хэрэглэж байжээ. Мөн одоо ч гэсэн Өвөр монголын монгол эмийн үйлдвэрт дээрх янзаар хэрэглэж байна” (Авирмэд, Сээсрэгдорж 2014, 29-30) гэх дүгнэлтэд хүрчээ.

Амьтны гаралтай дараагийн нэг зүйлийн судалгаа бол **хүдрийн заарын** тухай юм. Эртнээс хэрэглэгдэж ирсэн уламжлалт анагаах ухааны 4000 жорын дотроос 573 жорд хүдрийн заар ордог байна (ШУА 2019, 131). Хүдрийн заар нь нян, хижгийг дарах үндсэн чадалтай бөгөөд орчин үеийн шинжлэх ухаанаар вирус, бактери устгах өндөр чадалтай юм. Мөн анагаах ухааны алдартай судар болох “Анагаах ухаан дөрвөн үндэс”-т (1991, 646) бичихдээ “Хорхойн жиданга-7, Сэбүрү-8 зэрэг эмд жиданга, цагаан саримс, марузэ, цахилдгийн үр, хар шавагны үнс, *заарыг* найруулж, халуун хүйтний хөлгөөр жолоодон дотрын хорхой өвчинд уулгах, толгойн хорхой өвчинд бол хамраар утах... зэргээр хэрэглэвэл аливаа хорхойн өвчнийг арилгахад сайн” гэхчлэн олон зүйлийн эмийн найрлагад ордог тухай бичжээ.

Орчин цагт хүдрийн заар агуулсан эм бэлдмэлийн судалгааг тусгай лабораторид хийж, хүдрийг үржүүлэх талаар анхааран ажиллаж байна. Тухайлбал, доктор

Ч.Чимэдрагчаа “Хүдрийн заар, заар агуулсан эм бэлдмэлийн туршилт, судалгааны үр дүн” сэдвээр Анагаахын шинжлэх ухааны доктор (Sc. D)-ын зэрэг 2021 онд хамгаалжээ. Тэрээр хүдрийн заар, заар бүхий “Гарди-5”, “Эрдэнэ үрэл”, “Гарди наалт” зэрэг эм бэлдмэлийн хими фармакологи, технологи стандартын судалгааг цогц байдлаар хийж, улсын стандартыг батлуулан, үйлдлийн механизмыг тогтоосон байна. Цаашлаад Баданга хүдрийн геномын бүрэн дарааллыг тогтоон хүдрийн заарыг нийлэгжүүлэн ялгаруулж буй бүлэг генийг илрүүлэн филогенетикийн хөгжлийн зүй тогтлыг тодруулсан үр дүнг АНУ-ын биотехнологийн мэдээллийн үндэсний төвийн нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлжээ.

Ч.Чимэдрагчаа “Монгол, Хятад хүдрийн үржил, генетикийн харьцуулсан судалгаа” хамтарсан төслийг 2017-2019 онуудад удирдаж, хүдрийг гаршуулан өсгөж үржүүлэхийн зэрэгцээ улмаар түүний эмийн түүхий эд болох заарыг саах аргаар авч, уламжлалт эмийн түүхий эдээр ашиглах, хими-фармакологийн нарийвчилсан судалгааг гүйцэтгэж, өндөр үр дүнтэй шинэ эм, бэлдмэл гарган авах, эмнэлгийн практикт нэвтрүүлэх асуудал тавигдаж байгаа тул хүдэр, түүний заарыг сонгон судалсан байна.

Уламжлалт анагаах ухаанд бугын эвэр, түүнтэй эмийн чадлын хувьд адилавар бөхөнгийн эвэр, бор гөрөөсний эвэр зэргийг өргөн ашигладаг байна. Энэ тухай “Анагаах ухаан дөрвөн үндэс”-ээс гадна Т.Пүрэв “Монгол уламжлалт анагаах ухаан” (2009, 418) номдоо бичиж, тухайлбал, бор гөрөөсний эврийг хэрхэн боловсруулах тухайд “эврийг нь нарийн хуурайгаар үрж, нэг килограмм нунтаг бэлдээд 150 мл усанд буцалган шүүгээд, хоёр хуваана. Өглөө, орой хооллохоос өмнө увал халуунтай өвчнийг анагаах чадалтай. Энэ бэлдмэлийг мөгөөрсөн хоолой, уушги, ходоод, гэдэс, бөөрний үрэвсэлтэй хүмүүс хэрэглэнэ”, харин бугын цусан эврийн тухайд, “бугын цусан эврийг хөрөөдөж авахад гоожсон цусыг бөөр өвчилсөн, цус ба үрийн шингэн багадсан, царай шарлаж, толгой эргэх... дүлийрэх, мэдрэл муудах, яр гарах зэрэг өвчинд 15 дулаар өдөрт 2 удаа хооллохоос өмнө ууна. Цусан эврийг авсны дараа буцлам усанд байлгаж, цус гарахыг нь зогсоогоод сүүдэр газар хатаана” гэжээ. Тэр бээр цаашлаад энэ номдоо гахай, үнэг, чоно зэрэг зэрлэг амьтдын мах, яс, бусад эрхтнүүдийг боловсруулан эмчилгээнд хэрэглэх тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна.

Судлаач Д.Гонгор бээр “Тарваганд хаях муу юм байхгүй” (1996) гэсэн бэсрэг ном бичиж, тарваганы эд эрхтнүүдийг хэрхэн анагаах чадалтай болохыг тодруулжээ. Тарваганы дотор эрхтэн, арьс, нүд, толгойн яс зэргийг өвчин тус бүрд тааруулан хэрэглэхээс гадна нэгэн сонирхолтой эмчилгээ хийдэг нь бүх яс махтай нь хатааж хэрэглэх явдал юм. Тодруулбал, “Тарваганы бүх бие эрхтний мах, яс нь морь малаас унах буюу техникийн осолд орж яс ба бусад бие эрхтэн гэмтсэн бол тэр хүний аль талын ямар яс мөч гэмтсэнээс тарваганы тэр талын мөн яс махыг төмөр ууранд хийж ширхэггүй болтол нунтаглан нүдэж эмийн тунгаар буцалсан усанд найруулж өдөрт гурван удаа уулгавал тэр хүний яс махны эдгэрэлт ердийн эдгэрэлтээс хурдан болно. Тиймээс тарваганы махыг хатаахдаа тодорхой нэр, хаяг зүүн хатаавал зохино” (Гонгор 1996, 9) хэмээсэн байна. Мөн тарвага нь бусад амьтдаас хоёр ходоодтойгоороо ялгардаг бөгөөд идсэн өвс ургамлынхаа аль сайныг сайн ходоодондоо, шимгүйг муу ходоодондоо ялган боловсруулдаг тул

тарваганы сайн ходоодыг хадгалан авбаас хүүхдийн гэдэс өвдөх, ходоодны шарх зэрэгт сайн гэжээ.

Тарвага болон баавгайн тухайлсан эд эрхтэн нь хүмүүний мөн тэр эд эрхтэнд сайн гэсэн уламжлалт анагаах ухааны үзэлд монгол домог зүйн төсөөлөл туйлын ойр байгаа нь харагддаг. Жишээ нь, тарвага бол нарыг харваж чадаагүйгээсээ болоод эрхий хуруугаа тайрч нүхэнд амьдардаг болсон хүн гаралтан, баавгай ч мөн адил эрдэж бардсанаасаа болоод амьтан болсон хүн гаралтан хэмээн домоглодог тул хүнтэй адилтгах олон шинжээр нь уламжлалт анагаах ухаанд үздэг байх талтай байна.

2010 онд анагаах ухааны доктор Т. Алимаа “*Амьтны гаралтай зарим нэгдлүүдийн модификаци үйлдлийг идээ ундаан засалтай холбон судалсан дүн*” (Алимаа, 2010:131) сэдвээр нэг сэдэвт бүтээл туурвисан байна. Мөн бусад судлаачдын хамт бичсэн “Эм таних ухаанд монголчуудын оруулсан хувь нэмрийг судлах асуудалд” (Чагданхорлоо, 2014:97-103) өгүүлэлдээ амьтны гаралтай эмийг монгол мэргэдийн бүтээлд хэрхэн ангилж ирснийг харьцуулан авч үзсэн байна. Энд, “Анагаах ухааны дөрвөн үндэс”-г амьтны гаралтай эмийг амьтны өөрийн эрхтнээр нь ангилсан байдаг. Үүнд: амьтны гаралтай эмийн зүйлд эвэр, яс, мах, цус, цөс, өөх, тархи, арьс, хумс, үс, шээс, баас, их бие лүгээ 13 бүлэг болгон бичсэн байдаг бол Жамбалдоржийн зохиолд хүнээс гаралтай, адгууснаас гаралтай эм гэж 2 хуваасан бөгөөд амьтны онцлог төрөл зүйлээр нь ангилсан байна. Үүнд, Адгууснаас гаргасан эмд: савраар малтагч, хошуугаар малтагчид, гөрөөс, араатан, хүчээр идэгч, хүнд эзлэгдэгч, нүхэнд оршигч, чийг усанд амьдрагч зэрэг 8 бүлэг байдаг” (Чагданхорлоо, Алимаа нар., 2014: 99) гэхчлэн судалсан нь орчин цагт ч хүмүүс ямар амьтан, амьтны ямар эд эрхтэнг хэрэглэж болох, болохгүй тухайд ач холбогдолтой, “өнөөдөр бараг бүх амьтны, магадгүй бүх эд эрхтэн хүний биед сайн гэх яриа газар авсаар байгаа нь амьдралд байж болох мэт боловч хэтийдсэн асуудал болж хувираад байгаа” (Ичинхорлоо, 2012:72-76) зэрэг нийгмийн хүчин зүйлсэд ч хамаатай судалгаа юм.

Шувуучлахуйгаас уламжлалт анагаах ухаанд болжмор, хэрээ, нугас, сойр, хараацай, хойлог, ахууна буюу ятуу, ёл, тас, шар шувуу, харцага, ууль, бүргэд, цахлай, тогоруу, цууцал, галуу, шаазгай, тоть, тоншуул, тогос, сарьсан багваахай зэрэг шувуудын эд эрхтэнд анагаах чадал буй гэж үздэг ажээ. Эдгээр нь Жамбалдоржийн Омон түмбо, Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Эм таних ухаан” зэргээс уламжилсан бөгөөд 1982 онд Ц. Хайдав эдгээрээс эш татаж, “Ардын эмнэлэгт хэрэглэж байсан амьтны гаралтай эм” (Хайдав, 1982) хэмээх ном бичжээ. Уг номд “... хойлог, ятуу зэрэг элдэв зүйлийн болжморын мах биеийг хөнгөрүүлж, хүч чадлыг нэмэгдүүлнэ” (Хайдав, 1982: 223) гэсэн байдаг.

Т. Пүрэвийн “Монгол уламжлалт анагаах ухаан” номд тасын нүд, улаан хоолой, зүрх, яс, ходоод тэргүүтэн, шар шувууны мах, өөх, өд, тархи тэргүүтэн, харцагын өндөг, мах тэргүүтэн, хэрээний өд, мах тэргүүтэн, уулийн мах, өд тэргүүтэн, бүргэдийн мах зэрэг нь анагаах чадалтай хэмээжээ (Пүрэв, 2009: 428-431).

Тус сэдэвт холбогдох дам зохиолуудад шувуугаар анагаах тухай судалгаа, баримт олон байна. Анагаах чадлыг нь монголчууд олон зуун жилийн турш ашигласаар ирсэн хойлог шувууны тухай олон домог бий. Тухайлбал, монголчуудын байлдан дагууллын үед

цэргүүдийг хойлгын мах идсэн, идээгүйгээр нь ялгаж, идсэн цэргүүдийг хамгийн түрүүчийн тулалдаанд оруулдаг байсан, хойлгын мах идсэн цэргийг олзолж авбал туг тахиад, түүний дараа олон хоног хатаан борцолж, дайнд шархдагсдад идүүлж эмнэдэг байсан зэрэг хууч, домог бий.

Судлаач Г. Зориг “Алтайн хойлог” (Зориг, 1989) ном 1989 онд хэвлүүлж, хойлгын экологи, биологи, биохимийн бүхий л зүйлийг судлан үзсэн байна. Эл судалгаанд хойлгын махны найрлага ямар байдаг учраас сувиалан эмнэх чадалтай байдаг вэ гэдэгт гол анхаарлаа хандуулж, бие махбодын тэнхээ тамирыг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөө, үрэвслийн эсрэг үйлчилгээ гэсэн хоёр үндсэн туршилт явуулжээ. Жишээ нь, үүний үр дүнд: “Алтайн хойлгын мах буюу хандмал нь хэмжээнээсээ хамааран бие, махбодын тэнхээ тамирыг 31,1-61,1%-аар тэтгэн сайжруулдаг нь туршилт судалгааны явцад батлагдлаа. Тодорхой хэмжээг сонгон авч үзвээс, биеийн жинд ноогдох 2800мг/кг хэмжээнд туршилтын амьтны динамик хөдөлгөөн дээд хэмжээгээр явагдаж байгаа нь батлагдав. Энэ хэмжээг алтайн хойлгын махыг хэрэглэх дээд хэмжээ гэж үзэх нь зүйтэй. Монгол ардын эмнэлэгт “холын аян дайнд яваа хүмүүс удаан хугацаагаар хойлгын махыг хэрэглэж болохгүй, ер нь сэрүүн чанартай гэж заасан байдаг. Энэ нь их хэмжээгээр хэрэглэвэл тамир тэнхээ сульдана гэсэнтэй адил утгатай” (Зориг, 1989: 204-205) гэхчлэн судлан баталжээ.

Алтайн хойлог хамгийн сөлтэй ургамлыг сорчлон түүж иддэг учраас эрт үеэс эмчилгээний зориулалтаар хэрэглэж ирсэн нь нэгэнт тодорхой болжээ. Харин хойлгын тэжээлийн ургамлыг 3 хуваан,

1. Үе буурцагтан
2. Ургамлын ногоон хэсэг (нахиа, навч, найлзуур)
3. Ургамлын газар доорх хэсэг (булцуу, үндэс, үндэслэг иш) гэж [Зориг, 1989:76] ангилсан байна.

Ургамлын зүйлээр анагаах ухаан

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-т өвсөн эмийн тухай дэлгэрэнгүй дурдаж, ангилсан байдаг. Хамгийн чухал нь хэд, хэчнээн төрлийн ургамлыг эмчилгээнд хэрэглэх зүй зохистой гэх боловч доор дурдсан зүйлийг анхаарахгүй болбоос тэдгээр эмийн чадал доройтно гэж үздэг байна. АУДҮ-г:

“Өвсөн эм бол элбэг баялаг эх сурвалжтай. Өвсөн эмийг ашиглахад долоон гишүүнийг эрхэмлэх хэрэгтэй. Үүнд, ургавал зохих газартаа ургасан, түүвээс зохистой цагт нь түүсэн, хорыг гаргасан, сайтар хатаасан, хуучирсангүй, зөөлрүүлсэн, зохилдож найруулах зэрэг 7 болно” [АУДҮ, 1991: 667] хэмээжээ.

Монгол уламжлалт анагаах ухаанд хэчнээн төрлийн ургамлын зүйлийг эмчилгээнд ашигладаг тухай эртнээс судалж ирснийг монгол маарамбуудын хийсэн ургамлын лавлах, дүймин, эмийн жорын түүвэр зэргээс мэдэж болно. Энэ нь Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Эм таних ухаан” (Lonsangcültüm, 1998), “Өвсөн эмийн тухай” модон барын судар, Жамбалдоржийн “Үзэсгэлэн нүдэн чимэг” (Володя ба бусад, 2008), Жанжаа хутагт

Ролбийдоржийн “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даягаас тэжээхүй ухааны аймаг оршвой” зэрэг зохиолоос уламжлаад, олон арван номд ургамлын гаралтай эмийн тухай судалгаа дурдагджээ.

Ц. Володя, Д. Цэрэнбалжир, Ц. Ламжав нар 2008 онд “Монгол орны эмийн ургамал” (Володя ба бусад, 2008) хэмээх ном бичиж, эмийн ургамлуудыг:

- Хоол боловсруулах үйл ажиллагаанд нөлөөлдөг ургамлууд
- Аргаах, үрэвсэл намжаах чанартай ургамлууд
- Туулгах чанартай ургамлууд
- Салслаг бодист ургамлууд
- Цэр ховхлох чанартай ургамлууд
- Мэдрэл, зүрх судасны тогтолцооны үйл ажиллагаа, биеийн тэсвэрт чанарыг сайжруулах нөлөөтэй ургамлууд
- Цэс, шээс ялгаралтыг ихэсгэх, хөлөргөх, элэгний үйл ажиллагааг сайжруулах чанартай ургамлууд
- Витаминт ургамлууд
- Умай агшаах, цус тогтоох чанартай ургамлууд
- Фитонцидтэй ургамлууд
- Шимэгч хорхойн эсрэг нөлөөлдөг ургамлууд (Володя ба бусад, 2008: 3-8) гэж ерөнхийд нь ангилаад, 160 гаруй эмийн ургамлын онцлог, эмнэх чадлыг өгүүлжээ.

Др. Я. Ганбаяр “Уламжлалт монгол засал” (Ганбаяр, 2010), “Монгол эмийн жорын хувилбар нэрийн түүвэр” (Ганбаяр, 2010), “Монголын уламжлалт анагаах ухааны онолын үндэс” (Ганбаяр ба бусад, 2003) зэрэг ном бичсэн бөгөөд эдгээрт ургамлын гаралтай эмийн түүхийн эдүүдийг судлан оруулсан байна.

Заримдаа амьтнаас гаралтай эмийн зүйл мэт, заримдаа ургамлын гаралтай мэт андуурагддаг эмийн зүйлс цөөнгүй байдгийг судлаачид өдгөө ч судалсаар байна. Үүнд, Матрын цус (Чүсрин таг), Матрын хумс өвс (Чүсриндэрмо), Матрын хумс гэх мэт орно.

“Чүсрин таг (тө.) (血竭 хуејіе), төвөд нэршлээс нь орчуулбал “Матрын цус” гэх утгатай, харин (血竭 хуејіе) гэх хятад нэршлээс орчуулбал “Хатсан цус” гэх утгатай байна. Энэ эмт бодисын талаар төвөд нэршлээр нь тэмдэглэн бичсэн зүйл алга байна. Харин Өвөр монголын эрдэмтдийн үзэж байгаар анхлан Гомбожавын зохиолд тэмдэглэсэн эмт бодис бөгөөд өнгө болон хэлбэр нь хатсан цус адил учир түүнд тулгуурлаж төвөд хятад нэршлийг оноосон гэж бичжээ. Мөн латинаар *Daemonorops draco* B1 гэдэг бөгөөд ховор хэрэглэгддэг эмийн зүйл, чадал нь цусыг зогсоож, шинэ махыг төрүүлэх үйлдэлтэй ажээ. Харин хятадын судлаачид тухайн эмт бодисыг халуун оронд ургадаг нэгэн төрлийн модны давирхайлаг ханд өнгө нь улаан боровтор яг хатсан цус адил иймээс гаднах байдалд тулгуурлаж өгсөн нэр гэжээ. Энэ эмийг хятадын анагаах ухаанд хэрэглэдэг бөгөөд амт нь чихэрлэг тэгш чанартай, бага зэрэг хортой чадал нь хавдрыг хариулж, өвдөхийг зогсоох, цусыг тогтоох, шинэ махыг төрүүлэх чадалтай, голдуу цохигдсон шарх, дотор шарх, хавдар, сарын тэмдгийн өвдөлт, төрсний дараах нуруу өвдөлт, цус алдаад тогтохгүй байгаа шарх гэх мэтчилэн олон төрлийн өвчинд тустай гэсэн байна. Үүнээс харахад



тухайн эмт бодис нь матар хэмээх амьтны цус биш харин ургамлаас гарган авсан өнгө нь хатсан цус адил эмийн түүхий эд болох нь ээ” (Авирмэд, Сээсрэгдорж, 2014: 28-29) хэмээжээ.

Матрын хумс өвс буюу чүсриндэрмо нь Матрын хумс-9 танд орох бөгөөд “матрын хумс өвс, гурван сэрүүн, балэга, удвал, хадны хаг, мэхээр, бивлинг чихэртэй найруулж уулгавал савны хүйтэн халуун харшсан, бор бадган, шар бадган зэргийг дарна” (АУДҮ, 1991: 639). Харин амьтны гаралтай 13 зүйлийн нэг болох хумсны төрөлд “матрын хумсыг нунтаглан ууваас ясны халуунд сайн” (Ганбаяр, 2010: 37) хэмээсэн нь өвс ба хумсыг ялган уух ёстойг сануулж байна. Иймийн учир уламжлалт анагаах ухааны эм танд хэрэглэгддэг амьтан, ургамлын нэрсийг орчуулах, зөв дүйлгэх асуудал байнгын судалгаа шаардаж байдаг байна. Энэ талаар С. Авирмэд, С. Сээсрэгдорж нар “Гүн Гомбожавын “Эмийн нэршлийн Төвөд, Хятад хэлний хадмал оривой” зохиол дахь амьтны гаралтай эмийн түүхий эдийн нэршлийг бусад зохиолуудын зохих хэсэгтэй харьцуулсан үр дүн” гэсэн өгүүлэл, магистр Ц. Батзаяа “Монголын уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэгддэг зарим ургамлын нэршлийг дүйлгэн оноох тухай асуудалд” (Батзаяа, 2012) нэртэй магистрын судалгааны ажлыг 2012 онд хийсэн байна. 2010-аад оноос монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр судалгаа хийж буй судлаачдаас тухайлсан нэг ургамлын эмчилгээний үр дүнг туршилт судалгаагаар баталсан нэг сэдэвт ажлыг олноор хийсэн байна. Жишээ нь, туйплангийн<sup>5</sup> тухай:

- 2001 онд Б. Бямбадорж “Гломерулонефритийг туйплангаар (*Smilax Glabra Roxb*) эмчлэх асуудалд” (Бямбадорж, 2001) сэдвээр анагаах ухааны докторын (Ph.D) зэрэг,
- 2014 онд П. Даваацэрэн “Туйплан-7 тангийн фитохими, технологи- стандартын судалгаа” (Даваацэрэн, 2014) сэдвээр магистрын зэрэг,
- 2014 онд М. Жигжидноров “Туйплан- 7 тангийн бөөр хамгаалах үйлдлийн фармакологийн судалгаа” (Жигжидноров, 2014) сэдвээр анагаах ухааны магистрын зэрэг горилж, судалсан байна.

XVIII зууны эрдэмтэн Ишданзанванжилын “Шүрэн унжлага” зохиолд эл туйплангийн тухай “Туйплан хятад, орос хоёр янз байдаг. Энэ хоёр туйплангаар өвчин бүхнийг анагааж чадна гэж эмч бүхэн хэлдэг боловч найруулах ёс, идээ ундаа, явдал мөрийг мэдэж үйлдэх нь тун цөөн байдаг. Тиймээс би энд бодит үйлдлийн дунд хэрэглэсэн туршлагаа танилцуулья гэж Ишданзанванжил өөрийн номдоо бичсэн нь буй. Туйплангийн чадал их, мөн чанар нь сэрүүн тул хийн өвчинд бүлээн эмтэй, шарын өвчинд сэрүүн эмтэй, бадганы өвчинд шингээлтэд нь тохируулж, нянтай өвчинд цус, хорхойн ерөндөгтэй хамт өгнө гээд гэм тус бүрийн үед шүтэх ёс, нэмэр тавих эмүүдийг нарийн нямбай дурдсан нь практикийн чухал ач холбогдолтой байдаг” (Болд, 2013:287) хэмээн бичжээ.

---

<sup>5</sup> Халуун дулаан орны ургамлын хатуу, хүрэн өнгөтэй үндэс.

## Тангаар эмчлэх арга ухаан

Монгол Улс өнөө үед уламжлалт анагаах ухааны эм тангийн зохистой хэрэглээг ДЭМБ-аас боловсруулсан “Ургамлын гаралтай эмийн хяналтын удирдамж” болон ургамлын гаралтай эмт бодис, эм бэлдмэлийн ЭМЯ-ны Сайдын 1991 оны №А/11 тоот, уламжлалт болон ургамлын эмийн зүйлийг улсын бүртгэлд бүртгэх асуудлыг Эрүүл мэндийн сайдын 2001 оны 7 сарын 10-ны 169-р тушаалын шийдвэрээр зохицуулан шийдэж ирсэн байна. Манай улсын хувьд уламжлалт эм бэлдмэл үйлдвэрлэн хэрэглэх, эм тангийн хяналтын аргыг боловсруулахдаа чанарын хяналтыг гол болгож, Өвөр Монголын Өөртөө Засах Оронд баримталж буй гарын авлагуудыг баримжаа болгодог байна (Дагвацэрэн 2003).

Дээр дурдаж буй “Жүд ши” буюу “Дөрвөн үндэс” ном нь МЭӨ 1500 онд эртний Энэтхэгт бичигдсэн Аюурведийн анагаах ухааны түүхтэй холбогдож байна. VII зуунд Төвөдөд буддын шашин хүчтэй дэлгэрч байх үед Лозова Бирузана 747 онд “Дөрвөн үндэс” номын санскрит хэлнээс төвөд рүү орчуулсан байна. XIII зууны орчим Монголд шарын шашныг улсын шашин болгон дэлгэрүүлэхээр оролдож байсан үед буддын шашны хамтаар Энэтхэг-Төвөд эмнэлгийн ном зохиол манай оронд хүрэлцэн ирсэн ч тухайн үед төдийлөн өргөнөөр дэлгэрч чадаагүй бололтой.

Харин XVI зууны эцсээс Монголд буддизм хүчтэй дэлгэрч, үүний зэрэгцээгээр буддын шашны ном судрын хамт анагаах ухааны нэлээд зохиол орж иржээ. Тэдгээр ном судрын нэг болох эртний Энэтхэгийн эмчилгээ сувилгааны зохиол “Дөрвөн үндэс” Монголд уламжлагдан ирснээр хий цөс, бадган, хурмал өвчнийг эдгээх онолын суурь тавигдаж, ном нь монгол оточ нарын гол гарын авлага болж байсны (Баттогтох 1991) зэрэгцээ монгол хэлэнд орчуулагдаж, олон дахин хэвлэгдэж байсан байна. Гэхдээ энэ номыг хэдийд, хэн гэгч анх орчуулсан нь тодорхойгүй үлджээ. Германы эрдэмтэн В.Хайссиг бичихдээ: “Жүд ши-г XIV зууны үед Чойжи-Одсэр орчуулж, дараа нь Лигдэн хааны үед дахин засварлан орчуулсан” гэсэн байдаг байна. Буддын шашин өргөн дэлгэрч эхэлсэн XVI зуунаас Монгол эрдэмтэн мэргэд Энэтхэг-Төвөдийн анагаах ухааны арга замаас гадна өөрсдөө анагаах ухааны ном бүтээл төвөд, монгол хэл дээр туурвиж байсан нь өнөөгийн Монгол улс дахь уламжлалт анагаах ухааны суурь болсон байна.

Уламжлалт анагаах ухааны дөхөм эмчилгээний гар дэвтэр буюу Жүрүтүшил ном нь тан хийх арга ухааныг гүнзгийрүүлэн судалсан бүтээлүүдийн нэг юм. Уг номыг XIX зууны сүүлчээс XX зууны эхэн үед (1895-1906?) Өвөр Монголын Шилийн гол аймгийн уугуул анагаах ухаантан яруу найрагч Ишданзанванжил Төвөд хэлээр зохиожээ. Тэрээр олон жилийн эмчилгээний туршлага дээр тулгуурлаж, мөн Ордос, Хөх хот, Их Зуу, Цахар, Шилийн гол, Халх зэрэг орны монгол эмч нарын эмчилгээний онцлогийг судлан энэхүү уламжлалт анагаах ухааны дөхөм эмчилгээний гар бичмэлээ бичжээ. Тус зохиолд гадар, дотор, эмэгтэйчүүд, хүүхэд, арьс өнгө, халдварт өвчин, чих, хамар хоолойн өвчин зэрэгт базаж, 100 шахам нэр бүхий өвчнийг эмчлэх арга болон 223 эмийн жор найрлага багтаасан байна. Зохиогч Ишданзанванжил нь Түгээмэл Элбэгтийн IV он Хөх барс жил, одоогийн Шилийн гол аймгийн Цахарын Хөвөөт Цагаан хошууны Төгрөг овоо гэдэг газар амбан

ноён Намжилдоржийн хүү болон төрсөн. Бадаргуулт төрийн 10-аад оноос эхэлж, хөхөгчин хонь жил (1895 он) Сөнөд нутгаас их хүрээнд хүрч, улмаар Халхын хөдөө нутгаар эмчилгээ хийж байсан ба Дорноговь аймгийн Даланжаргалант, Хамрын хийд зэрэг газарт нэлээд хугацаагаар сууж эм барьж байжээ.

Үзэгсдийн баясал буюу Тунгааганжид Энэхүү зохиолыг Өвөр Монголын Шилийн гол аймгийн Сөнөд вангийн хошууны маарамба Жигмэдданзанжамц 1888-1901 онд төвөд хэлээр зохиосон. Зохиогч насан туршийн эмчилгээний бодит туршлага дээрээ тулгуурлаж, анагаах ухааны ном судрын шимийг шингээн, шинийг санаачлах зорилгоор уг номоо зохиосон бөгөөд номыг бүхэлд нь авч үзэхэд, эмчилгээний туршлага, өвчлөл, оношилгоо, эм зүйн талаар дэлгэрүүлэн бичсэн байдаг. Уг ном нь судас барьж оношлох ёс, эм танг дүллэж номхотгох арга, яс барих, цул сав болон тархи домнох зэрэг аргыг заан сургаснаараа монгол эмч нарын дунд гарын авлага болж уламжлагдан ирсэн байна. Эм тан 348 төрөл зүйлийг танилцуулан бичсэн байдаг.

“Монгол анагаах ухааны сонгомол” цуврал бичиг: “Эмийн жор” ус номд монгол эмийг тан эм, талх эм, үрэл эм, зуурмал эм, тосон эм, үнсэн эм, ханд эм, архин эм гэж 8 ангилан хий, шар, бадганд суурилсан өвчнийг анагаах эм найруулах арга, хэрэглэх зааврыг оруулсан эм, танг жагсаан бичсэн байна. Тан эмийг тус номд тодорхойлохдоо: “Тан эм бол ус, сүү мэтийн ямар нэгэн шингэнт найрлага ба чанах буюу дэвтээж найруулсан шингэн биет найрлагын хэлбэр болно. Тан эмийг найруулахад дөхөм, эмийн хүч түргэн болохоор цочмог түргэн өвчинд хэрэглэхэд тохиромжтой байдаг. Дараа нь эс боловсорсныг боловсруулах, сарнисныг хураах, муу цусыг ялгах, хорыг тайлах, хөлөргөх, шээлгэхээр хэрэглэхэд мэдэгдэм үйлдэлтэй бөгөөд уусмал эм болохоор сэдэлт бага, гаж үйлдэл үгүй байдаг. Тан эмд ширгээх тан, дэвтээх тан гэж хоёр зүйл байдаг. Эдгээрийг дотуур гадуур хэрэглэж болно. Уулгахдаа дангаар хэрэглэх буюу бусад талх, үрэл мэтийн эмд хөл болгодог. Гадуур бол угаах, жин тавих, дэвтээх, эрхтэнд дусаах, зайлах мэтийн аргаар хэрэглэнэ” гэжээ.

Уламжлалт анагаах ухааны эмт бодис, эм тангийн химийн судалгааны эрдмийн бүтээл: IV Боть нь “Уламжлалт анагаахын эмчилгээний зарим арга, эм тангийн технологийн судалгаа” төсөл (2010-2012)-ийн үр дүнд суурилж бүтээгджээ. Тухайлбал уламжлалт анагаах ухаанд хий ядаргаа, тархи толгойн өвчнийг анагаан эмчлэх зорилгоор хүний хөтөл гавал, хонины толгой, үлэг гүрвэлийн чулуужсан ясаар эм, тан хийж байсан талаар ном сударт дурдсан байдаг. Монголын анагаах ухаанд хүн ба амьтны ясыг номхотгон эм, тангийн жорын найрлагад оруулж эмчилгээнд хэрэглэж иржээ. Тухайлбал, хий ядаргаа, тархи толгойн өвчнийг анагаан эмчлэх чадалтай митод-3, мана-10, чагдар-10 гэх зэрэг тангийн найрлагад хүний хөтөл гавлын яс, хонины толгойн яс ордог байна. Эдгээр тангууд нь тархины эдийг сэргээх, тайтгаруулах, тархи ба бүлх шөрмөс гэмтэж яс бэртсэн, мэсний шарх, хулгай хөлс гарах, шижин өвчин, дусал алдах, нойр хулжих, зүүд олшрох, бам өвчин зэргийг засах үйлдэлтэй байдаг байна. Уг судалгаанд мэдрэлийн гаралтай өвчинд дээрх малын толгойн яснуудын анагааж буй нөлөө, үйлчилгээг шинжлэх ухааны зүгээс судалж, судалгааны үр дүнгээр тайлбар хийхийг зорьсон байна.

Монгол эмийн жор Уг номд монгол эмч Юй Чин Шиян 50 гаруй жилийн турш өөрийн биечлэн туршсан эмчилгээний үр дүнд тулгуурлан бичсэн “Монгол эмийн жор” номоо 1983 онд хэвлүүлжээ. Энэхүү номд тодорхой өвчнүүдийг анагаах 279 эмийн жор бичигдсэн байна.

Уламжлалт эмт бодис, жорын хяналтын лавламж Уг гарын авлагад 182 эмт бодис, 177 танг багтаасан ба эм тангийн хяналтын аргыг боловсруулахдаа чанарын хяналтыг гол болгож, ӨМӨЗО-д баримталж буй гарын авлагуудыг баримжаа болгон ургамлын болон байгалийн гаралтай эмт бодис, эм бэлдмэлийн зохистой хэрэглээний жор найрлагыг оруулжээ. Тус номд тан эмийн үйлдвэрлэх ерөнхий шаардлагыг дараах байдлаар тусгасан байна:

- Тан эм гэдэг нь дан ба олон хөлийн эмийг тус тусад нь сонгон цэвэрлэж, хамт нунтаглан сайн хольж найруулсан бүдүүн ширхэгтэй нунтаг эмийг хэлнэ.
- Тан эмийг ус, сүү, шөл зэрэг шингэнд чанах буюу дэвтээн бүрж ууна.
- Тан эмийн онцлог нь өвчнийг боловсруулах, цусыг ялгах, сарнисныг хураах, хор тайлах, хөлөргөх үйлчилгээтэй байдаг.
- Тангийн найрлагад орсон эмт бодисын онцлог байдал, шинж чанар нь тухайн жорын өнгө, үнэр, амтыг агуулсан байх шаардлагатай.
- Тан эмийн нунтаглалтын зэрэг 0,5-2 мм байна гэжээ.

Тан эмийн үйлдвэрлэл дараах үе шатаар бэлтгэгддэг байна.

1. Эмт бодисыг цэвэрлэх, хатаах
2. Эмт бодисыг хэмжин авах, номхотгох
3. Нунтаглах
4. Холих
5. Шигших
6. Боох, савлах зэрэг болно.

Уламжлалт анагаах ухааны арга ухаануудаас орчин үеэд хамгийн ихээхэн хэрэглэгдэж байгаа нь тан юм. Монгол улсад уламжлалт анагаах ухааны эмийн үйлдвэрээр 7 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр эмийн үйлдвэрүүд хамгийн сүүлийн байдлаар уламжлалт эм тан болох 1034 эмийг бүртгүүлсэн байна. Харин хөдөө орон нутаг өвлөн уламжлагч нарын хувьд цөөн тооны тан бэлтгэн нутаг орны хүмүүст хүргэж байна. Энэ нь тухайн газар орны онцлогт тохирсон олон үеэрээ бэлтгэж байсан, нутгийн ард иргэд ч хэрэглэж сурсан тангууд байгаа юм.

Домын аргаар арга ухаан

Монгол хэлний журамласан тольд “Дом” гэж уламжлалт анагаах засал, мөн элдэв аюулыг зайлуулах зан үйл” гэсэн утгатай гэжээ. Монголчууд эрт дээрээс урт удаан түүхэн хугацаандаа аглаг буйд хөдөө нутагт мал маллан нүүдэллэн амьдарч, аагим халуун, тэсгэм хүйтэн, салхи бороо, цас шуурга мэтийн байгалийн гамшиг, үзэгдэлтэй ямагт тэмцэл хийдэг байснаас хүйтэн, нойтноос шалтгаалан үүсэх өвчин маш элбэг байсан байна. Иймээс халуун хүйтнийг зохицуулж, өвчин эмгэгийг анагаах тухай туршлага мэдлэг болон

орон нутгийн байгалийн газар зүй, өвчин эмгэг зэрэг орчин ахуйн нөхцөл байдалд тохирсон эмчилгээний хялбар арга барил, эм домьг гаргасан бөгөөд яс хугарсан, үе мултарсныг тэгшлэн барих, хурсан муу цусыг ханаж гаргах, төөнөх болон байгалийн халуун рашааныг ашиглах зэрэг мэдлэгтэй болж, тухайн үеийнхээ хэрэгцээ шаардлагыг хангаж байжээ (Цэрэнсодном 2007).

Монголчууд өвчнийг таньж оношлох, эмчлэх олон янзын арга барил хэрэглэж байсны дотор өвчнийг домнож эмнэх, бариа заслын аргаг эмчлэх, амьтны болон өвс ургамал, байгалийн гаралтай түүхий эдийг хольж найруулан тун хэмжээг тааруулж, эм тан хийж эмчлэх зэрэг гайхалтай арвин туршлага, мэдлэгийн өв сан, арга ухааныг бий болгожээ. Түүний дотроос маш эртний гарал үүсэлтэй, бүр буддын шашин монголд нэвтрэхээс өмнө монголчуудын гол шүтлэг болж байсан бөө мөргөлийн үеэс үүсэлтэй домьн (Баттогтох 1991) энэ эмчилгээ нь бөөгийн шашин, түүний зан үйлтэй холбоотой бөгөөд өвчний ад зэтгэрийг алив нэг юмтай холбоотой гай барцад, тэнгэр газрын юм уу лусын хорлол гэсэн ухаарал байснаас өвчнийг засах өвөрмөц арга бий болжээ. Монголчуудын өвөг дээдсийн бүтээн бий болгосон дом бол Өрнө дахины шившлэг, ид шид, увдис (magic)-аас өргөн хүрээтэй ойлголт юм. Өөрөөр хэлбэл эмчлэх, эдгэрүүлэх, нөхөн сэргээж засах болон гүн ухааны талаас нь авч үзвэл дом, дом засал нь монголчуудын хувьд язгуур буюу үндэсний анагаах ухаан (Ethnic medicine) гэж томъёолж болох байна (Ш. Болд 2013)

Зарим домьн сударт бичсэн зарим нэг дом нь хүний санаанд багтамгүй “инээдтэй, харанхуй мунхаг” мэт боловч, шинжлэх ухаан хөгжөөгүй, хурал номын дуу хүрээгүй газар ч энэ өргөн уудам нутагт олон байсан ба тэр хүмүүсийн итгэл үнэмшил, айдас дээр тогтож, домнож эдгээх арга нь явж байсан гэдгийг харах хэрэгтэй.

Монгол хар домьн судруудын чуулга номд “Чингисийн хар домьн судар”, “Ловонгийн хар домьн судар”, “Эрэндоо Нацагийн хар домьн судар” зэрэг арван гурван судрыг харьцуулан судалж үзээд хүний өвчнийг анагаан засах аргаас эхлээд малын элдэв зүйлийн өвчнийг эмчлэх арга заслыг тус судруудад өгүүлжээ. Эм домүүд хоорондоо адил төстэйг эмчилгээ, домьн аргыг нэгтгэн хүний эрхтэн тус бүрийн өвчин эмгэгийг анагаан засах төрөл зүйлээр нь эмхлэн нэгэн судар болгожээ.

Домьн судруудаас хамгийн их судлагдсан бүтээлүүдийн нэг нь “Домьн судрын зүйлүүд оршвой, Өлзий болох болтугай” судар юм. Хүн, малын өвчнийг анагаах 139 домтой. Гарчгийнхаа хажууд “Чонын шөрмөс түлэх” тарни бичсэн судар, олон янзын домүүдыг эмхэтгэсэн байна. Яагаад энэ тарнийг ингэж нүүрэнд бичих болов гэвэл, бусад домүүдыг бодвол илүү их олон хэрэглэх хэрэгтэй байдаг байснаас ч ийн нүүрэн дээрээ онцгойлон бичсэн байж болох юм. Говь-Алтай аймгийн харьяат олноо Гонио хэмээн нэрийдсэн Гочоо хэмээх номтой, арга чаргатай хүнээр “чонын шөрмөс түлэх” тарнийн арга заслыг яаж хийдэг байсан тухай асууж сурвалжлахад: *“Чонын зүүн хойд хөлийн шөрмөсийг бүтнээр нь авч хатаадаг юм. Энэ хөлийг хулгайч хөл хэмээн нэрлэдэг бөгөөд чонын мөр хөөж явахад зүүн хойд хөлийнх нь мөр тун бүдэг, цасан дээр бол дөнгөж шүргээд өнгөрсөн төдий байдаг. Тийм ч учраас хулгайч хөл гэдэг байх. Тэр хөлийг нь л*

цасан дээр ч юм уу, бүрэн гишгүүлж, хөшөөх буюу малын хулгайч хүнийг танин барих учиртай тарни юм. За ингээд сан тавиад, тарниа уриад галд өнөөх шөрмөсийг халаахтай нь зэрэг өнөөх шөрмөс агишина. Яг энэ үед мал хуй хулгайлсан хүний шөрмөс нь татаас ерөөсөө тавихгүй. Ингээд тэр хүн өнөөх чонын шөрмөс төлсөн хүндээ мал хуйг нь буцааж өгч, уучлал гуйж, дахиж хулгай хийхгүй гэж ам тангараг авч байж, сая нэг шөрмөсөө тавиулах. Зарим хүн тэр чигээрээ яваад хөл нь хазгар мижгэр болсон л байдаг. Мөн ихэнх судар номд зөвхөн шөрмөсийг нь татуулах тарни байхаас буцаагаад тавиулах тарни нь байдаггүй. Яах вэ буцаахдаа бол аяга усанд шөрмөс тавиулах тарниа тоолж гүйцээд, түлээд агисан шөрмөсөө хийхтэй нь зэрэг буцаж тэлээд хэвдээ орж байгаа юм. Нарийн учиртай, хамаагүй дураараа хэрэглэж болдоггүй, өөрийгөө ч сүйдэлж мэдэх айхтар ном шүү” хэмээн ярьж байжээ (Домын судрын зүйлүүд оршвой, Өлзий болох болтугай, х.9).

Нэр үгүй домын судар нь 122 домтой, “Ум суvasди - Аливаа амьтныг домоор засахад итгэл явуулж, шүтэн барилдсаны зүрхэнг гурвантаа уншиж үлээн тусалбаас туслахын дээд буюу” хэмээн уг судар эхэлдэг байна. Доторх домын төрөл зүйл, домнох засах арга зэрэгт, уламжлалт анагаах ухааны цагаан тан, эмийн зүйлс нэр орсон тул эмийн ном үзсэн, эм барьдаг хүн бичсэн байх магадлалтай (Нэр үгүй домын судар, 18).

“Хүмүүний элдэв өвчнийг анагаах нууц хар домын судар оршвой” судар нь 55 домтой. Хүний өвчнийг анагаах тухайд дэлгэрэнгүй тайлбартай домуудыг эмхэтгэсэн, судрын хэл хийгээд домнож буй байдал зэргээс нь үзвэл ХХ зууны эхээр Хангай нутагт амьдардаг хүн эмхэтгэсэн болов уу гэж таамаглаж болохоор. Тарвагатай холбоотой домууд олон оржээ (Хүмүүний элдэв өвчнийг анагаах нууц хар домын судар оршвой, 26).

“Элдэв эм домоор хүн, малын өвчнийг засах” судар нь 176 домтой. Уг судрын төгсгөлийн үгэнд:

“...Хүүхэд цагаасаа хөгширтлөө  
Хэн хэнд тус болохыг санаж  
Хэдэн мэргэдээс олж тэссэнээс  
Хэлхэн жигдлэн бичив би.  
Энэтхэг, Төвөд, Хятад, Хотонгоос  
Эшилж ирсэн эм дом эдгээр  
Эх болсноо их тус болж  
Эгнэгт оришин дэлгэрэх болтугай  
Эгүүнийг анхааран авагч бодгальс  
Эрдэнэ бодь сэтгэл лүгээ төгсч  
Эсэргүүцэгч хөнөөлөөр арилаад  
Эцэст бурхны хутгийг олтугай.

Ер увдисын зүйл олноо мэдэгдвээс адистид нь сулран алдрах ёст мэдэгдэхүй буй. Чингис богдын алтан ургаас чухал үүдсэн тайж Гомбожав Хүжт уулын аглаг орон Хотолд гэрэлт хэмээгдэх бухар хийдэд бичээд, гурав дахиж шүүсэн буй. Сарва Мангалам” хэмээн бичсэн байна. Үүнээс үзвэл, тайж Гомбожав хэмээх хүн бичжээ. Тэрээр Чингис хааны

алтан язгуурт мэндэлсэн язгууртан хүн байна. Хүжт хэмээх ууланд орших Хотолт гэрэлт хэмээх бухар хийдэд бичээд, гурав дахин ариутган шүүжээ. Хүжт уул хэмээх нь Монгол, Төвөд, Хятад сүм хийд болох тухайд тодорхой мэдээ алга. Ямартай ч энэхүү домын судрыг эмхэтгэгч нь бичгийн хүн төдийгүй монгол судрын утга зохиолд нийтлэг байдаг төгсгөлийн шүлэг бичсэн байна. Энэтхэг, Төвөд, Хятад, Хотон 4 өнгө, 5 харь улсын олон мэргэдийн бичиж бүтээсэн эмнэх домнох эш ухааны үндэснээс цуглуулан дээжлэн түүвэрлэж бичсэн хэмээн тэмдэглэж байгаагаас үзвэл, энэхүү хар домын судар хийгээд ерөөс домын арга засал нь дан ганц нүүдэлчин монголчуудынх бус дорно дахины, тэр дундаа яг нарийн задлан үзвэл Монголоор төвлөсөн энэ дөрвөн улсын анагаах ухааны охь гэсэн утгаар бичжээ. Ингээд үзвэл дом нь нийгмийн доод төвшний эгэл хар амьдралын ухаанаас дээш төр, шашныг хослон барих хос ёсны сургаалын салшгүй нэг хэсэг байжээ гэдэг нь энэхүү шүлгээс харагдаж байна. (Элдэв эм домоор хүн, малын өвчнийг засах, 38).

“Олон зүйлийн домын судар болой” судар нь дотроо хэд хэдэн бүлэг судраас бүрдэнэ. Тухайлбал 1-17 дугаар хуудсанд байх 1 судар нь 147 домтой. Энэ домууд нь зөвхөн хүний өвчнийг домнох арга заслууд голлосон байна. 17-20 дугаар хуудсанд байгаа судар нь “Аливаа малын арга бичиг” нэртэй нийт 22 домтой. Ингээд сударт нийт 169 дом багтсан.

“Хэрэгт увдисын товч хэмээх хар домын судар” нь дотроо 97 увдис байгаагийн дээр олон нэмэлт хувилбараар баяжуулж, дэлгэрэнгүй хийсэн байгаа тул яг хэдэн дом байгааг тоолох боломжгүй. Увдис хэмээх нь Энэтхэгийн хэлээр упадеша гэсэн үг бөгөөд монгол хэлнээ нэн эрт орж ирсэн бололтой. Энэ ном нь домын судар төдийгүй бичиг мэдэх, тэр дундаа итгэл, хариуцлага хүлээх эрх бүхий хүмүүсийн уншиж судалдаг ном байсан байна.

“Дом заслын судар оршвой” судрыг яах аргагүй Төвөд хэлтэй буюу сүм хийдийн боловсролтой лам хувраг хүний бичсэн буюу цуглуулж эмхэтгэсэн гэж хэлэх үндэстэй. Учир юу гэвэл, монгол үсэг мэдэхгүй хүн хэл аялгууных нь онцлогийг үзвэл, монгол бичиг бүр мэдэхгүй ч бус бичлэгийн дүрмийг нэлээд сайн мэддэг хүн төв халх аялгуу буюу хүрээний аялгуугаар тэмдэглэжээ. Жишээ нь, 2-р хуудсанд “*цэ жи ха гар ба са, ар бай аин гуу рил хонг нинг ни ауу раг дор бу цал га жэ ау ба са ссайн*” буюу “цээж хагарваас (одоо бол хорсох, гашуу оргих гэсэн утгатай) арвайн гурил, хонины уурагтай буцалгаж ууваас сайн” хэмээн буух ийм нэгэн дом байна.

Монгол эм домын засал номд Монголчууд эрт дээр үеэс судлан боловсруулж, өвлөн уламжилж ирсэн анагаах ухааны эрдэм буюу өвчин зовлон тохиолдвоос ямар ургамал, ан амьтны юуг авч хэрэглэвэл тус болдог, эдгээх чадалтайг судлан мэдэж уламжлуулж ирсэн домын заслуудыг хураангуйлан өгүүлжээ.

Эмгэг согог бүхнийг эдгээн илаарьшуулагч эм дом тарнийн сударт Халуун хүйтнийг зохицуулж, өвчин эмгэгийг анагаах тухай туршлага мэдлэг болон орон нутгийн байгалийн газар зүй өвчин эмгэг зэрэг орчин ахуйн нөхцөл байдалд тохирсон эмчилгээний хялбар арга барил, эм домыг гаргасан бөгөөд яс хугарсан, үе мултарсныг тэгшлэн барих, хурсан муу цусыг ханаж гаргах, төөнөх болон байгалийн халуун рашааныг ашиглах, бариа

заслын аргаар эмчлэх, амьтны болон өвс ургамал, байгалийн гаралтай түүхий эдийг хольж найруулан тун хэмжээг тааруулан эм тан хийж эмчлэх зэрэг арвин туршлага, мэдлэгийн өв сан, арга ухааны жагсаалт. Энэ номд домьг бөөгийн шашнаас үлдсэн зан үйл гэж тусгажээ.

Дом засал нь анагаах ухааны олон салбар үүссэн хөгжсөн өнөө үеэд ч ардын дунд эрүүл мэндийн анхны тусламж шиг оршин байсаар байна. Нүүдэлчдийн хувьд олон зуун хадгалагдаж ирсэн ахуй соёл нь байгаа учир түүнийг дагасан анагаах ухааны арга хэлбэрүүд нь түүнийгээ дагаад уламжлагдан ирсэн нь ажиглагдаж байна.

### Бариа заслаар анагаах арга ухаан

Эртний хүмүүс биеийн гадар шархны эвэршээлээр хэсэг газраа барих, атгаж үлээх буюу чимхлэх өвдөх нь намдаж хавдар нь буухыг олж мэдэхийн зэрэгцээ задгай шархыг боож цус гарахыг тогтоон, ясны хугарлыг барьж боовол яс эвлэн эдгэрэхийг танин мэдсэн байна (Ш.Болд 2013). Монголчууд бариа заслын аргыг дараах байдлаар дөрөв ангилдаг. Үүнд

1. Илэн барих
2. Эвлүүлэн барих
3. Даран барих
4. Доргиулан барих арга ордог.

Домын сударт бичсэн баримтаас ажиглахад илэн барих, даран барих, эвлүүлэн барих, доргиулан барих нь хэвлийн хөндийн даралт нэмэгдүүлэх, доргиох, булчин агшсаныг сулруулах аргаас бүрддэг байснаас гадна чиг тавих, ороох боох арга хэрэглэдэг (Ш. Болд 2013) ба энэхүү аргууд нь одоо ч нүүдэлчдийн дунд хэрэглэгдэж байна. Энэхүү аргууд нь түүхийн урт хугацаанд хадгалагдсан нь нүүдлийн соёл, ахуй соёлтой салшгүй холбоотой юм. Бариа заслын аргын түүхэн байдлыг авч үзвэл Төмөр зэвсгийн үеийн түрүү үеийн буюу МЭӨ VII-III зууны үед холбогдох иж бүрэн дурсгал болох Чандманы соёлт нүүдэлчдийн дунд урт мөчдийн яс болон бусад ясны гэмтэл 8.4 хувь байж, нас болон хүйсийн онцын ялгаа ажиглагдаагүй байна. Тэрхүү олдворуудын хугаралтын эдгэрэлтийн шинжээр нийт гэмтэл авсан ясны 70 хувь зөв бороолон эдгэсэн байсан бол 30 хувь нь буруу бороолон эдгэрсэн байна. Археологийн олдвор нь хүрэл төмөр зэвсгийн үеийн Баруун Монголын нутагт иргэншиж байсан нүүдэлчид бариа заслын арга ухааныг ашиглан эмчилж байсан нь тогтоогдож байна. Мөн өөр нэгэн мэдээ бол Юань улсын үед гэмтлийн эмнэлэг ихэд хөгжиж байсан ба хятад эмнэлгийн бариа заслын номын 39 дүгээр хуудсанд “Тай И Юан” эмнэлгийн хорооны тухай бичихдээ Юань улсын үед 13 тасагтай ажилладаг байсан бөгөөд ясны гэмтлийн гэх тусгай тасагтай байж, зарим мэдээнд Чин улсын үеэс 300 жилийн өмнө Монголчууд хугарсан ясыг үхрийн ясаар бэхлэн боох арга нь дотор газар уламжлагдан орсон хэмээсэн байдаг (Ш.Болд 2013)



## Зүү эмчилгээний арга ухаан

Зүү эмчилгээний тухай ярихын тулд Хятадын анагаах ухааныг ярих хэрэг болох юм. энэ нь юу вэ гэвэл Хятад Монгол улс олон зуун жил хөрш зэргэлдээ байсан бөгөөд соёлын хувьд олон зүйлсийг солилцсон байдгийн адил анагаах ухааны арга ухаанд ч гэсэн мөн адил юм. Хятадын анагаах ухааны гол бүтээл болох Хуан Ди Нэйжин гэх алдартай бүтээл байдаг. уг бүтээл нь 81 бүлэг бөгөөд үүний 14 бүлэг нь зүү эмчилгээтэй холбоотой маш нарийн заасан байдаг байна. Энэхүү бүтээлийн нь 2 номоос бүрдэх бөгөөд Лингши буюу зүү заслын сонгомол хэмээн орчуулагддаг (Ш.Болд 2013). Монгол улсад 16 оны дунд үеэс зүү заслын олон ном бүтээлүүд орчуулагдан ашиглагдаж байсан нь мэдэгдэж байна. Монголын анагаах ухааны зүү, төөнийн хөгжилд томоохон хувь нэмрээ оруулсан Юань улсын анагаах ухаантан Хутайбил (Хао тай би лие) “Алтан цахирамын эргэлтийн суваг” гэсэн номыг XIV зуунд зохиожээ. Харамсалтай нь энэхүү ном бидний үеийг хүртэл уламжлагдаж ирээгүй, устаж үгүй болсон байна. Энэ бүтээлийн талаар одоогоор мэдэгдэж байгаа баримтууд нь Юань болон Мин улсын анагаах ухааны зохиол болон Чин улсын номын гарчгаас олдож байна. Тухайлбал: Юань улсын Хуа Шоу (Hua Shou) “Арвандөрвөн жимийн дэлгэрүүлэл” (Shi si jing fahui, 1341) болон Мин улсын Ян Жизоу (Yang Jizhou) “Зүү төөнийн бүрэн бичиг” (Zhenjiu da chang, 1601)-ээс иш татан авчээ. Мөн “Зүү төөнийн бүрэн бичиг”-т “Алтанцахирамын эргэлтийн суваг”-ийг Юань улсын Хан лин шиу эйши Хао тай би лиезохиоваа гэсэн байдаг. Уг бүтээлд: цээж нурууны хоёр зураг, гар хөлийн гурван билиг, гурван аргын хандаш, арван дөрвөн сувгийн урсгал тус бүрт тайлбар хийж, ард нь зурагдагалдуулаад улмаар умард орноор уламжилваа хэмээжээ. Энэ ном зүү, төөнө болонсуваг, хэрдсийн талаар дурдсан зохиол болно. (Т.Дэлгэрсүрэн 2014)

Тиймээс ч БНХАУ эртний түүх сурвалж дээр үндэслэн 2010 оны 11 дүгээр сард Кени улсын Найроби хотод зохион байгуулсан Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах Засгийн Газрууд Хоорондын 5-р хуралдаанаар ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад “Зүү төөнүүр”-ийн арга ухааныг бүртгүүлсэн байна. Тиймээс бидний судалгааны гол зорилго болох ЮНЕСКО-д бүртгүүлэх монголчуудын гэх анагаах ухааныг судалж буй учир Зүү төөнүүрийн арга ухааныг цааш гүнзгийрүүлэн судалсангүй.

## 2. Ардын уламжлалт анагаах ухааны өвүүд ба өвлөн уламжлагчид

Бид энэхүү судалгааны ажлаараа Монгол улсад байгаа ардын уламжлалт анагаах ухааны нийт өв түүний ав савуудад байгаа 8 өвийн өвлөн уламжлагч нартай уулзаж, анагаах ухааны өнөөгийн байдал, өвлөн уламжилсан арга ухааны тухай нарийн судалсан юм. Нийтдээ 22 хүний 40 гаруй цагийн видео бичлэгээр баримтжуулан ярьсан ярилцлагыг хавсралт хэсэг оруулсан болно. Бидний судалгаан хамрагдсан өвлөн уламжлагч нарыг (хүснэгт 1) харна уу.

№	Аймаг сум	Нэр	Өвлөн уламжилсан арга ухаан	Бүртгэл
1	Өвөрхангай аймаг Есөнзүйл	Л. Цэцэгмаа	Бариа засал	Соёлын өвийн үндэсний төвд бүртгэлтэй
2	Өвөрхангай тарагт	А. Шоовдор	Бариа засал	Шинээр бүртгэсэн
3	Баянхонгор аймаг	Ж.Цагаанмуна	Ургамлаар анагаах	Шинээр бүртгэсэн
4	Баянхонгор аймаг Хүрээмарал сум	Б.Болдбаатар	Бариа засал	Бүртгэлтэй
5	Баянхонгор аймаг Баянбулаг сум	М. Батболд	Бариа засал	Бүртгэлтэй
6	Баянхонгор аймаг Баянбулаг сум	Д. Жадамба	Энергийг эмчлэх	Шинээр бүртгэсэн
7	Завхан аймаг Цагаанхайрхан	Ж. Цэенцогзол	Бариа засал	Бүртгэлтэй
8	Завхан аймаг Яруу сум	Д. Дэмчиг	Тан бэлтгэх	Бүртгэлтэй
9	Завхан аймаг Идэр сум	Нарантуяа	Ургамлаар анагаах	Шинээр бүртгэсэн
10	Завхан аймаг Тосонцэнгэл сум	М. Цэвэгжав	Гүрэм засал	Шинээр бүртгэсэн
11	Завхан аймаг сонгино сум	Б. Цэндсүрэн	Тан бэлтгэх	Бүртгэлтэй
12	Увс аймаг Завхан сум	Эмэгтэй	Бариа засал	Шинээр бүртгэсэн
13	Увс аймаг Тариалан сум	Ш. Алтанцэцэг	Бариа засал	Бүртгэлтэй
14	Увс аймаг Улаангом	Ш.Бадамсамбуу	Дом засал	Шинээр бүртгэсэн

15	Увс аймаг Ховд сум	А.Назгүл	Зүү засал	Бүртгэлтэй
16	Баян-өлгий аймаг Өлгий	С. Жамела	Бариа засал	Бүртгэлтэй
17	Баян-өлгий аймаг Өлгий	Б. Жазера	Бариа засал	Бүртгэлтэй
18	Баян-өлгий аймаг Алтанцөгц	Ц. Адууч	Бариа засал	Бүртгэлтэй
19	Говь-Алтай аймаг Бигэр сум	Б.Одонхүү	Яс барих засал	Шинээр бүртгэсэн
20	Архангай аймаг Тариат сум	Б. Цэвэгжав	Бариа засал	Шинээр бүртгэсэн
21	Архангай аймаг Өндөр-Улаан сум	Ч. Идэрмөнх	Бариа засал	Шинээр бүртгэсэн
22	Архангай аймаг Өндөр-Улаан сум	Ч.Эрдэнэсүх	Бариа засал	Шинээр бүртгэсэн

*Хүснэгт 1: Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нар*

Ардын уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагчдын ихэнх нь 3 болон 4 дэх үе дээрээ өвлөн уламжилж байгаа юм. Мөн дээрх өвлөн уламжлагч нараас 2 хүн нь өөрсдийн үр хүүхдүүдэд өөрсдийн эзэмшсэн арга ухааны заан сургаж байгаа юм.

### Ургамлын зүйлээр **анагаах**

Монгол орны эрс тэрс цаг уур болоод говь, хангай, тал хээр, өндөр уулын хэв шинж бүхий өвөрмөц байгальд ургасан өвс, ургамал бүр эмийн шинжтэй гэж хэлэлцдэг бөгөөд тухайлбал, Монгол Алтайн Алтай таван богдын орчим дахь “ургамал өвс бүр эм, ус булаг бүр рашаан”-ы шинжтэй гэж тэнд оршин суугч ард түмэн өгүүлдэг. Тиймээс монголчууд олон зуун эмийн ургамал, тэдгээрээр анагаах тухай дорно дахины ард түмнүүдийн дунд өөрийн гэсэн арга ухаан, уламжлалтай эсэхийг энэхүү судалгаагаар тодруулсан юм.

Монгол уламжлалт анагаах ухаанд хэчнээн төрлийн ургамлын зүйлийг эмчилгээнд ашигладаг тухай эртнээс судалж ирснийг монгол маарамбуудын хийсэн ургамлын лавлах, дүймин, эмийн жорын түүвэр зэргээс мэдэж болно. Энэ нь Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Эм таних ухаан” (Lovsangcültüm, 1998), “Өвсөн эмийн тухай” модон барын судар, Жамбалдоржийн “Үзэсгэлэн нүдэн чимэг”, Жанжаа хутагт Ролбийдоржийн “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даягаас тэжээхүй ухааны аймаг оршвой” зэрэг зохиолоос уламжлаад, олон арван номд ургамлын гаралтай эмийн тухай судалгаа орсон байдаг.

“Монгол эмийн жорын хувилбар нэрийн түүвэр” зохиолд модон эм юу юунаас бүрддэг тухай “Модон эм нь үндэс, хожуул, мод, мөчир, гол, холтос (хальс, дорс), давирхай, навч, цэцэг, үр зэрэг 10 зүйл болно” (Ганбаяр 2010, 31) хэмээсэн бол,

“Уламжлалт монгол засал” номд хүнсэнд хэрэглэдэг, мөн эмчилгээнд хэрэглэдэг үр болон жимсний зүйлийг жагсаан тайлбарлажээ. Үрийн зүйлд: тутарга, буудай, монгол амуу, шар будаа, эрдэнэ шиш, сагаг гурил, арвай, цагаан гаймуу буюу юнгэр будаа, шар буурцаг, наран цэцгийн үр, төмсний улаан цэцгийн үндэс, хонхорцог цэцгийн үр, нангиад арүр, овъёос (Ганбаяр 2010,183-190) зэргийг багтаажээ.

Харин жимсний зүйлд: алим, үзэм, гадил, чавга, чацаргана, долоогоно, нохойн хошуу, үхрийн нүд, тарвас, хушга, самар, мойл, гүйлс, тоор, жүрж, нохойн шээрэнгэ, ногооны зүйлд: жууцай, байцаа, лууван, халгай, сонгино, саримс, чинжүү, гашуун ногоо, билигт навч, яншуй, цоохор ногоо, гаймуу, өргөст ногоо, төмс, мөөг, гоньд, манжин, хурган чих, гишүүнэ, хуажуу, гаа, хөмүүл, таана, лууль, улаан лооль гэсэн (Ганбаяр 2010, 190-200) зүйлсийг багтаан, анагаах чадлыг тодорхойлжээ.

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-т өвсөн эмийн тухай дэлгэрэнгүй дурдаж, ангилсан байдаг. Хамгийн чухал нь хэд, хэчнээн төрлийн ургамлыг эмчилгээнд хэрэглэх зүй зохистой гэх боловч доор дурдсан зүйлийг анхаарахгүй болбоос тэдгээр эмийн чадал доройтно гэж үздэг байна. АУДҮ-т: “Өвсөн эм бол элбэг баялаг эх сурвалжтай. Өвсөн эмийг ашиглахад долоон гишүүнийг эрхэмлэх хэрэгтэй. Үүнд, ургавал зохих газартаа ургасан, түүвээс зохистой цагт нь түүсэн, хорыг гаргасан, сайтар хатаасан, хуучирсангүй, зөөлрүүлсэн, зохилдож найруулах зэрэг 7 болно” (АУДҮ 1991, 667) хэмээжээ.

Өнөөгийн байдлаар анагаах чадалтай өвс ургамлуудыг монголчууд өдөр тутам ашиглаж байна уу, үгүй юу гэдэг чухал бөгөөд бидний судалгаанд оролцсон Завхан аймгийн Идэр сумын харьяат, өвлөн уламжлагч Нарантуяагийн<sup>6</sup> хувьд өөрийн туршлагаар дараах ургамал, эрдсүүдийг эмчилгээнд ашиглаж, хүмүүсийг анагааж байна. (Хүснэгт 2 харна уу)

	<b>Ургамлын нэр</b>	<b>Анагаах чадал</b>	<b>Хэрэглэх арга ухаан</b>
1	Өмхий давс	Мухар олгой хатаах	Уулгана.
2	Нохойн хошуу	Цөсний чулуу хайлуулах	Найруулаад 7 хоног уулгана.
3	Сонгино	Бөөрний чулуу хайлуулах	Архитай хольж өгнө.
4	Жамц давс	Хоолойн мах хатаах, хоолойн цусыг шимэгдүүлэх	Долоолгоно.
5	Тэмээн зулын цагаан цэцэг	Цусны бүлэгнэлийг эмчилнэ.	Уулгана.
6	Боогон /шар цэцэгтэй/	Бөөр эмчилнэ.	Уулгана.
7	Боогон /хөх цэцэгтэй/	Бамбай булчирхай эмчилнэ.	Уулгана.
8	Боогон	Цагаан мах эргэх өвчнийг	Уулгана.

<sup>6</sup> Завхан аймгийн Идэр сум Нарантуяа

		эмчилнэ.	
9	Шар дэгд, дэгдэнэ	Элэг шарлах, В, С вирусийг эмчилнэ	Буцалгаж уулгана.
10	Жонш	Савны амсрын саадыг хайлуулна.	Номхотгоно. Найруулж уулгана.
11	Манчин [манжин] өвс	Хөл гарын өвчин, ясны сийрэгжилтэд бооно.	Номхотгоно. Их хэмжээний архинд хийж байгаад түрхэнэ.

*Хүснэгт 2 Ургамлаар анагаах арга ухаан болон хэрэглээ*

гэх мэтээр нэг өвлөн уламжлагчийн хувьд гэхэд олон жилийн туршлагын үр дүнд эдгээр эмийн ургамал болон газраас олборлодог эрдсүүдийг ашиглан бараг бүхий л төрлийн өвчнийг эмчилж чадна гэсэн итгэл үнэмшилтэй, дадал туршлагатай болжээ. Энэхүү өвлөн уламжлагч нь Завхан аймагт оношлогдсон цусны бүлэгнэл болон бусад төрлийн цусны өвчинтэй хүүхдүүдийг анагаах саналыг удирдлагуудад нь тавьж байсан ба “эмчлэх эрх”-ийн асуудлаас болж, зөвшөөрөөгүй байна. Мэдээж энд ардын анагаах ухааны дадлага туршлагыг сайн бусдыг нь муу гэх эсвэл шинжлэх ухааны үндэстэй, үндэсгүй гэсэн дуусашгүй маргаан өрнүүлэх гэсэнгүй. Харин олон зуун жилийн турш хэрэглэж заншсан, эмнэж дадсан зарим нэг өвчин хуучид энэ мэт уламжлалт арга ашиг тустай байдгийг анхаарч, заавар "эмчлэх эрх" зэргээр хяхаж хавчих бодлого барихгүй байвал дээргүй юу гэсэн санал дэвшүүлж байна. Бодит байдал дээр олон иргэн тухайн ардын анагаах ухааны мэргэжилтнээр эмчлүүлсээр, зөвлөж ярилцсаар байгаа нь тодорхой тул нэгэн тогтсон энэ харилцааг илүү үр дүнтэй байдлаар хадгалахад албан бодлого чиглэвэл тал талдаа тустай юм.

Эмийн ургамлаар эмчлэх эл уламжлал хоёр төрлийн хүрээ хязгаартай байна гэж үзэж болно. Нэгдүгээрт, Улаанбаатар хотод төвлөрөн, судар ном, сургууль, дацангаар суралцан төгссөн эмч нарын эмнэлэгт түшиглэн тан эм барих болон хөдөө орон нутагт өөрсдийн боломж бололцоог ашиглан өвсөн эм бэлтгэж, хүмүүсийг эдгээж байгаа 2 хэлбэр байна. Улаанбаатар хотод ирж эмчлүүлэх боломжгүй хүмүүс тухайн хөдөө орон нутагтаа байгаа эмийн ургамлаар эмчилдэг хүмүүст хандаж, эмчилгээ нь амжилттай болдог учир эмийн ургамлын эмчилгээ эрт үеэс өнөө үед ч тасраагүй явж ирсэн байна. Хөдөө орон нутгийн өвлөн уламжлагч нар нь цөөн тооны нутаг орны өвчин түүнд тохирсон тан тун сайн хийж гаршсан нь ажиглагдаж байна. Хүмүүсийн өдөр тутмын хэрэглээнд хэрэглэдэг, эсхүл юунд ч хэрэггүй гэж боддог энгийн өвс ургамал нь ямар ч өвчин зовуурийг анагаах чадалтай байдаг нь “өвсөн эм”, түүгээр анагаах эрдэм ухааны гол онцлог юм. Энд, дэгд өвч, таван салаа, чихэр уяа өвс, гишүүнэ, шархны шар цэцэг, ганга зэрэг орно. Тухайлбал, өвлөн уламжлагч Б. Болдбаатар “Шүд, нүд хоёрыг эмчлэх хамгийн хэцүү. Шүдний өвчин бол манай Монголд ургадаг зэрлэг сонгинын үрэнд жаахан найрлага хийгээд аргалын хөх цог дээр хийнэ. Тэгээд утаа гарахаас нь өмнө варианты шилийг шар тосоор юм уу, сүүлний тосоор тосолж байгаад дээрээс нь таглаад тавина. Тэгэхлээр тэр

*шил маань дүүрэн утаа болно. Цогон дээр тавьсан шил халж таарна. Тэгэхээр маарлаар зузаалж байгаад, чихэндээ тааруулан барина. Санаа дагаад ч тэгдэг юм уу, жижигхэн хар хялгасархуу, өтөрхүү юм гарсан байдаг.*(Зураг 3-ийг харна уу)Тэгээд л зүгээр болчихдог, шүдний өвчин бол гайхалтай дарагдана. Уйлж орж ирээд инээгээд л гарна. 15 минутын л ажил шүү дээ, ахиж тэр шүд өвдөхгүй, авхуулах шаардлагагүй, тэр шүд өгөрч л дуусна, ахиж өвчлөхгүй” хэмээн зэрлэг сонгинын үрээр шүд эмчлэх тухай ярьж байхад, орчин үеийн анагаахын шинжлэх ухаанд Алтайн сонгино буюу *Allium Altaicum Pall*-ыг лабораторид түшиглэн судалж, сонгино ба хальс нь таргалалт, өөх тосны солилцооны алдагдал, артерийн даралт ихсэлт, бодисын солилцооны хам шинжийг анагаах, үрэвслийг анагаах зэрэг үр нөлөөтэйн сацуу ямар хурц хорон чанартайг цагаан хулгана дээр туршин дүгнэжээ (Номин-Эрдэнэ 2017, 4). Эндээс харвал, монголын уламжлалт анагаах ухааны эмийн ургамлаар анагаах ай сав нь хот- хөдөө, мэргэжлийн-мэргэжлийн бус, лабораторид туршигдсан- “амьдралд туршигдсан” гэх мэт олон ялгааг дотроо агуулж байгаа ч үр дүнгийн хувьд хараахан хол зөрөхгүй байгаа нь нэн сонирхолтой юм.



*Зураг: 3 Уламжлалт аргаар шүд эмчилсэн дараах байдал*

Өөр нэгэн өвлөн уламжлагчийн хувьд: “Үлд гээд өвчин сүүл үед гараад байгаа шүү дээ. Бие нь битүү яр шархандаа баригддаг. Анагаахаар бол эм тариа хийлгээд хэд хонодог, ахиад хэд хоноод гараад ирдэг. Энэ зүйлийг би бас эмчилдэг. Энд эмчилгээ хийсэн тохиолдолд дахиж үлдний асуудал байхгүй. Хөх арвай болон билүү гээд хутга хурцалдаг чулуу хоёроор эмчилнэ. Хөх арвайгаа тэгшихэн төмпөнгийн ёзоор дээр тавьж байгаад халуун хайруулаар хайрна. Тэгэнгүүт хөх арвай маань түлэгдээд хар баас гарна. Тэр нэг их

гоё үнэртээд л, давирхай шиг ч юм уу тийм зүйл гарна. Арвай шатаж дуусахад халуун хайруулаар түлсний ором, арвайг тойрсон шар юм гарч ирдэг. Түүнийг билүүтэй холиод түрхэхэд маш их хорсоно. Тэгээд л гурав түрхсэн байхад ахиж гарахгүй дээ” хэмээн хөх арвайгаар үлд яр эмчилдэг тухай ярьж буй нь хэдийгээр “эмчлэх эрх” байхгүй боловч ургамал, түүнийг найруулан анагаах энэхүү уламжлалыг орхигдуулж болохгүйг харуулж байна. (Зураг 4-ийг харна уу)



Зураг:4 Ургамал, Чулуу ашиглан домнох арга

Ардын анагаах ухааны уламжлал бүрийг "шинжлэх ухааны аргаар" нотолж, "үнэн зөвийг" нь тогтоох аргагүй байж болно. Гэвч бодит амьдрал дээр хүн бүр эсвэл хүний амьдрал тэр чигтээ юм уу ихэнх хэсэг нь "шинжлэх ухаанаар нотлогдсон" зүйл дээр тулгуурлаж, хөтлөгдөж явдаггүйг энэ салбарын жишээ баримтаар ойлгож болмоор байгаа юм. Өмнө хэлсэн шиг алив нэгэн эрхтэн дархтан "эмчлэх эрх, хүний амь насны асуудал" зэргээр далайлгаж, олон бодлого, журам ярилаа ч энэ мэт уламжлалт арга туршлага байсаар л зохих хэмжээнд үр нөлөөгөө өгсөөр л байх нь судалгааны явцад улам тодорч байна.

Харин өвсөн эмээр анагаах уламжлалыг орчин үеийн анагаах ухааны түвшинд шинжлэн туршиж, ургамал тус бүрийн анагаах чадлын тухай монгол эрдэмтэн судлаачдын хийсэн судалгаанууд улам өргөжиж буй нь эмийн ургамлаар анагаах, тэр дундаа өдөр тутам, гар доор хэрэглэх боломжтой өвс ургамлаар анагаах эрдэм ухааныг дэлхий нийтэд танилцуулах, гүнзгий судлах, монголчуудын тээн хадгалж ирсэн биет бус соёлын өв хэмээн хүлээн зөвшөөрүүлэхэд нэн тустай юм. Мөн хавсралт 5-д дурдсан 2010-аад оноос эхлэн идэвхтэй хийгдэж буй тухайлсан нэг ургамлын анагаах чадлын тухай судалгаанууд ч онцгой ач холбогдолтой юм.

#### Амьтны эд эрхтнээр анагаах

Монгол уламжлалт анагаах ухаанд амьтны эд, эрхтнийг эм танд ашиглан анагаах арга түгээмэл байдагт гөрөөлөхүй, шувуучлахуй, загасчлахуйгаас, мөн таван хошуу малаас бэлтгэн авдаг байна. Монголчуудын гөрөөлөхүйгээс бэлтгэн авч, эм тан боловсруулдаг түүхий эдэд бугын эвэр, бөхөнгийн эвэр, хүдрийн заар, бугын чив, баавгайн цөс зэрэг нийтлэг ордог бөгөөд эдгээрийг эцсийн бүтээгдэхүүн болгож түүхийгээр экспортлохыг хоригложээ. Мөн амьтнаар анагаах арга ухаан нь мал, амьтны түүхий эд эрхтнийг иддэг,

цусыг нь уудаг гэдгээрээ орчин цагт ихээхэн шүүмжлэлд өртдөг арга барилтай ч холбогдоод зарим нэг талаар элдэв янзаар ойлгогдох болоод байгаа уламжлал юм. Энэ мэтээр түүхий эд эрхтэн, цус зэргийг хэрэглэх нь уламжлалт анагаах ухаанд ямар зэрэг байр суурьтай байсныг улам тодруулах хэрэгцээ бидэнд бий нь дамжиггүй. Түүнчлэн уламжлалт анагаах ухааны арга барил, арга чарга бүрэн эмчилгээний эерэг үр нөлөөтэй юу гэдгийг ч давхар бодож тунгаах зайлшгүй шаардлага байгаа юм. Нэгэнтээ хүний итгэл үнэмшил гэдэг бодит байдалтай заавал таарч, таацаж байх албагүй тул бид судалгааны явцдаа хэт нэг талыг баримтлан ардын анагаах ухааны уламжлал бүр үнэ цэнтэй, үнэн гэж үзээх эсвэл эсрэгээрээ шинжлэх ухааны үндэсгүй гэж үгүйсгэх хэт туйлширсан хандлагаас татгалзсан юм.

Эдүгээ монголчуудын өдөр тутмын амьдрал ахуйдаа хамгийн өргөн хэрэглэдэг амьтны эд эрхтнүүд нь хойлгын мах, цагаан шувуу буюу ахууна шувууны мах, тарваганы яс байна гэж судалгаагаар тогтоогдов. Учир нь араатан амьтан, шувуудыг агнах нь хуулиар хориотой учраас хүмүүс том ан амьтан болох буга, хандгай, зэрлэг гахай зэргийг бараг агнадаггүй, шувуу болон тарвагыг л нууцаар агнаж хэрэглэх багахан боломжтой болжээ. Энэ нь нэг талаар ан амьтан, байгаль хамгаалж буй сайн талтай ч нөгөө талаар тэр амьтан шувуутай холбоотой анагаах ухааны мэдлэг, туршлага тодорхой хэмжээнд хумигдах нөхцөл болж байна.

Шувууны мах үнэ өртөг ихтэй бөгөөд нэг хойлгын мах худалдан авахад 250 мянган төгрөг байдаг байна. Бидний уулзсан өвлөн уламжлагчдаас тан эмийн өвлөн уламжлагч Ж.Цагаанмуна (Завхан, Улиастай) гэхэд зөвхөн сарлагийн цөс, тарваганы цөс хоёрыг дангаар нь эмчилгээнд хэрэглэдэг байна. Өвлөн уламжлагч Нарантуяа (Завхан, Идэр) бол ямааны халуун цусыг цус багадалттай, бүлэгнэсэн хүмүүст уулгадаг хэмээв. Таван хошуу малын бааснаас өөр бусад бүхий л зүйлийг боловсруулан хэрэглэдэг монголчуудын хувьд малын эд эрхтнээр анагаах гэдэг нь хамгийн эгэл жирийн үзэгдэл болно. Үүний нэг жишээ нь, үхрийн гиван юм. Үхрийн цөсний чулуу болох энэхүү түүхий эдээр Жуган-3, Жуган-11, Гиван-9 зэрэг халууныг намдаах чадал бүхий олон төрлийн тан бэлтгэдэг байна (АУДҮ 1991, 638-639).

Харин судалгааны явцад өнөө үед амьтны эд эрхтнээр анагааж байгаа, нийтэд дэлгэрсэн зарим арга ухааны тухай авч үзвэл, хамгийн түрүүн цагаан шувуу буюу ахууна шувууны мах орно. Ахуунын цусыг монголчууд ид шидтэй хэмээн ярьдгийн үндэс нь түүний анагаах чанарт оршино. Ахуунын цусны анагаах чадлын талаарх нэгэн домгийг доктор Б.Батмөнх “Монголчуудын уламжлалт ан ав (XIX-XX зууны зааг дахь Ойрад монголчуудын жишээн дээр)” номдоо сийрүүлжээ. Тэнд, “Эрт урьд цагт нэгэн анчин өвгөн ганц хүүтэйгээ амьдран суудаг байжээ. Гэтэл тэр өвгөнд өш хонзонтой нэгэн лам байж гэнэ. Нэгэн өдөр тэр лам өвгөнийг эзгүй араар хүүг нь дагуулан анд яваад нэгэн буга алжээ. Тэр лам, хүүг яаж хорлох вэ гэж бодож байгаад бугын чөмгийг тастаж махыг нь аваад, чөмгөө галд шарж, хувхайрсных нь дараа цохиж, голыг нь идүүлжээ. Тэгээд араас нь хүү минь, цангана шүү, ус уу гэсээр хүйтэн ус уулгасан байна. Үүнээс хойш хүүгийн гэдсэн дотор ямар нэгэн юм өвдөөд байна гэж явсаар хоёр гурван жилийн дараа нас барж



гэнэ. Гэтэл тэр үед өнөөх лам ч бас нас баржээ. Нэгэн өдөр өвгөн хүүгийнхээ шарилын хажуугаар явж байгаад тарсан ясных нь дундаас сөөм хэртэй цагаан шар өнгийн хатуу зүйл байсныг авч, гэртээ хариад хутганы иш хийжээ. Өвгөн сайн анчин байсан тул мөнөөх хутгаараа ангаа төхөөрдөг болов. Тэгээд нэгэн удаа ахууна алж, уг хутгаараа цээжийг нь ярахад хутганых нь иш хайлаад уначхаж гэнэ. Үүнийг үзсэн өвгөн хэсэг зуур бодож сууснаа, тэр үед л муу хүүдээ ахуунын цус уулгадаг байж дээ гэж амаа барьсан гэдэг. Тэгээд өвгөн нутгийн ард түмэндээ ахуунын цус бол эм гэдгийг хэлж мэдүүлсэн ажээ” (Батмөнх 2005, 57) хэмээсэн нь сонирхолтой байна.

Ахуунын махыг бодит амьдралдаа туршин хэрэглэж, ходоодны шархаа бүрэн эмчилсэн хүнтэй бид тааралдахад дараах зүйлийг ярих. “2011 онд миний ходоод муудаад, дөрөв, таван сарын үед байсан юм. Ховд аймгийн баруун бүсийн эмнэлэгт шинжилгээ өгсөн. Ходоод чинь шархлалтай, улайлттай байна гээд. Эмчилгээ тариа хийлгэ гээд. Тэр хугацаанд идээгүй юм байхгүй. Хамгийн сүүлд би 9 цагаан шувуу идсэн. Тэгээд жилийн дараа Ховд аймагт очиж дурандуулсан. Тэгэхэд миний ходоод яг эхээс гарсан шиг болсон байсан. Тэгэхэд тэр эмч намайг гайхаж байсан, яахдаа ингэв гээд. Урьд нь бол цээж хорсоод, хар цай уухаар зовоод, хоол идэхээр зураад байдаг байсан. Хавдар арай болоогүй, эхлэл нь тавигдсан байсан. 9 цагаан шувуугаа идэхдээ, нэг цагаан шувууг гурав хоног иддэг юм. Сайн ходоод гэж байдаг, муу ходоод гэж байдаг юм. Сайн ходоодыг нь аваад ялгах хэрэгтэй. Би тэр 9 шувууны ходоодыг бүгдийг тусгай авсан юм. Хатаасан. Махыг нь бол сайхан хөшиглөөд, нэг литрийн варианы шилэнд буцалсан ус хийгээд, махаа хийгээд орхино. Тэгэхээр хүрэн улаан өнгөтэй болдог байсан. Тэрийг би жижиг аягаар авч уудаг байсан. Өглөө өлөн элгэн дээрээ, өдөр, унтахын өмнө гээд 3 удаа ууна. Тэрний дараа нөгөө сайн ходоодоо усанд үйрүүлээд хийнэ. Өөрөө уусаад байхгүй болчихдог. Тэрийг нь уудаг байсан. Нэг шувуунаас нэг хагас аяга л мах гарна. Тэрийг нь буцалсан усан дээр хийгээд л таглаад тавина. Нэг газар амттай, (шороо шиг) тэрийг нь л цээрлэлгүй, өвчнөөсөө салья гэвэл иднэ. Хөшиглөсөн мах нь халуун усандаа борлоод ирэхээр нь махтай нь л иднэ”<sup>7</sup> гэж байв. Тус шувууны мах, ходоодны анагаах чадлын тухай эрдэм шинжилгээний судалгаа хараахан олоогүй ч энэ мэт өөрийн хувийн туршлагыг хуваалцах хүмүүс байгаа нь нэгэн төрлийн бодитой баримт юм.

Мөн тэрээр өөрт тулгарсан өөр нэг өвчин болох хугарсан хөлөө тарваганы ясаар эмчилсэн тухай ярихдаа: “Би хөлөө хугалаад. Тэгээд тарваганы дөрвөн хөл байна шүү дээ, мөч. Тэрийг зарим нь чанаж иднэ. Би бол шатааж идсэн. Шатааж идэхээр тэр 4 хөлийн яс нь хүний кальцийг нөхдөг юм байна. Би бол хэсэг тарваганы хөл түлж идсэн. Хөх аргал байдаг даа, түүн дээр тавиад шатаагаад тэгээд сайхан нүдээд нунтаглаад, цэвэр сокны шилд хийгээд. Тэгээд амны халбагаар идээд, араас нь цэвэр усаар даруулаад уудаг байсан. Өдөрт хоёр, гурав ууж болно. Хүний сонирхлоор л болно. Хугарсан хөлөө би хадуулсан юм. Хадуулчхаад хадаасаа авалгүй гурван жил яваад авхуулсан. Тэгсэн чинь тэр эмч бол хэлж байсан. Чиний энэ хөл бол яг кальци гэдэг юм хамгийн сайн, гоё болсон байна. Бэхжилт

---

<sup>7</sup> С. Дүгэржав Увс аймгийн Ховд сум

*сайн болсон байна гээд. Надтай хамт хадаасаа авхуулсан нөхдүүд өвдгөөр өвдөөд байна аа гээд. Надад бол одоо ч гэмгүй, өвдөнө гэж байхгүй, хугараагүй юм шиг явна. Одоо би улсуудад хэлдэг юм. Чадвал нэг тарваганы 4 мөч шатаагаад ид ээ гээд”* хэмээсэн нь тарваганы ясны анагаах чадлын тухай тодорхой түвшинд илэрхийлж байна. (Зураг 5-ийг харна уу)

Судалгаагаар явж байхад монголчууд, “зэрлэг гахайн элэг элгэнд сайн”, “туулайн мах ханиаданд сайн, битүү шөл хийж ууна”, “цагаан шувууны мах сахрын өвчинд сайн”, “янгирын элэг нь хүний элэг, цөсөнд сайн”, “яргуй идсэн гөрөөсний цусыг уухад сайн”, “тарваганы элгийг өвчин намдаагч эмийн оронд хэрэглэнэ” гэх мэт олон жишээг хэлж байсан ч хэрхэн хэрэглэх жор, үр дүнг нарийвчлан хэлж чадахгүй байлаа. Магадгүй энэ бүхэн нь ардын анагаах ухаантай гэхээсээ илүү хувь хүний туршлага, сонссон дуулсанд тулгуурласан зүйл ч байж болно. Өөрөөр хэлбэл судалгааны явцад тулгарсан нэгэн асуудал нь энэ хүний хэлж ярьж буй анагаах ухааны уламжлал дээр суурилсан уу эсвэл саяхан, хаа нэгтэйгээс уншсан, сонссон дээр нь тулгуурласан уу гэдгийг байнга хянаж, бодож байх шаардлага гарч байлаа. Мэдээлэл дамжуулах хурд, эх сурвалж нэмэгдсэнтэй холбоотой хүний авч буй мэдээллийн хүрээ өргөсөж, олон зүйлийн талаар "мэдлэгтэй" болсон нь анагаах ухааны тухай судалгаа хийж явах үед ч анзаарагдаж, "тэрийг тийм өвчинд сайн гэдэг" гэх мэтээр илэрч байв. Судлаач хүн тэр олон мэдээллээс "судалгааны үнэ цэнтэй" гэсэн хэсгийн шүүн авах, баримтжуулах чадвартай байх ёстой нь бидний судалгаанд ч мөн илэрч байлаа.

Харин хойлгын мах идсэн олон хүнтэй таарсан бөгөөд тухайлбал, “*Би нэг хагалгаанд орохдоо хойлгийн мах гээд хүнээс нэг жаахан юм аваад идсэн, тэрийг идсэн чинь ердөө цус гардаггүй л юм байна лээ. Хагалгаанд орохоос нэг хоногийн өмнө л уусан, шархаа боолгоход цус гардаггүй юм байна лээ, хурдан аньсан*”<sup>8</sup> хэмээн хагалгаанаас нэг өдрийн өмнө идсэн тухайгаа ярьж байхад, өөр нэг тохиолдолд нэг жилийн өмнөөс идэж бие бэлдэх ёстой гэж ярьж байлаа. “*Хойлог гээд шувууны махыг хагалгаанд орохын өмнө хоёр гурван урьд л идэх ёстой юм байна. Чадвал зургаан сар, жилийн өмнөөс идэх ёстой гэж хэлдэг. Шууд тулгамдаад идчихвэл сайн нөлөө гарч чадахгүй. Тэгэхээр тэгж идэж болохгүй. Жилд нэг удаа ер идчихэд хэрэгтэй. Хагалгааны шархыг л хурдан бүтээдэг юм байхгүй юу*”<sup>9</sup> гэхчлэн хүн, хүний ярианд багахан ялгаа гарч байлаа. Магадгүй хойлог шувууны мах шарх зэрэгт сайн гэдэг нь монгол нутаг даяар хамгийн өргөн тарсан уламжлал, арга барил болов уу.

Бидний хээрийн судалгаа хийсэн газруудад амьтны эрхтнээр анагаах ухаанаар дагнасан өвлөн уламжлагч гэж байсангүй, харин эмийн ургамлаар анагаах аргын өвлөн уламжлагч, эсхүл тан эм хийдэг өвлөн уламжлагч нарын хавсран анагаадаг арга ухаан болох нь харагдаж байв. Үүнийг нэг зүйлээр батлан харж болох нь тан эмийн өвлөн уламжлагч, Завхан аймгийн иргэн Б.Цэндсүрэн өөрийн ааваас уламжилсан тан эмийн

---

<sup>8</sup> Говь-Алтай, Есөнбулаг, О. Туул

<sup>9</sup> [С. Дүгэржав]

найрлага дотор “шүдлэн хонины баруун хонгоны мах” хэмээн бичээд орхисны “учрыг олж, хужрыг тунгааж” чадахгүй явж байгаагаа хэлж байсан нь амьтны эрхтнээр анагаах уламжлал өнөөдрийн байдлаар уламжлалт анагаах ухааны дотор биеэ даасан арга ухаан болж уламжлагдаж чадаагүйг илтгэж байна. Заавал анагаах чадал гэлтгүй хонины махны бие тамир сэргээх чадлын тухайн ойлголт манай улсын аль ч нутагт өргөн тарсан байдаг нь өмнө дурдсан таван хошуу малтай он удаан жил харилцаж, тэдгээрийн эд эрхтний анагаах чадварын таньж мэдсэн ардын ухааны уламжлал үр нөлөөг харуулж буй хэрэг юм.



*Зураг: 5 Тарваганы ясыг шатаан нутаглаж бэлтгэсэн байдал*

### Бариа заслын аргаар анагаах

Монгол бариа засал нь өвөг монголчуудаас уламжлагдан ирсэн хамгийн эртний анагаах аргуудын нэг байх бүрэн боломжтой. Нүүдэлчдийн амьдралын онцлог хэв маяг, өдөр тутмын биеийн хүчний ажил эрхлэх явц дунд тохиолдох гэмтэл, дайн тулааны үед мориноос унаж бэртэх нь бариа заслыг үүдэн бүтээж хэрэглэх, цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх эх суурь болсон байна (Болд 2006, 135). Бариа засал нь дотроо олон янз. Тухайлбал, илэн бариа, даран бариа, эвлүүлэн бариа гэх мэт ялгаатай байдаг (Болд 2006, 134). Бидний хээрийн судалгааны үр дүнд дээрх 3 арга одоо ч байдаг бөгөөд уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагч нарын дийлэнх хувийг эзэлж буй бариачид дээрх 3 аргыг бүгд хэрэглэж байна. Бариа засал нь монголын уламжлалт анагаах ухааны эмчилгээний аргууд эмнэлгийн тусламжийн үндсэн арга байсан ба одоо ч хадгалан үлдсэн байна. Учир

нь нүүдлийн соёлт монголчуудын ахуй байдал одоо ч хадгалагдаж үлдсэн тул яс бэртэх, бэртлийн өвчлөл өндөр байсаар байна.

Бидний судалгаагаар ажиглагдсанаар бариа засал нь тархи толгой доргих, бөөр доргих, нурууны суулт, ясны бэртэл, үе мөчний зовуурь, эмэгтэйчүүд сав, жирэмсэн эмэгтэйн хүүхдийн байрлал өөрчлөгдөх зэргийг барьж, илаарьшуулахад өвлөн уламжлагч нар ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ талаар хийсэн сүүлийн үеийн судалгаа бол орчин үеийн эмчилгээний аль ч хэлбэр тус болохгүй, өвчин зовуурьтай хүмүүсийг монгол барианы аргаар барьж мэдрэн оношилж, барьж эдгээх зорилготой судалгаа байсан юм (Алтангэрэл 2017, 21). Мөн энэхүү судалгаанд монгол бариа нь уламжлалт анагаах ухааны бие даасан салбар, эмгүй эмчилгээний төгс хэлбэр болохыг нотлон нийт 760 хүнд үзлэг бариа хийж, итгэмээргүй үр дүнд хүрсэн байна.

Соёлын Өвийн Үндэсний Төвийн соёлын өвийн өвлөн уламжлагч нарын анхан шатны бүртгэл мэдээллийг дунд 53 нь бариа заслаар өвлөн уламжлагчид байсан юм. Үүнээс ажиглахад, бариа засал нь нийт нутгаар хамгийн их тархсан анагаах ухааны арга ухаан бөгөөд бүртгэлгүй маш олон бариач, бариа хийдэг хүмүүс байна. Бариа заслын хувьд бусад арга ухааны хувьд хувь хүний хичээл зүтгэлээс гадна тухайн хүний мэдрэмжийг ихээхэн чухалчилдаг бөгөөд шавь орохоор ирсэн хүмүүсийг шалгадаг байсан байна. Үүнд, *гүзээтэй усанд малын хугарсан яс хийж эвлүүлүүлдэг*<sup>10</sup> гарын үеийг шинжиж, алгыг нь мэдэрдэг, *шуудайтай шороон дотор хугарч үйрсэн яс бариулдаг*<sup>11</sup>, *За хэн нэгэн хүн над дээр ирээд “танд шавь оръё, таны өгөгдлөөс суръя” гэвэл эхлээд би тэр хүнийг судална. Тэр хүнийг судлахын тулд би 3, 4 давхар даавуунд байгаа модыг эхлээд эвлүүлүүлнэ. Энэ модыг ямар хэмжээтэй аль тийшээ хугарсан мод вэ гээд мэдэрч байвал би өгөгдлөөсөө зааж өгнө* (Б.Болбаатар)<sup>12</sup> гэх мэт аргаар мэдрэмжийг нь шалган, сайжруулдаг байжээ. Судалгаанд хамрагдсан бариа заслын өвлөн уламжлагчдыг дүгнэн үзвэл,

- Бага залуу байхаасаа гарын мэдрэмжийг мэдрэх, гар халуу оргих, хүн баримаар санагдах, далдын зүүд, зөн совин мэдрэгдэх, мал, амьтан барих зэргээр мэдэгдэж, идэр насандаа хүний бэртэл, бие барьж эхэлсэн байна.
- Нэг үе дуусаж байж гарын мэдрэмж увдис нь дараагийн өвлөн уламжлагчдад дамждаг ба өөрт тухайн өвийг зааж сургасан, аль эсвэл аав ээж нь бариа хийж чадаж байгаа үед бариа засал хийдэггүй байна.
- Бариа заслын увдис, гарын мэдрэмж нь нэг үе алгасан ач зээд өвлөгддөг<sup>13</sup>. Өөрийн үр хүүхдүүдэд биш, тэдний хүүхдүүдэд өвлөгдөх магадлал их гэж үздэг.
- Хүн барих тусам гарын мэдрэмж сайжирч, бариа заслын хамгийн оргил үе нь 35-45 насны үе байна гэж дүгнэн үзэж болохоор байгаа юм.
- Бариа заслын арга ухааны салшгүй нэг зүйл бол судас барих арга ухаан юм.

<sup>10</sup> Өвөрхангай аймгийн Тарагт сум. А. Шоовдор, 69 настай

<sup>11</sup> Баянхонгор аймгийн Хүрээмарал сум. Б. Болдбаатар, 50 настай

<sup>12</sup> Баянхонгор аймгийн Хүрээмарал сум. Б. Болдбаатар, 50 настай

<sup>13</sup> Увс аймгийн Улаангом сум. Цэвээн. 70 настай

- Бариа заслын арга ухааныг цааш өвлүүлэн уламжлуулах хандлага бага байна. Энэ нь тухайн хүн үнэхээр мэдрэмжтэй бол өөрөө барьж сурна гэдэг итгэлтэй байдаг. Мөн дээрээс нь орчин үеийн анагаах ухаан хөгжсөн тул цаашид уламжлуулах шаардлагагүй гэж үздэг тал байна.

Монголын нүүдлийн ахуй байдлаас хамааран бариа заслын хувьд нийгэм дэх эрэлт ихээхэн байдаг нь доорх судалгаанаас ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь голчлон бариа засалч бэлтгэдэг сургалтын төвүүдтэй холбоотой юм. Эдгээр газруудаас жишээ болгон дурдвал, “Увдист мутар” бариа заслын сургалтын төв нь 45 хоногийн хугацаанд бариач бэлтгэж байна. Уг байгууллага нь 2011 онд анх байгуулагдаж, өдгөө 3600 гаруй хүмүүсийг амжилттай суралцуулан төгсгөсөн байна. Бариа заслын сургалтын төвийн сургалтад: Үзлэг, Онош, Зураг унших (рентген, MRI), Бүтэн биеийн бариа, Үе мөчдийн бариа, Гэмтлийн дараах нөхөн сэргээх бариа, Жирэмсний болон эмэгтэйчүүдийн бариа, Хүүхдийн бариа, Онол лекц, Тараах материал зэргийг заан сургадаг байна. Мөн төгсөгчид нь бие даан бариа заслын төв нээх эрх, олон улсад хэрэглэх диплом, Монголын Мэргэшсэн Бариа Заслын Холбооны гишүүн болох Улсын бүртгэлтэй гэрчилгээг монгол, англи хэл дээр авдаг байна<sup>14</sup>. Мөн одоо цагт рентген зураг авхуулан бэртэл гэмтлийг илүү нарийвчлалтай мэдэх боломжтой болсон давуу талтай уялдаж, хавсарсан бариа засал байгаа нь уг арга барилын эерэг үр дүнг улам нэмэгдүүлж, ард олны дунд өргөн хэрэглэгдэх, үр нөлөө ихтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн явдал байна. Заавал хүнд, яс хугарах, булчин тасрах гэлтгүй өдөр тутмын амьдралд толгой өвдөх зэрэг тэр бүр эм уух, эмчид очоод байхад түвэг чирэгдэлтэй зовуурийн үед бариа засал анхан шатнаас цаад шатны эмчилгээ, өвчин шаналгааг намдааж чаддаг давуу тал буюу хэрэглээ ихтэй уламжлал болсон байна. Ялангуяа Улаанбаатар хот зэрэг эмнэлгийн үйлчилгээ авахад төлбөр, хүлээлт зэрэг чирэгдэл ихтэй орчинд амьдарч буй хүний хувьд дээр дурдсан толгой өвдөх, тархи хөдлөх зэрэг эмгэгт анхан шатны тусламж болох арга бол бариа юм. Энэ төрлийн уламжлал тээгчид нь тодорхой хэмжээнд албан эмнэлгийн ачаалал, төсөв санхүү, цаг завьг хэмнэж буй давуу талтай ч юм.

### Дом заслаар анагаах

Монголчуудын хамгийн эртний анагаах урлаг бол дом засал болов уу. Өвөг дээдэс маань өнө эртнээс байгалийн хатуу ширүүн уур амьсгал, нүүдлийн амьдралын онцлог хэв шинж, дотоод, гадаад зөрчил, тэмцлийн улмаас үүдэлтэй бие махбодын эмгэг өөрчлөлт, гэмтэл бэртлийг эмчлэх талаар давтагдашгүй өвөрмөц заслын аргыг бүтээж, хөгжүүлсээр бидний үед хүрсэн байна (Болд 2006, 184). Мөн Аюурведийн анагаах ухаанд сэтгэлээс үүддэг 404 зүйл өвчин гэж байдгийг номлодог байна. Тэр нь юу вэ гэвэл биеийн хямрал, оёг, бэртэл гэмтлээс бус, сэтгэлээр буюу сэжиглээд айгаад, ширвээд олдог өвчин. Ийм өвчинд эм, хануур, төөнүүр, мэс засал хэрэггүй, итгэл бишрэлээр нь сүсэг сэтгэлээр нь эмчилж болдог гэсэн үг (Галбаабадраа 2009).

<sup>14</sup> Увдист мутар ММБЗ дэргэдэх сургалтын төв

Дом засал нь олон бөгөөд бөөгийн шашин ба дом, “Дөрвөн үндэс”-ийн урсгал ба дом засал гэх олон дом заслын төрөл байдаг. Хар дом болон хар домын судрын тухай судалгаа бол монгол судлалд одоо ч хөндөгдөж, бүрэн дүүрэн судлагдаагүй байгаа салбарын нэг юм. Дом засал урт хугацааны турш бөөгийн шашин, шарын шашин зэрэг нийгэм, бодгальд хүчтэй нөлөө үзүүлдэг үзэл санаа, сурталд нэг үе автаж яагаад судлагдсангүй вэ гэхээр Монгол улсад европ маягийн анагаах ухаан хөгжүүлж байхад хоцрогдсон, балар бүдүүлэг, хар домьг судлах гэлээ, шашин судлах гэлээ гэсэн эш үндэсгүй үзэл суртлаас болжээ (Галбаабадраа 2009). Энэ бүхэн нь Монгол улсад нэгэн үзэл онол хуваарьгүй ноёрхож, нам засгийн дэмжлэгийг авч бусад үзэл санаа, итгэл үнэмшилд таагүй хандаж байсан үеийн улбаа болов уу.

Дом заслын хувьд бүхий л өвчин зовлонд ашиглах эртний олон судар ном байдаг хэдий ч бидний ажигласнаар домьн аргыг хүүхэд айж хөлсөх үед ширэглэх, горьдоо (хөх бэрсүүтэх, хавдах), нүдэнд өвдөг гарах зэрэгт дом заслыг гэрийн нөхцөлд хүн бүр хийж байгаа юм. Бидний судалгааны үр дүнд дом шившлэгийг хүмүүс орчин үеийн анагаах ухааны эмчилж чадахгүй байгаа, аль эсвэл эмчилгээ, эм шаардлагагүй өвчинд ашиглаж байна. Энэ нь дорнын уламжлалт анагаах ухаанд домьн аргаар эдгэрдэг өвчин гэж тусдаа байдаг гэж үздэг учраас түүнийг орчин үеийн анагаах ухаанаас урьтаж эмчилдэг байна.

Бидний судалгааны үр дүнд тэмдэглэн авсан нэгэн сонирхолтой хар домьн аргаар эдгээж байгаа нэгэн чухал зан үйл болох “цахих” зан үйл юм. Увс аймгийн Улаангом дахь хээрийн судалгаагаар уг анагаах аргыг ажиглан тэмдэглэж авсан бөгөөд Тайж удмын цагаан ястай хүн үйлддэг гэх зан үйл нь ихэнх төрлийн усархаг яр шархыг цахиж эмчилдэг байна. Мөн орчин үеийн анагаах ухаанд “Могой яр” гэж нэрлэгддэг өвчнийг “цахиац” гэж нэрлэдэг бөгөөд уг өвчнийг гарсан байдлаас хамааран олон давтамжтайгаар цахих байдлаар эмчилж байна. Нэг сонирхолтой зүйл нь орчин үеийн анагаах ухаан уг өвчнийг бүрэн гүйцэт эдгээдэггүй бөгөөд өвчнийг намжаах, удаашруулах арга авдаг байна. Тайж удмын цагаан ястай гэх Увс аймгийн Тэс сумын баяд угсаатнуудын хувьд л энэ цахих зан үйлийг<sup>15</sup> үйлддэг. “...Цахих гэж ярьж байна. Хэт цахиур чулуу хоёроор арчдаг. Тэгэхдээ тэнгэртэй харьцдаг бөө гэж байдаг шүүдээ бид нар бас нэг тиймэрхүү бас өвөг дээдэс тэнгэрт байгаа өөрсдийн өвөг дээдсийн удам судар дөрөв таван үеэрээ ингэж дуудаж цахидаг тийм тангарагтай хүмүүс. Цас шиг цагаан ясанд толбо үлдээхгүй гэсэн тангарагтай тэр тангаргийн дагуу тэр хүний өвчнийг илаарьшуулж байдаг. Хүн амьтны эрүүл мэндэд тус болж ирдэг хүмүүс.” (Ш.Бадамсамбуу)

Дом засал нь хүний биед ямар ч хор хүргэхгүйгээр эмчилж болдог арга юм. Дом засал, шившлэгийн арга нь нийт ардын дунд энгийн хар бор эмчилгээний арга болон үлдсэн бөгөөд үүсэл, онол арга зүйн хувьд судлагдсан байдал маш бага байна. Мөн хүмүүст хор учруулдаггүй учраас орчин үеийн анагаах ухаан, эмчилгээнээс урьдаар өөрсдийн хэмжээнд гэртээ хийж гүйцэтгэдэг байна.

---

<sup>15</sup> Цахих зан үйл нь ямар нэгэн усархаг яр шархыг цахиур, чулуу хоёрын хавсран оч үсэргэх зан үйл

*Дээр үед оточ гэдэг байлаа шүү дээ миний ээжийн нагац ах болох оточ Дойд гэдэг хүн байсан бас бариа хийдэг. Хүүхэд эх барьж авдаг, ээжүүд тэр үеэр гэртээ төрдөг байсан тэгэхдээ тэр хүнийг дуудаж төрдөг байсан гэсэн . Тэр хүн хугарал бэртэл юу л байна бүгдийг нь бас барьдаг байсан. Намайг хэлд орсноос хойно өнгөрч байсан би санаж байна. Тэр уламжлалаараа би өөрөө эх баригчаар төгссөн хүн аав маань ярьдаг байсан юм тэр хүн их мундаг бариач байсан төрсөн эхийн эхэс гарахгүй үед нагац ахыг дуудаж гаргуулдаг байлаа гэж. Тэр хүн эхэсийг нь домнож гаргадаг домнохдоо өрхний оосор оруулж ирээд аманд нь хийн огиулдаг гэж. Огихоор тэр булчин агишиж сунаж, сав жаахан ширгэдэг байсан байх гэж би бодож байна. Намайг эмч болсны дараа аав маань тийм дом байдаг янз бүрийн хүн таарвал хэрэг болно шүү гэж хэлж байсан. Би 1982 онд төгсөж, эмнэлэгт ажилд орсон. Нэг удаа гэрээг төрж байгаа айлд очиход амаржсан эхийн эхэс гарахгүй гэрийнхэн нь одоо яана гээд л тэр үед би гэрийнхэнд нь хэлж байсан ийм нэг дом байдаг гэж хэлсэн ,тэгсэн гэрийнх нь өрхний оосрыг тотгоор оруулж ирээд, аманд нь хийлгээд тэр хүн ёстой л огьдог юм байна лээ тэгээд эхэс нь гарч байсан тэр үед домыг оргүй ч биш юм байна даа гээд бодож байсан (Цоозол)*

Энэ бүхнээс үзвэл монголчуудын дээрхийн мэт зан үйлийн бусад улсын эмчилгээний үед хэлдэг хэллэг, шившлэг, үг зэрэгтэй харьцуулан судлах боломж байгаа нь харагдана. Барууны болоод бусад олон улсын ардын эмчилгээнд зарим нэгэн өвчин эмгэгийг эмчлэх, аргалахдаа дан ганц эм тангаас гадна шившлэг давхар хэлэх, эсвэл үг хэлийн хүчийг ашиглах явдал түгээмэл байдаг нь энэ төрлийн уламжлал дэлхий дахинаа өргөн тархсаныг харуулж буй юм.

Тан эмээр анагаах арга ухаан

“Жүд ши” буюу “Дөрвөн үндэс” номын “Шинжлэн заслын үндэс”-т амирлуулах тан, арилгах тан гэж байдаг талаар дурдсан байна (Тунбаа 1990). Эмийн найрлагыг чадлаар нь найруулахдаа **амирлуулах, арилгах** гэсэн хоёр зүйлээр салган үздэг. Амирлуулах эмийн найрлагад тан, талх, үрэл, зуурмал, тосон эм, ханд эм орно. Арилгагч эмийн найрлагад зөөлөн шимт туулга, бөөлжүүлэх, хамрын туулга зэргийг багтаан үздэг байна. Уламжлалт эмнэлэгт тусгай жор зааврын дагуу эмт бодисуудаар хийсэн тан, талх, үрэл эмийг өргөнөөр хэрэглэх боловч тосон, үнсэн, ханд, зуурмал эм гэх зэрэг олон төрөл зүйлийг ашиглаж байжээ. Эдгээр эмүүд нь тус тусдаа найруулах онцлог арга ажиллагаатай, эмчилгээний ёс зарчимд тохируулсан тусгай зориулалттай ажээ. Тан эмийг **дэвтээсэн, ширгээсэн** гэсэн хоёр янзаар хийдэг байна. Тан эмийн онцлог нь өвчнийг боловсруулах, цусыг ялгах, сарнисныг хураах, хор тайлах, хөлөргөх үйлчилгээ нь түргэн байдаг (Баавгай 1989) гэжээ.

Өнөөдрийн байдлаар Монгол улсад тан эмээр эмчилгээ хийж, өвчтөнийг илаарьшуулж буй хэд хэдэн том эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс дурдвал, Оточ Одь, Цагаан тан, Монг-Эм, Манба дацан эмнэлэг, Энэрэлт манал зэрэг эмнэлгүүдээр

хамгийн олон өвчтөн үйлчлүүлдэг байна. Энд дээрх амирлуулах болон арилгах тангийн зүйлүүдийг лаборатори, эмийн үйлдвэрүүдэд бэлтгэн эмнэлэгтээ авч, уламжлалт аргаар судас барьж оношилсон оношоо орчин үеийн аппарат, тоног төхөөрөмжийн хариугаар баталгаажуулсны үр дүнд өвчтөн тан эм залдаг байна. Өөрөөр хэлбэл энэхүү төрлийн уламжлалт анагаах арга барил нь сүүлийн үеийн техник, технологийн давуу талыг ашиглах, түүнтэй хорших замаар үйлчилгээний үр дүн, эмнэх домнох чадвараа улам чадавхжуулах болсон байна гэсэн үг. Тиймээс зарим нэгэн ардын уламжлал анагаах ухааны арга барилыг дээрхийн мэт техник, технологитой хавсарсан үгүйгээр нь ангилан ялгаж судалж болохоор байгаа юм.

Гэтэл бидний судалгааны гол судлагдахуун болсон хөдөө орон нутаг дахь 3, 4, 5 дахь үеийн өвлөн уламжлагч нарын хувьд тан эм барих байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын өвлөн уламжлагч нарынх нь ирээдүй хэрхэх талаар олон зүйл судалгааны явцад ажиглагдлаа. Завхан аймгийн Яруу сумын 5 дахь үеийн өвлөн уламжлагч Д.Сувдаа ярихдаа: *“Манай өвөг эцэг Галуутын хүрээнд маарамба байсан юм. Одоо дөрөв дэх үе дээрээ явж байна. Манай аав одоо нас өндөр гарсан гээд надад уламжилж байгаа. Аав өөрөө судас барьдаг, тэгээд миний хүү одоо энэ хүнд тийм эм өг, ийм эм өг гээд, энэ хүний зүрх тийм байна гээд ярьдаг надад. Би одоо 3 дахь жилдээ явж байна. Манай ээж, аав бол чамайг нэг явуулаад судас бариулаад сургачих юм сан гээд ярьдаг байхгүй юу. Тэгэхээр нь би за яах вэ, танаас л өвлөхөөр болно шүү дээ гэдэг”* хэмээн ярьж байгаагаас үзвэл зарим өвлөн уламжлагч нь сургуулиар биш зөвхөн гэрээр суралцах, гэрийн хүрээнд өвлөн уламжлах сонирхолтой байгаа нь харагдана. Энэ мэт өвлөн уламжлагчид, анагаагч нарт тухайн удмын, гэрийн өвөрмөц уламжлал хадгалагдан үлдсэн байх магадлалтай тул шинжлэх ухааны тун үнэ цэнтэй мэдээлэл, мэдлэгийг нээн илрүүлэх боломж дүүрэн юм.

Зарим өвлөн уламжлагчийн хувьд дээд үеийн өвлөн уламжлагчаасаа дутуу суралцсан, залуу байхдаа өвлөө, юм сурья гэж боддоггүй байсандаа харамсдагаа илэрхийлж байсан нь дараагийн үед уламжлуулах боломж бий эсэхдээ эргэлзэж байгаа шинжтэй байсан юм. Тухайлбал, Завхан аймгийн Улиастай сумын өвлөн уламжлагч Б.Цэндсүрэн *“Аав өөд болоод 20 жил болж байгаа юм байна. Ганц цэцэг ч болов заалгаад авдаг байж гэж бодсон юм байна. Тухайн үедээ би энүүгээр яадаг юм гэж бодсон ч юм уу. Манай ээж бас ааваас хойш 10 гаран жил байлаа, тэгээд миний хүү үүнийг янзалмаар байна гээд л. Тэрийг нь би хайнгуутаа олж өгчхөөд л гараад явдаг. Ээжийг өнгөрснөөс хойш бүр толгой дээр ирсэн. Ганц эм ч болтугай заалгаж авахгүй гээд. Жишээлэхэд, “шүдлэн хонины баруун хонгоны мах” гээд орж байгаа юм, тэрийг нь би мэдэхгүй байна. Тийм зүйл бичээд юм руу хийсэн байгаа байхгүй юу, аав. Гадаа байгаа жаахан замбараа муутай юмнууд нь, тэр дотроос би өөрийн мэддэг юмнуудаа авчхаад бусдыг нь хэрэглэхгүй байгаа юм”* гэхчлэн дээд үеийн өвлөн уламжлагчийн өв болох зарим жорыг бүрэн сайн мэдэхгүй байгаа ч, хүмүүсийн эрүүл мэндийн төлөө хичээж байгаагаа илэрхийлж байлаа. Энэхүү байдал нь зөвхөн тухайн хүний хайхрамжгүй, анзаардаггүй байдалтай гэхээсээ гадна тухайн цаг үеийн нийгмийн нэгэн хандлага болох ардын гэх зүйлийг "хоцрогдсон, бүдүүлэг, феодалын үеийн" гэх мэтээр ад шоо үзэж байсан бодлого,



суртахуунтай ч гэсэн их бага хэмжээгээр холбогдоно. Одоо ч гэсэн еврод зүгийн болон ардын эмнэлэг, эмчилгээний аргыг хооронд нь эсрэгцүүлэн аль нэгийнх нь зөв үнэн байх ёстой мэтээр сурталддаг явдал мэр сэр бий. Гэвч энэ байдал, хандлага нь хүн амын өвчин эмгэг тусгай аль нэг аргыг олж нээх, улам олонд түгэхэд саад тотгор болохоос гадна үнэ цэнтэй, ховор нандин арга, технологийн чанар, чадварыг буруу ойлгох, үгүйсгэх ч нөхцөлд хүргэж болох төвөгтэй үзэл санаа болно.

Хөдөө орон нутагт тан эм бэлтгэж, анагааж буй хүмүүст хэд хэдэн бэрхшээл тулгардгийн хамгийн эхнийх нь үрийн төрлийн эм Монголд байдаггүй, тэдгээрийг хамгийн ойроос гэхэд БНМАУ-ын Эрээн хотоос дамжуулан авах боломжтой байдаг байна. Үр эмийн тухай ярихад, уламжлалт эмийн найрлагад *арур, барур, жүрүр* хэмээх гурван төрлийн үр онцгой үүрэгтэй байдаг. “Арур нь давслагаас бусад 5 амттай тул бие махбодыг төлжүүлж, хий, шар, бадганаас болсон өвчин бүгдийг анагаана. Барур нь бадган, шар усыг арилгана. Жүрүр нь бадган, шар, цусны өвчнийг арилгана” (Ганбаяр 2010, 32) хэмээдэг. Өвлөн уламжлагчдын ярихаар бол “*Бид нар цэцэг навчаа өөрсдөө түүнэ, үрийн юмыг гаднаас авна. Эрээнээс авдаг, гаднаас болохоор их үнэтэй. Гэхдээ бид нар аргалаад л авдаг, тэр хүнд захъя гээд*”<sup>16</sup>, “Хот руу дүү нар руу үр эмээ хэлж захиж авдаг. Гадаадаас орж ирдэг. Ойрдоо бас их ховордуу байх шиг байна. Хил гааль нь хаалттай”<sup>17</sup> хэмээж байв.

Заавал үр эмийг хэрэглэх ямар шаардлага, шалтгаан байдаг вэ гэвэл, уламжлалт анагаах ухааны тан барих ёсонд нэг зүйлийн орц л дутуу бол тан боодоггүйд юм. “*Гаднаас авдаг юмнуудаа нийлүүлээд хийнэ. Нэг зүйл дутвал битгий хийгээрэй гэж өвөө маань аавд хэлдэг байсан. Манай аав надад одоо тэгж хэлдэг, нэг зүйл дутвал битгий хий гэж*”<sup>18</sup> хэмээн ярьж байв. Цаашлаад энэхүү үр эмийн гаднаас хараат байдлаас болж өвчнийг эмчилж чадахгүй байгаа тохиолдлоо ч хэлж байв. “*Ханахын тулд яадаг гэхээр цусыг нь ялгадаг тан өгөх хэрэгтэй. Сайн мууг ялгана. Тэгээд яг ялгарсан цусыг ханах хэрэгтэй. Ялгараагүй үед нь ханавал сайн цус гарна, хэрэг байхгүй. Тэгэхээр цус ялгадаг тан бэлдье гэхээр тангийн үр бол Энэтхэгээс авдаг эд. Тэгэхээр манай энд тийм зүйл ор тас байхгүй*”<sup>19</sup> гэсэн нь тан эм барих монгол уламжлал өнөө хэр өвлөн уламжлагдсаар байх боловчиг өвлөн уламжлагчаас шалтгаалахгүй томоохон хүчин зүйл болж байгааг харуулж байна.

Тан эм бэлтгэх явцад тулгардаг дараагийн нэг чухал үйл бол “номхотгох” юм. Энгийнээр хэлбэл, байгалийн зэрлэг өвс ургамалд буй хорон чанарыг гадагшлуулсны дараа эм боодог гэсэн үг юм. Зарим өвлөн уламжлагч “талхлах” ч гэж хэлж байлаа. Номхотгох нь биднийхээр хоёр үе шаттай бөгөөд эхнийх нь “номхотгох”, дараагийнх нь номхотгосны дараа “зөв хэрэглэх” явдал юм. Энэ тухай жишээлэн өвлөн уламжлагч Нарантуяагийн хэрхэн манчин өвс номхотгодог тухай танилцуулбал, “*Номхотгоход аюултай нэг ургамал байдаг. Тэр нь болохоор манчин гээд өвс байгаа. Тэрийг хүн ч бай,*

<sup>16</sup> Завхан аймгийн Яруу сумын өвлөн уламжлагч Д.Сувдаа

<sup>17</sup> Завхан аймгийн Улиастай сумын өвлөн уламжлагч Б.Цэндсүрэн

<sup>18</sup> Завхан аймгийн Яруу сумын өвлөн уламжлагч Д.Сувдаа

<sup>19</sup> Завхан аймгийн Идэр сумын өвлөн уламжлагч Нарантуяа

*мал ч бай амслаа л бол үхнэ. Тэрийг түүгээд хатаагаад тавина. Мааш бага хэмжээний архинд хийгээд дарна. Хоногоо гүйцээхлээр энэ байшинд бол болохгүй, гэрт тооно нь онгорхой, агаар орж байгаа газар эмчлүүлж байгаа хүнийхээ нүд амыг бооно. Өөрийн гарыг бооно. Тэгээд хөл гар нь өвчтэй хүний тэнд түрхэж бооно. Боолтоо аваад цэвэрлэж дахиад бооно. Тэр бол хамгийн аюултай, хүнд эмчилгээ” гэж байв.*

Мөн номхотгох тухай бас нэг өвлөн уламжлагч: *“Номуудаас үзэж хараад номхотгохыг нь номхотгоно. Одоо жишээлбэл, гожид гээд юм байдаг юм. Үстэй гадуураа. Гал дээр улайсан халсан зуухан дээр тавьж байгаад түлээд, түлэхээр бондойгоод гараад ирж байгаа юм. Тэгэхээр гадна талын үсийг нь авна. Тэрний үсийг нь хор гэдэг юм байна л даа. Тэрийг нь хусаж арилгаад, буцалгаад аав маань хүнд өгдөг байсан. Би тэрийг өөрөө хусдаг байсан байхгүй юу. Тийм учраас би тэрийг мэдэж байна, наадах чинь хор шүү л гэдэг байсан”<sup>20</sup>* гэхчлэн амьд уламжлал болон ном судраас зэрэг суралцдаг тухайгаа ярьсан юм. Номхотгох нь дотроо хэд хэдэн төрөл байж болох талаар: *“Ургамлыг номхотгох гэж **түлж номхотгох, хуурч номхотгох** гэж ном дээр байгаа. Тийм янз бүрийн аргаар номхотгоно, цагаан идээнд хийж номхотгох ч байх шиг. Янз бүрийн тэр хүчийг сайжруулж, цаашаа зөөллөж явах гэж аргууд байна. Хамгийн хэцүү нь жони л байна л даа. Их хүчтэй түлж, олон хоног шатаана. Тэр шатаах сав бат бөх байх гээд. Ой модны хормойд өнөөдхөө түлээд, сайн саван дотор хийгээд, гадуур нь шавраар бүрээд ч юм уу. Болсон болоогүйг нь өөрөө шинжлэх тийм юм байдаг юм. Тэгээд сүүлд нь өнөөдөх чинь бүр зөөлрөөд болсон гэж үзвэл эм тандаа хэрэглэнэ. Бараг тэр хатуу зүйл имрэхэд л бяцрахаар болгож хэрэглэ гэсэн ч заалт байна”<sup>21</sup>* гэж ярьж байв.

Тан эмээр анагаах монгол уламжлал нь өвлөн уламжлагчдынхаа хувьд тасраагүй, энэ талын эрдэм ухааныг дэлгэрүүлэн суралцах хүсэлтэй олон хүмүүс хөдөө орон нутагт байх боловч сүүлийн үед байгаль, цаг уурын өөрчлөлтөөс болж эмийн ургамлын ургалт муудсан, чухал орц болох “үр эм”-ийн төрлүүдийг гадаадаас авдаг гэх бэрхшээлүүд тулгарч байгаа бөгөөд эдгээр асуудлыг цаашид хэрхэх нь тодорхойгүй байна. Улаанбаатар хотод эмчилгээ явуулж буй уламжлалт анагаах ухааны эмнэлгүүдэд бол эдгээрийг гадаадаас бүрэн шийдвэрлэж байгаа учраас “тан эм барих монгол уламжлал” гэж бүрэн дүүрэн үзэхэд учир дутагдалтай юм.

Ханах заслаар анагаах арга ухаан

Орчин үеийн анагаах ухаанд ханах аргыг өргөн ашигласаар байгаа бөгөөд Улсын клиникийн төв эмнэлгийн эмийн бус эмчилгээний тасагт (реабилитаци) хануур эмчилгээг олон жил хийснээс сүүлийн 8 жилийн эмчилгээний үр дүнг судалж үзэхэд дараах байдалтай байна. Сээр, ууц нурууны мэдрэлийн үрэвсэл, тархины даралт ихсэх, судас хатуурч эхлэх, тархины судас хатуурахаас урьдчилан сэргийлэх мэдрэлийн үрэвсэл, өвдөлт зэрэг мэдрэлийн өвчний оноштой 357 өвчтөнийг ханаж эмчилснээс эдгэрсэн 41,

<sup>20</sup> Завхан аймгийн Улиастай сумын өвлөн уламжлагч Б.Цэндсүрэн

<sup>21</sup> Баянхонгор аймгийн Баянхонгор сумын өвлөн уламжлагч Ж.Цагаанмуна

эрс сайжирсан 192, сайжирсан 89, дунд зэрэг сайжирсан 20, хэвээрээ 12, эмчилгээнд ирээгүй шалтгаантай 2 өвчтөн байв.

Артерийн даралт ихсэх, элэг, ходоод, цөсний үрэвсэл өвчний цочмог үе нь өнгөрсөн үе шат, уушгины багтраа, бөөрний үрэвсэл зэрэг дотрын өвчний оноштой 153 өвчтөнийг ханаснаас эдгэрсэн 8, эрс сайжирсан 74, сайжирсан 49, дунд сайжирсан 16, бага зэрэг сайжирсан 5, эмчилгээнд ирээгүй 1 өвчтөн байна. Мөн гүйлсэн булчирхайн үрэвсэл, залгиур ба мөгөөрсөн хоолойн үрэвсэл, хамар улайх, хамрын нусгай ханиад зэрэг хамар хоолойн өвчний оноштой 173 өвчтөнийг ханаж эмчилснээс эдгэрсэн 22, эрс сайжирсан 71, сайжирсан 58, дунд сайжирсан 9, бага сайжирсан 10, эмчилгээнд ирээгүй 3 өвчтөн байна.

Нүдний даралт ихсэх өвчний эхний үе шат, нүдний үрэвсэл, хаврын улиралд нүд улайж үрэвсэх өвчин зэрэг нүдний өвчний оноштой 111 өвчтөнийг ханаж эмчилснээс эдгэрсэн 11, эрс сайжирсан 12, сайжирсан 36, дунд сайжирсан 18, өөрчлөлт ороогүй 34 байв. Ясны хуудас үрэвсэх, гүн ба гүн бусаар вений судас үрэвсэх зэрэг мэс заслын өвчний оноштой 14 өвчтөнийг ханаснаас эрс сайжирсан 6, сайжирсан 5, дунд сайжирсан 1, бага сайжирсан 1, эмчилгээнд ирээгүй 1 өвчтөн байв. Мэргэжлийн эмчийн гардан хийх ёстой, буруу хийвэл эрсдэл дагуулах энэ эмчилгээ хэр үр дүнтэй нь эндээс харагдаж байна. Хамгийн гол нь ханах засал нь бусад заслыг бодвол хүнээс цус гаргадаг тул, эмнэлгийн нөхцөл, яаралтай тусламж авах боломжтой нөхцөлд хийхийг эмч экспертүүд зөвлөж, хануур хийж байгаа өвлөн уламжлагчид ч энэ заслыг хийхээс татгалзаж байгаа бөгөөд ханалаа гэхэд 3 дуслас илүүгүй цус ханаж гаргадаг байна.

Ханах засал эмчилгээний үйлчилгээ:

- Цусны хоруу чанарыг гаргана.
- Венын судасны хавлагуудыг сэргээнэ.
- Мэдрэлийн эсүүдийг цочроож, биеийн эсэргүүцлийг сайжруулна.
- Цусны эргэлтийг сайжруулна.
- Цус сэлбэлтийн нэгэн хэлбэр болдог дутуу боловсорсон цусны элементүүдийг гадагшлуулж чөмөг, дэлүүнд дахин цусны элементүүдийг үйлдвэрлэх боломж олгодог.

Ханах заслын хувьд өвлөн уламжлагч цөөн бөгөөд бүртгэл мэдээлэл дээр байхгүй байгаа нь анзаарагдаж байна. Бидний судалгаагаар хүмүүс ардын уламжлалт эмчилгээний эмнэлгүүд, мэргэжлийн эмчид хандан ханах заслыг хийлгэдэг байна. Ханах заслын талаар уламжлалтын эмнэлгийн эмч *“Миний бодлоор хануур засал Монголд их дэлгэрч хүмүүс хэрэглэж байсан, одоо ч гэсэн хэрэглэдэг. Хүмүүс их рашаан усанд явдаг, тэрний дараа хануур хийлгэх ёстой гээд бүр яг оюун ухаанд нь суусан байдаг. Тэгээд урин дулаан болоод хүмүүс рашаанд яваад ирсэн ханууль гээд их ирдэг. Тэрийг хүн хэн нэгэн хүн зааж өгөөд тэгсэн юм байхгүй. Манай аав зааж өгөөд тэгдэг байсан, рашаанд явсны дараа хануур хийлгэх ёстой гэдэг байсан ч юм уу. Тийм байдаг учраас би хануур засал их ойр гэж бодож байна.* Ханах заслын хувьд цөөн хэдэн өвлөн уламжлагч байдаг бөгөөд орчин үеийн анагаах ухааны үүднээс, монгол уламжлалтын эмч, экспертүүд ч өвлөн уламжлагчдын талаар ихээхэн болгоомжилсон, эмзэглэсэн хандлагатай байна. Тухайлбал,

"Одоо энэ Архангайд билүү аймар юм сонсогдоод л байдаг юм. Тэр ерөөсөө зүгээр л ханаад. Эрүүл цусыг нэг дусал цус ч гаргаж болохгүй гэсэн манай онолтой ном байна. Ямар өвчтэй хүнийг, ямар цаг, ямар сард ханах уу гэдэг юм байдаг. Тэгэнгүүт ямар цаг, жилд ханавал гурван жилийн дараа тэр хэсэгт нь тийм өвчин үүснэ гэдэг. Үүнийг нэг ч мэдэхгүй улсууд хийж байгаа. Тэгээд энийгээ бид давраагаад яах гээд байгаа юм. Тийм хүмүүсийг та нар өв тээгч нар гэж хэлэх үү, үгүй юу гэдэг юм яригдана шүү"<sup>22</sup>... "Одоо Өвөрхангайд (Архангайд) нэг товарищ хүмүүсийг мал шиг ханаж байна гэж байна. Тэр одоо юу хийж байгаа юм, хүн ухаан алдаад зүрх нь зогсоод үхвэл яах болж байна? Та нар эмнэлгээр яваад үз, хануур чинь яаралтай тусламж. Энэ чинь 21-р зуунд амьдарч байна. "Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага" одоо аюулгүй, чанартай тусламж үйлчилгээ үзүүлээч ээ гээд олон жил болж байна. Ямар ч яаралтай арга хэмжээ авч чадахгүй юман дээр хүнийг мал шиг ханаж байна. Та нар тэрийг судлаад дөвийлгөж болохгүй"<sup>23</sup> хэмээн хэлж байгаа нь нэг талаар зарим хүн нэг зүйлийг сайн гэвэл даган дуурайж, цаашид гарах үр дагаврыг сайтар судлан үздэггүй байх талтайг, нөгөө талаар, эдгээр цус ханагч хүмүүст ямар нэгэн хориг тавих уу, эсвэл эмчлэх эрх олгох уу гэх мэт асуудлыг хөндөх ёстой нь харагдаж байна.

Эдгээр экспертүүдийн зөвлөснөөр бид хээрийн шинжилгээний явцдаа Архангай аймгийн Хашаат сумын иргэн Т.Дагмидтай уулзахыг зорьсонгүй. Ханах заслын хувьд анхаарах чухал зүйл бол тухайн өвчтөний муу цус, сайн цусыг ялгах нь хамгийн чухал асуудал юм. Энэ нь цус ялгах тан уулгаж байж тухайн хүнийг ханадаг бөгөөд ханахад бас анхаарах олон зүйл байдаг. Тиймээс ханах засал нь дан ганцаар хийгддэггүй бөгөөд судас барьж оношлох, зүү тавих, тан уулгаж муу цусыг ялгах гэх зэргээр бусад уламжлалт анагаах ухааны арга ухаантай хавсрах, хамтрах байдлаар хийгддэг байна.

Энэ талаар Баянхонгор аймгийн Баянбулаг суманд ажилласан хээрийн судалгааны тэмдэглэлд: "Гол нь ерөөсөө цусыг хорыг нь гаргаж байгаа юм чинь ганц дусал цус. Авсан байхад хор гардаг. Зүү бол тэр үенд байгаа шар ус гаргаж өгч байгаа юм л даа. Эмнэлэг энэ цус хамаагүй авдаг болсон юм байна лээ, энэ чинь уг нь улиралтай байдаг байхгүй юу. Ерөөсөө 6 сараас 10 сар хүртэл хүний цус бүрэн гэсдэг. Тэр хооронд хүн хатгаж самнадаг. Бусад үед ерөөсөө бохирдсон байдаг болохоор цус авч болдоггүй юм. Одоо бол хамаагүй зун ч бай, өвөл ч бай аваад байна. Би бол тэгж авдаггүй юм. Бусад үед өвдлөө барилаа гэвэл сайхан барьж өгөөд, гурван дусал цус гаргачихдаг юм. Тэгээд өгчихөд тэр хүн тэр өвөлдөө, хавартаа яах ч үгүй"<sup>24</sup> хэмээн сүүлийн үед цаг улирал болоод муу цусыг ялгахгүй их ханаж байгааг өгүүлж байлаа. Ийм ч учраас ханах арга ухааныг олон өвлөн уламжлагч хийдэггүй, харин уламжлалт анагаах ухааны эмнэлгүүдэд хүмүүс ихээхэн хийлгэх болсон байна. Ханах засал нь хүний судсыг нээж байгаа учир ихээхэн хариуцлагатай хандах арга ухаан юм.

---

<sup>22</sup> Мамба дацан хийдийн Хамба лам, Монгол Улсын Гавьяат эмч Д. Нацагдорж

<sup>23</sup> Монгол анагаах ухаан олон улсын сургуулийн захирал Ph.D Д. Цэнд-Аюуш

<sup>24</sup> Баянхонгор аймгийн Баянбулаг сум, А. Батболд, 53 нас

## Зүү, Төөнүүрийн аргаар анагаах арга ухаан

Зүү төөнүүр эмчилгээ нь Хятад улсаас гаралтай бөгөөд 2010 оны 11 дүгээр сард Кени улсын Найроби хотод зохион байгуулсан Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах Засгийн Газрууд Хоорондын 5-р хуралдаанаар ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгүүлсэн байна. Хятадын зүү, төөнүүрийн эмчилгээний судрууд монголын уламжлалт анагаах ухаанд багагүй нөлөө үзүүлсэн байдаг. Тиймдээ ч “Зүү, төөнө эмчилгээний товч” номыг 1690 оны сүүл үеэр хятад хэлнээс тод бичиг рүү орчуулсан байна (Болд 2006, 56). Түүнээс хойш монголын уламжлалт анагаах ухааны, ялангуяа Өвөр Монгол зүү төөнүүрийн арга ухаан хөгжсөн нь харагдаж байна. Харин Монгол улсад зүү төөнүүрийн арга нь хэрэглэгдэж байгаад орчин цагийн анагаах ухаантай хослуулах байдлаар 1958-1990 онд хооронд зүү болоод төөнө заслын эмчилгээний хэсгийг сэргээсэн байна.

1958 онд Д.Бадарчин, Б.Цэрэнчимэд нар төв эмнэлгийн хажууд зүү төөнүүр заслын кабинетыг байгуулан ажиллаж, Д.Бадарчин нар “Зүү төөнүүр засал” (1989) бүтээлдээ зүү төөнүүр, хануур хийх арга зүй, хуваарь, бэлчрүүдийн талаар гарын авлага бүхий нарийн судалгаа хийсэн байдаг. Тухайн үед дотоодын болон Зөвлөлт Холбоот улсуудын эмнэлгийн салбарын эмч мэргэжилтэн нарт зүү-төөнүүр заслын курс хичээллүүлж байсан байна. Тухайн үед Монгол улс нь ардын уламжлалт анагаах ухаанаар Зүүн Европын олон мэргэжилтнийг сурган төгсгөсөн байна. Тэр цагаас хойш зүү төөнүүрийн арга ухаанаар одоог хүртэл анагаах ухааны сургуульд мэргэжилтэн бэлтгэсэн байна. Уг мэргэжил олгох сургалтанд өөрийн орны 800 гаруй зүү-төөнүүр заслын мэргэжилтэй эмч бэлтгэснээс гадна ах дүү социалист орны (ЗХУ, БНСЧУ, БНБАУ, БНПАУ, Куба, БНАГУ) 100 гаруй эмч нарыг зүү-төөнүүрийн засалд сургасан байна. (Болд 2006, 315). Зүү-төөнүүрийн эмчилгээ, эмч нар бэлтгэх хамгийн сүүлийн байдлаар (2022) Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуульд Улаанбаатар хотоос 70, орон нутгаас 11 хүүхэд мэргэжил эзэмшихээр бүртгүүлсэн байна.<sup>25</sup> Соёлын өвийн анхан шатны бүртгэлд анагаах ухааны арга ухааны нийт 100 гаруй өвлөн уламжлагч байгаагаас зүү, төөнийн нэг л хүн байсан юм. Ер нь өвлөн уламжлагч гэхээсээ илүүтэй орон нутгийн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны эмнэлгүүдэд зүү төөнүүрийн эмчилгээ их тустай байдаг байна. Орчин үеийн анагаах ухаанд эм тарианаас гадна зүү төөнүүрийн эмчилгээ нь үзүүрийн эсүүдийг сайн дэмждэг тул орчин үеийн анагаах ухаантай хамгийн сайн хоршдог уламжлалт анагаах төрөл байна.

---

<sup>25</sup> АШУҮИС-д элсэгчдийн бүртгэл мэдээлэл 2021-2022

### 3. “УЛАМЖЛАЛТ” АНАГААХ УХААН БА СОЁЛЫН ӨВ

ЮНЕСКО-д бүртгэгдсэн Уламжлалт анагаах ухааны олон улсын туршлага

Монгол төдийгүй дэлхий дахины олон ард түмний хувьд ардын уламжлалт анагаах ухаан нь тухайн ард түмний эртнээс нааш амьдарч ирсэн газар орон, байгаль цаг уурын нөхцөлтэй уялдан бий болсон ахуйгаас урган гардаг, нэг талаас аливаа өвчнийг анагаах хэрэглээний ухаан болох бол, нөгөө талаас *соёлын үүрэг ажиллагааны онолоор*<sup>26</sup> (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012, 93) тэдний өвөрмөц соёлын нэгэн элемент юм. Өнөө үед байгалийн шинжлэх ухааны олон салбар ухаанууд болон техник технологийн дэвшилд тулгуурласан “орчин үеийн” “өрнийн” “европын” анагаах ухааныг нэгэнтээ бүгд нийтээр хүлээн зөвшөөрч, дэлхийн өнцөг булан бүрд өргөн тархжээ. Энэ нь ч аливаа өвчнөөр өвдөж шаналж буй олон сая хүнийг өвчин, зовлонгоосоо ангижрахад нь тусалж байгаа ч үүнтэй зэрэгцээд “орчин үеийн” “өрнийн” “европын” анагаах ухаанаас ялгаатай зарим ардын уламжлалт анагаах ухааны талаарх мэдлэг болон түүний хэрэглээний орон зай шахагдаж байгаа нь хэн бүхний нүдэнд ил байна. Цаашлаад анагаах ухааны хүний хэрэглээ ч, соёл ч болох шинж болон түүний харилцан хамаарлын үүрэг, ач холбогдол нь буурах буюу алдагдах үйл явц зарим ард түмний өмнө тулгарч байхыг ч үгүйсгэх аргагүй тул Монгол улс өөрийн ардын уламжлалт анагаах ухааныг хадгалж хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авах нь зүйн хэрэг юм. Энэ тал дээр соёлын элемент болох талаас нь хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулах боломжтой нэгэн механизм байгаа нь ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Жагсаалт<sup>27</sup> яахын аргагүй мөн билээ. Тиймээс Монголын ардын уламжлалт анагаах ухааныг ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Жагсаалтад бүртгүүлэхэд шаардлагатай нөхцөл боломжуудын талаар дор өгүүлье.

Уламжлалт анагаах ухааны өвийг ЮНЕСКО-д бүртгүүлсэн олон улсын жишээ:

Зарим улс, ард түмний өөрсдийн уламжлалт анагаах ухааныг ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Жагсаалтад амжилттай бүртгүүлсэн байдал. Энэ талаар судлан үзвэл,

1. Хятад зүү төөнүүр-БНХАУ-аас Хятадын зүү төөнүүрийг дангаар нэр дэвшүүлж, 2010 оны 11 дүгээр сард Кени улсын Найроби хотод зохион байгуулсан Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах Засгийн Газрууд Хоорондын 5-р хуралдаанаар ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад

---

<sup>26</sup> “...Хэрэглээ болон түүний нийлэлт бүхэн өөр өөрсдийн гэсэн соёлын нарийн үүрэгтэй. Ингэж үзвэл хүнд хэрэглээ байна гэдэг бол түүнийг шийдвэрлэх шаардлага бий болгож байгаа хэрэг бөгөөд шийдвэрлэл нь эргээд үүрэг болон буцаж хүн рүү хандсан хүний бүтээл болж байна. Малиновски энэхүү бүтээлийг соёл гэж тодорхойлсон бөгөөд энэ нь хадгалагдаж, дахин боловсруулагдаж, зохион байгуулагдсаар байдаг” гэжээ.

<sup>27</sup> Үндэснийхээ соёлын биет бус өв (СББӨ)-ийг ЮНЕСКО-д бүртгүүлж баталгаажуулна гэдэг нь тухайн улс үндэстний нэр төрийн хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн хүндтэй үүрэг хариуцлага юм. Тухайн өвийг орон нутаг, улс үндэстэн, олон улсын түвшинд танин мэдүүлж, хадгалж хамгаалах, сэргээн амилуулах, түгээн дэлгэрүүлэх явдал хамгийн чухал. Иймд соёлын өвөө бүртгүүлсэн улс орон илүү их идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй болдог. “Соёлын биет бус өв - ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс” <https://unesco.mn/mn/soyol/soyoliin-biyet-bus-uv/>.

бүртгүүлсэн байна. Зүү, Төөнүүр нь хүний биеийн тэнцвэрт байдлыг зохицуулах, эрүүл мэндийг сахин хамгаалах мэдлэг, дадлын цогц бүхий Хятадын Уламжлалт Анагаах Ухаан (ХУАУ)-ны нэгэн төрөл юм. Тус арга ухаан нь “Хүн байгаль хоёрын нэгдэл” гэсэн цогц ойлголтод суурилдаг ба хүний биед орших тодорхой сувгууд болон зүүний цэгүүдийн байршлын тухай өөрсдийн онолд үндэслэж, тэр хэсгүүдийг төөнөх болон зүүгээр хатгах аргуудаар хүнийг эмчилдэг. Хятадын ард түмний оюуны соёлын нэгээхэн өвөрмөц өв болох энэхүү эмчилгээний арга нь түүхийн явцад тасралтгүй хөгжиж, хүмүүсийг эрүүл саруул амьдрахад чухал үүрэг гүйцэтгэн үеэс үед уламжлагдсаар өдийг хүржээ.

“Хүн байгаль хоёрын нэгдэл” гэсэн цогц ойлголт нь хүнийг орчлон ертөнцийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг бөгөөд хүний үйл ажиллагааг арга билгийн онолын үүднээс тайлбарладаг. Энэ үзлээр бол хүн, орчлон ертөнц хоорондын арга билгийн тэнцвэр алдагдсанаас, мөн хүний биеийн арга билгийн тэнцвэр алдагдсанаас үүдэж аливаа өвчин эмгэгт өртдөг байна. Зүү төөнүүрийн эмчилгээнд хүний биеийн бүх хэсэг нь өөр хоорондоо сувгаар холбогдсон бяцхан ертөнц гэж үздэг бөгөөд энэ нь урт хугацааны дадал, туршлагын үндсэн дээр онолын түвшинд хүртлээ хөгжиж, 12 суваг нь 12 сарыг, 365 зүүний цэг нь жилийн 365 хоногийг илтгэдэг ч гэж тайлбарладаг. Биеийн дээд, дунд, доод гэсэн гурван хэсэг болон зүүний гүний 3 хэмжээсээр хүн, диваажин, дэлхий 3 холбогддог гэж үздэг. Биеийн дээд хэсгийн өвчлөлийг доод хэсгийн цэгүүдээс сонгож хатгадаг бол, зүүн хэсгийн өвчлөлийг баруун хэсгийн цэгүүдээс сонгож хатгадаг нь ХУАУ-нд хүний биеийг бүхэл, цогц гэж үздэгийн нэгэн илрэл юм.

Энэхүү эмчилгээний уламжлал нь зүү болон төөнүүр гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Зүү тавих нь урьдчилан сэргийлэх болон эмчилгээний зориулалтаар юун түрүүнд тухайн хүний биеийн байдлыг тодорхойлж, таарсан зүүг сонгохоос эхлээд аль цэгт, хэрхэн хатгах (өргөх, түлхэх, эргүүлэх, дугуйлах) гэх мэт маш нарийн арга техникийг шаарддаг эмчилгээ юм. НТӨ II, III зууны үест бичигдсэн Зэн Жин (Classic of Acupuncture) сударт олон янзын хэлбэртэй 9 төрлийн зүү, мөн зүүг хатгах хэдэн арван арга техник байдаг талаар өгүүлсэн байдаг. Зүүг голдуу чулуу болон хүрэл, төмөр, алт, мөнгө зэрэг металлуудаар хийдэг байсан бол орчин цагт ихэвчлэн гангаар хийх болсон.

Төөнүүр нь хүний арга билгийн тэнцвэрийг хангах зорилгоор цэгийн гадаргууг шууд төөнөх болон гадаргуугаас зайтай, ойролцоо хэсгийг төөнөх гэсэн үндсэн 2 аргатай, тодорхой цэгүүдийг халааж эмчилдэг арга юм. Төөнүүрийг нэгэн зүйл шарилжийн навчийг боловсруулан хатааж гаргаж авдаг бөгөөд шатамхай, өөрийн гэсэн дулаантай, удаан уугьдаг. Төөнүүрийн түүхий эд болох Artemisiae (Шарилж) анхилуун үнэртэй нэгэн төрлийн ургамал юм. Энэ нь Хятадад ихээр ургадаг ба хятадууд эртнээс нааш элдэв зүйлийн өвчин үүсгэгчийг устгадаг гэж үзэн төөнүүр болгон ашиглах болсон байна.

Зүү төөнүүр нь газар газрын хүрээлэн буй орчин, байгалийн нөхцөлтэй уялдан өөр өөр газруудад хөгжиж ирсний үндсэн дээр өнөө тодорхой бүлэг болон хувь хүмүүсийн дэг сургуулиудаар дотроо ялгардаг. Чэн Шиннон (1921) -ийн сайжруулсан “гурван үе шат бүхий зүү тавих арга” болон Хэ Пүрэн (1926-) -ийн эмхэтгэсэн “гурван чиглэл бүхий зүү

тавих арга” зэрэг нь тус уламжлалыг үргэлжлүүлэн өвлүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэжээ.<sup>28</sup>

Жагсаалтад амжилттай бүртгэгдсэн тус уламжлалт анагаах ухааны нэр дэвшүүлэх материалыг холбогдох шалгууруудыг хангасан байдлаар бэлтгэсэн байх бөгөөд ингэхдээ Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцод заасан 2-р зүйлд заасан 4. Байгаль болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншлууд хэлбэрийн дагуу тодорхойлж тайлбарлажээ. Тиймээс юун түүрүүнд зүү төөнүүрийн эмчилгээний онолын үндэс нь “хүн байгаль хоёрын нэгдэл” гэсэн санаанд тулгуурлаж, түүний бусад төрлийн анагаах ухааны онолоос ялгарах өвөрмөц талуудыг нь ихээхэн тодотгосон байна. Мөн арга билгийн онол (yin and yang theory)-ийн үзэл санаанд хүний биеийг орчлон ертөнцийн салшгүй нэг хэсэг гэж үздэг талаар тайлбарласнаар конвенцын 2-р зүйлд заасан холбогдох хэлбэрийн шаардлагыг хангаж байна.

Түүний дараагаар ерөнхий “зүү тавих” болон “төөнүүр”-ийн эмчилгээний талаар тус тусад нь, тэдгээрийн үүсэл, хөгжил, түүхэн сурвалжуудад дурдагдсан байдал болон хийх арга, техникийн талаар тайлбарлажээ. Мөн энэ хэсэгтээ зүүг хийдэг материал болон төөнүүрийн түүхий эдийн тухай ч мөн дурдсан байна. Дээрх байдлаар тус эмчилгээний анагаах ухааны суурийг тайлбарласан бол түүний дараагаар зүү, төөнүүрийн эмчилгээтэй холбоотой ёс уламжлал, зан үйлүүд болон ам дамжсан яриа гэх мэт соёлын үндэстэй итгэл үнэмшлийн талаар мэдлэг, дадлуудыг дараах байдлаар өгүүлжээ. “...*Хятадуудын дунд ‘Ганц ширхэг зүү, нэг багц ургамал байхад л хүнийг хөгшин насандаа ч эрүүл амьдрах нөхцөлийг хангадаг’, ‘Цагаан сарын шинийн 5-нд гэрийнхээ үүдэнд төөнүүр асааж орхивол бүтэн жилийн турш тэр гэрт эмч ирэх шаардлагагүй болдог’ гэсэн яриа байдаг...*”.

Түүнээс хойш мөн жагсаалтын шалгууруудын дагуу зүү төөнүүрийн хадгалагдсан байдал, холбогдох өвлөн тээгч бүлэг хүмүүс, эмнэлэг, эрдэм шинжилгээний байгууллагууд, хамрах хүрээ зэрэгт тус бүрийг нь дэлгэрэнгүй тайлбарласан байна.

2. Хятад дахь Төвөдүүдийн Сова Ригпагийн “Лум” рашаан, усанд орох эмчилгээг (Lum medicinal bathing of Sowa Rigpa, knowledge and practices concerning life, health and illness prevention and treatment among the Tibetan people in China) бүртгүүлсэн байна. Тус өвийг мөн БНХАУ-аас нэр дэвшүүлж, 2018 оны 12-р сард Мауритиус улсын Порт-Луи хотноо зохион байгуулсан Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах Засгийн Газрууд Хоорондын 13-р хуралдаанаар ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгүүлсэн байна. БНХАУ-ын ТӨЗО, Хөх нуур, Сичуань болон Юннань зэрэг мужуудад тэргүүтэй төвөд үндэстнүүд олноор суух газруудаар өргөн тархсан бөгөөд ойр хавийн ШУӨЗО, ӨМӨЗО зэрэг газар орнуудад ч мөн тодорхой хэмжээн тархжээ.

Сова Ригпагийн “Лум” рашаан, усанд орох эмчилгээ нь төвөдүүдийн Таван махбодийн онол (Са буюу газар, Чу буюу ус, Мэ буюу гал, Лун буюу хий, Намхай буюу

---

<sup>28</sup> “Representative List - Intangible Cultural Heritage.” <https://ich.unesco.org/doc/src/07512-EN.pdf>.



огторгуйд) суурилсан ертөнцийг үзэх үзэл болон Ниёпа-сум буюу Гурван хүчний онол (Лун, Трипа, Пеканд) суурилсан анагаах ухааны үзэл санаанд тулгуурлан үүсэж хөгжжээ. Төвөд хэлэнд Лум гэдэг үг нь бие сэтгэлийн тэнцвэрийг хангах болон аливаа өвчин эмгэгийг эмчлэх зорилгоор халуун рашаан, ургамлын хандтай ус эсвэл ууранд орох уламжлалт мэдлэг дадлын талаар утгыг агуулдаг байна.

Төвөдийн ардын уламжлалт анагаах ухааны мэдлэг, дадлыг шингээж, Бонын шашин болон Төвөдийн Буддизмын нөлөөг хүртсэн, Аливаа өвчин эмгэгийг анагаах, урьдчилан сэргийлэх зорилгоор үйлддэг энэхүү эмчилгээний арга нь орчин үеийн анагаах ухаанд Гюд Жи буюу Дөрвөн Тарнийн Судраар дамжин дэлгэрч байна. Лум нь Манба (уламжлалт анагаах ухааны эмчийн) заавраар дараах үндсэн 2 аргаар үйлдэгддэг. Нэг нь олон төрлийн эрдэс агуулсан Таван төрлийн Халуун рашаанд орох. Нөгөө нь Таван төрлийн цэцгийн хандтай усанд орох, уураар нь утах болон биеийг арчих гэсэн 3 хэлбэр юм. Энэ аргаар Манба нь Лум Журхан /Эм зүйч/ болон Манёк /Лумын туслах/ нартай хамтран өвчтөнөөс зовуурь, шинж тэмдгийн тухай асууж, судасны цохилтыг үзсэний үндсэн дээр оношийг нь тодорхойлж байж хүнийг эмчилдэг. Ингэхдээ ургамлуудаа хольж нийлүүлэх, буцалгах болон исгэх зэргээр өмнө нь бэлддэг.

Энэхүү эмчилгээний арга нь үеэс үе дамжин төвөдүүдийн өдөр тутмын амьдрал, шашны зан үйл, ардын аж ахуй болон олон жилийн туршлагаар баталгаажсан ардын анагаах ухааны мэдлэг болон уламжилж иржээ. Төвөд- Хөх нуурын өндөрлөгөөс гаралтай энэхүү соёлын элемент нь хүний эрүүл мэндийг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх болон нийгэмд байгаль эх дэлхийг хайрлаж хүндэтгэх талаар хэв ёсыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Өдөр тутамдаа үйлдэж хэвшсэн байдаг ч Төвөд хуанлийн долоодугаар сард болдог Карма Дулпа, Дудцы Мандруб зэрэг уламжлалт баяр ёслол, шашны үйлүүдийн үеэр хамгийн өргөн хүрээтэй үйлдэгддэг. Тиймээс энэ элемент нь Төвөдийн ард түмний соёлын ижилслийг өдөөгч нэгэн хүчин зүйл болдог бөгөөд уран зураг, сийлбэр, тууль, яруу найраг, Тангка зэрэг бусад уламжлалт соёлуудад ч мөн ихээхэн дүрслэгджээ.<sup>29</sup>

Төвөдийн ард түмний дунд үүсэж хөгжсөн уламжлалт анагаах ухааны энэ аргыг БНХАУ-аас тус жагсаалтад нэр дэвшүүлэхдээ мөн л Соёлын биет бус өвийн тухай конвенцод тодорхойлсон Байгаль болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншлууд хэлбэр болох талаас нь тайлбарласан бөгөөд тэр үндэслэлдээ тулгуурлан тухайн өвийг байгаль эх дэлхийн талаар зурхай, Таван махбодын онол, Гурван хүчний онол зэрэг тухайн ард түмний ардын уламжлалт мэдлэгүүдтэй хэрхэн холбогдож байдаг талаар өгүүлснээс харж болно. Энэ өв болон зүү төөнүүрийн аль алины жишээнээс үзэхэд тухайн соёлын элемент нь конвенцын 2-р зүйлд заасан соёлын биет бус өвийн чухам аль хэлбэр болохыг нь юун түрүүнд тодорхойлж, түүнээс хойших бусад хыэсгүүдэд түүндээ үндэслэн холбогдох шалгуурыг хэрхэн хангаж байгааг тус тус тайлбарласан байна.

---

<sup>29</sup> “Lum medicinal bathing of Sowa Rigpa, knowledge and practices...” <https://ich.unesco.org/en/RL/lum-medicinal-bathing-of-sowa-rigpa-knowledge-and-practices-concerning-life-health-and-illness-prevention-and-treatment-among-the-tibetan-people-in-china-01386>.

Энэ мэтээр БНХАУ-ын тухайд ЮНЕСКО-ын Соёлын биет бус өвийн жагсаалтуудад нийт 31 өвийг, Малайз болон Монгол улстай хамтран 2 өвийг бүртгүүлсэн байна. Эдгээрээс анагаах ухаан, эмчилгээтэй холбоотой өөр нэг өв нь Хятадын уламжлалт гимнастик буюу Тайжикуан байна. Тус өвийг 2020 оны 12 сард Төлөөллийн жагсаалтад бүртгүүлсэн байна.

Эднээс гадна бусад Азийн улсуудаас Тайланд улс Нуад Тай буюу Тай Массажийг 2019 оны 12 сард Колумб улсын Богота хотод зохион байгуулагдсан хуралдаанаар ЮНЕСКО-ын Соёлын Биет Бус Өвийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад амжилттай бүртгүүлсэн байна<sup>30</sup>. Ингэхдээ конвенцын 2 дугаар зүйлд заасан Заншил, зан үйл, баяр ёслол болон Байгаль болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншлууд гэсэн 2 хэлбэрээр тодорхойлж, материалдаа эмийн бус ардын уламжлалт анагаах ухааны төрөл байдлаар тайлбарласан байна. Эндээс үзэхэд манай улсын рашааны, шавран зэрэг эмчилгээг нарийвчлан судалж, бусад улсад буй арга туршлагаас юугаараа ялгаатай, адил төстэй болохыг тогтоон, цаашид бие даасан соёлын өв гэж үзэх үндэс бий эсэхийг тодруулах хэрэгцээ байна.

---

<sup>30</sup> "Nuad Thai, traditional Thai massage - Culture Sector - UNESCO." <https://ich.unesco.org/en/RL/nuad-thai-traditional-thai-massage-01384..>

## “ЮНЕСКО-д бүртгүүлэх Нүүдэлчдийн анагаах ухааны төрөл”

Судалгааны явцад судалгааны баг хамт олон хэд хэдэн анагаах ухааны төрөл, арга барилыг ЮНЕСКО-гийн Биет бус соёлын өвд Монгол Улсын нэрийн өмнөх бүртгүүлж болох боломж байгаа гэж үзэв. Үүнээс ургамлаар анагаах арга ухаан болон бариа заслыг онцолж байна.

### *Ургамлаар, өвсөн эмээр анагаах арга ухаан*

Ургамлаар анагаах болон өвсөн эмээр анагаах арга ухаан нь нүүдэлчин монголчуудын язгуурын шинж чанартай анагаах ухаан гэж үзэж байна. Ийн үзэж буй хэд хэдэн үндэслэл буйгаа доор дэлгэрүүлэн тайлбарлалаа. Тэдгээр нь:

**Үндэслэл 1:** Ургамлаар анагаах, өвсөн эмийн хэрэглээ Монгол улсын хэмжээнд хамгийн их тархсан бөгөөд ардын уламжлалт анагаах ухаан дундаас өдөр тутамдаа одоо ч хамгийн их хэрэглэгддэг ашиглагдаж байгаа арга ухаан юм. Эрт дээр үеэс амьтан, ургамал, эрдсийн гаралтай байгалийн нэгдэл нь уламжлалт анагаах ухааны үндсэн тулгуур, түүх соёлын нэг хэсэг болж ирсэн түүхтэй. Энгийнээр тунгаан үзэхэд ч хүний гарын доорх, гэрээсээ гараад түүж болох ургамалд эмийн хүч чадал байгааг нээж олох нь тийм ч их хүч хөдөлмөр, тусгай боловсрол шаардсан ажил биш байсан болов уу. Байгалийн нэгдлийг “өвсөн эм”, “ургамлын эм”, “хүнс” байдлаар олон мянган жил хэрэглэж ирсэн ба одоо үед байгалийн нэгдлийн өвөрмөц, сонирхолтой молекулын бүтцэд тулгуурлан шинэ бүтээгдэхүүн гарган авах судалгаа шинжилгээ хийгдэж байна (Одонтуяа 2018). Тиймээс өвсөн эм, ургамлаар анагаах арга ухаан нь ард олны дунд үеэс үед дамжин ирсэн асар олон жилийн уламжлалтай харагдаж байна. Тухайлбал: Хонин зээргэний үнсийг, азу гэх ургамалтай хольж хамрын тамхи хийж даралт тогтворжуулах байдлаар хэрэглэж байна, “гоёохон”- гэх ургамлыг зуны улиралд хүнсэнд хэрэглэж дархлаа болон ходоод гэдсийг амраах, “суль”, “сульхир”-ын гурилаар шээс задгайрах, дархлаа дэмжих, зээргэнэ дэгдийг бөөр нуруунд, боогоньг цагаан мах эргэхэд, “манчин”-г ясны сийрэгжилтэд гэх мэт олон янзаар одоо ч хэрэглэж байна.

М

**Үндэслэл 2:** Өнөө үеийн анагаахын судалгаанд ургамал, өвсөн эмийн судалгаа ихээхэн хийгдэж байгаа юм. 21-р зуун гарахад хамгийн чухал, хэрэгцээтэй 252 эмийн 11% нь цэцэгт ургамлын гаралтай гэж ДЭМБ-н мэдээлэлд тэмдэглэгджээ. 1940 оноос 2014 оныг дуустал хугацаанд хорт хавдрын эмчилгээнд 175 эмийг баталсан байдаг ба үүний 131 нь буюу 75% нь нийлэг биш, 85 нь буюу 49% нь байгалийн нэгдэл цэврээр юм уу эсвэл түүнээс уламжлуулан гарган авсан нэгдлүүд байна (Одонтуяа 2018). Сүүлийн жилүүдэд Монгол улсын хэмжээнд Монгол оронд ургадаг эмт ургамлын судалгаа хурдацтай явагдаж

байна. Тухайлбал, Н.Чулуунсүрэн (2007) "Монгол оронд ургадаг зарим ургамлуудаас ялгасан биологийн идэвхт бодисуудын дархлалын тогтолцоонд үзүүлэх идэвхийн харьцуулсан судалгаа" сэдэвт магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Д.Хонгорзул (2007) "Монгол оронд ургадаг зарим ургамлаас ялгасан тосны бодисын антиоксидант идэвхийн судалгаа", Д.Зандансүрэн (2009) "**Синдэрийн** бүтэц, найрлага, гадар шарханд үзүүлэх нөлөөллийг судалсан нь" сэдэвт анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Э.Наранчимэг (2009) "**Гишүүнэ-3** уламжлалт жорын туулгах үйлдлийг эмийн зарим хэлбэрт судалсан дүн", Ц. Мөнхтуяа, (2009) "**Удвал навчит тавилгана** (SPIRAEA AQUILEGIFOLIA PALL)-ы фармакологийн судалгаа" сэдэвт анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, С. Хишигжаргал, (2010). "**Ямаан сэрдэг**" ургамлын элэг хамгаалах, цөс хөөх үйлдлийн судалгаа. Анагаах ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Д. Хашгэрэл, (2010). "**Сэрдэг дэгд**"-ийн овгийн зарим зүйл ургамлын цөс хөөх үйлдлийн харьцуулсан судалгаа. Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Д. Энхгэрэл, (2010). "**Чихэр өвс**" (*Glycyrrhiza uralensis fisch*) ургамлын бөөр хамгаалах идэвхийг үрэвслийн эсрэг үйлдэлтэй нь холбон судалсан дүн. Эм зүйн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Д. Нямсүрэндэжид, (2011). *Чихрийн шижинд монголд ургадаг "хусны онгол"-ын хандны үзүүлэх нөлөө.* Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, С. Долгор, (2012). "**Монгол тэрэлж**" (*Rhododendron adamsii rehd.*), *энэтхэг тэрэлжийн* (*Rhododendron nivale hook. F*)- ийн фармакологийн идэвхийг харьцуулан судалсан дүн. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Б. Цолмончимэг, (2013). "**Дагуурын тарваган шийр**" (*Thermopsis dahuica czeft*) ургамлын уушиг хамгаалах үйлдлийн фармакологи судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Д. Чанцалмаа, (2013). "**Хөдөөний бираа**"-гийн (*Thlaspi arvense L.*) бөөр хамгаалах үйлдлийн судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Б. Цэрэнцоо, (2014). *Элэгний хавдрын эсэд байгал "гүүнхөх"* (*SCUTELLARIA BAICALENSIS GEORGI*) ургамлын үзүүлэх нөлөөг *in vitro* орчинд судалсан дүн. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Б. Отгонцэцэг, Б. (2015). *Ханиалга намдаах үйлдэлтэй ургамлын гаралтай сироп бэлдмэлийн фармакологийн судалгааны дүнгээс.* Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Ц. Мөнхзул, (2015). *Туришилтын амьтанд үүсгэсэн ходоодны шархлаанд "том навчит дэгд"* (*Gentiana macrophylla pall*)-ийн үзүүлэх нөлөөг судалсан нь. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Э. Жаахандүү, (2016). "**Дэрэвгэр хависгана**" (*Scorzonera divaricata turcz*) ургамлын фармакологи судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Ц. Гүндэгмаа, (2016). "**Дэрэвгэр жиргэрүү**" (*Saposhnikovia divaricata (Turcz) schischk*) ургамлын филогенез, фармакологийн зарим үйлдлийн судалгаа. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, С. Жавзанпагма, (2018). "**Улаанбуудай**" (*Triticum aestivum.L.*) болон "**шивүүрт цулхир**" (*Agriophyllum pungens (VAHL.) Link. EX. A. Dietr.*) ургамлын фитохимийн харьцуулсан судалгаа. Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Л. Солонго, (2018). "**Таримал сарьслаг хунчир, байгал гүүн хөх, гинкгобилоба**" ургамлын цус бүлэгнүүлэлтэд үзүүлэх нөлөөг

судалсан дүн. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, Ц. Таванцэцэг (2018). *Энгийн буржгар (Thalictrum Simplex L.) ургамлын бөөр хамгаалах үйлдлийн судалгаа*. Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл гэх зэргээр судлагдсаар байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Мөн засгийн газраас Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/220 дугаар тушаалаар байгуулагдсан “Уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эд, жор найрлагын нэр томъёог цэгцлэн нэгтгэх ажлын хэсэг” нь Монгол улсад одоо үйлдвэрлэж байгаа уламжлалт эмийн нэр, нэршил, нэр томъёог судалж, 483 эмийн жорын нэршил, уламжлалт эмийн найрлагад оролцож буй 544 уламжлалт эмийн түүхий эд, латин, монгол, англи, орос, төвөд, хятад хэлээр нэгтгэсэн байна.<sup>31</sup> Энэхүү мэдээллээс харахад Монгол орон нийт хэрэглэгдэж байгаа уламжлалт эм, түүний түүхийн эдийн судалгаа, үйлдвэрлэл ихээхэн хөгжсөн нь харагдаж байна. Энэхүү суурь, судалгааны үндэс дээр тулгуурлан Өвийн жагсаалтад бүртгүүлэх ажил ч хурдан шуурхай, үндэслэл тулхтай байх боломж харагдаж байгаа юм.

**Үндэслэл 3:** Өвс ургамал нь байгаль сав шим ертөнцийн шууд хэрэглэж болдог бүхий л өвчин анагаах боломжтой хамгийн энгийн хэрэглээ юм. Жил бүр Улаанбаатар хотод зохион байгуулагддаг жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих, танилцуулга өдөрлөгт олон тооны асарт өвсөн эмийн худалдааны асруудад байдаг. Энэхүү асрууд нь үйлчлүүлэгч болоод хэрэглэгчид олонтой байдаг. Энэ талаар ургамлаар анагаах ухааны өвлөн уламжлагч Отгонбаярын хэлснээр: эмийн ургамал хэрэглэгч сүүлийн жилүүдэд ихсэж байгаа хүмүүс химийн найрлагатай эм тарианаас ихээхэн татгалзах болсон. Тиймээс уламжлалт өвсөн эм, эмийн ургамлын ихээхэн ашиглах болсон гэнэ. Эргээд энэ байдал нь зах зээл болоод хүн зоны дунд ч энэ төрлийн хэрэглээ их байгааг илтгэхээс гадна органик гэсэн зүйл бүрийг чухалчлан үзэж буй өнөө цагийн нийгмийн өнгө төрхтэй давхцаж буй, амьдрал дундаас үүдсэн тодорхой хэрэгцээ байгааг харуулж буй хэрэг юм. уламжлалт анагаах ухааны гол бүтээгдэхүүн болох эмт ургамлаар бүтдэг эмийн 53 хувь нь монгол улсад ургадаг ба 47 хувийн импортоос авдаг бөгөөд нийт импортоос орж байгаа эмийн бүтэгдэхүүний 74 хувь нь ургамал байдаг байна. Тиймээс монгол эмийн үйлдвэрүүд тан бэлтгэх, уламжлалт эмийн үйлдвэрлэхэд эмийн ургамлыг ихээхэн ашиглаж байна<sup>32</sup>. Монгол нутагт ургадаг өвс, ургамлаар хийсэн эм, тан гэсэн ойлголт эргээд манай гэсэн ардын уламжлалт анагаах ухааныг төлөөх бүрэн чадвар байгааг ч харуулж буй явдал болно.

**Үндэслэл 4:** Ургамлаар анагаах болон эмийн ургамлын талаар монгол эрдэмтдийн олон ном бүтээл байдаг нь энэ арга ухаан ямар хэмжээнд "монгол" вэ гэдгийг хариу юм. Тухайлбал, Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Эм таних ухаан” (Lonsangcültüm 1998), “Өвсөн эмийн тухай” модон барын судар, Шинбай тойн (1630), Жамбалдоржийн “Үзэсгэлэн нүдэн чимэг” (Володя ба бусад 2008), Жанжаа хутагт Ролбийдоржийн “Мэргэд гарахын орон

---

<sup>31</sup> <https://moh.gov.mn/news/3913>

<sup>32</sup> Пүрэвсүрэн, С “Traditional Mongolian veterinary medicine” mini symposium 08 July 2022

нэрт тогтоосон даягаас тэжээхүй ухааны аймаг оршвой” зэрэг зохиолууд юм. 900 гаруй ургамлын анагаах чанарын тухай монгол эрдэмтдийн бичсэн 200 гаруй судар байдаг. эдгээр сударт 1 хуудас бүхий сударч байдаг ба энэ нэн ховор хүдрийн заар, баавгайн цэс зэргийг ямар ургамлаар орлуулах тухай байдаг байна<sup>33</sup>. Тиймээс монгол эрдэмтэн мэргэдийн эдгээр бүтээлээс үндэс эх авсан анагаах ухааны эмийн ургамал, өвсөн эмийн олон арван бүтээл төрөн гарсан нь дамжиггүй байна.

### *Бариа заслаар анагаах арга ухаан*

Бидний үзэж буйгаар ЮНЕСКО-гийн Биет бус соёлын өвд Монгол Улсын нэрийн өмнөх бүртгүүлж болох нэгэн өв бол Бариа заслын арга юм. Монголчуудын амьдрал ахуй, эрхлэн аж ахуйгаас үүдэх хамгийн анхны эрсдэлийн нэг бол толгой тархи доргих, бие булрах, үе мөч сулрах зэрэг бариа заслаар анагааж болох өвчин хууч орно. Уг арга уламжлалыг тус өвийн жагсаалтад бүртгүүлж болох хэд хэдэн үндэслэл байна. Тэдгээр нь:

**Үндэслэл 1:** Бариа засал нүүдэлчдийн дунд хамгийн түгээмэл тархсан анагаах ухааны арга ухаан юм. бидний судалгаагаар болоод Соёлын өвийн үндэсний төвийн ардын уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагч нараас бариа засалчид нь нийт өвлөн уламжлагч нарын дийлэнх хувийг эзэлж байна. Нийт ардын арга ухаан өвлөн уламжлагчдын бүртгэл мэдээллээс бидний шүүн үзэхэд 103 нь ардын уламжлалт анагаах өвлөн уламжлагч байгаагаас 50 хувиас дээш буюу 53 хүн нь бариач байсан юм. Энэ тоо баримт нь уг арга хэр зэрэг өргөн дэлгэр манай нутаг тархсан төдийгүй хэр зэрэг хэрэгцээ, хэрэглээтэй, бидний ахуй амьдралтай холбоотойг шууд утгаараа зааж байна. Мөн бидний хээрийн судалгааны үеэр Соёлын өвийн газрын бүртгэл мэдээлэлд ороогүй шинээр бүртгэн, уулзсан хүмүүсийн 90 хувь нь бариач байсан. Бидний судалгааны ажиглалтаас сум бүрд гартаа домтой, увдистай гэх 2, 3 хүн байсан бөгөөд ихэнх нь бүртгэл мэдээллийн санд ороогүй, соёлын төвийн ажилчид ба хамгийн сайн, нутаг орондоо нэртэй бариачдаа бүртгүүлдэг байна. Бариачид нь нүүдлийн ахуй соёл хамгийн түгээмэл тохиолддог бэртэл гэмтлийг анагааж, эдгээдэг учир олон зууны турш ардын дунд хадгалагдан үлдсэн нь харагдаж байна.

**Үндэслэл 2:** Зөвхөн нүүдэлчдийн гэж хэлж болохуйц өвчин эмгэгт тохирсон Монгол бариа засал нь бөөр, нуруу, толгойн доргилт, ясны хугаралд одоо ч ач тусаа өгсөөр байна. Энэ нь өвлөн уламжлагч нарын өгүүлж байгаагаар цаг хугацаа хэмнэх, мэс хүргэхгүй байх, тусламж авахад хурдан зэргээр гэмтсэн бэртсэн хүмүүс ихээхэн "ашигтай" тул өвчин зовлонд тулсан хүмүүс анхан шатны тусламж үйлчилгээ нэгэн төрлийн "өрхийн эмнэлэг" нь тухайн нутгийн бариач, илээч улс болсноор харагдана. Өөр нэгэн онцгой зүйл бол хүний тархи доргисон үед тэд бариа заслын өвлөн уламжлагчдад ханддаг байна. Тиймээс нийт уулзсан өвлөн уламжлагч нар дээр ирдэг өвчний шалтгааны 80 хувь нь тархи толгойтой холбоотой байдаг гэж хэлж болохуйц орчин нөхцөл хэдийн үүсжээ. Энэ

---

<sup>33</sup> Болд, Ш. “Traditional Mongolian veterinary medicine” mini symposium 08 July 2022

утгаараа уг арга барил төлөөлөх чадварын хувьд монголчуудын уламжлалт анагаах ухааныг бүрэн дүүрэн төлөөлөхүйц байна. Мөн бариа заслын нийгэм дэх эрэлт хэрэгцээ их ба хөдөө орон нутгийн бэртэж гэмтсэн гэх хүмүүсээс гадна Улаанбаатар хот дахь бариа заслын эмнэлэг, төвүүдийн үйлчлүүлэгч ихтэй байдаг талаар дурдаж болох юм.

Өвлөн уламжлагч нарт тулгамдаж буй асуудал, хэтийн төлөв

Энэхүү соёлын биет бус өвийн уламжлалт анагаах ухаан, арга ухааны өвлөн уламжлагчдын байршлыг “Соёлын Өвийн Үндэсний Төв”-ийн өвлөн уламжлагч нарын анхан шатны мэдээлэл дээр үндэслэн гаргасан билээ. Уг бүртгэл мэдээлэлд уламжлалт арга ухааны 500 гаруй өвлөн уламжлагч байгаагаас ардын анагаах ухаан, арга ухааны 103 уламжлагчийг шүүж, аймаг сумаар нь тэмдэглэсэн юм. Үүнд, “бариа засал” 53 хүн, “төөнүүр хийх” арга ухаан 2 хүн, “эмийн ургамлаар анагаах” арга ухаан 14 хүн, “зүү тавих” арга ухаан 1 хүн, “дом засал”-ын арга ухаан 6 хүн байгаа юм. Энэхүү анхан шатны мэдээлэл, уламжлалт анагаах ухааны экспертүүдийн зөвлөмж дээр үндэслэн хээрийн судалгааны ажлыг одоогийн байдлаар 9 аймгийн 20 суманд өвлөн уламжлагч нартай уулзаж, судалгааны ажлыг хийж гүйцэтгээд байна. Гэвч энэ бүхэнд нийт өвлөн уламжлагч нарыг бүртгэн, тогтооход хангалтгүй байгааг дурдах хэрэгтэй. Холбогдох газраас яг энэ зорилгоор тусгай судалгааны баг гаргаж, цаг хөрөнгө зарвал сая манай улс өвлөн уламжлагч нарынхаа талаар бүрэн дүүрэн тоо, баримттай болох боломж байна.

Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын эзэмшсэн арга ухаанаа цааш нь өвлүүлэх эсэх талаар дүгнэн үзвэл: Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарыг сум, орон нутгийн соёлын төвөөс анхлан бүртгэж, аймгийн бүртгэл мэдээллийн санд оруулснаар “Соёлын Өвийн Үндэсний Төв”-ийн анхан шатны бүртгэл мэдээлэлд ордог байна. Бидний судалгаагаар өвлөн уламжлагч нар сум, орон нутагтаа ихээхэн нэр хүндтэй нь ажиглагдсан бөгөөд нутгийнхнаас гадна ойр зэргэлдээ сум, аймгуудаас ирж, эмчлүүлэх нь ч элбэг байдаг байна. Ихэнх өвлөн уламжлагчид нь их дээд сургуульд боловсрол эзэмшээгүй, хөдөө орон нутагтаа мал маллаж байгаа, тэтгэвэрт гарсан, сумын төвд амьдарч байна. Сумын төвд амьдрах нь нэг талаар амар бөгөөд хөдөө хээр зусланд үзүүлэх хүмүүс нь тэднийг очиж авдаг тул чирэгдэл хүндрэлийг бодож, төв бараадах болжээ.

Өвлөн уламжлагчдын ардын уламжлалт анагаах ухааны өвийг өвлөн авсан байдал нь харилцан адилгүй байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь нийгмийн хувирал, шашны талаар авч хэрэгжүүлж байсан төрийн бодлого зэргээс хамаарч байгаа юм. Ихэнх өвлөн уламжлагчид нь 3, 4 дэх үеийн өвлөн уламжлагчид байгаа бөгөөд өвөө эмээгийн үед уламжлалт анагаах ухааны арга ухааныг хэрэглэх, хүмүүс эмчлэх хаалттай үед байснаас цааш нь өвлөн уламжлуулахдаа ихээхэн зүйл орхигдуулсан гэж болохоор байна. Өөрийн удамд мэдрэмжтэй, хүсэл сонирхолтой хүн байвал зааж сургаж, өвлүүлэх боломжтой гэж үздэг. Мөн тэд орчин үеийн анагаах ухаантай өөрсдийн арга ухааныг ихээхэн хослуулж байна. Жишээлбэл, яс барьж боосныхоо дараа заавал аймаг, хот орж зураг авхуулахыг зөвлөх, өвчтөнтэй байнга холбогдож биеийг нь асуух, зарим үед эргэн очиж үзэх зэргээр ард олонд ач тусаа өгч байна.

Орчин үеийн анагаах ухааны эмч нар нутгийн бариач, уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагч нартай хамтран зарим өвчнийг анагаадаг нь судалгааны явцад тодорхой мэдэгдэж байсан юм. Энэ талаар, ялангуяа өвлөн уламжлагчид ясны хугарал, тархи толгойны доргилт, цусны өвчин, устай яр шарх, сэтгэцийн өвчнүүд дээр сумын эмнэлэг, өвлөн уламжлагч нар нь хамтрах, урьдчилсан сэргийлэх тал дээр нь дэмжих, мөн орчин үеийн эмнэлгүүд уламжлалтын тасагтай байвал зүгээр гэсэн нийтлэг саналыг өвлөн уламжлагч нар санал болгож байв. Энэ мэт илүү багтаамжтай, бусдын мэдлэг ухааны үнэлдэг, ойлгодог, хэрэглэдэг хандлага хөдөө орон нутагт их ажиглагдаж байгаа ч хот суурин газар нэг нэгнээ үгүйсгэх, үнэн зөв, жинхэнэ хуурамч гэсэн дуусахгүй маргаан өрнүүлдэг ч хүмүүс байна. Нэгэнтээ эмчлээч хүний эцсийн зорилго эмнэж, домнох юм л бол аль ашиг тусгай арга ухаанд нээлттэй, хүлээцтэй хандах нь нэн тэргүүний зорилго байх ёстой болохоор өөрийгөө "жинхэнэ, мундаг, чаддаг" гэдгийг нотлох нь чухал биш болов уу.

Уламжлалт арга ухаанаа цаашид өвлүүлэхгүй, өвлүүлэх бодолгүй байгаадаа бус, увдис, чадвар үнэхээр байдаг бол өөрөө сурна, өөрөө гартаа юмтай бол заавал хэн нэгнээр заалгах шаардлагагүй гэх хандлага ажиглагдаж байна. Зарим арга ухааны хувьд хичээл зүтгэл бус, цаанаас заяагдмал увдис байна гэж үздэг учраас өөрийнх нь удмаас бариач төрөн гарна гэдэгт итгэдэг байна. Өөрөө эцэг эхээсээ сураагүй учраас хэн нэгэнд зааж сургалгүй, тэд нь өөрсдөө чадвартай болж, бариач болно гэдэгт итгэсээр байгаа юм. Сүүлийн үед уламжлалт анагаах ухааны бариа засал, эмийн ургамлаар анагаах 2 нь анагаах ухааны анхан шатны хэлбэр болж, хөдөө орон нутагт идэвхтэй хэрэглэгдсэн хэвээр байна.



#### 4. ДҮГНЭЛТ

Монголын уламжлалт анагаах ухааны ай савд “бариа заслын арга”-аар анагаах арга ухаан, “мал амьтны эд эрхтэн”-ээр анагаах арга ухаан, “ургамлын зүйлээр анагаах” арга ухаан, “дом шившлэг”-ийн аргаар анагаах арга ухаан, “зүү тавих” арга ухаан, “хануур хийх” арга ухаан, “төөнүүр хийх” арга ухаан, “тан бэлдэх” арга ухаан, “гүрэм дом”-ын арга ухааны төрөл зүйлүүд багтах бөгөөд “Соёлын Өвийн Үндэсний Төв”-ийн анхан шатны бүртгэл мэдээлэлд дээрх ай савын тавдугаар ай сав болох “Уламжлалт арга ухаан”-ы бүртгэл мэдээлэлд тус арга ухааны 500 гаруй өвлөн уламжлагч бүртгэлтэй байгаагаас ардын анагаах ухаан, арга засал хийдэг 103 хүнийг шүүж, аймаг сумдаар нь ялган тэмдэглэсэн тэмдэглэгээг хийв. Үүнд, бариа засал 53 хүн, төөнүүр хийх арга ухаан 2 хүн, эмийн ургамлаар анагаах арга ухаан 14 хүн, зүү тавих арга ухаан 1 хүн, дом шившлэгийн арга ухааны эрдэмтэй 6 хүн байгаа юм.

Энэхүү анхан шатны бүртгэл мэдээллээс харахад Монгол улсад уламжлалт анагаах ухааны арга ухааны өвлөн уламжлагч нарын ихэнх хувийг бариа заслаар анагаах арга ухаан эзэлж байгаа бөгөөд газар зүйн байрлалаас харахад төвөөс баруун тийш төвлөрөн байршсан байна. Энэ нь төвөөс холдож алсрах тусам уламжлалт анагаах ухаан нь өөрийн уугуул хэв шинжийг хадгалах, эмнэлгийн үйлчилгээ хол, хүрэлцээ муутай байх үед тухайн нутгийн ард иргэдийн хэрэглээ ч их байдгийг харуулж байгаа юм. Үүнээс гадна нийт нутгийн хэмжээнд дом засал, эмийн ургамлаар анагаах гэх арга ухаануудыг энгийн хэрэглээнд ихээхэн ашиглаж байна. Ардын анагаах ухааны өвлөн уламжлагчид нь өвлөн авсан арга ухаанаасаа хамгийн сайн сурсан арга ухаанаа буюу анагаах чадвараараа л өдий хүртэл дагнан хүн эмчилж байгаа бөгөөд бусад арга ухааныг хослуулах, хавсарган судалж, нарийн суралцаж хөгжүүлээгүй байна. Мөн монголын уламжлалт анагаах ухаан, түүний өвлөн уламжлагчдын ихэнх нь гурав, дөрөв дэх үеийн өвлөн уламжлагчид бөгөөд тэдний уламжлан авсан байдал нь улс төрийн хараат байдал, цаг үе, нийгмийн амьдралаас шалтгаалан ур чадварын хувьд өөр өөр байгаа нь ажиглагдаж байна.

Уг төслийн хүрээнд сэдвийн судлагдсан байдал, хээрийн судалгааны дүгнэлт, экспертүүдийн зөвлөмж зэргийг харгалзан үзэж, монголын уламжлалт анагаах ухааны хамгийн чухал арга ухааныг дүгнэн үзвэл: Эмийн ургамлаар анагаах, бариа заслын эмчилгээ нь нүүдэлчдийн ахуй амьдрал, соёлын онцлогийг тусгасан язгуурын шинжтэй, одоо ч уламжлагдан хэрэглэгдэж буй анагаах ухааны арга ухааны уламжлалт хэлбэрүүд юм. Нүүдэлчид малыг гаршуулан тэжээсэн цагаас хойш Монгол орны экологийн олон бүс бүслүүр, өргөрөг, уртрагийн дагуу хавтгайд, уулын дээш доош босоо чиглэлд жилийн дөрвөн улирал нүүж амьдрахдаа эмийн ургамлыг таньж тогтоож, өвчтэй мал ан амьтныг ажиглан, тэдний хэрэглэж буй эмт ургамал, өвсний ашиг тусыг мэдэж, хүн малыг эмчлэх мэдлэг болгон хуримтлуулсан юм. Мөн мал аж ахуйг адгуулан, ашиг шимийг нь хүртэж байх явцдаа малын анатомийн мэдлэгийг нарийн эзэмшиж, улмаар малыг эдлэх унах явцад хүн болон малд гарч буй бэртэл гэмтлийг барьж эвлүүлэх, байранд нь оруулах зэргээр бариа заслын мэдлэгийг бий болгон өвлүүлсэн байна.

Зарим тохиолдолд дээрх уламжлалт арга ухаан нь хоорондын хамаарал бүхий нэгэн цогц байдлаар хэрэглэгддэг нь ажиглагдаж байна. Энэхүү цогц байдлаар хэрэглэгдэж байгаа нь бидний ажигласнаар уламжлалт анагаах ухааны сургууль, эмнэлгүүд дээрх аргуудыг өөр хооронд нь ихээхэн зохицуулан хэрэглэгдэг байна. Дээрх хоёр уламжлалт эмчилгээний аргыг ЮНЕСКО-д бүртгүүлэх суурь судалгааг бид хийж байна. Эдгээр 2 арга ухаан нь нүүдэлчин монголчуудын дунд орчин үеийн анагаах ухаантай зэрэгцэн оршиж, хэрэглээ болон өвчтөнд үзүүлж буй нөлөөлөл нь ихээхэн ач тустай нь бидний судалгаанаас харагдаж байна. Сүүлийн жилүүдэд уламжлалт анагаах ухаан хөгжиж байгаа бөгөөд АШУҮИС-ийн элсэлт болоод уламжлалт анагаах ухааны Оточ манрамба их сургууль зэргийн төгсөлт зэргээс уламжлалт анагаах ухаан хэрхэн хөгжиж байгаа нь харагдаж байна. тухайлбал оточ манрамба их сургууль нь 21 дэх удаагийн төгсөлтөөр Уламжлалт анагаах ухааны хүний их эмч 697, УАУ-ы Сувилагч 59, Эм зүйч 21, Уламжлалт анагаах ухааны 98 магистрыг тус тус бэлтгэн гаргаад байна<sup>34</sup>. Уламжлалт анагаах ухааны их дээд сургуулиуд ихээхэн хөгжсөнөөр монголын уламжлалт анагаах ухаан хүлээн зөвшөөрөгдөх чухал ач холбогдолтой нь ажиглагдаж байна.

---

<sup>34</sup> <https://otoch.edu.mn/>

## 5. НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. *Авирмэд, С., Сээсрэгдорж, С. (2014). Гүн Гомбожавын “Эмийн нэршлийн Төвөд, Хятад хэлний хадмал оршвой” зохиол дахь амьтны гаралтай эмийн түүхий эдийн нэршлийг бусад зохиолуудын зохих хэсэгтэй харьцуулсан үр дүн// Шинжлэх ухаан, танин мэдэхүйн “Дорно дахины уламжлалт анагаах ухаан” сэтгүүл, Дугаар 6, 2014(IV), 25-32*
2. *Агваандондов, Ш. (1991). Монгол хар домын судруудын чуулга. Улаанбаатар: Армийн хэвлэх үйлдвэр*
3. *Алимаа, Т. (2010). Амьтны гаралтай зарим нэгдлүүдийн модификаци үйлдлийг идээ ундаан засалтай холбон судалсан дүн. Анагаах ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. ЭША-ын удирдагч: Акад. Н.Төмөрбаатар, АШУ-ы доктор, проф. Ч.Чимэдрагчаа, Улаанбаатар*
4. *Амбага, М., Саранцэцэг, Б. (2002). Уламжлалт анагаах ухааны онолын зарим асуудлыг эс, мембран, молекулийн түвшинд тайлбарлах нь. Улаанбаатар: Соёмбо Принтинг*
5. *Анагаах ухааны дөрвөн үндэс. (1991). Орч. Х. Тумбаа, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар*
6. *Баавгай, Ч., Болдсайхан, Б. (1990). Монголын уламжлалт анагаах ухаан. Ред. Д. Батчулуун, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар*
7. *Батмөнх, Б. (2005). Монголчуудын уламжлалт ан ав (XIX-XX зууны зааг дахь Ойрад монголчуудын жишээн дээр). Улаанбаатар: Соёмбо принтинг*
8. *Баттогтох, Б. (1991). Эмгэг согог бүхнийг эдгээн илаарьшуулагч эм дом тарнийн судар. Улаанбаатар: “Нууц товчоо” хэвлэлийн нүүс*
9. *Болд, Ш. (2005). Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар*
10. *Болд, Ш. (2006). Монголын уламжлалт анагаах ухааны түүх. Улаанбаатар: Адмон Принт*
11. *Болд, Ш., Цэрэнсодном, Д. (2013). Монголын уламжлалт анагаах ухааны тайлбарт дээж бичиг. Улаанбаатар: Адмон принт*
12. *Володя, Ц., Цэрэнбалжир, Д., Ламжав, Ц. (2008). Монгол орны эмийн ургамал. Ред. Б. Дагвавцэрэн, Улаанбаатар: Адмон*
13. *Галбаабадраа, Л. (2009). Уламжлалт анагаах ухааны дом засалд суралцагчдын гарын авлага. Улаанбаатар: Адмон*
14. *Ганбаяр, Я. (2001). Монгол эмийн жорын гарын авлага. Улаанбаатар: Бит сервис*
15. *Ганбаяр, Я. (2010). Монгол эмийн жорын хувилбар нэрийн түүвэр. Улаанбаатар: Битпресс*
16. *Ганбаяр, Я. (2010). Уламжлалт монгол засал. Улаанбаатар: Битпресс*

17. Ганбаяр, Я., Төмөрбаатар, Н. (2003). Монголын уламжлалт анагаах ухааны онолын үндэс. Улаанбаатар: Бит сервис
18. Гонгор, Д. (1996). Тарваганд хаях муу юм байхгүй. Улаанбаатар: Есөн Эрдэнэ
19. Дагвацэрэн, Б., Хишигжаргал, Л нар. (2003). Уламжлалт эмт бодис, жорын хяналтын лавламж. Улаанбаатар. 2003
20. Дандаржав, Д., Байгалмаа, Р. (1992). Монгол ардын эмнэлгийн жор. Өндөрхаан хот
21. Дэжидмаа, Б., Чимэдрагчаа, Ч. (2012). Цусны бүлэгнэлтэд нөлөөтэй эмийн ургамал, уламжлалт жор найрлагын судалгаа// Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүл. 2012(4)21, 54-56
22. Дэсрид Санжайжамц. Манаг Лхантав буюу Увдисын үндэсний нэмсэн арга. Модон барын төвд судар.
23. Дэсрид Санжайжамц. Рашааны шимийн найман гишүүнт нууц увдисын үндэсний тайлбар хөх биндэргяа. Модон барын төвд судар.
24. Жамбалдорж. Анагаан үйлдэгч рашааныг эндүүрэлгүй танин барих уран толинд асар номлосон Үзэсгэлэнт нүдний чимэг оривой. Төвд хэлээр модон барын судар.
25. Жигмэдданзанжамц. (2011). Үзэгсдийн баясал буюу Тунгааганжид. Улаанбаатар
26. Жигмэддорж, Урт, Нүгнайжав нар. (1986). Амьтны зурагт толь. Тунлиао хотын хэвлэлийн хороо
27. Зориг, Г. (1989). Алтайн хойлог. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
28. Ичинхорлоо, М. (2012). Амьтнаар анагаах уламжлал ба орчин үе// Эрдмийн хэлхээ. Боть I, Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв. Улаанбаатар: Удам соёл, 72-76
29. Ииданзанваанжил. (2011). Уламжлалт анагаах ухааны дөхөм эмчилгээний гар дэвтэр буюу Жүрүтүшил. Хөрвүүлсэн Б. Намтай, Ч. Чимэдрагчаа. Улаанбаатар
30. Лүнриг Дандар. (1999). Анагаах ухааны дөрвөн үндэсний бэрх үгийн утгыг тайлбарласан намжил арурийн эрхсийн үзэсгэлэнт чимэг оривой. Орч. И. Дэмбэрэл, П. Оюунбаатар, Улаанбаатар
31. Lonsangcültüm. (1998). Em taniqui uqayan. KökeQota: ündüsüten-ü keblel-ün qorig-a
32. Пүрэв, Т. (2009). Монгол уламжлалт анагаах ухаан. Улаанбаатар: Адмон Принт
33. Төмөрбаатар, Н., Хатанбаатар, Ж., Цэрэндагва, Д. (2006). Уламжлалт анагаахын суурь мэдлэг. Улаанбаатар: Мөнхийн үсэг
34. Уламжлалт эмийн технологи /номхотгол/, үйлдвэрлэл, стандартын судалгааны эрдмийн бүтээл. (2013). Боть 5. Ред. Ч. Чимэдрагчаа, Улаанбаатар: Мөнхийн үсэг
35. Хайдав, Ц. (1982). Ардын эмнэлэгт хэрэглэж байсан амьтны гаралтай эм. Улаанбаатар. ШУА-ийн ХҮ
36. Хайдав, Ц., Чойжамц, Д. (1965). Монгол анагаах ухаанд хэрэглэгддэг эмийн ургамлын нэр// Улсын нэр томъёоны комиссын мэдээ. Улаанбаатар. ШУА-ийн ХҮ
37. Хишигээ, Д., Оюун, З. (2013). Уламжлалт анагаах ухааны эмт бодис, эм тангийн химийн судалгааны эрдмийн бүтээл. IV Боть. Улаанбаатар

38. Хүрэлчулуун, Б., Батчимэг, Ө. (2004). Монгол эмд хэрэглэдэг гадаад ургамлын түүхий эд. Улаанбаатар: ЭМШУИС-ийн Эрхэс ХГ
39. Хүрэлчулуун, Б., Батчимэг, Ө. (2006). Монгол орны ургамлын гаралтай зарим түүхий эдийн лавламж. Улаанбаатар
40. Цэрэнсодном, Д. (2007). Монгол эм домын засал. Улаанбаатар
41. Чагданхорлоо, Х., Алимаа, Т., Цэрэнцоо, Б., Дагвацэрэн, Б. (2014). Эм таних ухаанд монголчуудын оруулсан хувь нэмрийг судлах асуудалд// Шинжлэх ухаан, танин мэдэхүйн “Дорно дахины уламжлалт анагаах ухаан” сэтгүүл, Дугаар 6, 2014(IV), 97-103
42. ШУА-ийн Эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны 2019 оны тайлан. (2019). Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан
43. Эмийн жор. (2012). Монгол анагаах ухааны сонгомол” цуврал бичиг. Улаанбаатар
44. Юй Чин Шиян. (1990). Монгол эмийн жор. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар

Англи хэлээр:

45. Filin S.A. (2017). 'The Formation of The European Healthcare Systems and Veterinary Medicine in Mongolia in The 19th-20th Centuries'. *History of Medicine* 4(1): 43–50.
46. Gunbilig, D. and Boland, W., (2009). 'Defensive Agents of *Blaps femoralis*, a Traditional Mongolian Medicinal Insect'. *Scientia Pharmaceutica*, 77(3): 597-604.
47. Gunbilig, Disan and Rentsendorj, Ulziinyam. (2016). "Phytopharmaceuticals in Mongolia: Past, Present, and Future" *Erforschung biologischer Ressourcen der Mongolei*. ISSN 0440-1298. 162.
48. Meserve, R., (2003). 'On the History of Medicinal Plant Research in Mongolia'. *Studia Orientalia Electronica*, 97, pp.155-168.
49. Pitschmann, A., Purevsuren, S., Obmann, A., Natsagdorj, D., Gunbilig, D., Narantuya, S., Kletter, C. and Glasl, S., (2013). 'Traditional Mongolian medicine: history and status quo'. *Phytochemistry reviews*, 12(4): 943-959.
50. Saijirahu, B., (2008). 'Folk Medicine Among the Mongols in Inner Mongolia'. *Asian Medicine*, 4(2): 338-356.
51. Ruhlmann, Sandrine. (2018). 'Dealing with highly contagious animal diseases under neoliberal governmentality in Mongolia'. *Medicine Anthropology Theory* 5(3): 99–129.
52. Pitschmann A., S. Purevsuren, A. Obmann, D. Natsagdorj, D. Gunbilig, S. Narantuya, Ch. Kletter and S. Glasl (2013). 'Traditional Mongolian Medicine: history and status quo'. *Phytochemistry Reviews: Fundamentals and Perspectives of Natural Products Research* 12(4): 943-949.
53. Ganbayar, Ya. And N. Tumurbaatar. (2007). 'Ayurveda in Mongolia from Antiquity to 1937'. *Journal of Sasang Constitutional Medicine* 19(3): 300-307.
54. Kletter, C., Glasl, S., Thalhammer, T. And Narantuya, S., (2008). *Traditional Mongolian Medicine—a Potential for Drug Discovery*. *Scientia Pharmaceutica*, 76(1): 49-64.

## 6. Хавсралт.

### Хавсралт 1. Монголын уламжлалт анагаах ухааны экспертүүдийн ярилцлага зөвлөмж

Монголын уламжлалт анагаах ухааны чухам ямар ай савыг нэн тэргүүнд чухалчлан үзэх тухай бид энэ салбарын эксперт 3 хүнээс хээрийн судалгаанд явахын өмнө зөвлөгөө, мэдээлэл авсан юм. Үүнд, Манба дацан хийдийн тэргүүн хамба Д. Нацагдорж, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн захирал Д. Цэнд-Аюуш, Монг-Эм эмнэлгийн эмч З. Мэндсайхан нарыг хамрууллаа. Тэдний хувьд хамгийн түрүүн энэхүү судалгааны зорилго, судалгааны баг бүрэлдэхүүнийг илт сонирхож байсан бөгөөд өөрсдийн зүгээс хамтран ажиллаж болох эсэх тухай асууж байв. Мөн тус бүр уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх, аль нэг хэсгийг ЮНЕСКО-д бүртгүүлэх талаар монгол улсын төр, яам, тамгын газруудад хүсэлт тавьсан талаараа ярьцгааж байлаа.

Эдгээр экспертүүдтэй уулзаж, өнөөгийн монголчуудын дунд уламжлагдаж ирсэн уламжлалт анагаах ухааны эрдэм ухаан, тэдгээрийг өвлөн уламжлагчдын тухай санаа бодлыг нь сонсоход дараах хариултуудыг өгч байв.

*“Одоо манайхан ардын эмнэлэг гэхээр бариа заслын эмнэлэг гаргаад ирж байна. Энэ чинь жаахан хэсэг нь. Тэр дотор чинь хануур, зүү нь орчхож байгаа юм. Хэдийгээр зүү нь Хятадынх ч гэсэн тэрийг бол манайх олон жил хэрэглэсэн. Монголын уламжлалт анагаах ухаан гэдэг бол судалж барагдахгүй соёлын том өв. Ардын эмнэлэг гэдэг бол, тэр дотор нь дом нь орно, жишээ нь цөс нь өвдсөн хүнд тийм өвс уугаарай ч гэдэг юм уу, тэрийг хэрэглэж байгаа хүн ховор байх. Чацга алдсан хүүхдэд энийг буцалгаад өгчих гэдэг чинь ардын эмчилгээнд орчхож байгаа юм. Тэр алслагдсан хөдөө орон нутагт эмнэлэг домнолго юу билээ. 14-р зуунаас хойш монголын эрүүл мэндийн системийг авч явж байсан юм бол Төвөдөөс ирсэн уламжлалт анагаах ухаан, тэрнээс урьдах нь дом биш юм байгаа даа... Яагаад гэвэл, тэнд нүдний өвчин ч бий, чихний өвчин ч бий, яг орчин үеийн ангилал. Энэ бол судалгааны том объект болохоос биш, хүнээс та мал хатгадаг уу гэвэл хатгадаг л гэнэ. Энэ мөн л дөө. Ард түмэн энэ юмнаас аль зэрэг хэрэглэдэг юм бол доо...”* (З. Мэндсайхан) хэмээн ард түмний дунд уламжлалт анагаах ухаан ямар байр суурь эзэлж байгаа вэ, өвлөн уламжлагчид өнөө цагт бий юу, бий бол дом засал, эм тангийн талаар юу гэж зөвлөдөг бол доо гэсэн хандлагатай байв.

Харин монгол оронд аж төрж байгаа уламжлалт анагаах ухааны өвлөн уламжлагчдын талаар эрс өөр байр суурьтай байгаа нь:

*“Диплом аваагүй хүмүүс эмчилгээ хийж, судас барьж болохгүй, энэний эсрэг байдаг хүмүүс та нарын өөдөөс хараад сууж байна. Яагаад гэвэл, Монголын эрүүл мэндийн салбарын хууль дээр энэ гэр бүлээрээ “Family line” гэж байдаг тийм ээ, шаглан сургах гээд энэ хүмүүс эмчлэх эрхтэй гэсэн ганц ч эрх зүйн факт байхгүй”* (Д. Цэнд-Аюуш) гэж хэлснээр харагдах ба зөвхөн уламжлалт анагаах ухааны чиглэлээр их, дээд сургуульд суралцаж төгссөн эмчлэх эрхтэй хүн л бусдыг эмчлэх ёстой гэсэн байр суурьтай байв. Энэ

нь ч бас тодорхой нэр заан, баримтаар өгүүлэх шалтгаантай бөгөөд экспертүүд зарим жишээг тодруулан тайлбарлаж байлаа.

Бидний хээрийн судалгааны үеэр анхаарч ажиллах ёстой, цаашид ЮНЕСКО-д бүртгүүлэхэд тохиромжтой, зөвхөн монголынх байж болох уламжлалт анагаах ухааны ай савын тухай тэдний зөвлөсөн нь харилцан адилгүй байсан юм. Тухайлбал, Д. Нацагдорж:

*“Раашааны шим, Найман гишүүн, Нууц жүрдийн дамжлага гэх судар байна. Ийм хөлгөн судар байгаа, энийгээ зүтгүүлэх хэрэгтэй. Надаас одоо ийм санал орж ирсэн гэж бичиж тэмдэглэх хэрэгтэй. Энэ Монголын урдаа барих хамгийн түрүүнд бүртгүүлэх ёстой шаанс [chance] энэ байгаа шүү”* хэмээсэн нь биет бус соёлын өвд биш, биет соёлын өвд орох тул бидний зорилгоос өөр юм. Мөн тэр бээр:

*“Тарнийн эмчилгээ, тарнийн анагаах ухаан гээд тарни судлаад хүнийг тарни бясалгалын аргаар эмчилдэг. Энийг гаргаж ирэх хэрэгтэй. Би бол тарниар ажилладаггүй, аймар олон хүмүүсийг тарниар эдгээнэ. Энэ сэтгэцийн өвчнүүдийг, уналт таталт бүгд тарни ордог шүү. Лусын өвчин тарни ордог гэх мэт энэ олон өвчнийг бид одоо болтол тарниа авч явсан. Энэ их тарнийн өв соёлыг болтол одоо авч явж байна. Уламжлалт анагаах ухаанаар “сахар” яаж эдгээдэг, “бамбай” өвчин тарниаар байдаг шүү дээ. Хүмүүс юун тарни гэдэг. Гэтэл одоо энэ бамбайны асуудалтай хүнд “гүрэм” тарни орж байгаа байхгүй юу. Тэр хүмүүст тарни бичээд өгнө, тэр тарниа уншиж байгаа. Би өөрөө “гүрэм” хийж өгдөг, тэгээд эмчилгээ явуулна. Төвөдүүдээс өмнө тарнийн эмчилгээ гээд баруунд одоо эмчилгээ гарчхаад байна, Төвөдийн ринбүүчи нар очоод заагаад байна. Тийм учраас бид нар бол тусгаар тогтносон Монгол улс бол одоо бид нар энэ үүлэн чөлөөний завсарт л хийх хэрэгтэй”* хэмээн саналаа хэлэв. Д. Цэнд-Аюушийн зөвлөсөн нь:

*“Манайх шиг цаг ууртай газар хаана ч байхгүй Энэтхэг хүнийг Монгол хүнтэй харьцуулж оношилно гэж байхгүй. Эмийн ургамал, газар тариалан, экологи шал өөр байгаа. Гэхдээ family line хар домын аргаар орж ирсэн арга ухаан зэргийг та нар их сайн цуглуулах байх л даа. Би бол ингээрэй тэгээрэй гэж юм хэлж чадахгүй нь, гэхдээ бидний байр суурь бол ЮНЕСКО-д бүртгүүлэх өв бол монголчуудын өөрийнх нь оюуны хөрөнгө оруулалт, хийсэн ном судар, эмчилгээний аргууд байна”* хэмээсэн нь дээрх Д. Нацагдорж гуайн яриатай адилаар бөгөөд монгол эрдэмтэн маарамба нарын бүтээсэн ном судрыг үнэлэх ёстойг дахин сануулсан юм. Мөн тэрээр монгол эм тан бэлтгэх аргыг өвлөж авах, эс тэгвээс өвлөн тээгчтэйгээ хамт устаж үгүй болдгийг судлах нэн шаардлагатайг хэлж байлаа.

*“Манай нэг оюутан эм номхотгодог аргуудыг Хөвсгөл рүү очоод нэг өвөөгөөс сураад ирэх жишээтэй. Тэгэхгүй бол тэр өвөө, тэр мэдлэг дадлагаа өөртэйгөө аваад өнгөрчих гээд байгаа юм. Тэр өвөөд чинь сургууль байхгүй, эмийн үйлдвэр байхгүй. Тиймээс авч үлдэх мэдлэг оюун байгаа”* (Д. Цэнд-Аюуш) гэж байлаа.

Домын арга заслын тухай З. Мэндсайхан “боломжгүй” хэмээн хэлсэн бөгөөд эмээр эмнэх аргыг илүүтэй боломжтой гэж байв. Тэрээр:

*“Манайд бол нэг их домноод эмчлээд байсан юм байхгүй. “Та уламжлалтын эм хэрэглэдэг үү” гэж асуух хэрэгтэй, зүү бол Хятадын юм. Идээ ундаа, дом, эм, засал гэсэн*

*дөрвөн арга байдаг юм. Идээ ундаагаа ч барьж мэдэхээ байчихсан, сүүлд Европтой холилдоод мах битгий ид гэж “донгосдог” болчихсон байхгүй юу. Та нарын судалгааны сэдэв бол домоор юм хийгээд мэдэх ч үгүй, сайндаа л Тарган бандидагийн, Өвөрхангайн хүн шүүдээ, тэр хүн их юм хийдэг. Тэр хүн мал хатгах зэрэг эмчилгээний юм их хийсэн. Жишээ нь, мал хатгах гэдэг бол яг уламжлалт анагаах заслын нэг гэж явдаг”* гэхчлэн эм хэрэглэх талаар асуухыг зөвлөсөн юм.



Дээрх экспертүүдийн ярианаас нэгтгэн харвал, монголын уламжлалт анагаах ухаан нь олон зуун жилийн түүхтэй боловч өнөө үед буюу техник технологийн эрин зуунд тохирох эсэх талаар маргаан дэгдэж эхэлж байгааг мэдэж болно. Мөн нийслэл хотод уламжлалт анагаах ухааны төвүүд, эмнэлгүүд байх боловч тэнд ажиллаж буй эмч, сувилагчид сургуулийн боловсролоор мэдлэг, ур чадвар эзэмшсэн нь дийлэнх байдаг, гэтэл хөдөө орон нутагт зөвшөөрөлгүй хэдий ч анагааж байгаа өвлөн уламжлагчид нь үе дамжсан, “гартаа юмтай” хүмүүс байдаг зэрэг ялгаа нь энэхүү салбарыг нэгэн цул болгохгүй байгааг харж болно. Хөдөө орон нутагт байгаа өвлөн уламжлагчдын чадвар болон эмчлэх эрхийн талаар экспертүүд ихэд санаа зовниж буй нь мэдэгдэж байна.

Монголын уламжлалт анагаах ухааны доторх 8 ай саваас чухам алиныг сонгох талаар дээрх экспертүүдээс нэгдсэн санал гарч чадаагүй ба өөр өөрсдийн санал болгож буй арга ухаанаа л “боломж” хэмээн харж байсан юм.



## Хавсралт 2. Хээрийн судалгааны ажил 1


Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл 21 аймгийн бүртгэл мэдээлэл дээр үндэслэн 2022 оны 04-25-наас 05-17 хүртэл нийт 4 аймгийн 12 суманд хээрийн судалгааны баг ажилласан. Уг хээрийн судалгаагаар Соёлын өвийн бүртгэл дээрээс гадна Аймгуудын Соёл Урлагийн газрын бүртгэл мэдээллийг ашиглаж, зарим өвлөн уламжлагчдыг шинээр бүртгэх, Соёлын өвийн үндэсний мэдээлэлд бүртгэгдээгүй хүмүүстэй уулзаж ярилцсан. Хээрийн судалгаанд нийт 15 хоногийн хугацаанд 3500 км замыг НСИСОУХ-ийн судалгааны баг бүрэлдэхүүн туулж, хийж гүйцэтгэсэн болно.



Уг судалгаагаар соёлын биет бус өвийн уламжлалт арга ухаанд бүртгэлтэй 5 өвлөн уламжлагч, соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид бүртгэгдээгүй 7 өвлөн уламжлагч нартай уулзан ярилцаж, дуу дүрс бичлэгээр баталгаажуулсан. Үүнд Өвөрхангай аймаг Есөнзүйл сум Л.Цэцэгмаа, Өвөрхангай аймаг Тарагт сум А.Шоовдор, Баянхонгор аймаг Баянхонгор Ж. Цагаанмуна, Баянхонгор аймаг Хүрээмарал сум Б.Болдбаатар, Баянхонгор аймаг Баянбулаг сумын М.Батболд, Д.Жадамба, Завхан аймаг Шилүүстэй сум, Завхан аймаг Цагаан хайрхан сум Ж.Цээнцогзол, Л.Ууганбаяр, Завхан аймаг Улиастай Д.Дэмчиг, Д.Сувдаа, Завхан аймаг Идэр сум Нарантуяа Завхан аймаг Тэлмэн сум, Завхан аймаг Сонгино сум Б.Цэндсүрэн Завхан аймаг Тосонцэнгэл сум М.Цэвэгжав, Архангай аймаг Цахир сум, Архангай аймаг Өндөр-Улаан сум Ч.Идэрмөнх, Ч.Эрдэнэсүх нар, Архангай аймаг Цэцэрлэг зэрэг суманд ардын анагаах ухааны өвлөн уламжлагч нартай уулзсан.

### Хавсралт 3. Хээрийн судалгаа 2

2022 оны 06 сарын 04-ний өдрөөс 06 сарын 16-ны хооронд Увс, Баян-өлгий, Ховд, Говь-Алтай зэрэг аймгийн нутагт ажилласан. Уг хээрийн судалгаагаар уламжлалт бариа засал, дом шивилэг, ургамлаар анагаах зэрэг нийт 10 хүнтэй уулзаж, ярилцлага бичлэг хийсэн. Увс аймгийн Завхан, Тариалан, Ховд, Баян-Өлгий аймгийн Өлгий, Алтанцөгц, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Бигэр суманд ажилласан.



Ажилласан газрын тэмдэглэл

№	Очсон газрын нэр	Очсон сар, өдөр	Буцсан сар, өдөр	Гарын үсэг (тэмгэ)
1	Увс - Завхан	06.04	06.05	[Signature]
2	Увс - Тариалан	06.05	06.06	[Signature]
3	Увс - Ховд	06.06	06.07	[Signature]
4	Увс - Ховд	06.08	06.10	[Signature]
5	Баян-Өлгий	06.10	06.12	[Signature]
6	Ховд	06.12	06.13	[Signature]
7	Говь-Алтай	06.13	06.14	[Signature]
8	Говь-Алтай	06.14	06.15	[Signature]

Увс аймгийн Завхан сум Ш. Алтанчимэг 40 настай эмэгтэй, Увс аймгийн Улаангом сум Ш. Бадамсамбуу 63 настай эрэгтэй, Цэвээн 70 настай эрэгтэй Увс аймгийн Тариалан сум Б. Цэвэгжав, Увс аймгийн Ховд сум А. Назгүл эмэгтэй, Баян өлгий аймгийн Өлгий сум С. Жамела 70 настай эмэгтэй, Ногооннуур сумын харьяа Б. Жазера 72 настай, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын харьяа Ц. Адууч 62 настай эрэгтэй, Говь-Алтай Бигэр Б. Мөнхнайрамдал 26 настай эрэгтэй /лам/, Говь-Алтай аймаг Богд сумын харьяа Д.Одонхүү эрэгтэй зэрэг хүмүүс судалгаанд хамрагдсан болно.

Хавсралт 4. Нутагшил, байршлын хүснэгт

д/д	Өвийн нэр, төрөл	Өвийг үйлдсэн газар, байршил, хугацаа GPS	Баримтжуулалт хийсэн хугацаа	Үйлдсэн хүний нэр, нас хүйс, Регистр	Бичлэг ийн хэмжээ (GB)	Гэрэл зургийн тоо (GB)	Гэрэл зураг, дүрс бичлэг хийхэд ашигласан камер	Тайлбар
1.	Бариа засал	Өвөрхангай,Е сөнзүйл сум 46° 45' 38" N 103° 30' 26" E	2022 оны 4 сарын 25	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	17.4 GB	3 зураг (32.1 MB)	Canon 90 D	
2.	Бариа засал	Өвөрхангай,Т арагт 46° 18' 08" N 102° 26' 46" E	2022 оны 4 сарын 26	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	22GB	3 зураг (34.1 MB)	Canon 90 D	
3.	Ургамлаар анагаах	Баянхонгор 46° 10' 47" N 100° 43' 18" E	2022 оны 4 сарын 27	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	8.3GB	3 зураг (36.6 MB)	Canon 90 D	
4.	Бариа засал, Ургамлаар анагаах	Баянхонгор, Хүрээмарал 46° 24' 33" N 98° 16' 56" E	2022 оны 4 сарын 28	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	12.8GB	3 зураг (28.8MB)	Canon 90 D	
5.	Бариа засал	Баянхонгор, Баянбулаг	2022 оны 4 сарын 29	Г.Зулбаатар 31 настай	7.4GB	3 зураг (29.7 MB)	Canon 90 D	

		46° 48' 39" N 98° 05' 28" E		эрэгтэй ФЖ 91061510		МВ)		
6.		Завхан, Шилүүстэй 46° 48' 01" N 97° 11' 49" E	2022 оны 4 сарын 30	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510			Canon 90 D	
7.	Бариа засал	Завхан, Цагаанхайрх ан 47° 29' 42" N 96° 47' 38" E	2022 оны 5 сарын 01	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	8.9GB	3 зураг (33.4 МВ)	Canon 90 D	
8.	Тан бэлтгэх	Завхан, Улиастай 47° 44' 46" N 96° 49' 25" E	2022 оны 5 сарын 02	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	10.4G B	3 зураг (30.3 МВ)	Canon 90 D	
9.	Ургамл аар анагаах	Завхан, Идэр 48° 13' 09" N 97° 22' 29" E	2022 оны 5 сарын 03	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	13.1G B	3 зураг (32.6 МВ)	Canon 90 D	
10.		Завхан, Тэлмэ н 48° 38' 36" N 97° 36' 45" E		Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	6.9GB		Canon 90 D	Цаг агаарын саатал, байгалийн давагдашгүй хүчин зүйл.
11.	Тан бэлтгэх	Завхан, Сонгино 49° 01' 24" N 95° 55' 55" E	2022 оны 5 сарын 04	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	13.5G B	3 зураг (27.15 МВ)	Canon 90 D	
12.	Гүрэм засал	Завхан, Тосонцэнгэл 48° 45' 30" N	2022 оны 5 сарын 04	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй	16.64 GB	3 зураг (32.8 МВ)	Canon 90 D	

		98° 16' 38" E		ФЖ 91061510				
13.	Бариа засал	Архангай, Цахир 48° 05' 54" N 98° 52' 08" E	2022 оны 5 сарын 05	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	10.3G B	3 зураг (25.5 MB)	Canon 90 D	
14.	Бариа засал	Архангай, Өндөр-Улаан 48° 02' 30" N 100° 29' 53" E	2022 оны 5 сарын 06	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	9.81G B	3 зураг (22.9 MB)	Canon 90 D	
15.		Архангай, Цэцэрлэг 47° 54' 46" N 106° 54' 28" E	2022 оны 5 сарын 08	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510			Canon 90 D	
16.	Бариа засал, Дом шивилэ г	Увс, Завхан 48° 49' 04" N 93° 07' 43" E	2022 оны 6 сарын 05	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	5.76 GB	12 зураг (128.1 MB)	Canon 90 D	
17.	Бариа засал, Дом шивилэ г	Увс, Улаангом 49° 59' 50" N 92° 04' 28" E	2022 оны 6 сарын 06	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	23.4 GB	15 зураг (170.8 MB)	Canon 90 D	
18.	Бариа засал	Увс, Тариалан 49° 46' 01" N 91° 54' 45" E	2022 оны 6 сарын 07	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	11.9 GB	3 зураг (34.1 MB)	Canon 90 D	
19.	Зүү засал	Увс, Ховд 49° 16' 47" N	2022 оны 6 сарын 08	Г.Зулбаатар 31 настай	12.2 GB		Canon 90 D	

		90° 54' 35" E		эрэгтэй ФЖ 91061510				
20.	Бариа засал, Ургамл аар анагаах	Баян-Өлгий, Өлгий 48° 58' 05" N 89° 58' 01" E	2022 оны 6 сарын 10	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	20.8 GB	8 зураг (81.5 MB)	Canon 90 D	
21.	Бариа засал	Баян-Өлгий, Алтанцөгц 49° 03' 47" N 90° 27' 25" E		Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510			Canon 90 D	Алтанцөгций н хүн сарын өмнө Өлгий рүү нүүсэн. (Өлгийд уулзсан )
22.		Ховд	2022 оны 6 сарын 12	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510			Canon 90 D	Газар мэдэхгүйн улмаас төөрсөн.
23.	Бариа засал, Ургамл аар анагаах	Говь-Алтай, Бигэр 45° 42' 00" N 97° 10' 37" E	2022 оны 6 сарын 14	Г.Зулбаатар 31 настай эрэгтэй ФЖ 91061510	16.23 GB	8 зураг (78.1 MB)	Canon 90 D	

Хавсралт 5. Өвлөн уламжлагч нартай хийсэн ярилцлагууд

**Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сум, Жанцангийн Цагаанмуна**

Ца: Би анагаах ухаанд огт суралцаагүй, Эрдэнэцогт суманд ганц нэг хуучны өвлөн уламжлагч, ганц нэг барьдаг өвгөчүүл байсан юм. Тэрнээс мэдэхгүй юмаа жаахан сэдэв аваад асууж сураад л, ямар ургамал байдаг гэж сурч мэдээд л байсан юм. Тэгээд сүүл рүүгээ явсаар байгаад 40 гаран жил, бараг 50 жил энийг оролдсон. Тэгэхдээ суралцсан юм нэг ч байхгүй. Амьтан хүнээс л сурсан дуулсан юмаа сураад байсан. Дурныхаа юманд л ингээд гарч байгаа хүн л дээ. Олон ч хүн эмчиллээ, эхэндээ бол бараг практик маягаар, энэ хүнд өгвөл хор болчихгүй гэсэн юмаа өгдөг. Тэр нь нэлээн үр дүнгээ өгдөг. Тийм л юмаар эхэлсэн. Тэгээд өгсөн хүн эдгээд байхаар өөрт урам орно. Ахиж бас бодож урамшина. Энэ үедээ энэ хүн юу хэрэглэж байгаа юм, нэг шалгаад үзье гэсэн хүн та нараас өөр ирээгүй юм шүү. Тэрийг жаахан гайхдаг юм. Хүмүүс “энэ сураагүй хүн хүнийг яаж эмчлээд байна” гээд гайхна даа. Аймаг дээр зөндөө л мэргэжлийн хүмүүс байгаа шүү дээ. Чухам олон цонхтой, байшингийн дор бүр л зар дэлгэсэн залуучууд байдаг. Тэрийг би гайхаад байдаг. Тэгээд засгийн газраас энэ хүмүүсийг судал ЮНЕСКО-д бүртгүүл гэсэн. Нэг иймэрхүү л хүмүүс ингэж бас дэмжинэ гэдэг их сайн байна. Бид хэд дэмжлэггүй байсан юм. Ардчилал гараад л нэг жаахан дэлгэсэн шүү дээ. Тэр үеэс л би чинь дээшээ гарсан. Тэрнээс өмнө бол ганц нэг төмөр нүдүүр гаднаа нууцаар нүдээд сууж байсан. Ардчилал гарснаас хойш тэрийгээ чанга, чанга цохиод л хадан дээр гарчихсан. Тэр үед хөдөө байсан юм. Нүдээд бүр нэг задгай боллоо. Тэр үед сайхан болсон. Зөв юм дэмжсэн гэж боддог, уруу юм байхгүй л дээ.

**Зу: Та өөрийгөө танилцуулбал?**

Ца: Би Эрдэнэцогт сумын иргэн байсан. Одоо энд бүртгэлтэй болсон юм. Жанцангийн Цагаанмуна гэдэг хүн байна 1941 онд төрсөн.

**Зу: Та анх эм тан хийх уламжлалт анагаах ухааныг хэзээнээс сонирхсон бэ? Нутгийн хөгшчүүдээр заалгалаа гэсэн. Энэ хүмүүстэй хэзээ яаж холбогдоод сурсан бэ?**

Ца: Аймгийн төв ойр болохоор. Тэр үед бол холбогдох юм байхгүй дээ. Ер нь очиж юмаа асууж сурна. Энэ ургамал мөн үү, биш үү гээд асуух жишээтэй.

**Зу: Тэр хөгшчүүлийн нэрийг санаж байвал та хэлээч, энийг л надад их сайн зааж өгсөн ч гэдэг юм уу?**

Ца: Миний ах дүү болох Цэрэннамжил гэдэг хүн байсан юм. Сүүл үед Жигмид гэдэг хүн байсан юм. Энд байж байгаад өөдөө очсон юм, зайлуул таалал төгссөн юм. Тэр Цэрэннамжил, Жигмид гэдэг хоёр хүн надад их тус болсон. Үнэд-Орох гэж хүн бригад дээр байсан. Тэр хүн бас нэлээн тус дэм болдог байлаа. Гол хүн бол энэ гурван хүн л байгаа.

**Зу: Энэ гурван хүн маань бурхны шашинтай лам хүн байв уу? эсвэл эгэл жирийн хүн байв уу?**

Ца: Бурханы шашинтай, тангад ном уншдаг, жинхэнэ судраа дэлгэдэг улс байсан юм. Тэгээд уламжлалт анагаах талдаа намайг бодвол мэдлэгтэй тийм хүмүүс байсан

болохоор би очиж байхгүй юу. Би тэгээд 40 гаран жил яваад, одоо нас ч өндөр гарсан. Нэг эмгэнтэй байсан диваажин явсан /алдчихсан/.

**Зу: Таныг эмийн ургамлаар эмчилж байна гэж ойлгож болох уу?**

Ца: Болно.

**Зу: Энэ ургамлуудыг хамгийн анх ямар хүмүүст хэрэглүүлж байв, хэдий орчим насандаа ч гэдэг юм уу?**

Ца: Ер нь анхандаа яг тийм, тийм хүмүүс гэж хэлэхэд бас явдалтай. Миний ноорог нэг иймэрхүү л. Жишээлбэл иймэрхүү зүйл дээр нэр ус бичээд хөтөлдөг юм байдаг. Ёстой хар данс, хар ноорог ингээд л явдаг.

**Зу: Та энэ дээр бол эм тан зовуурь бүртгэсэн байна шүү дээ. Хамгийн их түгээмэл өвчин зовуурьтай хүмүүс ямар хүмүүс байгаа вэ?**

Ца: Голдуу хий ядаргаа ихтэй, сэтгэл санааны хямрал ихтэй тийм хүмүүс ирдэг. Гэхдээ цаашаа хүнд, хүнд өвчинтэй хүмүүс бий л дээ. Тэр хүмүүс бол цаашаа дээд эмнэлгээр үзүүлээд, цаашлаад л янз бүрийн мэс засалд ороод, дээгүүрээ томроод явчихна шүү дээ. Би бол наагуур ахархан жижиг өвчнүүдийг эдгээгээд явна. Одоо энэ цусны өвчин гээд бага насны хүүхдэд голдуу тохиолддог өвчин байгаа юм. Тэрийг углуургаар нь бас задалж чадаагүй байна. Голдуу эрэгтэй хүүхдүүд байдаг гэхдээ 16, 17 насны улс голдуу таардаг. Тэгээд ургамлын эм тангаас өгөхөөр заримдаа таараад шахуу өгнө. Тэгээд өнөөдөх чинь таараад тохироод эдгэнэ. Мухар олгой гэхэд л ардын анагаахаар эдгээнэ.

**Зу: Жишээлбэл та мухар олгойнд ямар эм тан өгч байна вэ?**

Ца: “Лонлонсэмбэрүү”, “өрөв зургаа”, “шижид зургаа” өгнө. Ер нь ходоодны эмүүд л дээ. Тэр эмнүүдийг өгөөд “лонлонсэмбэрүү” өгөөд хэдэн минутын дараа нь “шижид зургаа” өгнө. Хооронд нь зай нормыг нь тааруулаад өгөх юм бол эдгэрнэ. Хагалах шаардлагагүй, миний практик байгаа юм.

**Зу: Таны боловсруулж байгаа эмийн онцлог тал юу юм бэ?**

Ца: Онцлог тал гэвэл байгалийн ургамлын чанар чансааг нь алдагдуулахгүй. Боловсорч байгаа хугацаандаа их эмзэг байдаг юм. Ургамлаа хамгийн гол нь стандартын дагуу авч, нямбай сайн хэрэглэх ёстой юм.

**Зу: Одоо таны хэлж байгаа эмзэг байгааг нь авч түүх зэргийг та түрүүний гурван хүнээс сурсан уу?**

Ца: Өөрөө уншиж судалсан, тэднээс ч асууж мэдсэн.

**Зу: Та өөрөө судлахдаа ямар бүтээл ном судар ашиглаж сурсан бэ?**

Ца: “Анагаахын дөрвөн үндэс” гэдэг номоос гол уншиж байсан шүү. Тэгээд ном бий, бий.

**Зу: Дээрийн гурван хүнээс танд өвлүүлсэн ном бүтээл бий юу?**

Ца: Би өөрөө цуглуулсан ном л байдаг юм. Номоо үзүүлнэ: Энэ их чухал “Маш гайхамшигт хуримын сан”, “Монголын эм домын засал” олон улсын хоёрдугаар их хурлаар гаргасан “Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийн гурван цагийн хэлхээс” ном шүү.

**Зу: Та оролцож байв уу?**



Ца: Оролцож байсан. Уламжлалт анагаах ухааны хоёрдугаар их хурал гэж. Тэгээд нэг иймэрхүү ноорог болсон дэвтэр ном байдаг юм. Тэгээд хотын улсуудтай ярина, холбогдоно, очно. Гадаад эмийн түүхүүд авах гэж явна, голдуу ном авах гэж явдаг юм.

**Зу: Тэд нарт та зөвлөж өгч тусалж байна уу, эсвэл тэд нараас сурч байна уу?**

Ца: Тэгнэ, тэд нараас гадаад ургамал эм авах гэж явна. Захисан юмыг нь олж өгөх талаасаа явж очдог. Мэндсайхан гээд эмч, доктор, профессор хүн бий.

**Зу: Зөвхөн танай нутагт ургадаг эм ургамал байна уу, тэр эмээр эдгээдэг өвчин гэж бас байгаа юу?**

Ца: Байгаа шүү дээ. Ганц дангаар эдгээх ургамал бол цөөхөн. Энэ эм тан чинь дан ганцаар биш хажуугаас нь дэмждэг, хамждаг тийм ургамал байж бас өвчин анагаадаг.

**Зу: Эм номхотгох гэж юу байдаг вэ?**

Ца: Ургамлыг номхотгох гэж түлж номхотгох, хуурч номхотгох гэж ном дээр байгаа юм. Тийм янз бүрийн аргаар номхотгох, цагаан идээнд хийж номхотгох ч байна. Янз бүрийн хүчийг сайжруулж цаашаа зөөллөж явах аргууд байна. Хамгийн хэцүү нь жонш л байна л даа. Их хүчтэй, түлж олон хоног шатаадаг. Тэр сав бат бөх байх шаардлагатай болдог.

**Зу: Та жоншийг номхотгож хэрэглэж байна уу?**

Ца: Хэрэглэдэг юм.

**Зу: Өөрөө номхотгож байна уу?**

Ца: Өөрөө л номхотгоно.

**Зу: Та тэр арга технологийг нэг тайлбарлаж өгвөл яадаг юм бол?**

Ца: Ном дээр байгаагаар л би тайлбарлана л даа.

**Зу: Танд энэ эм номхотгох, ургамал номхотгох аргыг дээрийн хэлдэг гурван хүн зааж зөвлөж байв уу?**

Ца: Өгнө. Түлдэг л гэсэн тэрнээс цааш нэг их лавлаж аваагүй.

**Зу: Тэрнээс цааш та өөрөө лавлаж судалсан уу?**

Ца: Номоо хараад л тэгээд энэ жоншийг жишээлбэл “тэгж шатаах юм байна”. Жишээлбэл “ой модтой газар хийдэг юм байна”. Дээр үед нэг “байя” өвс шатаана гэж нэг юм байсан. Түүн шиг ой модны хормойд өнөөдхөө түлээд, сайн саван дотор хийгээд, гадуур шавраар бүрээд ч юм уу болсон болоогүйг нь өөрөө шинжлэх тийм юм байдаг юм. Тэгээд өнөөдөх чинь бүр зөөлрөөд болсон гэж үзвэл эм тандаа хэрэглэнэ. Бараг тэр хатуу зүйл имрэхэд л бяцрахаар болгож хэрэглэ гэсэн ч заалт байна. Янз бүрийн арга байгаа юм. Эмийн ургамал түүж бэлтгэхэд ганц анхаарах зүйл бол ухаад авна. Ухаж авахдаа ахиж ургах боломжийг бий болгоод, үндэснүүдийг бүрэн авахгүй үлдээгээд, буцаагаад шороогоор бүлээд, ингэж энэрэлтэй сайхан авах ёстой. Манайх бол хөдөө Өвөр-жарантад л голдуу байдаг байлаа. Цаашаа ой модтой газар руу явна. Говь бол их цөөхөн явсан. Ой модтой газар л ер нь гарч ирнэ. Наана байгаа жаахан гандуу ургамлууд ой модоо дагахаар ургачихсан байдаг. Ургах боломж бий болсон байх жишээтэй. Ургамал авсан хойноо уут саванд хийчхээд байлгаад байх юм биш. Нэг өдөржингөө байлгаад хонуулчихаад маргааш нь нөгөө ургамлаа хатаалгад оруулна

гэвэл чанар дунд алдагдсан байж байна. Тэр байтугай түүгээд талыг нь төмпөнд хийж байгаад дөрвөн цаг болоод ирэхэд дотроо халууцчихсан байх жишээтэй. Нартай үед бол тийм байдаг юм. Гол нь чанарыг алдагдуулахгүй хэрэглэх ёстой. Тэгээд нэг машины ар руу хийгээд хонон өнжин явчих юм бол тэр ашгаа өгөхгүй шүү дээ.

**Зу: Одоо та өөрийн сурсан арга ухааныг хэн нэгэнд өвлүүлж гэж бодож байгаа юу?**

Ца: Өвлөөд авчих нэг тийм хүн олдохгүй л байгаа юм. Энийг тоохгүй, учир утгыг нь мэдэхгүй, сургууль соёлоор яваад л. Одоо манай сургууль энэ уламжлалт анагаах ухааныг заадаг хичээл байхгүй учир дагалдсан байдалтай байгаа юм. Уг нь бол уламжлалт заадаг анхны мэдэгдэхүүн өгдөг хүн баймаар л байгаа юм.

**Зу: Сургуулиуд нээгдээд үйл ажиллагаа явуулж л байна.**

Ца: Хотод бол байгаа. Миний мэдэхээр “Манба дацан” гээд л төгсөөд ирсэн Баяндалай гээд банди байдаг юм. Тэр бид хоёр, надаас байхгүй зүйлээ аваад л, би нэг жаал жуул юм өгөөд л байж байдаг.

**Зу: Тэр хүүхэд таны хувьд боломжийн сурсан байна уу? Зарим нэг зүйлийг сураагүй мэдэхгүй байна уу?**

Ца: Сурах нь бол гайгүй л сурсан юм уу гэмээр байгаа юм. Архи дарс уудаггүй, нэг хэвийн тийм үг дуу цөөтэй, нэг тийм л нөхөр байдаг. Тэр хүүхдийг би гайгүй цаашаа явах боломж байгаа юм уу гэж хардаг юм. Бариа засал хийгээд байгаа юм. Тэр хүнийг боломжоор нь хангаж өгч чадахгүй юм л даа. Төгсөөд аймагт ирж байгаа хүнийг жаахан боломжоор нь хангаад өгвөл бас их зүгээр. Бариа засал хийе гэхээр байр нь гологдоод, байр түрээсэлье гэхээр тэр хүний санхүү боломж нь хүрэхгүй, тэрнээс гарах жишээтэй. Өөрөө тийм тохирсон байр боломжоо хайгаад явж байдаг юм байна лээ.

**Зу: Одоо та жонш номхотгоход хэцүү байдаг гэдэг шиг хамгийн хэцүү бүтдэг тийм эм нь ямар эм тан байна? Түүхий эд болоод танаас гарч байгаа хүчин чадал шаарддаг юм уу, тийм эмийн тухайд?**

Ца: Жонш чинь нэг тиймэрхүү л байдаг юм. Тэгээд бас нэг “манчин” гээд хортой ургамал байна. “Тамбарам” гээд бас байж байх жишээтэй, бас номхотгож байж хэрэглэнэ. Номонд заасны дагуу л номхотгоно. Их ажиллагаатай эд л дээ энэ анагаахын уламжлалт ухаан.

**Зу: Зарим хүмүүс зах үзэсгэлэнгээр эмийн ургамлуудыг тавиад буцалгаж хэрэглэнэ, ингэж хэрэглэнэ гээд байж байдаг. Энэ хүмүүсийг талаар та юу бодож байна, шууд буцалгаж хэрэглэдэг ургамал байдаг юм уу эсвэл заавал бусад ургамалтай хамтатгаж хэрэглэдэг юм уу?**

Ца: Хамтатгаж хэрэглэнэ, номхотгох шаардлагатай ургамал зөндөө байгаа. Миний түрүүний ярьдгаар баахан ургамал түүчхээд л зараад байгаа биз дээ. Энэ чинь бол миний бодлоор буруу гэж үзнэ. Хэзээ, хаанаас түүсэн, энэ жилийн юм уу, урд жилийн юм уу, яаж түүсэн, чанарыг нь алдагдуулаагүй гэдгийг тэр хүн өөрөө тайлбарлахгүй шүү дээ. Тэгэхээр зөв биш, буруу тал руу орно.

**Зу: Зааврыг нь харахаар энгийн өдрийн тэд буцалгаж ууна гэсэн зүйл байж байдаг шүү дээ.**

Ца: Тийм.

**Зу: Одоо энэ уламжлалт анагаах ухааны эм тан бэлдэх яг монголчуудынх мөн үү эсвэл Энэтхэг, Төвөдөөс авсан зүйл болов уу, энэ талаар та юу гэж бодож байна?**

Ца: Энэтхэг Төвөдөөс авсан зүйл их байдаг юм шиг байгаа юм. Олон жил уламжлалар яваад үр дүнд хүрээд гээгдэхгүй явсан ургамал олон бий л дээ.

**Зу: Та өөрийн сурсан арга ухааныг хэн нэгэнд өвлүүлэхэд танд ямар зүйлс шаардлагатай гэж та үзэж байна вэ? Түүнийг сурах чин сэтгэлтэй хүүхэд хэрэгтэй юм уу эсвэл сурья гэсэн сонирхол мэдрэмж шаардлагатай юу?**

Ца: Энийг би сурья гэсэн идэвхтэй, шаардлагатай хүн бол заалгах мэдэх талаасаа түргэн мэднэ шүү дээ. Жишээлбэл тийм хүн таараад би заалаа гэхэд газар зааж өгөх хэрэгтэй, унаа тэрэг хэрэгтэй, хаашаа ч авч явдаг юм, говь руу ч юм уу явах шаардлагатай. Тэгээд дагуулаад “ийм ургамал тэгж авдаг” гээд “ийм нэртэй ургамал дотроо хортой”, хоргүй юуг агуулсан ургамал зэргийг хэлж өгнө. Тэгэхээр бас нэлээн ажил орно шүү дээ. Зүгээр нэг өөрийн түүсэн юмыг үзүүлээд байх гол биш.

**Зу: Одоо тан дээр ихэвчлэн ямар хүмүүс ирж байна вэ?**

Ца: Тэрүүгээр, энүүгээр өвдсөн янз бүрийн л улс ирнэ шүү дээ. Эмэгтэй голдуу ирнэ.

**Зу: Орчин үеийн анагаах ухаанаар аймаг сумандаа үзүүлээд ирж байна уу эсвэл үзүүлэхээс өмнө үү?**

Ца: Янз, янз. Эмчид үзүүлээд эм уусан байгаа юм. Тэгээд тэр нь үр дүнгээ өгөөгүй хүмүүс ирнэ.

**Зу: Таны эдгээсэн хүмүүсээс “за би тийм хүнийг эдгээж байсан шүү” гээд өөрөөрөө бахархаж дурдвал?**

Ца: Тэр дотроос дурдвал бөөрний дутагдалд ороод хойд эмнэлэг гаргасан хүнийг эдгээсэн. Бөөрний дутагдал болоод бөөр нь ямар ч ажиллагаагүй, бүр хэвтэрт орсон залуу хүн над дээр ирээд би эм өгсөн. Өгөөд л байсан, өгөөд л байсан. 2, 3 өгөөд сүүлдээ гайгүй сайн болоод тэгээд л эдгээсэн. Тэрнээс хойш нэлээн хэдэн жил болж байгаа. Мухар олгой гээд ирсэн бас эдгээсэн. Түрүүн цусны өвчин гэж ярьсан, цусны өвчтэй хүмүүс бол нэлээн хэдийг эдгээсэн.

**Зу: Одоо тэр эдгэсэн хүмүүс танд эдийн засгийн хувьд мөнгө өгөх үү эсвэл та өөрийн зориулсан эмийг бэлдээд өгч байна уу?**

Ца: Бэлдээд өгнө, зарим нь бол сэтгэлээсээ өгнө. Зарим нь энэ ямар үнэтэй вэ, үнээ хэл гэнэ. За тэгээд арван хэдэн цаас сайндаа өгнө дөө. Одоо энэ “Мон эм”, “Улаанбаатар сувилал”, “Манба дацан” гээд цаанаасаа эмийн ургамал авчирдаг. Эд нар хятад голдуу байдаг юм болов уу. Үнэ ихтэй. Тэгээд тэр үнэ ихтэй юмыг чинь би авна даа. Захисан юмыг нь аваачиж өгөөд жаахан татуу байдаг юм.

**Зу: Одоо Монгол улсад ургаж байгаа хамгийн ховор эмийн ургамал, нэг хэсэг таныг залуу байхад ургаж байгаад одоо ургахаа болиод ховордож байгаа аль эсвэл овоо ургаж байгаад одоо ургахаа больсон ийм зүйлийн ургамал байна уу?**

Ца: Байгаа, тэгэхээр ховор ургацтай ургамал бол бүжиг, сараана гээд ургамал байгаа.

**Зу:**Одоо энэ уламжлалт анагаах ухаан дээр таны гаргасан энэ зүйл шинэ байх магадлалтай гэсэн тийм зүйл байгаа юу? Таны туршилтаас, энийг үүнтэй холиод үзье гэсэн тийм зүйл байгаа юу?

Ца:Үгүй, үзээгүй. Нэг их туршаагүй шүү.

**Зу:** Одоо та энэ арга ухааныг хэн нэгэнд өвлүүлэх бол танд тогтсон арга ухаан мэдлэг хуримтлагдсан гэж үзэж байна уу?

Ца: Их юм хуримтлагдана даа. Одоо жишээ нь би чамд заалаа гэхэд эндээс эхлэх үү гэж байгаад заана. Тэгээд эхлээд хийх заавар зөвлөгөө орно, яаж хамгаалах, хадгалуулах уу, хэдэн сард яаж авах уу гээд явах шаардлагатай.

**Зу:** Та өөрийн арга ухааныг ном бүтээл болгох юм уу, олон нийтэд түгээе гэсэн бодол байдаг уу?

Ца: Байгаад боломж олдохгүй юм чинь яах вэ. Ганц өвгөн энд сууж байна, хажуугаас дэмжлэг байхгүй.

**Зу:** Одоо тэр жонш номхотгох ч юм уу тэрийг эмийн үйлдвэрүүд яаж номхотгодог юм, тэр олон тооны ургамлыг номхотгож болдог юм уу, үгүй юм уу гэдэг бас асуудал шүү дээ. Шинж чанараа алдах юм уу, жишээлбэл дөрвөн цаг болоод шинж чанараа алддаг гэж байсан. Тэгэхээр энэ бүх зүйлийг өвлөн уламжлуулах арга байна уу. Танд бол өвлөн уламжлуулах хүсэл байгаа. Энэ дээр дэмжлэг дутагдаж байна гэж ойлгож болох уу?

Ца: Бололгүй яах вэ, яг жоншийг бол номхотгоод авсан байхад буцаж шинж чанараа алдах нь удаан л даа. Номхотгоно гэдэг чинь энэ жил номхотгоод хоёр жил ахиад хэрэглэх боломж байгаа юм. Нэг л номхотгочихвол болно. Номхотгох бол их чухал.

**Зу:** Хамгийн энгийн мөртөө хүнд ач тустай ургамал ямар ургамал байна?

Ца: Ургамал бол бүгд л ач тустай. Дотроо хүчтэй, чадалтай ургамал бол “тамбарам”, “манчин” гээд тэгээд энэ говь руу ургана. Ер нь үндэслэг ургамлууд сайн байдаг шиг санагддаг. Бамбай бол тайвшрал өгдөг ургамал.

**Зу:** Дан Монголд ургаж байгаа ургамлууд нэгдээд нэг эм болж байгаа зүйл байна уу, гаднаас огт авахгүйгээр?

Ца: Цөөхөн байх. Манай оронд ургадаг гэвэл цөөхөн найрлагатай байж болно. Олон найрлагатай бол холоос авдаг эмийн ургамал орж байгаа юм.

**Зу:** Таны эмийг хэрэглэсэн хүмүүс гам барих шаардлагатай юу? Европ эм шиг уугаад унтдаг цагаар уудаг тийм зүйл байх уу? Энэ дээр ямар ялгаа байна вэ?

Ца: Гам барилгүй яах вэ “яг ингэж тийм юмаар даруулж уугаарай” гээд зааврыг нь хэлж өгнө.

**Зу:** Дээр дурдсан гурван хүнээс хамгийн чухал сурч авсан зүйл чинь юу вэ?

Ца: Хамгийн чухал гэвэл “цагаан тампурам” их чухал. Тэгээд “шар төмс” наагуур бол “нанжин гарав” гээд ургамлууд чухал байгаад байна.

**Зу:** Танд зааж байсан үед цаг үе хэцүү байсан байх. Тийм учраас танд тийм зүйлийг сайн зааж өгөөгүй болов уу гэсэн зүйл бий юу?

Ца: Нэг их задгай заагаагүй, хүний дэргэд зааж өгч чадахгүй шүү дээ. Тэр улс өөрсдөө айна хориотой байсан юм чинь. Сумын төвийн эмч чинь дургүй, “лам нар руу явдаг” гээд л хэл үг гаргаж байх шиг.

**Зу: Одоо та ач зээ, хүүхдүүдээ ханиад хүрч өвдлөө гэхэд өөрийн эмээс өгөх үү?**

Ца: Өөрийн эмээс л өгнө. Хоолой нь өвдлөө гэхэд л “балжингарам” өгнө. Балжингарав чинь хоолойн эм шүү дээ. Хугацаанд нь уулгаад л, хоолойг нь зайлуулж асгуулаад, хоолойг нь арчуулаад л, бүр болохгүй боочих гээд байгаа хүүхдийг ороогоод л байна. Тэгээд л эдгэнэ шүү дээ.

**Зу: Сая ковидын үеэр тан дээр хүмүүс ирэв үү, хүмүүст эм тан өгч эмчлэв үү?**

Ца: Би өгч байсан гэвэл “цагаан тан”, “лидэр долоо” эртний тан л даа.

**Зу: Ковидын үед орчин үеийн анагаах ухаанаас гадна уламжлалт анагаах ухааны “норов долоо”, “мана дөрөв” хэрэглэнэ гэж байсан. Үүнийг та гэртээ боловсруулах бүрэн боломжтой юу?**

Ца: Боломж байна. Гадаадын түүхий эдийг олоход болно. Энэ “мана дөрөв” гэхэд л “ганжаа”, “мана” хоёр хэрэгтэй. Бүр хойшоо хангай, нугаар явж ирж байж олж байгаа юм. Лидэр нь говь руу байдаг. Ганжаа, мана хоёр бол гадаадын ургамал. Норов долоо гэхэд л гадаадын таван юм орж байгаа юм. Ар үр, жүр үр, бар үр гээд дээд гурван үр тэгээд “гажаамаа” бас орно. Энэ “ар үр” чинь дээд ургамал байгаа юм. Тэд нар орсон тул, эрдэнэ долоо гэдэг нэр өгсөн байгаа юм. Тэгээд цагаан танд, эрдэнэ долоод ордог дөрвөн юм орчихлоо шүү дээ. Тэгэхээр эрдэнэ долоо, мана дөрвийг зэрэгцүүлж өгөх шаардлагагүй гэж би бодож байгаа юм.

**Зу: Одоо энэ гадаад ургамлыг Монголд тарьж ургуулах боломж байдаг юм болов уу?**

Ца: Байдаг юм гэнэ лээ, хотын зарим газар тарьдаг юм гэсэн.

**Зу: Тэгэхээр гадаадад ургадаг ургамал Монголд тарихаар шинж чанараа алдах болов уу?**

Ца: Өө мэдэхгүй.

**Зу: Та одоо Өвөрхангай байн, байн явж чадахгүй тохиолдолд тэндээс авчраад эндээ тарьж болохгүй юм уу?**

Ца: Ойр зуурын юм шороо нь таарвал ургана. Хотын эмийн газрууд бол маньг их тариад байгаа юм байна лээ. Мана бол нэлээн арвин тарьж байж үр шимээ өгнө л дөө. Үндэслэг ургамал чинь үндэс нь боловсорч, бүдүүрч чанар нь болтол хүлээвэл хоёр гурван жилийн зай байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр гурван үр гээд ярьсан, гурван үрийг тарих боломж байхгүй гэж үзэж байгаа юм. Юундаа ч ургадаггүй юм бүү мэд. Модлог ургамлаас ургах уу, цэцэг, навч, иш гарч байж ургах юм уу мэдэхгүй.

**Зу: Жишээлбэл ардын болон уламжлалт анагаах ухаан хоорондоо хэр уялдаатай вэ? Бариа засал тан ч гэдэг юм уу. Та эм хийхдээ амьтны эд эрхтэн ашигладаг уу?**

Ца: Байна. Ганц нэг зүйл байлгүй яах вэ. Жишээлбэл сарлагийн цөс, тарваганы цөс хэрэглэнэ. Одоо өөрт байгаагаа хэрэглэнэ.

**Зу: Тэдгээрийг номхотгож хэрэглэх үү?**

Ца: Үгүй зүгээр л хэрэглэнэ.

**Зу: Бусад ургамалтайгаа хольж хэрэглэх үү?**

Ца: Үгүй, дангаар нь ч хэрэглэнэ.

**Зу: Тэгэхээр бариа засал хийлгэж байгаа хүн ийм тан дотроосоо увал бүр сайн, яс хугарсан хүн дотроосоо ийм ургамал ууна гэсэн хоорондын уялдаа бий юу?**

Ца: Байна л даа. Яс гэмтсэн хүн бол янз бүр л байна.

**Зу: Жишээлбэл хамгийн энгийн алтан гагнуур гээд ярьдаг шүү дээ. Тэр эмийг түүж аваад хэрэглэдэг юм уу, номхотгодог юм уу?**

Ца: Зүгээр шууд аваад хэрэглээд байгаа юм. Номхотгох шаардлагагүй, нэлээн тэнхээтэй чадалтай ургамал бас хортой, тэгээд аваад л хэрэглээд байгаа юм. Тун тааруулахгүй бол хордоно. Тариалдаг ургамал ч гадаад ургамалд байгаа л даа. Манай Монголын ургамал тариалаад хэрэглэх боломжтой ургамал байна гэж харж байна.

**Зу: Эм бэлтгэхэд хэрэглэж байгаа багаж юу байна вэ?**

Ца: Жижиглэх миксер хэрэгтэй, уур нүдүүр хэрэгтэй. Голдуу л уур нүдүүр хэрэглэж байна. Тэр хүчтэй миксерүүд бол дор нь пажигнуулаад жижиглэнэ. Бас хүчирдэггүй юм бий л дээ. Жижиглэж барьж хийхгүй бол. Тэр эргэлтээр жаахан халалт өгдөг болов уу. Нүдсэнээс чанар нь арай муу байна уу гэсэн бодол байдаг юм.

**Зу: Одоо танд байнга эм тан ирж авдаг, үйлчлүүлдэг хүмүүс байна уу?**

Ца: Ганц, нэг байдаг юм.

**Зу: Ямар өвчинд голдуу таны бэлдсэн эмийг тэр хүн хэрэглээд байна?**

Ца: Голдуу сэтгэл санааны, хий өвчтэй, шар өвчтэй улсууд л голдуу байнга эмчлүүлнэ. Би өнөөхөд нь голдуу сэргэлт эм өгөөд л эмчлээд байгаа юм даа. Тэр хүндээ бас сэтгэл санаагаар унасан, зүрх нь жаахан суларсан, ер нь тэгээд үйл ажиллагаа нь жаахан сул, тийм улс. Тэрийг би хий талын юм жаахан хийх дуртай хүн болохоор дараад байхгүй юу.

**Зу: Та тэр тал дээрээ өөрийгөө тун дажгүй гэж бодож байна уу?**

Ца: Тийм, тэр талаараа судалснаараа номтой мөргөнө шүү дээ. Андашгүй л дээ. Ядаргаатай, хий ихтэй, сэтгэл санаагаар унасан улс чинь царай зүснээс нь андаш байхгүй. Тэгээд яаж байна гэхээр судас бариад үзэхэд л мэдэгдээд эхэлнэ.

**Зу: Та судас барьдаг юм уу?**

Ца: Барьдаг, судас барьж оношилно.. Даралт үзнэ судас барина тэгээд асууна.

**Зу: Тэгээд өврийн дэвтэр дээр тэмдэглэх үү?**

Ца: Тэмдэглээд утсыг нь бичиж аваад заримдаа тэр хүнд тийм зүйл өгсөн, тэр хүн маань юу болж байгаа бол гээд утсаар “яаж байна” гээд асууна. “Хууч байна уу”, “яаж байна” гэхээр “гайгүй болж байна” гэхээр надад бүр сайн болж байгаа юм. Овоо доо гэж бодоод. Зарим нь бүр энээ барсан хүнд юм өгчхөөд, “энэ хүнд эм өгөх үү, байх уу” гэж бодож байгаад өгчихнө. Тэгээд өгчхөөд сүүлд нь өөрөө айдаг юм. Өнөө нөхөр юу болж хоноо бол, явчхаагүй л байгаа даа гэж бодно. Тэгээд л асууна л даа.

**Зу: Тухайн хүмүүс танд ямар нэг гомдолгүй гэсэн зүйл хэлэх үү?**

Ца:Өө хэлнэ. “Чамд энэ эмийг өгчихвөл жаахан хатуу л эм байгаа юм, сүүлд нь иймээ тиймээ зүйл болчихвол гомдол ярих уу надтай” гэхээр “аа үгүй” л гэдэг юм. Үгүй гэсэн

хүнд гарын үсэг зуруулаад байх тийм зүйл байхгүй л дээ. Тэгээд л итгээд явуулдаг юм.

**Зу: Та судас барьж үзээд ярилцаад за ер нь болохгүй юм байна гээд буцааж байсан хүн бий юу?**

Ца: Байдаг юм. Бүүр за энэ ямар ч эм тан өгөөд сэхэхгүй нь гэсэн хүнд бол өгөхгүй шүү дээ. За энийг ч би барахгүй юм байна. Тэр хүмүүс чинь эмнэлгээр яваад бүр тартагт нь тулгачихсан. Эмнэлэг хүч хүрэхгүй болсон тиймэрхүү хүмүүс гараад ирдэг юм.

**Зу: Танай аймагт та болоод түрүүний хэлдэг залуу та хоёр л байна уу?**

Ца: Тийм. Бид хоёр л байна.

**Зу: Та Эрдэнэцогтын хүн үү?**

Ца: Тийм.

**Зу: Бид бол “Соёлын өвийн үндэсний төв”-ийн мэдээллийг харсан. Тэгсэн Баянхонгорт хоёр хүн байдаг гэсэн, тэр хоёртой уулзана. Тэгээд соёлын өв дээр очиж уулзаад таныг мэдээд тан дээр ирсэн. Танд ер нь соёлын биет бус өвийг бүртгүүлэх, өвлөн уламжилж байгаа хүн гэдэг талаар ямар бодолтой байгаа вэ?**

Ца: Тэрийг бол нэг их бодохгүй байна. Арай хэдэн жилийн өмнө бол бас боддог л байлаа. Ямар нэг хүн эсвэл тэр хүн мэргэжлийн хүн ч байж болно. Зөв хүн юм хийж байна уу, буруу юм хийж байна уу гэж хоргоох хүн байна байхдаа гэж боддог юм. Тэгдэггүй л юм байна лээ. Орж ирдэггүй юм, бүр сүүлдээ үзэсгэлэн худалдаа гараад эм дэлгээд хот руу хоёр гурван удаа явсан шүү дээ. Хотод ядаж хоргоох хүн байдаг байх гэхээр үгүй л байдаг.

**Зу: Та бол шалгуулах хүсэлтэй байдаг юм уу?**

Ца: Нэг хэсэг байдаг байсан. Нас өглөөд одоо бол юу гэхэв. Юм хийж суухаасаа ч өнгөрсөн. Одоо 80 гарсан хүн чинь яах юм. Нэмж сурах, одоо тэгье дээ гэсэн хүсэл ч байхгүй. Нас ахиад ирэхээр насаа дагаад ухаан санаа муудчихна.

**Зу: Одоо нас өндөр гарч байна, энэ зүйлийг аль нэг хүүхдэдээ өвлөн уламжлуулъя гэсэн бодол байдаг уу?**

Ца: Байдаг юм, боломж нь олддоггүй юм. Хүүхдүүд яах вэ хэдэн төгрөгт даруулчих гээд тэр уурхайд очоод том тэрэг бариад явсан юм. Ингээд боломж олддоггүй. Сурахаараа өөр юмаар сураад явчихдаг.

**Зу: Тэгэхээр аймаг нутаг орон цаашлаад улс дэмжлэг байвал энэ зүйлийг хэн нэгэнд заах боломжтой гэж бодож байна уу?**

Ца: Боломжтой л байх. Дэмжих ёстой л доо уул нь. Тэгээд нэг их дэмжихгүй л байгаа юм. Дэмжихгүй байсаар байгаад өдийг хүрсэн. Заримдаа жаран естэй явна, заримдаа бензин арай дутмаг болох жишээтэй. Тийм үе зөндөө байгаа. Надад арай дэмжлэг болсон хүн Жаргалсайхан гээд хүн байсан. Манай аймгийн даргыг 3 жил хийж байсан. Тэгээд л тэр хүнийг шууд гаргачих шив дээ.

**Зу: Тэр хүн бол таныг тусалж дэмжиж байсан уу?**

Ца: Дэмжиж байсан. Тэр хүн надаа бензин л хийх гэсэн болзолгүй гэсэн. Төгрөг аваад өгч байсан удаа бүр 2, 3 байдаг юм.

**Зу: Та ер нь сум аймгийн эмнэлэгтэй хэр холбоотой ажилладаг вэ?**

Ца: Нэг их холбоогүй. Миний бодлоор бол аймаг сум хоорондоо холбоотой ажилламаар л санагддаг юм. Жишээ нь гэхэд л бөөрний дутагдалтай хүнийг эмчилж байна гээд угаас нь дордуулаад тавьсан шүү дээ манай эмнэлэг. Тэгэхэд хамжаад явсан бол тэнд нь зассан бол арай тийм болгомооргүй л байсан байхгүй юу. Тэр ганц удаа биш. Цус өвчтэй хүмүүсийг хамтарч эмчлээд, би хажуугаар нь үзээд хамтраад эмчилбэл болмоор л байгаа юм л даа. Харилцан эмчилгээ байхгүй.

**Зу: Бидний бас нэг ажил бол соёлын өвлөн уламжлагчид бүртгэгдээгүй хүмүүсийн шинэ бүртгэлийг хийж яваа юм. Таны мэдээлэл байхгүй байгаа юм чинь бид очоод Баянхонгорт нэг ийм хүн байна гээд мэдээллийг тэр хүмүүст өгөх юм. Мэдээж таны овог нэр, регистр ямар арга ухаан хэрэглэдэг дээр эм тан барих гэж оруулж болно гэсэн үг үү?**

Ца: Болно. Мөн асуух хүрэлцэх талаас нь эмчилнэ л дээ. Онош гаргана, өөрөө зүгээр нэг эм тан өгөх биш л дээ.

**Зу: Ер нь та өөрийн эзэмшсэн арга ухааныг Монголын уламжлалт анагаах ухаан гэж болох уу?**

Ца: Болно.

**Зу: Монголчуудынх уу эсвэл дорнын арга ухаан уу эсвэл тухайн орон нутгийн арга ухаан гэж үзэж байна уу?**

Ца: Орон нутаг гэж үзэх нь гол нь байхаа даа. Гэхдээ би ганцхан орон нутаг хийхгүй байгаа биз дээ. Одоо жишээ нь хот руу явж байна. “Эрдэнэ долоо”, “мана дөрөв” хийлээ гэхэд хотоос очиж л таньдаг хүн, газруудаасаа авна.

**Зу: Хотын эмийн газруудаас энэ эмийг авъя гэхэд танд шууд өгөх үү?**

Ца: Өгнө.

**Зу: Таныг таньдаг болоод өгч байна уу, өөр хүнд өгөх үү?**

Ца: Очсон хүн болгонд өгнө гэдэг чинь тэр том газар, доктор цолтой улс чинь өөрийн туршлагатай ч байгаа. Тэд нарыг үзэж байгаад, тийм эм тан өгнө гээд өгнө л дөө. Тийм эм авна гээд надад өгнө. Үнэ нь л өндөр байдаг юм. Тэгэхээр бас чанар нь дэндүү муу юм хэлсэн болох юм болов уу. Том газруудын эмийн чанар л жаахан дутмаг гэсэн бодол байдаг.

**Зу: Тэгэхээр том газрууд номхотгохдоо алдаа гаргаад байна уу эсвэл номхотгохдоо орчин үеийн техник технологи ашиглаад чанар нь муудаад байна уу?**

Ца: Номхотгохгүй ч эм байна шүү дээ. Тэгээд аль нэгээс нь аваад би эм тан эхлээд л бодохгүй юу, би эндээс “чун тав” гэдэг эм аваадахъя, норов долоогоос нэгийг аваадахъя гээд өөрийн хийсэнтэйгээ харьцуулж үзнэ. Үнэрлэнэ, амтална, өнгө харна. Тэгэхээр амт чанар миний хийснээс дутуу байгаад байдаг юм. Тэр том том 7, 8 саяын үнэтэй том бутлагчаар бутлаад тачигнуулаад хаяна. Тэрэндээ байдаг юм болов уу, олон хүний гараар хийсэн дээ байдаг юм болов уу гэж боддог юм.

**Зу: Эмийг номхотгоход тодорхой тогтсон зан үйл гэдэг юм уу, шившлэг гэдэг юм уу зан үйл байна уу?**



Ца: Байна.

**Зу: Та тэрнийг хэлээч ямар ургамлыг номхотгохдоо шившлэг дом хэрэглэж байна?**

Ца: Тангаа хийж байхдаа Манал бурхны ном уншина. Тэгээд үлээлгээ хийгээд хүнд өгөхдөө бэлэн болгож тавьж байна гэсэн үг.

**Зу: Эмийн үйлдвэр тэгж байгаа юу?**

Ца: Өө тэгж байгаа байлгүй. Би яаж мэдэх үү, тэгж л байгаа байх. Тэд нар чинь бүр том номтой. Тангад сурсан тийм улс хийх л байх. Корона хүрээд өөрөө эм тан уусан л даа. Би 30 гаран жил зогьсуулаад тэрийгээ өөрөө дарсаар өдий хүрсэн. Зогьсуулахгүй байж байгаад корона тусаад, тэрийг гаргаад ирдэг шүү. Мөн овоо байгаа биз. Зогьсуулаад л байсан. Зүрхэнд байсан хийгээр зогьсуулдаг юм байна лээ шүү дээ. Тэрийг хуучилбал их хөгтэй. Тэр үед чинь мал хураагаад 1959 онд тэгшилгээгээр мал хураагаагүй юу. Тэгээд хуваарилж өгсөн 12 үхэр, 4 адуу л надад өгсөн. Хонь бог байгаагүй юм. Тэгэхэд 10 гаран ам бүл болсон байсан. Тэгээд сүүлд үлдсэн 7, 8 үхэр үлдсэн. За байз, үнээгээ гурвыг дөрөв болгоё гэж бодоод. Нэг карабин буу байсан. Нэг хүн авъя гэхээр өгөөд үхэр авсан. Тэрийгээ охин дээр тоолуулсан чинь нэг үнээ гараад ирдэг юм. Засаг дээр аймгийн төлөөлөгч ирдэг юм, “Хүрээд ир” танайх зөрчилтэй юм байна гэсэн. Ямар юмны зөрчил гэсэн, нэг үнээ илүү гээд. Гаргаж авъя ч өвлийн хүнсэнд хүрэхгүй шүү дээ. Өвлийн хүнсэнд гэсэн чинь нэг залуу тэгж байна. “Тэр ардын их хурлын дүрмийг та бид хоёр зөрчиж чадахгүй, ёстой яаж ч чадахгүй, та ч чадахгүй, би ч чадахгүй, та тэгж ярьж болохгүй” гээд урдаас хэдэрлэж байна. Ярихгүй яадаг юм би байдлаа л ярьж байгаа юм чинь. Цаана нэг залуу “Цаадхаа дансал” гэдэг байна. Тэгэхээр нь зэвүү хүрээд жаахан маргаад явуулсан. Тэгсэн чинь данслаад, манайх нэгдлийн үнээ сааж байсан, нэгдлийн үнээнд сүүтэй үнээ нэмээд, тугалтай үнээ нэмээд ингээд хоёр болгоод чадаж байгаа юм байлгүй. Тэгээд дансалсан байдаг юм. 7, 8 үхэрт л 200 хэдэн кг мах оноочихно. Наана нь амны сүүг нь авна. Тэгээд цугаараа мал дарна. Тоо дөхнө, палан дарна. Тэгээд хонь дарах гээд л модон хашаа хийдэг юм. Хашаа хийгээд л, хашаандаа хонио хийх гээд л байж байсан хажуу талын мод дээр шаазгай юм хэлдэг юм. Тэгсэн чинь удалгүй өнөө манай хөгшин яаруу сандруу ч хөгшин байсан юм. Модны хормойноос хашхирч байна шүү. Одоо “шоронд орох нээ” л гэнэ, “цоожин гууль ирсэн” л гэнэ. “Болохоо байлаа, наад хэдэн хонио тэр чигт нь тавь” л гэнэ. Их юм хэлж байна шүү. Хашхираад л байх юм. Тэгээд л өнөө хэдэн хонио тавиад чоно идвэл идэг, дүүрсэн гээд гэртээ үлдсэн хоёр, гурван хонио аваад очсон. Тэр үедээ хөгшнөө явуулах гээд “чи яваа, яв” гэсэн “би явахгүй одоо шоронд орно” гээд байгаа юм. Яадаг юм би хүний юм хулгайлж нуугаагүй, өөрийнхөө юмаа өөрөөсөө нууж байгаа юм гээд л орилсон. Тэгсэн л зайлуул чимээ тасраад л явчихсан. Өөрийнхөө юмаа л өөрөөсөө нууж байсан юм даа. Өмнө нь өчнөөн төчнөөн мянга гаран малаа хураалгасан хүн шүү дээ. Тэгээд тийм байдалд орсон хатуу төр байсан юм шүү. Тэрийг би энэ биеэрээ туулсан. Тэгээд л очоод л хэдэн хонио хагас хугас цуглуулж ирээд нэг жаахан унтаад өглөө босож байгаа юм. Тэгсэн чинь зогьсуулаад л ирдэг юм. Тэрийгээ нэг дараад л авсан чинь зүрхэнд хурсан хий л байсан байгаа юм. Тэгээд өнөө хөгшин

чинь хашхираад, бүр намайг чинь дарамтад оруулаад, сүрдүүлсэн байхгүй юу. Тэгээд зүрхэнд хий суулгуулаад тэгээд тэрнээс эхлээд л зогьсуулсан. 30 гаран жил тэр хий юугаа хийгээд энд зүрхэнд байгаад байсан юм үйл ажиллагаа нэмэгдсэн байх л даа. Тэгэхээр тэрийг гаргаж ирсэн өвчин байхгүй юу. Зогьсуулдгаа дараад авдаг юм. Тэр талын юм аваад уугаад, овоо дарагдаад, дарагдсанаас хойш өнөө корона зогьсуулж байхдаа өгөөгүй байгаа юм. Тэгэхэд л ингээд санаа дагаад тэр үү, зүрх рүү нэг үзүүртэй юм ингээд л “дирх” гэж яваад зүрхийг бараг таглах шахаад л, таллаж очоод буцаад ухарч байгаа юм шиг болоод байдаг шүү. Зүрхэнд их хийтэй бол аваад явна. Тэр тал дээр нь очиж байгаа юм чинь ингээд явах юм бол амьсгаа хураагдах байдалд орох гэж байна лээ. Аюултай. Энэ чинь зүгээр хамрын ханиад биш. Би өөрөө үзээд тэгж байгаа юм. Сүүлд манай хүн яваад өгөхөд би сэтгэл санаа гундуу байсан. Тэгээд л эмнэлэгт үзүүлсэн чинь болохгүй нь зүрхний нэг судас нарийссан байна гээд бичлэг хийлээ, шинжилгээ хийлээ, хотод нэгдсэн эмнэлэгт очиж байж жаахан гайгүй болсон. Тэрнээс хойш би гурван сар эм тан уугаад л байгаа, одоогоос л овоо гайгүй болж байна.

**Зу: Та та уусан уу, европ эм уусан уу?**

Ца: Тан уусан, европ эм ч уусан. Европ бол дасаагүй. Тиймэрхүү журмаар л яваад байгаа даа. Тэр чинь бас л намайг авч явчих гээд байгаа байхгүй юу. Дөхөөд л байгаа юм. Тэр зүрх “дирх” гээд л дуугарсан. Би мэдрэмж ихтэй л хүн л дээ. Тэр мэдрэмжээрээ мэдрээд л байгаа юм. Тэгж л “хорвоогийн олон жаргал зовлонг амсаж эдэлж явлаа даа” гээд ардын дуунд дуулдаг аа. Тэр чинь над дээр болчихсон.

**Баянхонгор аймаг, Хүрээмарал сум, Бадам овогтой Болдбаатар**

Бо: За, би Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын иргэн Бадам овогтой Болдбаатар гэдэг хүн байна.

**Зу: Та ардын уламжлалт анагаах ухааны аль арга ухаанаар ард түмэндээ ач тус хүргэж, ямар арга ухааныг нь уламжилж байгаа вэ?**

Бо: За, хүний таван мэдрэхүй байдаг би судас барьж онош тавьдаг. Түүнийхээ давхар яс бэртсэн, гэмтсэн гар хөлийг барьж эвлүүлдэг. Миний барьсан хүмүүс ерөнхийдөө эдгэсэн. Тархи толгой барина. Таван мэдрэхүйн арван хуруугаар мэдрэх, оюун санаанд орж байгаа зүйлээ мэдэрнэ. Миний энэ зүйлийг зааж өгсөн миний аав болох Бадам гэж хүнээс би үүнийг уламжилж үлдсэн. 19 настайдаа анх өөрийн чадварыг мэдсэн. Нагац эгчийн охины гэмтсэн гарыг боож өгөөд үүнээс эхэлж өдийг хүртэл ард түмэндээ, сум орон нутаг болон ойр орчмын зэргэлдээ сумын улсуудад зохих хэмжээгээр өөрийн чадах ядахаар тусламж үзүүлдэг.

**Зу: Та хэд дэх үеийн өвлөн уламжлагч вэ?**

Бо: Миний мэдэж байгаагаар аавын маань аав Жамбал гэж хүн байсан. 1983 онд бурхан болсон хүн. Гэхдээ 99 настайдаа бурхан болж байсан хүн. Тэр хүний хоёрдох хүү

Бадам гээд хүн байгаа юм. Тэр хөгшчүүлийг бодохоор 1993 онд 90 хүрсэн гэхээр би гурав дахь үе дээр нь байна. Тэрнээс цаашаа бол би мэдэхгүй байна.

**Зу: Та түрүүн хэлсэн, 19 настайдаа өөрийн мэдрэмжийг мэдсэн гэсэн тэр мэдрэмжийн тухайд ярина уу?**

Бо: Миний мэдрэмжийн тухайд байгалиас заяасан мэдрэмжийн нэг нь жаахан илүү байсан юм болов уу гэж боддог юм. Би өөрөө өөртөө итгэхгүй байсан л даа. Энэ одоо “үнэн болов уу үгүй болов уу” гэж. Тэгж байж байгаад явцын дунд өөрөө өөрийгөө мэдэрч эхэлсэн, өөртөө итгэлтэй болж эхэлсэн. Улсуудад, хүмүүст өөрийн ач буянаа өгч эхлэхэд өөрийгөө би “энэ мэдрэхүй маань зөв байсан юм байна, хөгшчүүлийн маань хэлж байсан зүйл зөв байсан юм байна” гэдэгт бат итгэлтэй зогссон л доо.

**Зу: Таны өвөө, аав энэ уламжлалт анагаах ухаанаас ямар зүйлийг зааж сургасан бэ? Тэрнээс гадна та ном сургаал, ном бүтээлээс сурсан зүйл байгаа юу? Эсвэл яг түрүүний хэлсэн нэр дурдсан хүмүүс зааж сургасан уу?**

Бо: За миний тухайд бол хөгшчүүл маань надад заасан, тэгээд орчин үеийг дагаж телевиз, радио, сонин сэтгүүлээс янз бүрийн мэдээлэл олж авахыг л боддог доо. Би бол өөрийн мэргэжил нэгт хүмүүсийг маш их шүтдэг. Тэд нар бас их агуу хүмүүс байдаг юм. Энэ бол ховор, хүн болгонд ирээд байдаггүй тохиолдол. Хүн болгонд ч тэр мэдрэмж байхгүй, тэр арван хурууны өндгөн мэдрэмж гэдэг бас их чухал байдаг юм уу гэж би өөрийн тухайд боддог юм.

**Зу: Уламжлалт анагаах ухаан эсвэл ардын анагаах ухаан хоорондоо ялгаатай болов уу? Та энэ өндгөөр мэдэрдэг арга ухааныг зөвхөн монголчуудын арга ухаан гэж итгэдэг үү?**

Бо: Энэ бол монголчуудад л байдаг байх гэж би боддог юм. Зүгээр телевиз, радио харахад энд тэнд бариа засал янз бүрийн зүйл гараад байгаа. Тэр гэхдээ Монголоос шашны анагаах ухаан одоогийн анагаахтай нийлээд арай нэг өвөрмөц болгоод байх шиг байгаа юм. Эсвэл яг монгол анагаах ухаан гэдэг халаадаг, төөнөдөг зүйл байх. Би одоо дөнгөж 50 гарч байна. Гэхдээ би хүнийг гаднаас халааж төөнөх тиймэрхүү талын зүйлийг хийдэг. Гэхдээ би өөрийгөө нас арай залуу байгаа юм болов уу, надад сурах зүйл их байна гэж түүнд арай жаахан хүлээцтэй хандаад явж байна.

**Зу: Та байгалиас заяасан өгөгдөлтэй, арван хурууны мэдрэмжтэй гэж байна шүү дээ. Энэ мэдрэмж таныг одоо барихад маш их нөлөө үзүүлж байгаа. Орчин үеийн анагаах ухааны сургуулиуд бий болсон. Магадгүй энэ сургуульд суралцаж байгаа бүх оюутанд энэ мэдрэмж байхгүй байх. Энэ бариа заслыг удаан хугацааны турш практикаар сурч болдог юм уу эсвэл цаанаасаа заяагдсан байдаг юм уу?**

Бо: Энэ өгөгдөл бол заяагдсан байдаг байх гэж боддог. Гэхдээ хүн олон зүйл сурч болно. Манай Улаанбаатарт байдаг нэрийг нь хэлж яах вэ нэг сургуулийн маш сайн эмч бариа засал гээд над дээр ирэхэд би Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд байж байсан. Тэр үед би улсуудыг үзээд эм тан өгөөд байж байсан. Тэгээд би нэг өөрийгөө үзүүлдэг юм уу гэж бодоод. Би дотор эрхтэндээ анхаараад үзүүлсэн юм. Бид хоёр хоорондоо өгөгдөл таардаггүй юм байна лээ. Тэр хүн миний судсыг бариад “би барахгүй нь

ээ” гээд боссон. Би харин өөрт нь эсрэг үйлдэл үзүүлж “өөрийн харамсдаг зүйл, өөрийн чадахгүй байгаа зүйл”-ээ хэлэхэд тэр хүн надад “та бол маш лут хүн юм, та одоо намайг яаж ингэв ээ, та бид хоёрын энерги мөргөлдөөд байна” л гэж байсан. Түүнийг бол би анагаах талаараа мэдэхгүй юм л даа.

**Зу: Таны нэр “Соёлын өвийн үндэсний төв” дээр байгаа. Та бүртгүүлэхдээ яаж бүртгүүлсэн бэ ? Энэ бүртгэлийн талаар ярина уу?**

Бо: Энэ бүртгэлийн тухайд бол би өнөөг хүртэл мэдээгүй байсан. Энэ манай сум орон нутаг байдаг юм уу аль нэгэн газраас мэдсэн байх. Би бол өөрийгөө жаахан нууцлангуй байсан. Энэ соёлын өв дээр очсон гэдгийг хаанаас, хэнээс авсан гэдгийг бол мэдэхгүй байна. Би бол өөрөө бүртгүүлнэ гэдгийг мэдэхгүй байсан. Одоо л би мэдэж байна. Тэгэхээр би төрүүлсэн ээждээ, ах дүү, амраг садан, хань ижил бүх л ард түмэнд “баярлалаа” гэж хэлье даа.

**Зу: Та гурав дахь үеийн өвлөн уламжлагч байна. Та энэ арга ухааныг өөр хэн нэгэнд өвлүүлбэ гэсэн бодол байгаа юу ?**

Бо: За би бол таван хүүхэдтэй, хэн нэгэн нь байгалиас заяасан юмтай байгаад өвлөө гэвэл би уламжлуулна. Хэрэв хэн нэгэн нь чадахгүй байвал энэ сайхан мэдрэмж арга ухааныг буруу хүнд өвлүүлчих юм бол соёлын өвд байсан миний нэр бас хөгшчүүлийн минь нэрд их сэвтэй л дээ. Тэрийг бол би маш их хичээдэг.

**Зу: Та байгалиас заяасан өгөгдөлтэй гэдгийг мэдэрч байна. Би олон хүнтэй уулзаж байхад яг энэ зүйлийг ярьж байсан. Тэгэхээр өвлөн уламжлагчийг тэр хүн өгөгдөлтэй байна гэдгийг яаж мэдэх вэ ?**

Бо: За надад таван хүүхэд байна. Дөрвөн хүү, нэг охин байна. Охин бол өгөгдөлтэй. Өгөгдөл бол андашгүй л дээ. Байгалийн өгөгдөл гэдэг маань хүнийг гаднаас нь хараад л энэ хүн ямар хүн бэ гэдгийг мэддэг. Ер нь хүн бол андашгүй шүү дээ. Харахад л байгалиасаа ямар янзын хүн бэ, энэ хүн яасан хүн бэ, хэдэн хүүхэдтэй вэ, хань ижил нь яасан хүн бэ гээд л бүгд мэдэгддэг. Миний давхар өгөгдөл маань бас их сонин өгөгдөл. Монгол улсад их цөөхөн байдаг юм гэсэн гэж би их дээхэн үед сонсож байсан. Одоо бол их болсон юм шиг байна лээ. Энэ Баянбулаг, Гурванбулаг, Хүрээмарал маань гүүний хошуу гэж байсан. Энэ хошуунд сахиус гэж зүйл байсан юм байна лээ. Тэр сахиус гээч зүйлийг Улаанбаатар хотод нэг эмэгтэй хүн буулгадаг. Тэр хүн маш сайн тэр хүний өгөгдөл надад их нөлөөлдөг байх аа л гэж боддог.

**Зу: Та сая хэллээ манай нэг охин өгөгдөлтэй байх аа гэсэн. Энэ охиндоо өөрийн арга ухааныг өвлүүлэх бодол байгаа юу ? Цаашилбал Баянбулаг сумын хувьд дөрвөн хүн байна гэсэн. Хүрээмарал сумын хувьд та жишээлбэл ганцаараа байна, ийм зүйлийг хэн нэгэнд өвлөн уламжлуулах уу ? Хэн нэгэн хүн тан дээр ирээд би тан дээр шавь орёе гээд тэгвэл танаас шалтгаалах танаас хүсэх зүйл юу вэ?**

Бо: За хэн нэгэн хүн над дээр ирээд “танд шавь орёе, таны өгөгдлөөс суръя” гэвэл эхлээд би тэр хүнийг судална. Тэр хүнийг судлахын тулд би 3, 4 давхар даавуунд байгаа модыг эхлээд эвлүүлүүлнэ. Энэ модыг ямар хэмжээтэй аль тийшээ хугарсан мод вэ гээд мэдэрч байвал би өгөгдлөөсөө зааж өгнө. Янз бүрийн бариа засал өгөгдлөөс орчин

үед их мөнгө нэхдэг болсон. Хэрэв тэгэх юм бол би зааж өгөхгүй. Орчин үед бол өгөгдлөөрөө их мөнгө нэхдэг болсон. Өргөл барьц их өндөртэй “би эмчилж өгье тэдэн төгрөг өг, тийм хэмжээний өргөл барьц өг” гэвэл би заажгүй. Ер нь энэ өгөгдөл бол бурхнаас заяасан, өвөг дээдсээс заяасан энэ зүйлийг бол хэнд ч харамгүй түгээж байх ёстой зүйл. Тэр хүн бол халаасандаа мянган төгрөггүй хүн байж болно. Одоо орчин үед тийм зүйл байгаа шүү дээ, бас юмыг яаж мэдэх үү. Тэгвэл тэр хүнд сайхан сэтгэлийн дэм өгөөд л сайхан яс усыг нь эвлүүлж өгөөд тэр хүний өвдсөн зовлонгоос гэтлээд явуулбал хамгийн сайн зүйл гэж би өөртөө болон өвөг дээдэс минь надад захиж зааж сургасан юм.

**Зу: Танд зааж сургаж байсан хүмүүс таныг ямархуу хэмжээнд сорьж байв. Сурахад хамгийн хэцүү байсан арга технологи гэдэг юм уу би одоо сайн мэдэхгүй байна. Ямар байдал нь хэцүү байдаг вэ? Мэдээж олон хүнийг барьсны дараа өөрт чинь илэрдэг ямар нэг мэдрэмж байна уу? Одоо жишээлбэл ядардаг, өвддөг ч юм уу тийм зүйл байдаг уу ?**

Бо: Ер нь бол тэр тал дээр ядрах зүйл илэрнэ. Тэгэхээр тэр зүйлийг өөрөө өөртөө бясалгал маягаар байлгах юм уу, өөрөө өөрөөсөө маш түргэн холдуулахыг хичээдэг. Ирж байгаа хүмүүс маань хамгийн гол нь сайхан энергитэй орж ирэхгүй шүү дээ. Өвдсөн, зовсон хамгийн наад тал нь “ёо ёо” ч гэдэг юм уу. Хамгийн гол нь байгалийн өгөгдөл маань тэр хүн зүв зүгээр байж байгаад өвддөггүй байхгүй юу. Тэр хүн цаанаа нэг шалтгаантай ямарваа нэг дэв бузар зохисон юм уу, өөрт нэг болж бүтэхгүй л юмнаас тэр хүн бэртэж гэмтэх тийм өгөгдөлтэй байдаг. Тэрнээс бол хүний яс зүв зүгээр байж байгаад пад гээд хугарна гэж байхгүй. Хүн зүв зүгээр байж байгаад тархи толгой өвдөнө гэж байхгүй. Хүний солонгон бүрхүүл байдаг гэж анагаах ухаанд ярьдаг. Бид нарынхаар бол хүний баруун, зүүн мөрөн дээр хоёр зүйл байх ёстой юм. Нэг дээр бол баруун мөр дээр гал, зүүн мөр дээр солонго байж байх хэрэгтэй. Энэ хоёр зүйл гэмтсэнээс болж өвдөх, янз бүрийн гэмтэх, бэртэх өөр янз бүрийн зүйлээр илэрч байгаа юм. Энэ зүйл бол орчин үеийн анагаах ухаанаар бол хүнд солонгон бүрхүүл байдаг тэр зүйл цоорох юм бол гэмтэнэ гэдэг. Тэр бол ерөөсөө адилхан зүйл юм л даа. Тэгэхээр зэрэг тэр зүйлээ хүн хамгийн гол нь анхаарах хэрэгтэй. Хүн мөрөө хүнд даруулах их дургүй байдаг тийм үү? Дамаа эр хүн бол мөр дээрээ гар тавиулах их дургүй. Энэ бол тэр зүйлүүд маань гэмтчихээс их сэргийлж байгаа хэрэг. Одоогийн залуучууд бол андаа гээд нэгнийхээ мөрөн дээр цохидог мэндчилгээ болсон. Энэ бол уг нь их буруу мэндчилгээ байгаа юм л даа. Хүний тийм сайхан зүйл дээр гар хөл хүрнэ гэдэг бол.

**Зу: Бариа засал хийнэ гэсэн олон хүн байдаг. Фейсбүүк, сошиал, аймаг сум, Улаанбаатарт гээд. Та тэд нараас өөрийгөө юугаараа ялгаатай гэж хэлэх вэ?**

Бо: За би юугаараа ялгаатай вэ гэхээр, нэгдүгээрт би өөрийгөө чадна гэж сурталчилдаггүй. Дотроо бол би өөрийгөө чадна гэсэн бүрэн итгэлтэй байдаг. Түрүүнд ярианы цухаст надаас танд шавь оръё гэвэл гээд хэлж байсан. Тэр бол хүний өвчнөөр тэр хүн мөнгө олох, амар ашгаар, хялбар аргаар мөнгө олох зүйл юм болов уу гэж боддог. Хүн үнэхээр чадаж байх юм бол хүнээс хариу нэхдэггүй байх ёстой юм л гэж боддог. Би

өөрөө өвчилсөн шүдийг эмчилж байгаа, манай сумынхан бол сайн мэднэ. Зарим нь шүдний эмч гэж доог тохуу болгож хошигнож ярьдаг л даа. Биеэр нь юм гараад дийлдэхээ байсан ээд Улаанбаатараас манай авгайн нагац талын 20 орчим настай охин ирээд манайд 3 хоноод бүх яр шарх нь эдгээд явсан. Энэ хатги гээд лут зүйл гардаг энийг бол улсууд хагалж задалдаг. Үүний эмчилгээ нь 3-4 цагийн ажиллагаа байдаг юм, маш амархан. Би өөрөө одоогоос 14 жилийн өмнө 250 гр “Гоё” таргаар 2 хонодог болсон байсан л даа. Тэгээд өөртөө би дүн шинжилгээ өгсөн. Одоо надад хэцүү өвчин иржээ, би ийм богино настай болжээ л гэж өөртөө бодож байсан л даа. Манай бага хүү гарах гээд эхнэр явсан би түүнийгээ эмчлэх гээд янз бүрийн юм хэрэглэсэн. Долоо хоногийн дараа бол би нөгөө гоё тараг битгий хэл аяга хоол иддэг болж хоол ундандаа орсон.

**Зу: Та ямар арга хэрэглэсэн бэ ?**

Бо: Энэ бол улсууд унгадаг хар, бингийн хар гэдэг юм л даа. Энэ зүйлийг би ерөнхийдөө түлхүү хэрэглэсэн. Үүнийг цагаан архинд хийгээд түүнээ нэг ундааны саванд хийсэн юм. Би 60 орчим биндээ хар түүж хийсэн. Түүнийгээ үнэрлэхэд л тэр биндээ хар гээч лут үнэр үнэртдэг хэр нь уухад бол архины амт ерөөсөө байдаггүй. Дотор ходоодонд орохоор ходоодыг халуу асгуулаад их л лут болдог юм байна лээ. Гэхдээ хажуугаар нь бол ойр зуурын юм хэрэглэсэн л дээ. Тэр зүйлүүдийг би хэлээд байх нь тийм онц биш байх. Зарим улс нь миний ярьж байгааг аваад хүн амьтанд хэрэглээд янз бүрийн хортон суулгаж болно л доо. За бас нэг зүйл бол одоогоос 9,10 жилийн өмнө манай эхнэр бие нь өвддөг байсан, одоо бол сайхан болсон л доо. Ингээд яриад байвал сонин сонин түүхтэй сонин сонин эмчилгээнүүд бол их байна. Энэ болгон соёлын өв тээгчид маань орсны нэг үр дүн байдаг байх л даа би өөрөө мэдээгүй. Сум орон нутаг, засаг захиргаа, нэгж, соёлын төвийн дарга Батхолбоо болон сум орон нутгийг удирдаж байсан улс маань энийг соёлын өвд оруулж, миний нууц явсан зүйлийг нэлээн дэлгэрэнгүй тайлж өгч л дээ.

**Зу: Та одоо мэдээж маш олон хүнийг эмчилж анагаасан байх. Тэр дундаа та өөрөөрөө бахархаад би нэг тийм хүнийг эмчилсэн шүү гээд түүх яривал ?**

Бо: Түрүүн би өөрийгөө нэг ярьж байсан. Дараа нь бол юуг нь нуух вэ. Би ханиараа бахархана, ханийгаа эмчилсэн. Миний хань өдий зэрэгтэй амьдарч байна. Янз бүрийн юм байхгүй миний хамгийн бахархаж явдаг зүйл.

**Зу: Нууц биш бол ямар өвчин яаж эмчилсэн бэ ?**

Бо: Энэ бол одоо урт нэртэй буюу тийм өвчин байсан нь эдгэсэн. Би таван хүүхдэдээ эхийг нь амьд сэрүүн ингээд байж байгаад, өөрийгөө ханиа эмчилсэндээ бахархах юм даа. Өөр эмчилсэн хүмүүс бол байгаа гэхдээ тэр хүн надад гомдож явдаг уу, талархаж явдаг уу, юу гэж бодож явдгийг би мэдэхгүй шүү дээ.

**Зу: Та эхнэрээ эмчлэхдээ өвгөдөөс ирсэн арга ухааныг ашигласан уу ?**

Бо: Тэгсэн бариа засал хажуугаар нь янз бүрийн ургамал идэж уух. Тийм манай Монголд чинь идэж байгаа ургамал бүхэн маань витамин байна шүү дээ. Одоо бараг л (бараг) худлаа ярьдаг хүнд бол гашуун амттай шарилж гээд байгааг идэхэд л эмийн

ургамал шахуу байгаа. Бид нар л түүнийгээ шинжилж нээж чаддаггүй, манай монголчууд жаахан залхуу юм уу даа л гэж боддог. Энэ том том эмч нар маань Монголын сайхан ургамлуудыг судалж аргаа хийх юм бол эдгэхгүй өвчин байхгүй болов уу. Одоо манай буурай маань 90 гараад өнгөрсөн гэхээр 99 бол маш урт нас, дээр үедээ ч 90 хүрнэ гэдэг одоо бол их том хувь тохиол уу л гэж боддог.

**Зу: Яг таны хувьд монголчуудын юм уу эсвэл нүүдэлчдийн язгуурын анагаах ухаан нь яг юу вэ ?**

Бо: Монгол нүүдэлчдийн язгуур ухаан энэ цаг агаар, дөрвөн улиралдаа байдаг болов уу гэж боддог.

**Зу: Одоо жишээлбэл уламжлалт анагаах ухааны бариа засал, зүү төөнүүр, ургамал амьтнаар анагаах гүрэм дом гэдэг ч юм уу энэ зүйлүүдийг монголчууд эртнээс хэрэглэж ирсэн. Бид нар жишээлбэл энэ зүйлүүдээс энэ нь яг монголчуудынх гээд олон улсад хэлэх зүйл аль нь вэ ? Бид үүнийг бүртгүүлэх гэж зорьж яваа хүмүүс тэгэхээр дом шившлэг юм уу, бариа засал юм уу зөвхөн монголчуудад байдаг энэ онцгой зүйлийн талаар та хэлээч ?**

Бо: За, энэ монголчууд гэдэг маань тэнгэр язгууртай ер нь бол дээд тэнгэрийн өгөгдөлтэй гэж боддог юм. Энэ дөрвөн улиралтай бас холбоотой. Яагаад холбоотой гэхээр энэ зун, намар, хавар, өвөл гээд дөрвөн улирал чинь маш их чухал. Энэ өгөгдлөөс малын бүтээгдэхүүн гэхэд жишээлбэл: тарваганы шагай гэхэд хүний бэртсэн ясанд их сайн байна. Энийг би хэрэглээд гэмтсэн улсад өгөөд нэлээн хэдэн жил болж байна л даа. Энийг өгөхөд өөрөө сайн боож л өгөх хэрэгтэй. Муухан боогоод өгөхөд нөгөөх маань анагаахаар бараг салахааргүй болж гагнагддаг зүйл л дээ. Тийм болохоор зэрэг тарвага нь хүртэл гоц авьяастай газар доогуур байдаг. Одоо тийм шид байна. Буурын заар гээд ярьдаг, буур өөрөө шилбэнээсээ ялгаруулдаг тийм бохь шиг, хөө шиг хар юм гаргадаг тэр хавдрын өвчинд их сайн байна. Адууны хүүхэн туруу гээд байдаг юм адууны урд хөлийн дотор талд байдаг, тэр бол нойр булчирхайнд их сайн байна. Хонины дотор эрхтэнд жишээлбэл дэлүү болон сархинаг нойр булчирхайны өвчинд их сайн байна. Малыг зүйлс бол их сайн. Тэр чононы зүйлсийг их сайн гэж ярьдаг. Би бол тэд нарыг хэрэглэж ч үзээгүй хүнд ч өгч үзээгүй. Зүгээр өөрийн идэж байгаа адууны хүүхэн туруу гэх жишээтэй.

**Зу: Одоо жишээ нь яаж хэрэглэх үү ?**

Бо: Өлөн элгэн дээрээ л ууна л даа. Өлөн элгэн дээр уухаар стакан хэрээтэй ууна.

**Зу: Та тэрийг хэнээс мэдэж авсан бэ ?**

Бо: Тэр бол бүр дээр үеэс манай хөгшчүүл шүдний өвчинд хүртэл зуудаг гэж ярьж байсан байхгүй юу. Нөгөө дээр үеийн улс жаахан болхидуу байсан юм уу даа, юм өвдөхөөр л хэрэглэдэг байсан юм уу, сав өгөөд ч нэг нь хэрэглэж байсан юм уу. Энэ бол бүр дээр үеэс хүн болгоны амнаас дамжаад энэ сайн гээд хэлэхээр тэнд очиж нэг нь хэлээд түүнийг гаргасан юм шиг хүмүүс ихтэй болчихоод байгаа. Гэхдээ энэ бол ганцхан манай хөгшчүүд биш Монголын уламжлалт зүйл болохоор хүн болгон л мэдэж байсан.

Сүүл үед бол нойр булчирхайгаар их өвддөг болсон тул тэрийг их сэргээж байх шиг байгаа юм. Хонин зээргэнэ бөөрөнд их сайн.

**Зу: Хонин зээргэнийг яаж хэрэглэх үү ?**

Бо: Тэрийг бол бас л ууж хэрэглэнэ бөөрөнд маш сайн жаахан сэрүүн талдаа юм шиг байгаа юм. Энэ ганга өвс, хонин зээрд хоёрыг жорыг тааруулаад уух юм бол хаванд сайн. Одоо улсууд хавагнаад байна гээд тэгдэг шүү дээ. Хавангийн эм ууж байгаа, шээс боогдлоо гэдэг, энэнд уувал маш зөв зүйтэй юм шиг байдаг юм. Монголд бол хөрснөөс гарч ирж байгаа бүхэн л эм шахуу юм байгаа. Энийг л бид хэрэглэхгүй юм. Одоо ясны бэртэлд манайд түргэн цагаан гэж зүйл байна. Энэ бол гэр оронд байж болдоггүй хадгалж болдоггүй. Хадгалах юм бол бэртэж гэмтэх аюултай.

**Зу: Тэр зөвхөн танай нутагт ургадаг юм уу ?**

Бо: Манай нутагт ургана гэхдээ ер нь говь талдаа ургана. За тэгээд хар өвс гээд өвс байна. Энэ бол хавдрын өвчинд маш сайн өвс, хар тамхины хольцтой гээд Монгол улс хориглосон юм байна лээ. Энийг хориглохгүй анагаах талынхаа найрлага өвсөнд зарж байдаг бол зүгээр юм шиг байгаа юм. Гэхдээ хувь улс их зарж байна. Одоо бол бүтэхгүй юм их хийж байна шүү дээ. Одоо өөрийн сонссоноор морин зээргэнийг хонин зээргэнэ гээд аваачин уулгаж идүүлдэг. Иймэрхүү талын зүйлс хүний чанар муудаад их элбэг болж.

**Зу: Та бариа засал хийдэг, тан дээр голчлон хэр их хүн ирэх үү, та сүүлд шүдний өвчин эмчилж байна гэж байна. Шүдний өвчин мэдээж хамгийн хэцүү өвчин байдаг. Тэгэхээр та ямар арга хэрэглэж байна, шинэ арга хэрэглэж байна уу эсвэл уламжлалт арга хэрэглэж байна уу?**

Бо: Энэ бол уламжлалт арга. Дээр үеэс хийсэн, энгийн хүн ч хийж чадахаар арга гэхдээ буруу хийвэл хүн түлэх магадлал өндөртэй хамаагүй хүнд зааж өгөөд байх хэрэггүй. Одоо миний энд 3 хоногийн өмнө нэг багш шүд нь өвдөж орж ирээд инээгээд гарсан. Хэрвээ сэвхтэй бол авхуулахаас өөр аргагүй өвдөнө, сэвхгүй байвал болно. Яагаад тэгдэг юм бол доо. Уламжлалтын Нацаг хамбын Манба дацан сургуульд Даш маарамба билүү дээ, тэрүүгээр эрдмийн зэрэг хамгаална та өгчхөөч гэсэн тэгээд би өгсөн л дөө.

**Зу: Таны шүд эмчлэх арга гэсэн үг үү ?**

Бо: Тийм тэр хүнд би өөрт нь өгсөн л дөө. Дажгүй залуу байгаа тэгээд түүгээрээ эрдмийн зэрэг хамгаалдаг гэсэн үү тэгээд би болно гэсэн.

**Зу: Та жаахан дэлгэрүүлээд яривал ?**

Бо: Шүд эмчлэх бол шүд, нүд хоёр чинь ер нь хамгийн хэцүү шүү дээ. Шүдний өвчин бол манай Монголд ургадаг зэрлэг сонгинын үр байна шүү дээ. Тэрэнд нэг жаахан найрлага хийгээд аргалын хөх цог дээр хийнэ. Тэгээд утаа гарна, утаа гарахаас өмнө барианы шилийг шар тосоор эсвэл сүүлний тосоор тосолж байгаад дээрээс нь таглаад тавина. Тэгэнгүүт тэр шил маань дүүрэн утаа болно. Цог дээр тавьсан шил халж таарна. Тэрийгээ зузаандаа өдий хэрээний барианы шилэнд таарсан марлаар бооно, тэгээд чихэндээ тааруулна тэгээд санаа дагаад тэгдэг юм уу жижигхэн хар



хялгасархуу маягийн өтөрхүү юм гарсан байдаг. Тэр зүгээр өт гараад байгаа юм болов уу тэгээд зүгээр болчихдог болохоор, өөр янз бүрийн юм мэдэхгүй болохоор шүдний өвчин бол гайхалтай дарагдана, уйлж орж ирээд инээгээд л гарна. 15 минутын л ажил, ахиж тэр шүд бол өвдөхгүй авхуулах шаардлагагүй, тэр өгөрч л дуусна ахиж тэр шүд өвчлөхгүй.

**Зу: Тэгэхээр маш сонирхолтой байна л даа шүд өвдөж байхад чих рүү төөнөж байна гэсэн үг үү ?**

Бо: Тийм чих рүү.

**Зу: Энэ арга ухааныг та өвлөж авсан уу?**

Бо: Тийм өвлөж авсан. Энд өвдөж байгаа зүйлийг чих рүү хийж байгаа шүү дээ. Тэгэхэд л тэр дарагдана.

**Зу: Энийг бол би анх удаа сонсож байна л даа сүүлд олон юм судалж байхад долоон тогооны хөө ч гэдэг юм уу, оо ч гэдэг юм уу хүмүүс аргалдаг шүү дээ. Эдгээрийг бол яах вэ орчин үеийн анагаах ухаан шууд үгүйсгэдэг. Таны хэлсэн арга бол их сонирхолтой байна. Яг энэ шиг бас өөр ямар арга технологи байна вэ ?**

Бо: Одоо энэ үлд гээд өвчин сүүл үед гараад байгаа шүү дээ. Битүү бие нь яр шархандаа баригдсан. Анагаахаар бол эм тариа хийлгээд хэд хонодог ахиад хэд хоноод гараад ирдэг. Энэ зүйлийг би бас эмчилдэг. Энд эмчилгээ хийсэн тохиолдолд дахиж үлдний асуудал байхгүй. Тэр болохоор зэрэг хөх арвай, билүү гээд хутга хурцалдаг чулуу хоёроор эмчилнэ. Хөх арвайгаа бол тэгшхэн төмпөнгийн ёзоор дээр тавьж байгаад халуун хайруулаар хайрна. Тэгэнгүүт хөх арвай маань түлэгдээд хар баас гарна. Тэр арвай нэг их гоё үнэртээд л давирхай шиг ч юм уу тийм зүйл гарна. Арвай шатаж дуусахад халуун хайруулаар түлсэн тэр арвайг тойрсон шар юм гарч ирдэг. Тэрийг билүүтэй холиод түрхэхэд маш их хорсоно. Тэгээд л гурав түрхсэн байхад ахиж гарахгүй дээ.

**Зу: Яг бидний хайж байгаа зүйл бол ийм л зүйл байна. Орчин үеийн анагаах ухаан бол лазердах юм уу тийм байна. Бидний уламжлалт анагаах ухаанд ингэж анагаадаг гэсэн зүйл л хэрэгтэй байна. Тэгэхээр та өөр ийм аргууд байвал хэлж өгөөч? Энэ бол таны арга ухаан учраас танд л үлдэнэ бид энийг олон улсад бүртгүүлэхдээ ашиглана уу гэхээс өөр бусад зүйлд ашиглахгүй. Таны энэ аргыг өөр эрдэм шинжилгээ янз бүрийн зүйлд ашиглах бол таны нэрийг заавал ашиглана.**

Бо: Одоо тэр тарваганы яс байна шүү дээ. Одоо манайд байгаа л даа би бэлдээд авчихдаг байхгүй юу. Хүнээс “та надад жаахан тарваганы яс өгөөч” гээд авч нүдээд аргалын цог дээр үхрийн хөх аргал гэж байдаг шүү дээ тийм хөх аргалтай хольж шатаахаар тэрний үнс бурзайгаад яснууд нь үлддэг. Дамаа тэр чөмгөнд хэрэглэвэл их үр дүнтэй болно. Манай Монголын энэ ухаан бол лут том юм л даа. Одоо бол би юмнуудаа найруулж эхлээд л, ид хийж бүтээх насан дээрээ явж байна гэж би бодож байгаа юм. Яг одоо би баталгаатай туршаад хүн дээр эмчилсэн зүйлүүд эд нар байгаа байхгүй юу. Цаашаа бол улсуудад өгч эхэлж байгаа эмчилж байгаа зүйлс байна л даа.

Эд нартаа одоо бол 100 хувь итгэлтэй, миний брэнд гэдэг шиг зүйлүүд болж байна. Энэ нүдэнд цагаа хэрэглэдэг. Энэ бол одоо дун гэдэг зүйл байдаг юм. Энэ маань дээр үеийн далайн бүтээгдэхүүн юм, чи мэднэ шүү дээ лам нар үлээдэг. Тэр зүйлээс маш жижиг хагалж аваад нүдээд хуурайдаад юм уу, үрээд ширхэггүй болгож байгаад нүдэнд хаясан цагаа гэж ярьдаг шүү дээ түүнийг хуулж авдаг гэж байгаа. Тэрийг хоёр дусаахад тэр ерөөсөө алга болно. Ерөөсөө баталгаатай зүйл.

**Зу: Барианы хувьд тархи доргисон тохиолдол тан дээр маш элбэг ирдэг үү ?**

Бо: Энэ бол маш элбэг бас бөөрийг барина. Хүн болсон хойно гэдэс дотор, үе мөч хүний хүрч болох газруудад хүрч байна даа.

**Зу: Энэ бол хувийн асуулт шүү. Архи бага зэрэг хэрэглэхээр энэ мэдрэмж сэргэх үү үгүй юу ?**

Бо: Энэ бол яах вэ зориг орох гэдэг юм уу хэрэглэнэ. “Муу эр архин дахтай, муу морь төмөр дахтай” гэдэг энийг бол би хэрэглэж байсан. Зориг орж байна гээд архи уудаг, хүн хараад хэлмээр санагдсан юм уу жаахан ууж байгаад хэлчихдэг, зориг ороод хүн эрүүлдээ хэлж чадахгүй шүү дээ. Жаахан халсан үед арслан барс шиг болчихдог хүн чинь тийм үедээ айлгүй ичилгүй хэлчихдэг. Энэ бол өөрөө их буруу зүйл билээ. Архитай янз бүрийн зүйлийг холих бол буруу. Алдаа гаргах магадлал их, сүүлдээ өөрийн амьдрал бор дарсанд хөтлөгдөөд, шил архи гуйх хэмжээний болж болох буруу зүйл билээ.

**Зу: Одоо нэг зүйл байна л даа. Европын анагаах ухаанаар яваад барахаа болиод уламжлалт анагаах ухаан руугаа эргээд ханддаг ч юм уу тийм зүйл байгаад байдаг. Эсвэл зарим хүний хэлж байгаагаар орчин үеийн анагаах ухаан, европ анагаах ухаан зарим зүйл дээр бүр дордуулчихдаг тэгээд буцаад уламжлал дээр гайгүй болдог эсвэл бүр найдваргүй болсон байдаг тийм зүйл байна. Тэгэхээр тан дээр ирж байгаа хүмүүс орчин үеийн анагаах ухаандаа итгэхгүйгээр ирж байна уу ? Энэ бүхний талаар яривал?**

Бо: Энэ маань бүр арга ядахаараа ирдэг байхгүй юу. Европ талаар явж байгаад л нөгөөдөх нь тэндээс тийм үнэтэй юм түрх, тийм тариа хийлгэ гээд л хийлгэнэ. Тэгээд сүүлдээ бүр бүх биеэ дүүрэн үлдтэй болоод ирнэ гэдэг бол арга ядаад л ирж байгаа юм л даа. Үүгээр эдгэчихдэг болов уу гээд арга ядсан “Лам олдохгүй бол буцахдаа таныг залъя” гэдэг шиг тийм л зүйл болчихоод байна. Шашинтайгаа анагаах ухаан нь уялдаа холбоо нь нэг системд очих юм бол манай монголчууд өвчнийг анагаах зүйл бол маш их байгаа. Одоо хатги гэж лут зүйл гардаг нэг гарахаараа долоо гардаг. Энэ зүйлийг эмчлэхэд орчин үеийн анагаахаар зүслэг хийгээд эмчилдэг. Тэгэхгүйгээр манай тэр хөх арвай гэж ярьж байгаа хөх арвайн юнгар гээд зүйл гардаг юм. Энийг гурилтай холиод тавихад гурван цаг болоод зад үсэрнэ, дахиад гарна гэж байхгүй. Одоо манай жишээ байна даа Бямбадорж гээд хүн тархи нь тэр аяараа хатгинд баригдсан, толгой нь хэчнээн зүслэг хийгээд барахаа больсон ийм хүн ирсэн. Тэр хүн хоёр ирсэн билүү дээ тэгээд одоо зүгээр болсон. Хөх арвайн юнгар гээд жижигхэн үр шиг хүрэн юм байдаг юм.

**Зу: Энэ зүйлс дорнын анагаах ухааны ном сударт байдаг болов уу, эсвэл зөвхөн монголчуудын, Монгол угсааны, Монгол эм эмнэлэгт юм болов уу ?**

Бо: Энэ бол Монгол байх дорнын анагаах ухаанд юнгар гэж юм тавиад гэж зүйл байхгүй байх тэрийг би баталгаатай хэлнэ.

**Зу: Ер нь бол Монгол анагаах ухаан дорнын анагаах ухаанд ижил төсөөтэй маш олон зүйлс байна шүү дээ. Тэгэхэд тэр дундаас яг Монгол гэх онцлогтой зүйл маань юу вэ?**

Бо: Дорнын анагаах ухаан чинь орчин үеийн анагаах ухаантайгаа холилдож яваа зүйл шүү дээ. Энэ хоёрын удирдлагын системийг нэг болгочихоор нийлж байгаа юм. Тэгээд манай Монголын анагаах ухаанаас их хумсалсан байхгүй юу. Бид нар чинь үүнийг бүртгүүлж чадалгүй янз бүр болгож чадахгүй байсаар байгаад их алдсан. Тэр битгий хэл энэ дээр үеийн сайн улсууд бүр хэвтэрт орсон хоног тоолоод байж байдаг хүмүүсийг босгоод ирдэг байж. Манай хөгшин ярьдаг байсан за одоо өнөө маргаашиггүй боллоо гээд гэрийнхэн нь ярьдаг байсан юм. Тэгсэн нэг бадарчин орж ирсэн юм байна л даа. Энэ бадарчин гэдэг чинь дээхэн үеэр лам гэхэд лам биш асман болсон гэх юм уу. Одоогоор ярих юм бол шашны сургуульд суух гэхээр төвд номын юмандаа сууж чаддаггүй, тэгсэн хэр нь байгалийн өгөгдөл байж байдаг. Шашинтай холбогдож чаддаггүй ингэж явж байгаад нэг айлд орсон юм байна л даа. Айлд орж ирээд нөгөө хүн маань за одоо та манай эхнэрийг эмчилж өгөөч гээд тэгэнгүүт тэр хэвтэрт байгаа эхнэр нь юм хэлж чадахгүй нулимс нь цийлгэнээд ирж. Тэр үед өгөх юм олдохгүй тэр хүн хүзүүгээ имэртэл дээр үед олон хоногоор усанд оролгүй тэнэж явсан хүний хүзүүний хир хуйлрахгүй юу, гурван ширхэг хир хуйлрангуут түүнийгээ гурван өглөө буцалгаж өгөөрэй гээд хирээ өгөөд явсан байна. Тэгэхэд нөгөө хүн гурван хоног уугаад босоод ирсэн гэж байгаа байхгүй юу. Тэр бол Монгол хүний байгалийн өгөгдөл хиртэй хөлсөө өгөхөд хүртэл эдгэдэг тийм байгалийн өгөгдөлтэй хүмүүс их байсан байна л даа.

**Зу: Та энэ өгөгдлийг мэдээд улам хөгжүүлбэ гэж бодсон уу, эсвэл нууж дарагдуульа гэж бодсон уу, магадгүй жаахан хувийн юм байж магадгүй тэр талаар та дэлгэрүүлж яривал ?**

Бо: Залуу байхад бол 20 орчим настай байхад түүнийгээ хүнд яриад явбал итгэхгүй. Тэгнэ биз дээ? Би тэгэхэд 12 настай байхдаа Говь-Алтай аймгийн Гуулин тосгонд 110 настай Самбуу гэж хүний ойн бөхийн барилдаанд очоод байж байлаа. Говь-Алтайн эмч нар тэр хавийн бүх л баруун мөр нь мултраад гар нь унжчихсан бөхийг эмчлэх гэж тэнд хүмүүс 1 цаг 30 минут хэртэй ноцолдоод 2 цаг ч боллоо нөгөө хоёр бөхийг үзэх гэсэн улс зөндөө. Тойрсон улс бүр сүүлдээ тэр бөхийг л хараад. Тэгэхэд би хэлэхгүй юу “энэ хамгийн амархан зүйл байна” гэж. Хэлсэн чинь “чи чаддаг юм бол янзал, энэ олон хүн чадахгүй байхад чам шиг чацга чаддаггүй юм” гээд намайг бассан маягтай хэлэхгүй юу. Тэгсэн би өөрөө чаддаг учраас хүнд бас басуулсан хүн чинь яваад очлоо. Би оруулаад өгөх үү гэсэн “өө тэг” гэж байна. Тэгээд хүний булчин агшчихдаг юм. Агшихаар спирт өгөхөөр агшдаг байхгүй юу.

Дээр үед “нэг спирт аваад ир” гэхээр нэг архинд дуртай хүүхэд байна л гэж санасан байлгүй дээ. Улсууд чинь хараад л байна, би нөгөө мөрийг нь сайхан шавшлаа, ах нь гээд бас нэг бөх байсан, би тэгээд та гутлаа тайлж байгаач гээд гутлыг нь тайлуулаад хөлийн бондгор өсгийг нь энэ рүү хийгээд жаахан хөлжөөл татсан тас буугаад яваад өглөө. Барилддаг улс булчин гэж аймар байгаа шүү дээ. Тэгээд “туг” гээд дугараад ортол тэнд байсан улс намайг хугалаад хаячихлаа гэж санаж байгаа юм шиг байгаа юм. Тэгээд хэд илээд гараа хөдөлгө гэсэн хөдөлгөөд тэгээд би цаашаа явтал тэнд байсан улс намайг бурхан мэт тэврээд явж байсан. Тэгэхээр зэрэг тийм зүйл их байсан. Би тэгэхэд залуу байсан тэрийгээ жаахан нуух янзтай. Одоо бол би 40 гараад тэрнээсээ суралцах, мэдээллээс янз бүрийн юм авах хүнтэй ярилцах, хуучлах ном судар, тиймэрхүү талын зүйлээ дэлгэрүүлээд явж байна. Тэгээд одоо манай охин 10 дугаар анги. Охиндоо бол энэ зүйлээ өвлүүлэхээр бэлдэж байна. Түүрүү түүрүүчийнхээ толгой барих зэргээр. Толгой барих чинь ер нь бага зүйл шүү дээ. Монголд чинь тархины хөдлөлт зөндөө байна, энэ зүйлүүдийг зааж өгч байна. Бөөр, бөөрний өвчинд бол Монгол улсад эр, эм хөгшин, залуугүй нэрвэгдэж байна, энэ зүйлүүдийг зааж өгч байна.

**Зу: Нэг ийм зүйл байдаг л даа. Европ ч юм уу, Америкт тэд нарын спортын тэмцээн үзэхэд түүн дээр тамирчдын тархи доргисон гээд сарын хугацаанд тоглодоггүй. Монголчуудын хувьд бол үнэхээр сайн бариач, гартай юмтай хүн ч гэдэг юм уу тийм хүнээр бариулаад 2, 3 хоногийн дараа зүгээр л явж байдаг. Тэгэхээр энэ бол монголчуудын давуу тал юм болов уу гэж би боддог.**

Бо: Энэ тархи хөдөлнө гэдэг бол хүн үхлийн аюулд хүрч болох зүйл. Тархи гэдэг бол ийм бөөрөнхий зүйл, гадуураа ийм усан зүйл байдаг. Машинаар бол тосолгоо маягийн зүйл юм. Тэр гадуур байгаа тархи, яс хоёрыг салгаж байгаа зүйл нь жаахан гүйгээд нэг талдаа их болоод, нэг талдаа яс маань тархитайгаа хоёр яс хавиралдахаар хүн өрөөсөн тал нь татуу болох, гарын хуруу хүртэл урт богино болох, нүд дээр дор болох ийм зүйлүүд бол тархины саажилт болох гээд өөрчлөлт өгч байгаа юм шиг байгаа юм. Энийг барихаар зэрэг усыг тэнцвэрт байдалтай усан бүрхүүлээр жигд бүрхүүлэхээр тархи зүгээр болчхож байгаа юм. Гэхдээ толгой барихад анхаарах олон зүйл байна. Машинтай явж байгаад янз бүрийн аваар осолд орох, мотоциклтой явж байгаа гэмтсэн зэрэг тохиолдолд юмыг яаж мэдэх үү, суурь яс гэмтсэн тохиолдолд үүнийг барих шаардлагагүй. Барьж байгаад нөгөө хүн маань юмыг яаж мэдэх үү харвалт өгөх, нөгөө хүн маань цууралттай учир янз бүрийн байдалд орох, үүнийг өөрөө бас мэдрэмжээр тэр толгой ямар байна, яс ямар байна, хаана их өвдөж байна, жишээ нь: тархины суурь яс гэмтсэн бол хурууны үзүүр хүргээд энд энд ямар байна, их л сайн үзэж байж барихгүй бол хүний аминд хүрэх магадлалтай зүйл л дээ. Энэ дээр бас анхаарах ёстой.

**Зу: Тан дээр ирсэн зарим нэг хүмүүсийг би үнэхээр чадахгүй ч гэдэг юм уу больж байсан удаа байгаа юу ?**

Бо: Байлгүй яах вэ. Хүний алтан амь гэдэг чинь бас лут зүйл шүү дээ. Аваарт ороод нэлээн лут болсон хүн ирсэн. Би барьж өгөөгүй. Та бариад өгчих, бариад л зүгээр болдог шүү дээ гээд. Ах нь энэ удаа барихгүй ээ, наадах чинь чиний суурь яс гэмтэл өгсөн байна гэж хэлж байсан. Одоо тэр залуу маань эмнэлгээр яваад бүр групп тогтоолгох дээрээ болсон явж байгаа.

**Зу: Одоо би нэг асуух гээд байгаа зүйл нь мэдрэмж байхгүй хүн дадлаар сурахад тэр хүн мэдрэхгүй учраас аваарт орсон хүний суурь ясыг мэдрэхгүй байвал тэр хүнийг эрсдэлд оруулах боломжтой гэсэн үг үү ?**

Бо: Боломжтой байлгүй яах вэ.

**Зу: Одоо ямар ч мэдрэмжгүй ч гэлээ байнгын давталтаар сурсан хүн, яс нь цаанаа тийм зүйл нь гэмтжээ гэж мэдэрч чадах уу ?**

Бо: Тэрийг бол яах вэ өөрөө их хичээгээд сурсан хүн болгоомжтой хандаад мэдэрч болно. Тэгэхгүй барих юм бол асар их ноцтой зүйл. Жишээлбэл хавирга хугарсан гэж бодлоо гэхэд энэ нь уйланхайтай хэсгийн хавирга, энэ нь цээж хэсгийн хавирга, энэ нь ар дал хэсгийн хавирга гэж дарахдаа бүр алс дарна. Энд нь гэмтсэн, энэ дээр та дараадах гэхэд энэ ард юм уу энд нь юм уу дарна. Тэгж байж тэр гэмтсэн хавиргыг олж авдаг байхгүй юу. Ингээд явж байгаа хавирган дээр дарахаар өвдөнө дөө, тэгж байж болно. Зарим хүмүүс бол хугарсан хэсэгт дарж байгаа. Тэр бол тэртэй тэргүй хугарсан яс нь тодорхой. Тэгэхээр зэрэг бид энэ хавирга хугарсан байж байхад хоёр хавирга хугарсан бол нэг хавирга нь цаашаа цөсрөлттэй энэ хавирга нь хугараагүй байна гээд орхивол энэ хавирга өөр зүг рүү хазайх магадлал маш өндөр, цаашаа үзүүр нь сөрдийсөн тохиолдолд түүнийг маш сайн анзаарах хэрэгтэй. Нэг хүн түрүүнд барьсан юм байна лээ. Тэгээд тэр нь бороолж байсан чинь ахиж нөгөө хүүхэд маань тоглож байгаад ахиад гэмтээсэн. Одоо наадахаа боогоодох оо боохгүй бол болохоо байлаа гээд тэгэхээр нь хуучин боосон хүнээр нь боолгочих гээд хэлсэн чинь үгүй чи боогоодох гээд намайг гуйсаар байгаад боолгодог юм. Тэгээд нөгөөдхийг нь боож өгөөд явуулсан. Тэгээд би өөрөө хаширлахгүй юу. Түрүүнд хүн боосон байсан хэрэв янз бүрийн юм буруу боолттой байж байгаад тэр хүн гаргүй болбол над дээр хамгийн сүүлийн боолт байгаа. Би хэрэгт орно янз бүрийн асуудалд орно гэж санаад аймаг яваад үзүүлээдэх гэсэн юм. Тэгсэн аймаг яваад үзүүлсэн “энэ хоёр чүдэнзний мод зөрөх зайны буруу боогоод эргээд зөв боосон байна”, “энэ ямар хүн боосон” гэж асуусан байна лээ. Тэгэхээр тэр гарын мэдрэмж гэдэг бол лут зүйл байгаа юм. Одоо жишээ нь хүний хөл гэмтсэн юм уу гар гэмтсэн байж байгаад хэн нэгэн хүн боосон байхад би тэрэнд хүрдэггүй. Тэр хүн л тэрийгээ хариуцах ёстой. Тэр дараа нь над руу эрсдэлээ түлхэх магадлал өндөр байхгүй юу. Би өөрөө ч тэгдэг юм уу бүх яс ус барьдаг хүмүүс тэгдэг байх хүний боолт боочоод зайлшгүй султгах ёстой, суллахгүй байж байгаад гар хөлгүй болгосон улс зөндөө байна. Боолтоор нь чангалаад дэндүү боочихсон. Гар нь бүр хатаад цус эргэлдэхээ байгаад гар чинь их удаан байхаар хаталтын байдалд ордог, хүний гар бооно гэдэг маань том хариуцлага байгаа юм.

**Зу: Одоо жишээ нь интернэтээр лайв их хийдэг хүмүүс хүн бариад л байдаг шүү дээ. Та бас харж л байгаа байх. Тэр хүмүүс ямар байна боломжийн уу? Эсвэл мөнгө төгрөг ашиг хонжоо харж байна уу? Тэр талаар таны хувийн бодол?**

Бо: Миний бодол бол хийж чаддаг бол лайв хийж өөрийгөө сурталчлах шаардлагагүй аандаа л хүн ирнэ. Тийм учраас яриандаа дурдаад өнгөрсөн. Миний энэ зүйлийг сураад мөнгө авах гэж ашиглах вий. Үнэхээр барьж чаддаг бол мөнгө авах гээд байх шаардлагагүй, зүгээр сайхан бариад л өгчих. Тэр хүн чинь цаашаа хүнд хэлнэ, тэр нь хэлнэ гээд аандаа цааш нь явдаг тийм болохоор мөнгө авах шаардлагагүй. Өнөөдөр лайв хийгээд л зарим нь эдгэж байна гээд ярьдаг л даа. Би ямар тэнд очиж бариулж үзсэн биш, эдгэсэн хүнтэй уулзсан биш тэгэхээр бас л миний адил бариач болох гээд явж байгаа. Тэгэхээр би тэд нарыг үгүйсгэдэг ч үгүй муулах ч дургүй.

**Зу: Та сайн бариачтай амьдралдаа уулзаж байсан уу?**

Бо: За ёстой байхгүй. Би үнэхээр сайн бариач гээд хүн байсан, ер нь л их таалагдаагүй. Эхлээд тэр хүний сэтгэл зүйтэй гоё ярих ёстой, “за одоо барилаа, энэ жаахан зүйл дороо эдгэнэ” гэх ёстой. Хүнийг сэтгэл санаагаар нь үхүүлчихдэг байхгүй юу. Хүн чинь сэтгэлийн амьтан, хамгийн гол нь сэтгэлээр нь эхлээд сайхан тордоод “ингээд хугарсан байна” гэж хэлээд боочоод гэр орныхон болон өөрт нь сануулаад “3 хоноод султгана эсвэл их хавдах юм бол орой дуудаарай”, “яриарай намайг аваачаарай”, “боолтыг султгана шүү”, “7 хоноод, 14 хоноод ахиж султгана, чангална боолтыг нь султгаж байгаад чангална” гэх зэргээр сануулж хэлдэг. Эхлээд бооход дотор талын боолт сул байж байх хэрэгтэй. Тэгээд 3-4 давхраар бооно шүү дээ. Тэгж байгаад чигээ сайн тавих хэрэгтэй. Дотор талын 2 боолт сул байх хэрэгтэй тэгээд чангарсаар гадна талын боолт жаахан чанга байх ёстой. Тэгээд хавдар тулаад бүх юм хөхрөөд соронгуут боолтуудаа султгаад султгаад явна. Энэ мэтчилэнгээр ерөнхийдөө өөрөө өөртөө том хариуцлагатай л юм даа. Энэ бол том эрсдэл үүр байгаа.

**Зу: Би маш олон хүнтэй уулзаад явж байна. Дахиад ч уулзах байх. Тан шиг уламжлалт анагаах ухааныг уламжлагчид их даруухан байх юм.**

Бо: Даруухан гэж бас том хариуцлага л байгаа юм. Хөгшин хүмүүс хэлдэг шүү дээ “үхсэн хойно яс бага өндөлзүүлээрэй” гээд. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр тэр хүний нэр надтай давхар дуудагдах байхгүй юу. Тийм болохоор хамгийн гол зүйл бол хүн хийж байгаа зүйлдээ л өөртөө итгэлтэй байгаа бол цаад хүн итгээд ирсэн яс гэмтсэн байх юм уу, янз бүрийн бие хаа нь өвдсөн байх юм уу тэр хүн ямар ч тохиолдолд ирж байгаа үед тэр хүний итгэлийг алдахгүй л байх хэрэгтэй. Сайхан бариач нар орчлонгоор дүүрэн байгаа гэж би бодож байна. Тэгэхээр зэрэг би сүүл үеийн бариач нартаа хамгийн гол нь мөнгөнд шунаж болохгүй шүү гэж хэлмээр байна. Энийг хасаж болохгүй бүр цааш нь дэлгэрүүлэх хэрэгтэй. Би хүн болгонд л хэлье гэж боддог юм. Би хотод очоод байж байхад зарим улсууд ирээд намайг гэртээ аваачдаг. Хэдэн төгрөгийн өргөл барьцтай вэ гэдэг. Надад бол өргөл барьц чухал биш хамгийн гол нь надад тэр хүн эдгэрэх чухал. Би өөрөө тэрийг хүртэхгүй миний

үр хүүхэд тэрийг хүртэнэ. Хоолтой ундтай аз жаргалтай амьдарч байна, сайхан амьдарч байна гэдэг бол тэр улсын л ач буян байх аа л гэж бодож байна.

**Зу: Би энэ төсөл дээр ажиллаад, судалж байхад зүү төөнүүрийг Хятад 2010 онд бүртгүүлсэн юм байна. Гэхдээ зарим сурвалж дээр энэ бол Монголын арга, агаар нь эрс тэрс учир монголчууд энэ төөнөх аргыг хэрэглэдэг гэж ярьдаг боловч Хятад бүртгүүлсэн. Тийм болохоор бид юуг бүртгүүлбэл боломжтой гэж харж байна вэ?**

Бо: Одоо энэ бариа засал маань бүртгүүлэхэд буруудах юм ерөөсөө байхгүй. Манайх чинь хамаг юмаа алдчих гээд, бүх л сайхан сайхан зүйлээ алдчих гээд л байгаа юм. Энэ бариа засал гэдэг бол засал гэхээс гадна Монгол ухаан юм. Монголын маарамбууд гэж байсан. Тэр маарамбууд орчин үеийн анагаахтай холиод маш боловсронгуй болж байсан тэр зүйл бол устчихаад байгаа. Тэр зүйлийг Хятадууд булааж авчхаад байна. Одоо бол бид нарын төлөө дугардаг хүн байхгүй. Одоо хувиараа бариа засал хийдэг хүмүүсийг анагаах буруутгадаг шүү дээ. Одоо жишээ нь хувь хүнээр бариулж байхаар гипсдүүлж хадуулах байсан юм гээд. Тэрнээс хүнд хүнийг би барьж байсан одоо бүр хаашаа ч гарахгүй л яриа юм даа. Манай ээжийг хүн барьсан байсан юм. Бараг 90 хүрч байсан хүний дунд чөмөг ташчихсан, тэрийг би боож байх үед 45 хоносон байсан учраас боогдоогүй. Энүүгээрээ бүр ингээд гозолзоод тэгээд 15, 20 хоносон байх, тарваганы ястай нөгөө янз бүрийн юмтайгаа хольж өгөөд тэр хүн бол тэрнээсээ болоод бурхан болсон л доо. Гэхдээ бараг бороолоод бурхан болсон. Тэгэхээр хүн ер нь сэтгэлээсээ үнэнч байх ёстой л гэж боддог. Өвчнийг нь эдгээж өгөх гэж байгаа бол нэгдүгээрт, өөрт нь сайн тайлбарлаж өгөх ёстой. Хоёрдугаарт, хийж байгаа зүйлээ сайн тайлбарлах хэрэгтэй. Заримдаа бол манай эхнэр ч гараад явна. Тэр хүн болон тэр хүний ойр дотнын хүн л үлдэнэ. Гаднаас хүн үлдээд байх шаардлагагүй. Эрэгтэй хүний хажууд бол хүн байхгүй байж болно. Эмэгтэй хүн бол хажууд нь хүн байхгүй бол болохгүй. Одоогийн нийгэм мушгин гуйвуулдаг болсон. Янз бүрийн зүйл их болсон. Энэ тал дээр сайн анхаараарай л гэж хэлье

### **Завхан аймаг Бороохойн Цэндсүрэн**

Цэ: 1967 онд Завхан аймгийн төвд төрсөн. Манай аав Улиастайн 2-р баазад насаараа жолооч хийсэн. 1990 онд энд гарч ирсэн. Манай аав уг нь энэ нутгийн хүн байхгүй юу. Манай хөгшин аав энд амьдарч байгаад 1999 онд өөд болсон. Аав маань 2002 онд өөд болсон. Би эм тангийн юм хаашдаа үе дамжсан гээд хааяа нэг цэцэг, навч түүдэг юм. Одоо бол голдуу худалдаанаас л авдаг. Урд хилээс ирдэг юм уу, хойд хилээс ирдэг юм уу чухам сайн мэдэхгүй юм.

**Зу: Аваасаа сурсан зүйлээ нарийвчилж ярьвал?**

Цэ: Надаа яг сурсан зүйл байхгүй. Монгол эм чинь жороор хийдэг болохоор, жишээлэхэд надад эм чигнэдэг чигнүүр байна. Энүүгээрээ чигнээд хийдэг юм даа. Би энүүгээр л юм хийдэг юм. Ууранд хийгээд гараараа нүднэ. Би нэг их юм хийдэггүй юм. Чаддаг ч үгүй юм. Цэцэг, навч сайн танихгүй болохоор манай аав надад хар цүнх өгсөн, тэр дотор хийдэг жор нь байгаа.

**Зу: Та ааваасаа жор болоод сургаал ном авсан гэсэн үг үү?**

Цэ: Тийм, тийм зүйл авсан. Янз бүрийн цэцэг навчны зүйлийг өвлөөгүй. Яахав аавыг амьд байхад би хийсэн танг нь нүдэх, барих ойр зуурын юм хийлцэж л байсан. Хөгшин аавтайгаа бас их хийлцдэг байсан. 1999 онд аав маань өөд болсон. Хүн амьтанд тус болох болов уу гээд байж байна.

**Зу: Одоо тан дээр хэр хүмүүс ирж байна?**

Цэ: Нэг их хүн ирдэггүй юм. Хэдхэн хүн л зорьж ирнэ. Ойр зуурын хүүхдийн тархи толгой барьж илдэг юм. Тархи нь хөдөлсөн хүүхэд ирээд бариулаад гайгүй болчихдог юм байлгүй. Манай аав бас жаахан илж барьдаг хүн байсан юм.

**Зу: Танд зааж сургасан зүйл байгаа юу?**

Цэ: Үгүй тийм зүйл байгаагүй. Би зүгээр өөрөө хараад сууж байдаг байсан. Одоо яахав ганц нэг хүүхдийн толгой бариад л илээд л тиймэрхүү л юм хийнэ.

**Зу: Та сая хэлсэн ааваас танд үлдсэн хар цүнхтэй юм гээд?**

Цэ: Энд одоо байдаг юм. Монгол эмийн жор гэсэн гараар бичсэн бичмэлүүд байгаа. Энэний орц юмнууд нь ингээд бичээстэй.

**Зу: Одоо та аавын өгсөн, заасан зүйл дээр юм нэмж судалж байгаа гэсэн үг үү?**

Цэ: Энэ дээр бичсэн зүйлийн учрыг олохгүй юм. Заримдаа тооных нь учрыг олох юм.

**Зу: Одоо та ихэвчлэн ямар эм тан боож байна?**

Цэ: Ядаргаанд сайн “цагаан тан” байна, “шижид түг” гээд эм байна, “ав жүтэн” гэж байна, “лидэр” гэж байна. Иймэрхүү зүйл хийдэг, зарим хүн авч л байх юм. Настайхан шиг улс ирж авах юм.

**Зу: Ковидын үед хүмүүс хэр их авч байсан бэ?**

Цэ: Авч байсан. Цагаан танг голдуу авдаг юм. Норов 7, мана 4 гээд ковидын үед их сайн гэж байсан шүү дээ. Хааяа нэг хийдэг юм. Юм нь бас олдохгүй юм аа. Манай энд ургадаг юмыг одоо гадарлаад байна. Манай энд “дэгд”, “дашиг” гэх мэт тиймэрхүү цэцэг янз бүрийн юм байна. Аав маань надаар түүлгэж байсан болохоор би ойр зуурын юм олоод түүдэг.

**Зу: Та үрт ургамлууд хаанаас түүж байгаа вэ?**

Цэ: Хот руу дүү нарт захиж авдаг. Гадаадаас орж ирдэг. Ойрдоо бас их ховордуу байх шиг байна. Хил гааль нь хаалттай. Тэнд нэг уур байгаа.

**Зу: Ер нь танд аав чинь амьд сэрүүн байхдаа энийг заавал сураарай гэсэн зүйл хэлсэн үү?**

Цэ: Заавал сураарай гэсэн зүйл бол аав маань хэлж байгаагүй. Би жаахан өөрөө сониуч зантай болохоор. Би чинь эцэг эхээсээ наймуулаа.

**Зу: Та энэ уламжлалт арга ухааныг өвлөөд явж байгаа юм чинь энэ аргыг цаашид хэн нэгэнд өвлүүлж гэсэн бодол бий юу?**

Цэ: Одоохондоо тийм бодсон зүйл алга. Гэхдээ би 3 үе дамжаад өвлөж байгаа болохоор, өвлүүлэх бодолтой байгаа гэтэл өвлүүлдэг хүн нь хаа байгаа юм, ямар хүн өвлөх юм, одоохондоо мэдэхгүй л байна. Би 4 хүүхэдтэй, бүгд хотод л байх юм. Тэгээд мэдэхгүй шүү дээ.



**Зу: Таны өвөө аав лам хүн байсан уу ?**

Цэ: Манай өвөө аав лам хүн байсан. 1920-иод онд Нийслэл хүрээ рүү явж шавилан суугаад 1930-аад онд эсэргүүний үед наашаа яваад, авга билүү нагац ламыгаа Завханы нутагт оршуулаад наашаа ирсэн гэсэн. Энд ирэнгүүт нь барьж аваад явсан. Энэ аймгийн төвөөр нэлээн хоригдож байсан гэж ярьдаг юм.

**Зу: Таны аав ямар хүн байсан бэ?**

Цэ: Манай аав 1940-өөд онд төрсөн. Айлын ганц хүү байсан. Манай аав насаараа жолооч хийсэн. Шуудан тээврийн улсын аварга хүн байсан.

**Зу: Таны аав мөн ааваасаа энэ аргыг хэрхэн уламжилан авч байсан тухайгаа ярьж байсан уу?**

Цэ: Тэрийг бол ганц хүүдээ заасан л байх. Аав гартаа жаахан мэдрэмжтэй. Эмэгтэй хүний сав, толгой барьдаг хүн байсан. Би чинь өвөөтэйгөө их олон жил байсан. 4, 5 настай байхад эм хийдэг байсан. Би агар гандигар мод үрдэг байсан. “Миний хүү үр” гээд үрж байгаад нүдэхээр амархан нүдэгддэг байсан. Манай аав ном л байнга уншдаг байсан.

**Зу: Тухайн үед танайхаар хэр их хүн ирж эм тан авдаг байсан бэ?**

Цэ: Нэлээн авдаг байсан. Манай аав нэлээн дэлгэрэнгүй хийдэг байсан. Би бол олон төрөл хийж чадахгүй. Яагаад гэхээр юмнуудыг нь танихгүй. Таних гэхээр манай нутагт зөндөө ургаж байгаа. Танина гэж бодоод чадахгүй л байна.

**Зу: Та бол өөрөө сурсан гэж байна, танд зааж сургасан зүйл юу вэ?**

Цэ: Үгүй яахав, “ингэж чигнэж барьдаг юм” гээд зааж л байсан л даа.

**Зу: Уламжлалт анагаах ухааны болоод орчин үеийн анагаах ухааны ялгаа давуу, сул талын тухай та хэлж өгөөч?**

Цэ: Би бол энийг хүүхэд байхаасаа эхлээд насаараа хэрэглэсэн. Орчин үеийн анагаах ухаанаас арай удаан үйлчилгээтэй байдаг юм уу гэсэн бодол байдаг юм. Маниус бол уугаад л эдгэх юм шиг санадаг. Гэтэл 7 ширхэг уугаад 7-14 хоногийн дараа үйлчилдэг болов уу гэж бодоод байгаа юм. Би бол тийм бодолтой байдаг. Гэтэл энэ анагаахын эм бол 1 цаг болоод л тархи толгой өвдөхөө болино шүү дээ.

**Зу: Та тэгэхээр хүүхдүүдээ илүү нарийвчлаад зарим нэг зүйлийг зааж сургах арга технологийг өвлүүлэх үү?**

Цэ: Өвлүүлэх л санаатай байгаа юм. Өвлөх хүн нь одоо нас тогтоод ирэхээр өвлөх байлгүй дээ.

**Зу: Та түрүүн хүүхдүүдийн тархи толгой барьдаг гэсэн шүү дээ тэр тухайгаа ярьвал?**

Цэ: Би аавыгаа харж байгаад сурсан. Өөрийн хүүхдүүдийн толгойг илж байсан. Сүүлд нь яагаад толгой барьдаг болсон юм, сайн мэдэхгүй байна. Хүүхдийн толгой нухаад илэхээр зарим хүн цохиод байдаг. Би зүгээр илээд л бариад байхад гайгүй болдог юм.

**Зу: Та ямар нэг зүйл мэдэрдэг үү?**

Цэ: Яахав толгой хөдлөсөн хүүхдийн нүдний зовхи нь хоёр өөр өнгөтэй байх шиг санагддаг. Утсаар хэмжээд үзлээ гэхэд урт богино байх шиг. Тархи хөдөлсөн хүүхдийн хоёр шагайг нь харьцуулаад үзэхэд хөл нь урт богино л байгаа. Тиймэрхүү юм бол өөрийн хар ухаан шүү дээ.

**Зу: Уламжлалт анагаах ухааны бараг 5 сургууль байна. Өвлөн улажмлагч гэж байна. Энэ хооронд ямар ялгаа байгаа бол?**

Цэ: Тэр мэргэжлийн хүмүүс бол өөр л байдаг байх. Би ямар мэргэжил байх биш. Сайн мэдэх юм алга.

**Зу: Энэ уламжлалт аргаар тан бэлтгэх монголчуудын арга мөн болов уу, та юу гэж бодож байна?**

Цэ: Би бол энийг мөн гэж болож байна. Том том модтой газар анагаах зүйл зөндөө л байх шиг байна. Бараг үхэх гэж байсан хүн, юм олж идээд эдгэсэн гээд л зөндөө л юм бичигдээд байх юм байна шүү дээ.

**Зу: Таны бэлтгэж байгаа эм танд үрт ургамал оруулахгүйгээр зөвхөн Монголоос бэлтгэж байгаа тан байгаа юу?**

Цэ: Дан үрт ургамлыг оруулахгүй, цэцгээр хандалж байгаа эм тан бол бараг байхгүй. Яахав, зүгээр цэцэг холиод хийнэ гэвэл байж болох байх.

**Зу: Зөвхөн танай нутагт ургадаг ургамал бий юу?**

Цэ: Байгаа, манайд бол зөндөө. Би сайн танихгүй. Манай шар нуруу гэдэг газар маш олон цэцэг ургаж байгаа. Би ганц хоёрхоныг мэднэ. Тэрийг ургахаар очоод түүдэг юм. Манайх энэ доошоо 30 км зусдаг юм. Би өөрөө ногоо цагаа, модоо тарьчихна.

**Зу: Эмийн ургамлыг хэзээ түүдэг вэ?**

Цэ: 6 сарын 20-оос 8 сарын 20 хүртэл түүдэг гэж бодож байна. Ер нь 7 сарын 20-д хавиар доошоо шимээ өгдөг. Цэцэг их түүдэг улсууд мэднэ. Энэ Хөхийд их сайн цэцэг түүдэг хүн байсан. Манай аав их сайн найз байсан. Аав ганц нэг явдаг байсан. Би явж байгаагүй. Яахав тэрүүгээр шархны шар цэцэг, дүжин юм уу түүнэ. Тэр Ажигцэрэнг бол Цэрэн гэдэг хүн шархдсан буга хараад, идэж яваад зүгээр болсон юм ярьдаг.

**Зу: Зарим нэг ургамлыг газраас нь авсны дараа хадгалах уу эсвэл яаралтай хэрэглэхгүй бол өөрийн чанараа алдана гэсэн зүйл байх уу?**

Цэ: Тийм зүйл байхгүй. Ургамлаа газраас аваад хатаана. Би жишээ нь ганц нэг үндэс ордог юм хийдэг л дээ. “Шижид” гээд манай уулын бэлд урт ургачихдаг үндэстэй юм байдаг. Тэрийг аваад сайхан цэвэрлээд, сүүндээ идээлүүлж хатаана. Миний хийдэг эмнүүдээс ганц нэг юм байна. Түмэн олонд хэрэг болох болов уу гэж боддог юм. Манай хөгшин ааваас надад өвлөгдсөн юм ганц нэг халбага байх шив дээ. Энэ нь тангийн, энэ нь эмний халбага. Танг буцалгаж уудаг. Эмийг усаар даруулж уудаг.

**Зу: Та бэлтгэхдээ их цаг зав зарцуулж байгаа. Авъя гэсэн хүнд хэдий хэмжээний мөнгөөр худалдаалдаг вэ?**

Цэ: Би Улаанбаатар хотоос хүнээс тан авдаг юм. Тэгэхээр зэрэг тунг нь 200, 250 төгрөгөөр өгөөд байх шиг байгаа юм. Нэг боодолтойг нь би 200 хавиар л өгөөд байгаа юм. Ямар ханштай байдаг юм сайн мэдэхгүй. Тиймэрхүү л байна. Ах нь түмэн олонд тус болох болтугай гээд л залбираад байж байна.

**Зу: Та түрүүн модны үндсийг сүүнд хийдэг гэсэн тэр яаж байгаа вэ?**

Цэ: Яахав тэр идээ сайн оруулах зорилготой. Манай аав бас ном их үздэг хүн байсан. Манай ах зохиолч байсан аавын номнуудыг нь аваад явсан. Надад үзэх юм байхгүй, тэр хэдэн л ном байна.

**Зу: Эмийн номхотгох гэж юм байдаг гэж би сонссон?**

Цэ: Талхлана, номхотгоно гэж юм байна. Номон дээр л тэр талхлах, номхотгох гэж юм байгаа юм шиг байгаа юм. Номнуудаас үзэж хараад номхотгохыг нь номхотгоно. Одоо жишээлбэл “гожид” гээд юм байдаг юм. Гал дээр улайсан зуухан дээр тавьж байгаад түлэхээр бондойгоод гараад ирж байгаа юм. Тэгэхээр нь гадна талын үсийг нь авна. Тэрний үсийг нь хор гэдэг юм байна л даа. Тэрийг нь хусаж арилгаад буцалгаад, аав хүнд өгдөг байсан. Би тэрийг өөрөө хусдаг байсан байхгүй юу. Тийм учраас би тэрийг мэдэж байна. Наадах чинь хор шүү л гэдэг байсан. Би бол тэр талаар сайн мэдэхгүй хийдэггүй. Гэхдээ яахав ганц нэг хүнд өгч л байсан.

**Зу: Тэгэхээр тэр хор гээд байгаа зүйлийг гал дээр тавиад бусад эмийн ургамалтайгаа хольж хэрэглэх үү?**

Цэ: Бусад эмийн ургамал дээрээ хачир тавиад хүнд өгнө.

**Зу: Тэр ургамал хаана ургадаг вэ?**

Цэ: Тэр гадаадад ургадаг байх. Монголд лав байхгүй “гожид” гээд хөөрхөн бөөрөнхий юм л байсан.

**Зу: Таны аав тэрийг хаанаас олдог байсан юм бол?**

Цэ: Тэр худалдаагаар ирдэг байсан юм болов уу даа. Одоо ч ирж л байгаа л даа. Улаанбаатарт тиймэрхүү зүйл зардаг хүмүүс их байна. Үрт бус ургамал, цэцэг навч одоо энэ анагаах ухааны эмийн сангуудаар янз бүрээр зарж байна.

**Зу: Та ер нь ааваасаа илүү олон зүйл сурах байж дээ гэсэн зүйл байгаа юу?**

Цэ: Байна одоо өнгөрсөн. Өөд болоод 20 жил болж байгаа юм байна. Ганц цэцэг ч болов заалгаад авдаг байж гэж бодсон юм байна. Тухайн үедэ би энүүгээр яадаг юм гэж бодсон ч юм уу. Манай ээж бас ааваас хойш 10 гаран жил байсан. Миний хүү энийг янзалмаар байна гээд л. Тэрийг нь би хайнгуут олж өгчихөөд гараад явдаг. Ээжийг өнгөрснөөс хойш тэр бүр толгой дээр ирсэн. Ганц эм ч болтугай заалгаж авахгүй. Жишээлэхэд энэ шүдлэн хонины баруун хонгоны мах орж байгаа тэрийг нь би мэдэхгүй байна. Тийм зүйл бичээд юм руу хийсэн байгаа байхгүй юу. Жаахан замбараа муутай. Тэр дотроос би өөрийн мэддэг юмнуудаа авчхаад бусдыг нь хэрэглэхгүй байгаа юм.

**Зу: Тэр нь одоо багаж байх уу ?**

Цэ: Үгүй бэлдээд тавьсан ургамал зэрэг байна.

**Зу: Одоо болтол байж байгаа гэсэн үг үү?**

Цэ: Тийм, байгаад байгаа юм. Тийм юм олон жил болсон ч муудах нь бага гэнэ. Цэцэг навч нь яадаг юм лав л үрт ургамал мууддаггүй юм гэсэн.

**Зу: Тэд нар аавынх нь хэрэглэж байсан зүйл гэсэн үг үү?**

Цэ: Тийм, би тэндээс мэдэхээ аваад хэрэглэж байгаа, мэдэхгүй их байна. Ойр зуур хийдэг юмаа хийгээд л. Хүн хараас захиж аваад, цэцэг түүж аваад л байж байна.

**Зу: Тэнд тэгвэл ховор эмийн ургамал байх магадлалтай гэсэн үг юм байна шүү дээ.**

Цэ: Магадлалтай гэсэн үг байхгүй юу. Хөөрхөн шүр шиг хар мөлийсөн үрнүүд байгаа. Би тэд нарыг танихгүй байгаа. Тэгээд “дэгсэр” мэгсэр гээд нэр бичсэн.

**Зу: Тэрийг нарийн судлавал олон зүйл байх нээ?**

Цэ: Тиймэрхүү зүйл байгаа. Миний хийж байгаа зүйл дээд тал нь 12 найрлагатай зүйл байгаа. Тэгэхэд зарим маарамба 25, 35 найрлагатай байгаа. Тэрийг юу хийж байгааг би мэдэхгүй шүү дээ. Зүрхний эм гэхэд л хотод нэг маарамба бий. Хороололд Очирбат гээд. Тэр хүн дээр очоод авахад 35 орцтой зүрхний эм гэж байгаа байхгүй юу. Олон юм орсон байгаа биз. Тэр хүнтэй би нэлээн холбоотой байгаа. Би “чуна” гэдэг юм хийе гэж бодсон чинь тэр хүнийх өөр найрлагатай байгаа юм. Орц нь арай олон. Манай аавын хийж байснаас хоёр юм ахиу байгаа. Тэгэхээр “чуна” хийхэд энэ ном дээр өөр найрлага байдаг юм байна.

**Зу: Зарим ургамлаар нөхөж орлуулдаг байх боломжтой юу?**

Цэ: Тийм байх боломжтой.

**Зу: Одоо жишээлбэл хангайн ургамал их учир 4, 5 ургамлаар хийдэг. Говьд бол ургамал тун бага тул 7, 8 болдог ч юм уу?**

Цэ: Тиймэрхүү байж болно гэж бодож байна. Нэг юм гэхэд хоёр өөрөөр бичсэн байгаа юм.

**Зу: Одоо таны үзэж байгаа ном, таны аавын бичсэн жор хэр зөрөөтэй болон хэр зэрэг адилхан байна вэ?**

Цэ: Энэ зарим нь өөр байгаа юм. Жишээлбэл “шижид түг” гээд гэдэс дотор уудаг эм байдаг. Тэрнийг энд 10 гээд бичсэн байхад, манай аав 7 гээд бичсэн байгаа юм. Үйлчилгээ нь хэр байдаг юм, ёстой дажгүй л юм шиг байгаа юм.

**Зу: Та өөрийн бэлдэж боосон эмнээс хэрэглэдэг үү?**

Цэ: Хэрэглэнэ, энэ өвөлжингөө “маань шатанг” уусан. Энэ өвөл ковид тусаагүй. Ханиад хүрэх нь ч гайгүй л байна. Хүн амьтан ч нэлээн аваад байх юм.

**Зу: Таны хувьд өөрөө өөрөөрөө бахархсан эсвэл “би тэр эмийг дажгүй хийгээд тэр хүнийг эдгээсэн шүү” гэсэн зүйл байна уу?**

Цэ: Тийм юм байхгүй. Ах нь зүгээр хүнд тус больё гэж боддог. Нэг их бахархаад ч яахав, бахархахгүй гээд ч яахав. Надад зүгээр хүнийг эдгээсэн тиймэрхүү зүйл байхгүй. Энийг сонирхуулья янз бүрийн үр байна. Энэ гадна газар ургадаг байх. Гэхдээ Монголд ургадаг юм уу мэдэхгүй л байна. Халуун шош гэсэн юм байгаа юм.

**Зу: Энэ уламжлагаад ирсэн ч та ашиглаагүй юм уу?**

Цэ: Ашиглаагүй. Уламжлагаад ирсэн. Манай аав юмнуудаа ингэж хийдэг. Заримыг нь би өөрөө түүж барьсан цэцэг ч байна. “Ар үр”, “бар үр” гээд байна. “Лиш” гээд халуун чанарын хоолонд хийнэ. “Улаан, цагаан гаа” гээд байна. Иймэрхүү юмнууд байна. Манай газарт зөндөө юм байна. Энэ “сороо” гээд юм манай энд байна. Бас нэг “ханхуул” гээд тэрний чинь доор ургачихдаг үндэс, сороолон тэр чинь энд орж байгаа. Анагаах ухаан дэлхийд нэгт гээд байгаа “гишүүн” буюу айрагны үндсийг ухвал атгасан гар шиг үндэс байгаа. Тэр чинь гэдэс доторт сайн шижид гэдэг юмны үндэс байхгүй юу. Хавдарт их хэрэглэж байна.

**Зу: Хамгийн сүүлд хэзээ та эм тан боосон бэ?**

Цэ: Хамгийн сүүлд нэг самган жаахан юм аваад явсан. Жаахан гялгарт хийгээд өгдөг. Бас цаас олдохгүй юм байна шүү дээ. Би цэцэг бүр танихгүй байгаа. Их муу. Тиймэрхүү сонинтой л байна даа ахаар нь.

**Зу: Ер нь танай сумын хүмүүс л авч байна уу?**

Цэ: Сумын хүмүүс бас энэ доор залгаа Зүүнхангай сум гэж байдаг юм. Тэндээс эртээр надаас ганц хоёр дүү хүн ядаргаа болсон гээд хэдэн тун юм аваад явсан.

**Зу: Таны хийж байгаа эм тан харшил өгөх зүйл байхгүй юу?**

Цэ: Надтай чацуу анагаах ухааны эмч хүн байдаг юм. Тэр хүн намайг “чи юм хийж бай” гэдэг. Өөрөө бас юм хийдэг хүн. Тэр эмч тийм, тийм юм авна гээд над руу бичээд явуулсан байна. Тэрнээс нь би заримыг нь хийж чадах ч үгүй юм. Хийж үзээгүй юм. Гэхдээ хийвэл хийнэ л дээ. Хоёр юм хийгээд явуулсан. Цогзолмаа гээд хүний гавъяат эмч байгаа.

**Зу: Танай сум зарим нэг сумыг бодвол хоёр хүн байна. Та тэр хүнээс зарим нэг мэдэхгүй, чадахгүй зүйлээ асуудаг уу?**

Цэ: Асууна, угаасаа энэ хоёр чинь хоёулаа эмч мэргэжилтэй хүмүүс байхгүй юу. Эхнэр нөхөр хоёр.

**Зу: Өвлөн уламжлагч уу бас?**

Цэ: Өвлөн уламжлагч. Ардын чиглэлийн эм тан барьдаг. Бүр надаас илүү 70-аад насны хүн байгаа.

**Зу: Таны нэлээн сайн мэддэг юмыг өөрөөр хийх ч юм уу, тийм зүйл байдаг уу?**

Цэ: Тийм зүйл ховор болов уу л гэж бодож байна. Зарим нэг хүний жор өөр байдаг байж болно. Манай аав, эд нар их хамтардаг байсан юм. Тэгэхээр жор их адилхан болов уу л гэж бодож байна. Зарим том маарамба хүний жор адилхан л байдаг юм шиг байгаа юм. Олон орцтой юм хум хийхээр миний мэдэхгүй нэр гарахаар, би мэдэхээ байж байгаа байхгүй юу.

**Зу: Та аавынхаа үлдээс жорны хэдэн хувийг хийж байна?**

Цэ: Би 20 хувь л хийж байгаа байх. Манай аавын 50, 60 юм байгаа байхгүй юу. Би тэгэхэд 7, 8 юм л хийж байна. Өөрийнхөө чадахыг л хийж байна. Зарим юм нь олдохгүй юм. Жишээлэхэд “хүдрийн заар”, “баавгайн доньд” надад олдохгүй. Тэрийг би хаанаас олох юм. Ольё гэвэл л олох байх л даа.

**Зу: Та өөрийн арга ухааныг өвлүүлэх үү?**

Цэ: Өвлүүлнэ дээ миний энэ чинь үе дамжсан юм. Би гурав дахь үе явж байна. Тэгэхээр өвлүүлнэ дээ л гэж бодож байна.

**Зу: Тэрийг эхлүүлэх ямар нэг арга хэмжээ авсан уу?**

Цэ: Эхлээгүй байгаа, эхлэх байлгүй дээ.

**Зу: Эм тан барихтай холбоотой би танаас асуугаагүй чухал хэлэх зүйл байна уу?**

Цэ: Надад өөр юу байхав, алга даа.

**Зу: Одоо жишээлбэл эмийг боохдоо ингэж анхаарна ч юм уу ?**

Цэ: Манай аав бол эмийг тэгж боодог. Манай хөгшин аав тэгдэг байсан юм. Дээр үед цаасанд боодог байсан тэгэхдэ эмийг нь бэлгэвчлээд бооно, танг нь дээд талыг нь

шомбойлгож бооно гэнэ. Нэг ёсондоо хоёр юм өгөхөд нэг нь эм, нөгөө нь тан гэж мэдэх нь байна л даа.

**Зу: Эм тан хэрэглэхэд түүнийг дагаад гам, шившлэг гэж байх уу?**

Цэ: Байна, гам шившлэг гэж. Гам бол хүн өөрөө барина. Шившлэг гэж байхгүй. Яахав зүгээр эмийг хийчихээд би энэ бурхан дээр тавиад нэг юм уншдаг юм. Маналын равнай уншаад энэ эмээ бурхан ном руу цацна. Манай аавын крилээр бичсэн юм бий. Би тэрийг уншина, тэгэхгүй бол болохгүй шүү дээ. Домтой юмыг домоор нь хийнэ.

**Зу: За, танд их баярлалаа.**

Цэ: За баярлалаа.

**Баянхонгор аймаг, Баянбулаг сум, Дондогийн Жадамба**

Жа: Би энэ Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нэгдүгээр багт амьдардаг. Малчин Дондогийн Жадамба гэдэг хүн. Манай эцэг өвгийн үлдээсэн өв нь уламжлалт анагаах ухааныг баримталж олон түмэнд түгээж байсан юм. Манай өвөө Сэрээтэр гэж хүн байсан. Тэр хүний л үр надаар дамжигдаж уламжлагдаж ирсэн юм.

**Зу: Та ардын анагаах ухаанаар ямар анагаах ухааныг уламжилж байна вэ?**

Жа: Хөдөөгийн хүн болохоор мал хариулж явахдаа ааваараа заалгасан эмийн ургамлуудыг хэрэглэж ганц нэг хүнд тус болж байна. Түүнээс гадна бас энергийн гүйдэл, хийн гүйдэл тааруулж бариа засал хийж байна. Тэгээд сахиус буулгаж хүний энергийн хүч муудсан, муу энерги шингэсэн улсын тэрийг нь хөөж зайлуулж, иймэрхүү байдлаар ард түмэнд тус болж байна даа.

**Зу: Таны аав бас бариа засал эм тан барьдаг хүн байсан уу?**

Жа: Манай аав бол лам хүн байсан. Багадаа аав ээж нь нас бараад шашин номын үйл ажиллагаа эсэргүүний үеэр хаалттай болсон. Тэгээд тэр үедээ сурч байсан уншлагын номуудаа биедээ авч үлдсэн. Ааваараа заалгаж байсан тэр цэцэг навчаа л үлдээж, хоцорч, уламжлуулж надад зааж өгсөн.

**Зу: Эмийн ургамлыг таних, шинжих эсвэл хэзээ нэг цагт түүх гэдэг энэ зүйлүүдийг та бид нарт дэлгэрүүлж яривал?**

Жа: Эмийн ургамал түүх нь ерөнхийдөө гэвэл эрт дээр үеэс л онгон зэрлэг байгальд байгалийн амьтан болохоор модонд амьдарч байхдаа хаднаас унах, юманд бариулах, хазуулах тэр үедээ янз бүрийн цэцэг ургамал ногоог амсаж үзэж, идэж, тэрүүгээр мөн чанартаа дамжигдаж тэрнээсээ эмийн ургамлаар байгаа газрынхаа энергийг биедээ авах, тэр нутгийнхаа рашаан янз бүрийн юмаар угаах гэх мэт иймэрхүү байдлаар тэр өвчнүүдийг эдгээж ирсэн.

**Зу: Та хамгийн сүүлд эмийн ямар ургамлаар ямар хүнийг анагааж эмчилсэн бэ?**

Жа: Би дан цэцэгт ургамлуудыг хэрэг болох улсуудад нь түүн эмчилж байна. Шүдний өвчин, янз бүрийн хор харшлын өвчин, гэдэс дотор эвгүйрэх зэрэг өвчнийг ургамал болон хоол ундыг нь тааруулж анагааж байна. Сахиусны үйлээр муу лай ланчиг, хилэнц, үйлийн үрийг өөрт нь таниулж, үйлийн үрийг зугтаалгаж, тэрнээс нь янз бүрийн буян оруулж, биед нь эерэг энерги оруулах заслууд хийгээд явж байна.

**Зу: Бариа заслын хувьд та аавынхаа юм уу өвөөгийнхөө тухай яриач?**

Жа: Бариа заслын хувьд энэ сахиус миний өөрийн жаахан мэдрэмж. Гарт мэдрэгдэх мэдрэмжээрээ би барьдаг, хийн судлыг тааралдуулж, гүйлгэж өвчин тарааж барина.

**Зу: Энэ мэдрэмжийн тухай та жаахан дэлгэрүүлж яривал? Бас хэзээ өөрийгөө гартаа юмтай гэж мөн энэ сахиусыг хэзээ мэдрсэн бэ?**

Жа: Сахиусыг бол 1992 онд цэргээс ирээд манай нэг хүргэн ах манайд хоёр сахиус байдаг байсан юм. Тэрийг буулгаад, сахиус бууна гэж манай удмынхныг дуудсан. Тэгж байхад “надад бууна” гэж байсан юм. Тэр үед дотроо бодчихоод “хэзээ буух юм бол доо” гэж боддог байсан. Гэхдээ багадаа зөнгийн явдал надад байдаг юм байна. “Надад ер нь байдаг юм болов уу” гэж элдвийн юм мэдэх гэж оролдож үзээд байдаг байсан. 2000 оны үед хүргэн ахындаа очиход өөрт чинь буух юм байна гэж надад сахиус өгч буулгаад тэрнээс хойш буулгадаг болсон. Тэрнээс хойш голдуу өөрөө эхлээд буулгаад хүнд нэг их тус болохгүй бэлтгэл хийж байгаад, ганц нэг хүнд туслаад мэдрэмж орсон доо.

**Зу: Сахиуснаас гадна бариа засал хийх болон гарын мэдрэмжийн тухай яривал?**

Жа: Гарын мэдрэмж гэдэг бол ерөнхийдөө толгойд орж ирээд, сахиуснаас толгойд мэдээлэл авдаг, хүний энергийн байдал тэнцвэржүүлэх үйл ажиллагаа юм. Хийн урсгалыг дээж доош гүйлгэх барьж тараадаг. 7 хүрдний үйл ажиллагаагаар сахиусны үйлийг оруулж, доторхыг хөөж, тэр хүрдийг тойрсон аураг засаж байгаа. Гарын энергиэр бол төөнөх гадагшлуулах татлага татаж засна. Гүйхгүй байгаа хийн гүйдлийг гарын мэдрэмжээр дээш доош хөөх, сахиусаар адисалж дээш доош татах, бузар шингэснийг хөөх тийм л эмчилгээ хийж байна.

**Зу: Тан дээр ямар өвчин зовлонтой хүмүүс ихээхэн хандах вэ?**

Жа: Энергийн дутагдалд орсон, жаахан дэвтсэн улс ирдэг. Дэвийг сахиусаар арилгах тийм эмчилгээ их хийж байна. Номын заслаар засах, өвчин номыг нь заагаад өгөхөөр, тэр номоо уншуулаад сайхан боллоо гэсэн зүйл бас бий. Сахиуснаас гадна өвс ургамал асууна, харшлах янз бүрийн зүйл байгаа үгүйг мэдэж байж тааруулж өгнө л дөө.

**Зу: Өвс ургамлыг шууд өгч хэрэглүүлэх юм уу ямархуу байдлаар боловсруулж эм юм тан эсвэл бэлдмэл болгож байна вэ?**

Жа: Боловсруулж нийлүүлж, жор найруулж өгч болно, зүгээр дан ганц ургамлаар анагаагдах зүйл байвал судсыг нь барьж тааруулж өгнө.

**Зу: Тэгэхээр та бас судас барьдаг гэсэн үг үү?**

Жа: Судас бол барина.

**Зу: Судас барихад өөрөө бариад сурчих юм уу эсвэл хэн нэгэн өвлөн уламжлагч өөрт чинь уламжлуулж өгөх үү аль эсвэл сахиусаар өөрийн гарын мэдрэмжээр барьж байна уу?**

Жа: Ерөнхийдөө бол судсыг ааваасаа сурсан. Судас барьж янз бүрийн хүнд хөнгөн өвчин хэлж өгч байсан. Тэрнээс уламжлаад харж байгаад ааваараа заалгаад тэрнээс үүдээд олон ном уншиж хооронд нь тааруулж уншиж судалсны үндсэн дээр судас барихад, дотор өвчин анагаахад судасны мэдрэмжээр тааруулдаг юм.

**Зу: Та судалгаандаа ямар ном бүтээл ашигласан бэ?**

Жа: Судалгаанд “Анагаах ухааны дөрвөн үндэс” судар янз бүрийн судар номуудаас нэлээн судалсан. Янз бүрийн анагаах ухааны уламжлалт номуудыг ч харж байсан.

**Зу: Дорнын анагаах ухаан болон Монголын анагаах ухаан хоорондын ялгаа юу вэ?**

Жа: За, Монгол анагаах бол эрт үеэс хөгжсөн байсан. Дорнын анагаах ухаан бол цаг агаар байгалийн зүйлд тааруулсан тангууд бий. Монгол бол хануур төөнүүр янз бүрийн юм бий. Монголчуудын хийж байсан шар эсгий шатааж байгаад төөнөх, цагаан туруу цэцгийг түүж аваад төөнөх, чулуу болон янз бүрийн хатуу зүйлээс судас ханаж эмчилж байсан түүхтэй.

**Зу: Сахиус гэхгүйгээр өөрийн өвлөн уламжилсан арга ухаанаар эмчилсэн тийм түүхээс ярьж өгөөч?**

Жа: Ерөнхийдөө бол манай багш Ядамба гэж маарамбад Говь-Алтай болон Завхан зэрэг газруудаас ирж эмчлүүлдэг байсан юм. Би тэр хүний шавь нь юм байгаа юм. Тэр хүн бол хорт хавдрыг эм хийгээд л анагаадаг. Савны хорт хавдар гэх мэт. Тэгээд ийшээ яваад нас барсан зайлууул. Би бол ерөнхийдөө сахиусны юмаар ерөнхийдөө анагаагаад байгаа юм. Одоо бол тэр материалыг Хятадаас авах тийм зав зай малчин надад гарахгүй юм. Дан ганц хөнгөвтөр өвчнийг бол анагаагаад эдгээчихнэ. Энергийн өвчнийг сахиусаар анагаагаад эдгээнэ.

**Зу: Орчин үеийн анагаахаас давуу тал бий юу?**

Жа: Бий, тэр давуу тал бол хүний үйл амьдралаас өөрт бий болсон үйлийн үрээр дамжигдаж ирсэн өвчин байдаг юм. Янз бүрийн энергийн өөрчлөлтөд орох, жишээлбэл мах их идэх. Мах чинь хүнийг өөрчлөлтөд оруулдаг. Хотын халуун чанарын айхтар хүнд хоол идсэнээр дотоод бие мах бодь бузартаж барих юм үүссэн байдаг. Тэрийг сахиусаар хөөнө. Аяны эмчилгээ рашаан зааж өгч уулгах, булгийн рашаан амталж үзээд тэрэнд таарах эмчилгээтэй зүрхний өвчин бөөрний өвчин гэх мэтээр эдгээнэ. Бөөрний өвчин бол бариагаар илаарьшуулж байсан. Зүрхний өвчнийг усан засал хийгээд эдгээж байсан. Тиймэрхүү бариа засал, энергийн сахиусаар адис өгөөд эдгээж байсан.

**Зу: Энэ бүгдийг хийхэд танаас мэдээж их хүчин чармайлт гарна, үүнийгээ та хэрхэн яаж үнэлдэг вэ?**

Жа: Сурч мэдэж эцгээсээ заалгасан, хүчтэй ургамал ашиглаж өвчнийг анагаах бол мундаг зүйл. Өвчнийг анагаахад бол маш олон амт чанартай, хүний биед зохицсон юм их бий л дээ. Тэрийг их сайн оношилж тааруулж өгч чадвал хүний бие сайн эмчлэгдэнэ. Янз бүрийн хүрдний бөглөөс гаргах эмчилгээ номын засал хүртэл их л том эмчилгээ болно. Энийг зарим нь мэдэхгүй байх шиг байна. Номын засал бол их том энергийн засал. Бүр замтай нь цуг, цаашдын явах замыг нь хүртэл засах энергийн засал байдаг юм л даа.

**Зу: Одоо та энэ өвлөж авсан арга ухааныг өөр хэн нэгэнд өвлүүлэх тухай бодож байгаа юу?**



Жа: Бодож байгаа, би одоо ингээд сурсан мэдсэн зүйлээ хойчдоо үлдээх хоёр гурван хүүхэд бий. Сургууль соёлд нь явуулж байгаад тэд нар надаас хойш улсууд байж л байгаа.

**Зу: Та ерөнхийдөө мэдэж байгаа гэсэн үг үү?**

Жа: Мэдэж байгаа, энэ цаашаа аваад явчих болов уу гэснээ сургууль соёлд явуулах шаардлагуудыг хийж байгаа.

**Зу: Хэрвээ та сахиусгүй байсан бол яг энэ анагаах ухааны мэдрэмж чинь байх байсан болов уу, энэ хоёр салшгүй зүйл үү эсвэл танд хоёулаа байгаагаараа илүү давуу тал болж байна гэсэн үг үү?**

Жа: Хоёулаа байгаагаараа илүү давуу талтай. Хэрвээ би сахиусгүй байсан бол уламжлалт анагаах ухааны ном бичиг харж байгаад эмчилгээ явуулна. Гэтэл бүр цаана нь байдаг хүний биед үл үзэгдэх биеийн тэр энергийн оршилт, буруу энерги орсныг мэдэхгүй буруугаар эмчлэх тал бий. Тэрийг хосолж хийх нь хамгийн чухал.

**Зу: Эртний хүрээ хийд зарим нэг маарамба нь өөрсдийн уламжлалт дэг сургууль бий болгож байв уу, таны сурсан хүмүүс танд заасан хүмүүст өөрсдийн өвөрмөц арга ухаан байсан уу?**

Жа: Тийм арга ухаан байсан. Ерөнхийдөө хөгшин хүмүүсээс ам дамжсан зүйл их сонсдог. Тэрүүгээр уламжлагдаж ирсэн янз бүрийн түүх толгойдоо орсныг баяжуулаад харахад өвчнийг анагаадаг зүйл бий.

**Зу: Та анх өөрийгөө мэдрээд аав багшаараа заалгаад сурахад хэр хүндрэлтэй байсан бэ? Уламжлалт анагаах ухааны аргаас аль нь хамгийн хэцүү байсан бэ?**

Жа: Чадмааргүй зүйл бол зөндөө. Хүний дааж чадахгүй хүнд өвчин, эм тангийн хүч таарахгүй тэгээд бас энергийн тал дээр хүч төвлөрч дийлэхгүй зүйл бас бий. Түүнийг хүнтэй хавсарч хийх юм уу эмчилгээний тал дээр бол эм тангийн сайнаар эмчилж болно гэхдээ энергийн тал дээр лам нартай хавсарч цуг дэв бузар лай ланчиг арилгах юм бий. Тэрийг нь буцаагаад хүний бие эдгэхэд бэлэн болоод ирдэг.

**Зу: Мэдээж тан дээр өвчин зовлонтой хүмүүс ирж байгаа, тэр үед та үзээд үнэхээр эдгээж чадахгүй гээд буцаах үе байсан уу?**

Жа: Бараг л байхгүй, гол нь сэтгэлээр унагаахгүй л байх. Та эдгэнэ, сэтгэлээ зөв бариарай сэтгэлийн тэнхээ сайн байвал эдгэнэ шүү гээд. Сэтгэлээр эдгэх тийм зүйл ажиглагдаж л байдаг.

**Зу: Та өөрийн мэдрэмж сурсан зүйлээ байнга хөгжүүлж байгаа юу эсвэл нэг сурсан зүйлээрээ байдаг уу, эсвэл цааш нь сураад шинэ арга болгож хөгжүүлж болох уу?**

Жа: Хөгжүүлэх их зөв л дөө. Аливаа зүйл цааш хөгжиж байж шинэ юм нэмэгдэж, туршлага сууна, туршлага дээрээ, эмчлэх арга байна гэдэг нь бол цаашдаа мэдрэмжээр болон ухаанаар гарч ирэх тийм зүйл бий. Цаашдаа ухаанаар сэтгэж эмчлэх тийм зүйл бий.

**Зу: Жишээлбэл бид хүмүүсийн өмнө энэ бол зөвхөн Монголчуудын зүйл юмаа гээд бардам хэлэх анагаахын төрөл зүйл аль вэ таны бодлоор?**

Жа: Миний бодлоор дээр үеийн чулуун зэвсгийн үеэс эхлээд, жишээ нь ан хийж явж байгаад ангаа ажиглаад явж байхад тэр нь янз бүрийн цэцэг навч түүж идэж яваад тэр нь

эдгэж байсан тийм зүйлийг харж тэрийг нь түүж авч эмчилж байсан тийм түүх байна. Тийм учир уламжлалт анагаах ухаан яах аргагүй Монгол юм. Наранд шарах, төөнүүр хийх, янз бүрийн судас ханах. Монголчууд маань малаа хүртэл хатгаж эмчилж байсан энэ бол жинхэнэ Монголчуудын хөдөлмөрлөж байсан туршлагауд юм.

### **Баянхонгор аймаг, Баянбулаг сум, Батболд**

Ба:Баянхонгор аймгийн Баянбулаг сумын хоёрдугаар багийн харьяат малчин Батболд гэдэг хүн байна. 1993 онд гэр бүл болсон. Би 28 насандаа 2003 онд Улсын Сайн Малчин болсон. 1991 онд Анагаах ухааны сургууль төгссөн, эм зүйч мэргэжилтэй. Манай аав, ээж хоёр Улсын Сайн Малчин байсан. Амьдралын шаардлагаар аав ээжийгээ дагаад л малчин болсон. 2003 оноос хойш бариа заслаа хийж сурсан даа.

#### **Зу: Аав нь бариа засал хийдэг байсан уу?**

Ба: Хоёрдугаар үеийн бариач байсан, би гуравдугаар үеийн бариач.

#### **Зу: Сургуульдаа уламжлалт анагаах ухаан бариа заслаар сурсан уу?**

Ба: Зүгээр давтлагад хичээлийн хажуугаар явж байсан.

#### **Зу: 2003 оноос хойш бариа хийх болсон шалтгаан тань юу вэ?**

Ба: Манай аав бариач байсан учраас улсууд ирж бариулна. Тэрийг дагаад манай аав ийм юмыг ингэж барьдаг, тэрийг тэгдэг юм шүү гээд өвөлж өгч байсан. Айлын отгон хүү гэдгээр өвлөж авсан.

#### **Зу:Одоо хүмүүс их мэдрэмж, увдис, гартаа юмтай хүн гэж ярьдаг юм байна лээ тэр талаар юу гэж боддог вэ?**

Ба:Хүн ер нь гарын мэдрэмжээр л барьж байгаа юм. Гарын мэдрэмжгүй хүн бол хаана юу байгааг мэдэхгүй. Тийм болохоор гол нь гарын мэдрэмж чухал. Мэдрэмж гэдэг чинь ерөөсөө мэдрээд л тэрний яс нь ингэсэн байна, мах нь ингэсэн байна гэж мэдрэнэ. Тэрнээс мэдрэмжгүй хүн яагаад ч мэдэхгүй.

#### **Зу:Тэр гарын мэдрэмжийг хөгжүүлэхэд аав тань ихээхэн тус болсон гэсэн үг үү?**

Ба: Тийм, “энэ ингэсэн байна”, “чи эхлээд үүнийг үзээдэх” энэ хүн яасан байна гээд өөрөө үзчихээд надад хэлэхгүй. Би тэрийг нь үзчихээд “аа тэгсэн байна” гэхээр “аа зөв байна”, “одоо энийг ингэж барьдаг юм”, “булчин ингэж суллана”, “шөрмөс ингэж суллана”, “дараагаар ингэж барина шүү” гэж зааж өгдөг байсан юм.

#### **Зу: Та анагаахад сураад их сэтгэл татагдаж байсан уу?**

Ба:Тийм татагдаж байсан. Хичээлийн хажуугаар оточ маарамбын дугуйланд явдаг байсан юм.

#### **Зу:Та сургууль эсвэл, бага ангид байхдаа гарын мэдрэмжтэй гэдгээ мэддэг байсан уу?**

Ба:Үгүй, ер мэдэрч байгаагүй. Хүүхэд гараад толгой өвдлөө гэхэд барихаар, “өө сайхан барьж байна” гэдэг байсан. Тэр үед л мэдэрсэн. Гартай юмтай байж барьдаг юм байна гэдгийг ойлгосон. Тэгээд л бариаг сонирхож эхэлсэн.

#### **Зу:Одоо тань дээр хэр их хүн ирж бариулж байна?**

Ба:Одоо над дээр Улаанбаатар, Завхан, Алтай, Баянхонгор чигээс ирж байна.

#### **Зу:Энэ хүмүүс хаанаас мэдэж ирж байна?**

Ба: Хүмүүс яахав нэгнээсээ дуулаад л, “тэнд хүн сайн барьж байна”, “би бариулсан зүгээр боллоо” гээд ирдэг байх.

**Зу: Одоо орчин үед хүмүүс их өөрийгөө сурталчилж байна. Лайв хийж байна, зар тавьж байна. Газруудаар явж бариа хийж байна. Та сумдаар явж барих уу?**

Ба: Ерөөсөө сумаасаа гардаггүй юм. Хүмүүс өөрсдөө ирж бариулаад, зүгээр болоод “тэнд их сайн хүн байна” гээд тэр хүн нь ирж 3 хоног бариулаад “эргэс гарсан юм шиг боллоо” гээд босоод ирдэг. Голдуу ер нь яс их хугаралт бас бөөр сав барьж байна.

**Зу: Тан дээр ирж байгаа хүмүүс ихэнх нь ямар зовуурь өвчинтэй байна вэ?**

Ба: Нурууны суулттай хүмүүс ирж байна, бөөр их ирж байна. Хүүхэдтэй болж чаддаггүй хүмүүс их ирж байна. Бариулаад хүүхэдтэй болж байгаа хүмүүс бас их байна. Ууц нуруу нь өвдсөн хүмүүсийг бариад л зүгээр болчих юм байна шүү дээ.

**Зу: Уламжлалт анагаах ухаан эсвэл Монгол анагаах ухаан хоорондоо ялгаатай зүйл байгаа юу?**

Ба: Нэг их зөрөө бол байхгүй. Нэр нь л өөр болохоос хэлбэрийн хувьд адилхан шүү дээ. Монгол анагаах ухаан гэхээр илүү цэгэн бариагаар явах байх. Монгол анагаах ухаан цэгэн бариа илүү их заадаг юм байна лээ. Нэг л зүйл л дээ ер нь, нэр нь л өөрчлөгдчихөж байгаа болохоос.

**Зу: Бариа засал ер нь Монголчуудын өөрсдийн анагаах ухаан уу?**

Ба: Тийм өөрсдийн анагаах ухаан, гарын увдис гэж байгаа, европ бол шууд багажаар барина.

**Зу: Та европ байдлын сургуульд нь сураад төгссөн хүн шүү дээ. Энэ европ анагаах ухаан болоод Монгол анагаах ухааны ялгаатай тал юу вэ? Монгол анагаах ухааны онцлогийг ярьж өгвөл?**

Ба: Монгол анагаах ухаан бол ерөөсөө эм тангаар явдаг. Европ анагаах ухаан бол дандаа гадаад найруулсан эм тан гээд явж байгаа байхгүй юу. Түүрүүгээрээ ялгаатай байдаг. Монголчуудын найруулсан эм тан шал өөр байдаг. Хүний биеийн тархац бусад эрхтнийг гэмтээх нөхцөл байхгүй. Бусад анагаах ухаан нэгийгээ эдгээгээд нөгөөдөө хорны байдаг байхгүй юу. Нөлөө өгч муутгадаг. Газар ургамал бол ер гомдоох нөхцөл байхгүй. Тэр өөрийнхөө эмчлэх юмаа л эмчлэн.

**Зу: Та эм зүйч мэргэжлээрээ ажилласан уу?**

Ба: Ажиллаагүй. Төгсөөд шууд мал дээр гараад, малаа малласан.

**Зу: Одоо ер нь бараг мартсан гэсэн үг үү?**

Ба: Үгүй нэмж сураад, судсаар оношлоод, бас судсаар оношлон.

**Зу: Тэр ухааныг танд хэн заасан бэ?**

Ба: Бас л ааваасаа сурсан.

**Зу: Таны аав бас ааваасаа сурсан уу?**

Ба: Тийм.

**Зу: Та аав болоод өвөө аавынхаа арга барил мэдлэгийг бидэнд ярьж өгөөч?**

Ба: Манай аав тан ойр зуурын юм хийдэг хүн байсан юм. Би тан хийж байгаагүй. Нэг хийх гэж үзээд чадмааргүй болоод хаясан. Өөрөө чадахгүй байж хүн амьтанд өгчихвөл гэж бас айгаад хийгээгүй.

**Зу:Таны аав бурхны номтой хүн байсан уу? Шавилан сууж байсан уу?**

Ба:Баян-Адарга сумын унзад лам байсан юм.

**Зу:Ерөнхийдөө энэ арга ухааныг бурхны шашны ном судраас сурсан уу?**

Ба:Тэгсэн л гэсэн, дандаа бурхны ном судар дээр байдаг юм чинь. Тэрийг зөв өвлөж аваад л.

**Зу: Танд ном судраас зааж өгсөн үү эсвэл дан практик дээрээс заасан уу?**

Ба:Дан практик дээр заасан.

**Зу:Таныг анх сурах үед шашин хамаагүй нээлттэй болсон байсан үе үү?**

Ба:Тийм. Нээлттэй болоод Гандан нээгдсэн байсан.

**Зу:Соёлын өвийн үндэсний төвд таны мэдээлэл байгаа. Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Батболд гэдэг хүн бариа хийдэг гэж. Та энэ бүртгэлийн талаар мэдэж байсан уу?**

Ба: Мэдээгүй өчигдөр л мэдсэн.

**Зу: Тэгэхээр сум орон нутгаас таны нэр өвлөн уламжлагч гээд очсон байгаа. Та одоо хэдэн хүүхэдтэй вэ ?**

Ба: 4 хүүхэдтэй

**Зу: Хүүтэй юу ?**

Ба: 3 хүүтэй.

**Зу:Таны хүүхдүүд дунд ийм гарын мэдрэмжтэй хүн байгаа юу?**

Ба:Одоохондоо бол ерөөсөө мэдэгдэхгүй л юм байна шүү дээ.

**Зу:Та өөрийн мэдлэг арга ухааныг өвлүүлнэ гэж боддог уу?**

Ба:Авах хүүхэд байвал өгнө. Хүүхдүүд сонирхдог л юм байна лээ. “Би шавь ормоор байна” гээд ирсэн хүн байхгүй. Орьё гээд ирвэл би заагаад өгнө.

**Зу:Гаргаа мэдрэмжгүй юм уу эсвэл өөр барилаар суралцах хүн ирвэл та шавиар авна гэсэн үг үү?**

Ба:Авна л даа. Зааж өгөхөөр сурна даа.

**Зу:Хүн ер нь энийг байнгын хичээл зүтгэлээр сурвал боломжтой гэсэн үг үү?**

Ба:Тийм.

**Зу:Гарын мэдрэмжтэй хүн алдаа гаргах юм уу зарим нэг зүйлийг мэдрэхгүй өнгөрөх зүйл байх уу?**

Ба:Байлгүй яах вэ. Янз бүрийн тохиолдол гарч болно.

**Зу:Одоо уламжлалт олон сургууль байна. Энэ сургуулиудын талаар таны бодол юу вэ?**

Ба: Би бол өөрөө сургалтын төвд сууж үзсэн. Ерөөсөө бүрэн төгс юм байдаггүй юм байна лээ. Тэнд 40, 50 хүн байгаагаас цөөхөн 4,5 нь л гарын мэдрэмжтэй хүн байдаг юм байна лээ. Бусад нь ямар ч мэдрэмж байхгүй хар ухаанаар л. Уг нь болдог бол мэдрэмжтэй хүнээ шалгаж авч суралцуулбал дөхөм л байх даа. Хувь хүний л асуудал юм даа.

**Зу:Тэр хүн гартаа мэдрэмжтэй гэдгийг та жишээлбэл мэдрэх боломжтой юу?**

Ба:Тэр хүнийг мэдрэх боломж ер нь хэцүү. Эхлээд зааж өгнө л дөө. Тэгсний дараа мэдэгдэнэ. Байнгын мэдрэмж байна уу, байхгүй юу гээд. Мэдрэмжтэй хүн бол гурав заагаад өгөхөд л судас бариад, ингэсэн тэгсэн гээд хэлнэ. Мэдрэмжгүй хүн бол тэгээд байхгүй. Тэр улсууд бол тэгсэн, ингэсэн үзээдэх гэхээр юу ч алга гээд тэгдэг юм.

**ЗуТэгэхээр цаанаасаа увдис байна гэсэн үг үү?**

Ба:Тийм увдис байна.

**Зу:Та судас барьж, бариа засал хийж байна. Өөр уламжлалт анагаах ухаан, зүү төөнүүр хийх үү?**

Ба:Хийнэ. Бүгдийг хийдэг юм.

**Зу:Та өөрийн хийж байгаа арга ухааныг нэрлэвэл, ямар арга ухаан байна?**

Ба:Судас барина. Судас илж байна бас бариа хийдэг. Бумба төөнүүр тавьж байна, ханах гээд бүгдийг л хийж байгаа.

**Зу:Зүү тавих, ханахыг та хэнээс сурсан бэ?**

Ба:Би өөрөө оюутан байсан болохоор анагаахаар заалгасан л даа.

**Зу:Ханах болоод бумба тавих зэргийг үү? Энийг та бариа засалтай хоршуулаад явж байгаа юу?**

Ба:Тийм, хоршуулаад явж байна.

**Зу:Бариа засал, хануур, төөнүүр зэргээс хамгийн Монголынх байж болох нь юу вэ?**

Ба:Хануур, төөнүүр л юм шүү.

**Зу:Ямар учраас?**

Ба:Гол нь ерөөсөө цусыг нь гаргаж байгаа юм. Ганц дусал цус авсан байхад хор гардаг. Зүү бол үенд байгаа шар усыг гаргаж өгч байгаа юм л даа. Эмнэлэгт цус хамаагүй авдаг болсон юм байна лээ. Энэ чинь уг нь улиралтай байдаг байхгүй юу. Ерөөсөө 6 сараас 10 сар хүртэл хүний цус бүрэн гэсдэг. Тэр хооронд хүн хатгаж самнадаг.Бусад үед бохирдсон байдаг болохоор цус авч болдоггүй юм. Одоо болохоор зун ч бай, өвөл ч бай аваад байна. Би бол тэгж авдаггүй юм. Бусад үед өвдлөө барилаа гэвэл сайхан барьж өгөөд гурван дусал цус гаргачихдаг юм. Тэгээд өгөхөд тэр хүн, тэр өвөлдөө хавартаа яах ч үгүй.

**Зу:Би зурагтаар үзэж байсан юм. Хануур, төөнүүрийн эмнэлэгт цусыг бүр олгойдуулж гаргаж байсан, тэр ямар учиртай вэ ?**

Ба:Уг нь тэр болдоггүй л гэдэг юм даа. Ерөөсөө гурван дусал цус гаргахад л хүний бүх хор гардаг шүү гэж зааж өгч байсан. Тэгсэн хүмүүс шил шилээр нь аваад, мэдэхгүй юм даа. Би бол гурван дусал цус л авдаг. Аяндаа, ерөөсөө гурав юм уу, дөрвөн дусал цус гараад л тогтчихдог. Яг зөв авбал.

**Зу: Та ааваараа энэ олон арга ухааныг заалгаж байхад сурахад хамгийн хүндрэлтэй нь аль нь байсан бэ?**

Ба:Яс л байдаг юм. Түнх хавийн яс л эвгүй. Бусад яс бол гайгүй. Ер нь үенийхугарсан яс эвгүй, заавал анагаахаар явахгүй бол бэрх. Бусдаар бол гайгүй гаршсан болохоор ерөөсөө түгдрээд байдаггүй юм.

**Зу:Таны эсвэл таны аав зааж өгсөн онцгой арга техник гэж бий юу? Бусад хүмүүс арай өөрөөр хийдэг ч юм уу, тийм зүйл анзаарагддаг уу ?**

Ба:Нэг их тийм содон юм ч байхгүй л дээ. Гэхдээ хүн болгоны бариа шал өөр байдаг юм. Аймаг дээр байгаа бариач нар шал өөр барина. Хүн барьж сурснаараа юм уу гарын мэдрэмжээр юм уу өөр байх. Зарим бариулж байгаа хүн намайг “үгүй ээ мөн гоё барьдаг хүн шүү” гээд гайхдаг. “Ингэж барьж байгаа хүн үзээгүй, цаагуураа сэтгэлээсээ барьдаг юм байна” гэдэг. Би доод тал нь 30 минут барьдаг юм. Дээд тал нь 2 цаг барих юм. Удаан хугацаагаар барина. Зарим хүмүүс их хурдан барьдаг. Нэг бариулж байгаа хүнийг сайн барина. Ядаж нэрээ бодно шүү дээ. Эргээд нүүртэй, “энэ хүн чинь сайн барьдаг байсан шүү”, “ахиад бариулья” гээд ирнэ. Тэгж л би үнэн сэтгэлээсээ барьдаг юм.

**Зу: Тан дээр өвчтэй хүн ирээд, “би энийг чадахгүй юм байна” гээд буцааж байсан тохиолдол бий юу?**

Ба: Байхгүй, жаахан удаан хугацаанд барих хүн л гэж байна, тэрнээс буцаасан хүн бол байхгүй.

**Зу:Та өөрийгөө магтаад, за “би ийм өвчтэй хүнийг босгоод ирсэн шүү” гэж өөрөөрөө бахархсан өвчний түүхээс ярьж өгвөл?**

Ба:Тийм зүйл олон байгаа. Манай сумын Байдар гээд хүүхэд 4 билүү 7 м хавтан дээрээс нь унаж даруулаад дунд чөмөг нь хоёр хугарсан. Улаанбаатарт ирээд 3 сар болоод эмчилгээгүй. Тэгээд манай сум гуйгаад болдоггүй. Тэгээд би хэлсэн бариулья гэж байвал суманд аваад ир гэсэн. Дахиж боогоод гэрт нь долоо хоногт нэг ирж үздэг юм. Тэгээд 2, 3 сар болсон. Нөгөө улс чинь бөөн баяр. Үзээд л байсан, нэг өдөр үзээд овоо эвлэсэн юм шиг болоод байна. За нэг гаргаад гэрээ гурав тойруулаадах гэсэн, босоод гурав тойроод ирсэн. Гурав хоногийн дараа нөгөө хүүхэд чинь шууд хөл дээрээ гишгээд эхэлсэн. Цагаан сар болох байсан юм. Нөгөөх чинь шинийн нэгний өглөө шууд босоод морь унаад яваад өгсөн гэсэн. Тэгээд хөл дээрээ боссон. Одоо Эрдэнэтэд байгаа, гурван жилийн өмнө над дээр ирээд зүв зүгээр болсон юм даа. Уржнан машин мөргөлдөөд арван хэдэн настай энэ айлын хүүхэд бас дунд чөмгөөрөө хугарсан. Тэгээд танаар бариулна гээд бариулаад хоёр сар хэвтсэн. Хүүхэд гардаггүй хүмүүсийг бариад, нэлээн хэдэн хүн хүүхэдтэй болгож өгсөн.

**Зу: Яагаад тэр хүн хүүхэдтэй болохгүй байна, ямар эмчилгээ хийсний дараа хүүхэдтэй болж байна вэ?**

Ба: Нэгдүгээрт сав хөдөлсөн, биеийн юм ирэхээ больж байгаа юм, биеийн юм өвдөлттэй ирдэг болж байгаа юм. Тэгээд тэрийг дан дангаар нь барьж өгөөд л сайхан илээд хэвд нь оруулаад, давхар бөөр, нуруу барина. Тэр нурууны суултын нөлөө байдаг юм байна лээ. Тэрийг нь бүгдийг нь сайхан янзалж өгөөд л тэрний дараа хүүхэд олно.

**Зу:Та их буянтай ажил үйлдэж байна . Тэгэхээр та өөрийн энэ мэдлэгийг хэрхэн үнэлж байна?**

Ба: Үгүй, одоо хүн эдгэж байвал болоо л гэж боддог. Би шөнө өдөр гэхгүй л явна. Тэр тэглээ ингэлээ гээд шөнө ч л ирж байна. Хаа л хүн өвдлөө гэнэ, хүн гуйхаар шөнө унтаж байсан ч “за” гээд явна.

**Зу: Хүмүүс сэтгэлээсээ мөнгө төгрөг өгөх зүйл байх уу?**

Ба: Байлгүй яах вэ, хүний өгснийг л авна. Янз бүрийн тариф гэж байхгүй. Энэ жил нэг бариа заслын юм нээх гээд барьчхаад л байгаа юм. Хараахан нээж чадаагүй л байна.

**Зу: Бариа заслын төв нээвэл илүү амар болох байх гэж үү?**

Ба: Тийм. Төв дээр байгаа. Өвөл бариулчих гээд хүмүүс ирнэ. Зун би мал дээр гарчих юм, тэгээд л.

**Зу: Танай суманд танаас өөр бариач байгаа юу?**

Ба: Байхгүй, ерөөсөө л ганц нь би.

**Зу: Танай аав бас танай нутгийн ганц бариач байсан уу?**

Ба: Тийм, гэхдээ би ерөөсөө аавыгаа гүйцэхгүй байгаа л гэж боддог юм. Яг гүйцэж барьж чадахгүй байх шиг байна. Өөрийгөө хараад л бодоод байхад.

**Зу: Өөртөө чамлахгүй байгаа гэсэн үг үү?**

Ба: Тийм.

**Зу: Таны одоо мэдрэмж гээд зүйл байна шүү дээ, нас ахих хэрээр эсвэл хүн бариад байхаар тэр мэдрэмж буурна гэж байх уу?**

Ба: Байхгүй. Хүн барих тусам улам л гар чангарна уу гэхээс буурна гэж байдаггүй юм.

**Зу: Хүн барьсны дараа танд тэр хүний өвчин ирнэ гэж байх уу? Хөгшчүүл “хүн барьчхаад гараа модонд цохиорой, хүйтэн усаар угаагаарай” гэдэг байсан. Би бариач хүн биш болохоор сайн мэдэхгүй байна. Та жишээлбэл өвчтэй зовлонтой хүн байнга барихад тийм зүйл яаж мэдрэгддэг вэ?**

Ба: Барихгүй байж байгаад ихээр 5,6 хүнийг барихаар яг тэр хүний биеийг эхлээд авдаг юм. Тэгээд буцааж гаргахгүй бол тэр хүний өвчнийг өөртөө авна. Гаргахдаа янз бүрийн хүйтэн усаар гараа угаана хатуу юманд гараа цохиод, түрүүний хорыг гаргана.

**Зу: Тэр мэдрэмж болоод байгалиас өгөгдсөн уддисын талаар би их сонирхоод байгаа юм. Тэр зүйл цаанаасаа төрмөл гэж ойлгох уу?**

Ба: Тийм, уламжилж байгаа юм.

**Зу: Дээрээс нь арга ухаан ороод танд байгаа зүйл бүрэлдэж байна гэж ойлгож болох уу?**

Ба: Тэгж ойлгоно.

**Зу: Хэрвээ та мэдрэмжтэй ч гэсэн аав тань танд зааж өгөөгүй бол та одоогийнх шиг барьж чадахгүй гэж ойлгож болох уу?**

Ба: Мэдээж яах вэ барина гэхдээ дутуу л байх байх. Одоо бас тийм юмыг нь тэгж заалгаж байхгүй яав аа гээд бодож л байгаа юм. Тэрийг нь заалгаж байхгүй гээд боддог, гэхдээ яах вэ өөрөө оролдож л байгаа юм л даа.

**Зу: Энэ асуултаас залгаад асуухад та ааваараа заалгаагүй өөрөө оролдож байгаад хийсэн бариа байна уу?**

Ба: Ер нь нэг их заалгаагүй юм байхгүй. Ер нь дандаа заалгаснаа л хийсэн. Хугархай, мултархай, тулаа гээд.

**Зу:Жишээлбэл хүний хуруу маш их тулдаг, хуруу тулсан байж байгаад тэрийг буруу гаргаад бороолсныг засах боломжтой юу?**

Ба: Боломжтой, тэрийг айргаар задлаад дахиад боодог юм. Би бол боож байгаагүй. Манай аав бол тэгсэн хүнийг айргаар хэд задлаад л, дахиад боож байсан юм. Би бол үзээгүй. Над дээр тийм тохиолдол ирээгүй.

**Зу: Хүн анагаана эдгээнэ гэдэг бол цаанаа маш том хариуцлага. Энэ талаар та юу гэж боддог вэ?**

Ба: Хугархай янз бүрийн юмыг боогоод хүний гоо сайхныг муухай болгочих вий гэж айж явдаг хүн байгаа юм.

**Зу:Одоогоор бол танд буруу боосон тохиолдол байхгүй байна тийм үү?**

Ба:Байхгүй

**Зу:Бариулж байгаа хүмүүс танд эргээд ямар нэгэн гомдолгүй гэсэн тиймэрхүү зүйл анзаарагддаг уу? Ярьдаг уу? та асуудаг уу?**

Ба:Ярихгүй, би ч асуудаггүй юм. Шууд бариулаад явчихдаг болохоор, ерөөсөө тийм зүйл ярьдаггүй. Эвгүй хугарсан хүмүүсийг “аймаг руу яв” гэж хэлдэг байж гэж бодож л байдаг юм. Тэгээд гайгүй эдгэрсэн л явж байдаг юм. Бүр их хүнд хугарал бол боолгочоод аймаг руу явж үзүүлдэг юм л даа. Очоод үзүүлэхээр гайхдаг гэж байна лээ. Ямар сонин юм бэ? гараар боосон гэж үү гээд. Үгүй мөн гоё боодог юм байна яаж ингэж гоё боодог байна гэж.

**Зу:Тан дээр ирж байгаа хүмүүс ямар хүмүүс байна. Орчин үеийн анагаах ухаанаар эмчилж чадахгүй болохоор ирж байна уу эсвэл сумын эмнэлэг болоод аймгийн эмнэлэгт хандахаасаа өмнө танд хандаж байна уу?**

Ба: Манай сумынхан бол ойрхон болохоор сумын эмнэлэг биш эхэлж надад ханддаг.

**Зу:Орчин үеийн анагаахаар яваад ерөөсөө болоогүй хадуулж тайруул гэсэн хүнийг би эмчилсэн гэж хэлж байна. Зөвхөн яс биш өөр өвчнөөр танд хандаж байсан уу?**

Ба:Өөр гэвэл бөөрний улс их ирдэг юм. Аймаг хот руу яваад барахаа байсан, “хэдэн сар эмчилгээ хийлгэлээ эдгэхгүй байна” гээд хүмүүс хүрээд ирдэг юм. Тийм хүмүүсийг бариад засаад өгдөг юм.7, 14 хоног бариад зүгээр болчихдог юм. Өөр ч айхтар хүндрэлтэй өвчтэй хүн ирээгүй ээ.

**Зу: Хүний хугарсан ясыг барихдаа эм тан хавсаргаар хэрэглэж байна уу?**

Ба: Хэрэглэнэ, хүнийг чинь эхлээд булчин, шөрмөсийг нь суллаж байж цаашаа бооно. Боочоод тэр хүндээ сайхан зөвлөгөө өгнө. “Хэд хоног сайхан хөдөлгөөнгүй байлгаарай”, “тийм эм ууна” гээд. Би чинь голдуу алтан гагнуур өгдөг.

**Зу: Алтангагнуурыг яаж хэрэглэх ёстой вэ?**

Ба:Алтангагнуурыг өтгөн аарцаар буцалгаад, амны том халбагаар өдрийн гурваар уух ёстой.Зарим нь бүр шанагаар, аягаар уугаад байдаг. Тэгж болдоггүй юм, жороороо л уувал зүгээр.

**Зу:Тэрийг бас танд зааж өвлүүлсэн үү?**



Ба:Өвлүүлсэн. Өөр эм тан өгдөггүй юм. Европ эм, өвчин намдаагчийг бол хоёр гурав хоногтоо өгчихдөг юм. Гурав хоногоос илүү хийдэггүй юм. Гурав хоногтоо өвчин авчихдаг юм.

**Зу: Бариа засал хийхдээ эсвэл хануур хатгуур хийхдээ уншлага тарни хийдэг үү?**

Ба: Надад бол тийм зүйл байдаггүй. Өөрөө сэтгэлээсээ хийж байгаа болохоор. Ерөөсөө хүний гол зүйл сэтгэл. “За нэг зүгээр болгоод өгчих юм сан” гэсэн сэтгэлээр хийдэг.

**Зу: Мах, олон булчин, шөрмөс эвлүүлж боогоод танаас маш их хүчин чармайлт гарч байхад нөгөө хүн өөрөө гам барихгүй байх зүйл гарч байсан уу?**

Ба: Гарч байсан. Хөл дээр ганц нэг тийм зүйл гараад байдаг юм. Бусдаар гайгүй.

**Зу: Таны хүүхдүүдэд бид хоёрын ярьсан шиг мэдрэмжийн зүйл анзаарагдвал та бүх зүйлээ уламжлуулах уу?**

Ба: Тийм.

**Зу: Та хүүхдүүдээсээ тийм хүүхэд гарна даа гэсэн найдлага байдаг уу?**

Ба: Одоохондоо ерөөсөө мэдэгдэх юм байхгүй л юм байна. Оюутнууд зундаа ганц сар ирээд буцаад явчхаж байгаа болохоор.

**Зу: Та шалгалт сорилт байдлаар сорьж үзье гэж бодоогүй юу?**

Ба: Ерөөсөө тэгж үзээгүй.

**Зу: Бариа засал хийхээр өөрт сайхан мэдрэмж өгдөг үү эсвэл өвчин зовлон шингээдэг болохоор хэцүү байдаг уу? Тиймэрхүү зүйлийн талаар та яриач?**

Ба: Яахав олон хүн бариад ирэхээр жаахан ядардаг юм. Цөөн хүн барьж байхад янз бүрийн юм гарахгүй. Нас яваад жаахан тэгдэг болсон байна лээ.

**Зу: Та хамгийн анхны хүнээ хэдэн настайдаа барьсан бэ?**

Ба: 22, 23 настай байсан байх.

**Зу: Тэр үед бол таны аав тантай цуг байсан уу?**

Ба: Байсан.

**Зу: Та анх би барьж чадаж байна гэсэн итгэл хэзээ бий болсон бэ?**

Ба: 40 нас гараад л хүмүүс бариад болж байна гэсэн. Ямар ч гэсэн болж л байгаа юм байна даа гэж бодож эхэлсэн.

**Зу: Тусгайлан бариа заслын дэг сургууль ч юм уу арга зүй гэж зүйл байгаа юу?**

Ба: Түүн дээр нэг их тусгайлан арга зүй гэж юм байхгүй гэхдээ ерөнхий арга зүй байж л байгаа шүү дээ. Тийм бол тэгж барина гэхчлэн, хамаагүй барихгүй шүү дээ.

**Зу: Одоо заавал тэр өвчин зовлонг мэдэрч байж барих ёстой юм уу эсвэл орчин үеийн анагаах шиг урьдчилан сэргийлээд байх боломжтой юу?**

Ба: Урьдчилан сэргийлээд байх боломжтой. Яагаад боломжтой гэвэл судсаа олж үзүүлэх хэрэгтэй. Маш сайн судас мэддэг хүнээр. Ийм юм байна гээд ерөнхийд нь хэлээд өгнө шүү дээ тэр хүн чинь.

**Зу: Одоо жишээлбэл сүүлийн 4,5 жил суудлын ажил эрхэлж байна. Нуруу өвдөх, олон цагаар машин барихаар бөөр өвдөхөд энэ бүгдийг судсаар оношлуулах боломжтой юу?**

Ба: Боломжтой, судсаар барина.

**Зу:Энийг орчин үеийн анагаах ухаанд заавал шинжилгээ өгч байж оношлуулж байгаа. Тэгэхээр өвдөхөөс нь өмнө судсаар бариулаад, “таны тэр чинь одоо жаахан тэгэх гээд байгаа юм байна шүү” гээд тусад нь тааруулсан тийм бариа хийж болох уу?**

Ба: Болно, тэр бол нурууны загасан булчингууд чангарчхаж байгаа байхгүй юу. Нуруу суулт чинь мэдрэлийг нь дараад хаячхаж байгаа юм. Тэрийг жаахан суллуулаад өгөхөд яах ч үгүй зүгээр болчихно.

**Зу: Тэрийг заавал бариулахгүйгээр гэрийн нөхцөлд хийдэг дасгал хийх тустай юу?**

Ба: Телевизээр гарч байгаа бичлэг зарим нь зөв, зарим нь буруу л байдаг юм. Буруу хийх юм бол болохгүй шүү дээ. Булчин чангарсан үед бол булчингаа бүр л чангална.

**Зу:Тэрийг заавал нэг хүнээр бариулж суллуулж байна гэсэн үг үү ?**

Ба:Тийм. Ямар ч дасгал хийсэн суллах ёстой байхгүй юу.

**Зу:Та бариа засал хийхээс гадна улсын сайн малчин болсноо яривал?**

Ба:Би чинь 1993 онд гэр бүл болоод малаа маллаж явсаар байгаад л 2000 онд мянгат малчин болсон. 2002 онд аймгийн аварга малчин болоод 2003 онд улсын аварга малчин болсон юм. Бог мал голлож байсан. Үхэр адуу тэмээтэй байсан, одоо бол бог л байгаа.

**Зу: Энэ бариа засал хийх мэдрэмж болоод Монгол нүүдлийн соёл ахуй байдал хоёр хоорондоо хэр харилцаа хамааралтай вэ?**

Ба: Хамааралтай. Эрс тэс уур амьсгалтай байгаа газрын улс бол бөөр нуруу их өвчтэй, ер нь их даарч хөрнө. Хөдөөгийн улс их нурууны өвчтэй байгаа. Хүнд юм их өргөснөөс болж нурууны өвчтэй болдог.

**Зу: Миний танаас асуугаагүй таны өвлөн уламжилсан мэдлэг ухааны тухай та ярьж өгвөл танд хэлж яримаар байгаа зүйл байвал хэлж болно. Би өөрөө сайн мэдэхгүй. Яагаад гэвэл энэ чиглэлийн хүн биш бас гартаа мэдрэмж байхгүй бол яг энэ бариа заслын нарийн зүйлсийг мэдэхгүй байна л даа тэгэхээр та энэ арга ухаанаас миний танаас асуугаагүй зүйлсийг ярьж өгвөл?**

Ба:Судсаар оношлон гэдэг бол “ган, зун, цаг” гээд гурван махбод байдаг юм. Тэгээд дэлүү, бөөр давсаг чинь энд байна гээд судас дээр заагаад явчихдаг юм. Тэгэхгүй бол нөгөө улс чинь хий судсаа дарчхаад л ямар юм хаана байгааг мэдэхгүй улс худлаа оношлон. Би анагаахаар сураад махбодоо олсон болохоор түүн дээр тийм судас байгаа гээд ерөнхийдөө бол ойлгосон байхгүй юу. Тэр дээрээ гарын мэдрэмжээ ашиглаад л хаанаа ямар өвчтэй байна гэдгийг нь мэднэ.

**Зу:Тэгэхээр та орчин үеийн анагаах ухааныг хослуулж байгаа гэж ойлгож болох уу?**

Ба:Болно.

**Зу:Монгол анагаах ухаанд ч давуу талууд байгаа, европ анагаах ухаанд ч давуу талууд байгаа энэ хоёрыг нийлүүлэхэд илүү сайн болж байна уу?**

Ба:Тийм. Би Монголоороо ч эмчилнэ, европоороо ч давхар эмчилдэг юм.

**Зу:Аль нэгийг нь дагнах юм бол дутагдалтай тал байгаа юу?**

Ба:Байлгүй яах вэ.

**Зу: Жишээлбэл Монгол анагаах ухаанд дутагдалтай талууд юу вэ?**

Ба: Монгол анагаах ухаанд зарим өвчиндөө нарийвчилсан эм тан байхгүй. Тэрийгээ европ анагаах ухааны эмээр оруулж эмчлэхгүй бол болдоггүй.

**Зу: Бариа заслын хувьд дорнын анагаах ухаантай хольж барьдаг уу?**

Ба: Ер нь нэг их барьдаггүй юм. Ер нь бол хавсрахгүй.

**Зу: Дорнын гээд байдаг Энэтхэг, Төвөдийн анагаах ухаантай яадаг юм бол?**

Ба: Төвөдийн анагаах ухаан чинь Монголын анагаах ухаантай адилхан.

**Зу: Энэнээс яг Монголын хөрсөн дээр байгаа онцлогтой зүйл байгаа юу?**

Ба: Монголын хөрсөн дээр байгаа ургамал хамаагүй илүү байдаг юм.

**Зу: Ургамал уу?**

Ба: Тийм. Энэ хийж байгаа тан хүчтэй байдаг юм. Орон аймгаар өөр өөр байдаг. Манай өвчтөнд өгөхөд говийн ургамал бол хангайн ургамлаас илүү байдаг юм. Энд 50 хувь байлаа гэхэд говийн ургамал 100 хувь байдаг байхгүй юу.

**Зу: Бариа засал эсвэл ганц амьтан, малын эдээр анагаах зүйл байгаа юу?**

Ба: Байгаа малын эрхтэн чинь сайн зүйл байна шүү дээ. Жишээ нь нойр булчирхай гэж өвчин байна. Хүний үүнд бол хонины нойр булчирхай хамгийн сайн. Би үүгээр нойр булчирхайтай улсыг зөндөө эмчилсэн.

**Зу: Яг яаж эмчилж байна вэ?**

Ба: Нойр булчирхайг нь хатаагаад усаар дараад жороор уулгадаг юм.

**Зу: Жишээлбэл таван хошуу малын эд эрхтэн, үс ноосыг анагаахад хэрэглэж байна гэдэг маань зөвхөн монголчуудынх байх боломжтой шүү дээ. Тэгэхээр энэ талаар та улсын сайн малчин хүн байна, өвгөдөөсөө ч юм уу сурсан ямар мэдлэг ухаан байна вэ? Та түрүүн хэллээ шүү дээ, малын нойр булчирхайгаар хүнийг эмчилж байна гэдэг шиг өөр тийм зүйлс байдаг уу?**

Ба: Байлгүй яах вэ. Үхрийн элэг, богийн элэг байна. Энэ чинь дөнгөж усанд дүрээд хэрэглэхэд тэр элэг чинь өөрөө битүү витамин байдаг учраас элэгний өвчлөлд хамгийн сайн. Би бас үхрийн элэг, хонины элгээр эмчилж байгаа. Тэгээд хонины сархинаг янз бүрийн өвчинд сайн. Дэлүү нойр булчирхай гээд бас эмчилнэ.

**Зу: Зэрлэг амьтны эд эрхтнийг анагаахад хэрэглэдэг үү?**

Ба: Зэрлэг амьтнаас ямаан гөрөөсний сүү их сайн юм байна. Цус багадалттай, түрүү савандаа юм үлдсэн улсад өгдөг юм.

**Зу: Энэ арга ухааныг монголчууд яг амьдрал дээрээс суралцав уу эсвэл өөрсдийн ном бүтээл дээр бичиж үлдээсэн зүйл байдаг юм болов уу? Зарим нь ардын арга ухаан гэж нэрлэх юм зарим нь ардын эмнэлэг гэх юм энийг эцсийн байдлаар бичсэн ном судар байдаг юм болов уу? Та энэ талаар сонсож байв уу?**

Ба: Би энэ талаар ёстой үзээгүй. Би дээд өвгөчүүлээс мэдсэн юм л байдаг. Настай улсуудаас л өвлөж авсан зүйл. Тэр нь сайн байдаг шүү гээд хэлсэн зүйл байгаа. Тэрнээс би ном судар уншсан юм ердөө байхгүй.

**Зу: Одоо жишээлбэл та маш олон хүнийг эдгээж байна. Та өөрөө өвдөх үедээ хаана хандаж, ямар эмчилгээ хийх үү? Зарим нэг зүйл уудаг байх тэрнээс гадна?**

Ба:Би чинь өвдөж баривал эм тан л уучихдаг хүн байгаа юм. Өөрөө өөрийгөө эмчлээд. Яах вэ европоор орно л доо. Хавсруулаад л уучихдаг юм.

**Бу: Таны аавыг хэн гэдэг вэ?**

Ба:Агваан

**Бу:Таны аав бас энэ бариа заслын аргыг ааваасаа сурсан гэсэн үү?**

Ба:Тийм ааваас уламжилж байна, би гурав дахь үе.

**Бу:Сумын эмнэлгээс танд яаж ханддаг вэ?**

Ба:Сумын эмнэлгээс бэртсэн улсыг шууд над руу явуулдаг юм. Эмнэлэгтэй хамтарч ажилладаг.

**Зу:Өө, хугарсан байна Батболд гуай руу яв л гэх үү?**

Ба:Тийм, гэмтсэн бол манай эмнэлэг ямар ч арга байхгүй. Улсууд ч мэддэг болсон, гэмтэж хугарсан бол шууд л бариач дээр очъё гээд.

**Бу:Та сүсэг бишрэлтэй хүн үү?**

Ба:Шүтнэ, буддын шашин. Манай аав өөрөө лам хүн байсан.

**Бу:Та хэдэн онд төрсөн бэ ?**

Ба: 1969 онд Баянбулаг суманд төрсөн. Айлын отгон хүү, дээрээ 3 ах 4 эгчтэй.

**Зу:Таны ах эгч нараас барьдаг хүн байгаа юу?**

Ба:Ганц нэг манай эгч нар, нэг их хүн гуйхгүй өөрөө барьчихна.

**Зу:Таны ах эгч нар тан дээр ирж эмчлүүлж байсан уу?**

Ба:Эмчлүүлдэг. Бүгд ирдэг юм.

**Зу:Би танаас сонин юм асууж байж магадгүй, тан дээр хүн ирье бариульа гэхэд төвөгшөөж байсан удаа байгаа юу?**

Ба:Байхгүй, гэхдээ ажил ихтэй завгүй үед бол хэцүү л дээ. Тэгээд завтай болоод бариад өгье гэдэг юм.

**Зу:Энэ, “хүн анагаах ёстой” гэдэг зүйлийг та өөрөө өөртөө хэлж байна уу эсвэл өвлөн уламжлуулсан аав тань “чи ингэх ёстой шүү” гэж зааж сургасан уу?**

Ба:Манай аав бас хэлдэг байсан, “миний хүү чадах ядахаараа тусалж байгаарай” гэж хэлж байсан. Тэгэхгүй бол хүмүүс чинь бас чаддаг юмаараа боолоо гээд болохгүй шүү дээ.

**Бу:Ямар гэмтэлтэй хүмүүсийг та барьж чадахгүй буцаах вэ?**

Ба:Түнхний яг үеэр хугарсан үед болдоггүй юм. Өөр юм бол байхгүй. Бусдаар болж л байдаг юм.

**Зу:Боох тал дээр юуг анхаарах вэ?**

Ба:Ерөөсөө хамаг булчин суллана. Гадна шөрмөсөө суллана тэгээд сайхан ариутгана. Архи спиртээр язралт махыг бүгдийг сайхан хэвд нь оруулаад, сайхан ясаа татаж хэвд нь оруулна. Янз бүрийн цоорсон байвал эм шахна.

**Зу:Цоорох тохиолдол бас байх уу?**

Ба:Байна, яс чинь цоороод гараад ирнэ. Дотор нь эм хийхгүй бол идээлээд байдаг байхгүй юу.

**Зу: Тэгэхээр л бас нөгөө европ арга руу орж хосолж байна тийм үү?**

Ба:Тийм, европ арга руу орно шүү дээ хосолно.

**Зу:Өмнө нь ургамал хийдэг байсан уу?**

Ба:Тэгдэг байсан биз. Би дандаа европ эм хийдэг юм.

**Зу:Та бол мэргэжлийн хүн шүү дээ. Тийм болохоор бас айдасгүй хийдэг байх. Бусад хүнийг яадаг талаар сайн мэдэхгүй юм, тийм ээ.**

Ба:Тийм бол европ эмээ л хийдэг юм. Буглаа үүснэ. Тэгээд тэр антибиотикүүдийг хийж боодог юм.

**Бу:Та сургуулиа хэдэн онд төгссөн юм бэ?**

Ба:1992 онд 4 жил сурсан.

**Бу:1992 он хүртэл та юу хийсэн бэ?**

Ба: 10 жилээ төгсөөд цэрэгт яваад дараа нь Анагаахад орсон юм.

**Зу:Цэргийн албыг хаана хаасан бэ?**

Ба:Төв аймгийн Сэргэлэнд хаасан юм.

**Зу:Цэрэгт байхдаа барьдаг байсан уу?**

Ба:Үгүй.

**Зу:Барих бодол орж ирээгүй юу?**

Ба:Үгүй, ёстой нам гүм байсан.

**Бу:Хэдэн жилийн цэрэг вэ?**

Ба:Сүүлийн 3 жил. Дээрээ 2 үетэй, их нүдүүлдэг байлаа.

**Бу:Тэгээд цэргээс ирээд л сургуульд орсон уу?**

Ба: Тийм, 5 сард ирээд л шууд конкурс өгсөн.

**Бу:Анагаахын сургуулийг төгсөөд удаагүй байхдаа та сайн малчин болсон гэсэн үг үү?**

Ба:Тийм 1992 онд гэр бүл болоод 1993 онд Улсын Сайн Малчин болсон.

**Зу:Одоо таны хүүхдүүдээс мал өвлөж аваад нүүдлийн уламжлалыг өвлүүлээд явах хүн байгаа юу?**

Ба:Байхгүй. Бүгд хот орсон.

**Бу: Хүүхдүүд нь ямар мэргэжлээр сурч байна?**

Ба:Нэг нь одоо хуульчаар энэ жил төгсөх гэж байна. Нэг нь эм зүйчээр төгссөн. Хотод ажиллаж байгаа. Нэг нь “Хөдөө аж ахуйн их сургууль”-д сурч байгаа. Нэг нь энэ жил 12-р анги төгсөж байгаа. Тэгэхээр одоо гарч ирэхгүй байх.

**Зу:Танайх малчин авдаггүй юу?**

Ба:Үгүй өөрөө л маллана.

**Бу:Танай мал хаана байгаа вэ?**

Ба:Эндээс 14, 15 км хүн гуйж байлгаж байгаад, ийшээ ирчхээд л байж байна.

**Зу:Маш их цаг зарцуулж байгаад баярлалаа.**

Ба: Зүгээр зүгээр, та бүгдэд бас их баярлалаа

**Завхан аймаг, Идэр сум, Нарантуяа**

На: Одоо ерөөсөө дэлхийд чадахгүй байгаа юмыг монголчууд, Монгол уламжлал чадаж байгаа юм. Би Монголын бүх аймаг сумаар явж, энэ түүх уламжлалыг судалж, 5500 км

яваад олон аймаг сумдын үндэстэн ястантай уулзсан. Уламжлалын сайн монгол хүн байна уу гэж хайж яваад олоогүй.

**Зу: Та тэр судалгааны үр дүнгээс шинэ зүйл сурсан уу?**

На: Сурахаар зүйл бол харагдаагүй. Гэхдээ газар, газрын ёс заншил гэдэг бол өөр, өөр байсан. Би үнэхээр сайн хүн байвал олж уулзаад нэг л зүйлийг ярьж гэж бодсон юм. Гэтэл байгаагүй. Дээр үед бол яах вэ бүх юм хориотой байсан.

**Ми: Таныг ажиглаж байхад малчдын байр байдал яаж өөрчлөгдөж байх юм?**

На: Би ер нь яах вэ юм болгоныг л ажиглаж байдаг хүн.

**Зу: Танай нутагт одоо болдог бол хамгаалалтад авчихмаар тийм газар нутаг байна уу?**

На: За, ерөнхийдөө бол энэ урд тал улсын тусгай хамгаалалттай. Энэ чинь Отгонтэнгэрийн тусгай хамгаалалттай газар гэж явдаг юм.

**Зу: Тэгвэл уул уурхай хол байна уу?**

На: Байгалийн баялагтай газар бий.Түүнийг бол манайханд хөндөх хүн байхгүй, хөндүүлэхгүй. Би бол залуу насандаа уул уурхайн мэргэжлийн хүн байсан.

**Зу: Зөвхөн уул уурхайн баялаг биш малчдын соёл, ан амьтан, тиймэрхүү зүйлийг хамгаалахаар нүүдлийн соёлыг тусгайлан хамгаалж байгаа бүс, рашаан булаг иймэрхүү зүйлүүд маань устаж алга болж байна.**

На: Янз янзын рашаан маш олон бий.

**Зу: Одоо сүүл үед их л олон булаг шанд ширгэж алга болж байна шүү дээ. Танай нутагт гайгүй байна уу?**

На: Гайгүй.

**Зу: Одоо тэгээд малчдад тулгамдаж байгаа гол асуудал юу байна вэ?**

На: Тулгамдаж байгаа асуудал зөндөө бий, ухамсар байдаг бол тэр асуудалгүй. Бэлчээрийн даац гээд зөндөө байна. Хонь, ямаа зуун хэдэн мянган төгрөгийн юм хэрэглэдэг. Жилд үхэр найман зуун мянга, адуу сая хүрч байна. Хамгийн бага зардалтай нь тэмээ. Тэмээ уг нь хамгийн бага зардалтай. 600 мянга байсан. Харин одоо бараг бүгд үнээсээ давсан зардалтай. Тэгэхээр ерөөсөө төр засаг ийм мянгат малчин, тийм мянгат малчин гээд байгаль устгаад байхад шагнаад байдаг. “Ямар аймаар юм бэ” гээд би гайхаад байдаг, бүх тооцоог гаргасан. Малын хөлийн татвар ав, бид нараас ч бас хөлийн татвар адилхан л авах хэрэгтэй, адилхан л байгалиа сүйтгэж байгаа.

**Зу: Хүмүүсийн хоорондын харилцааны асуудал хэрхэн өөрчлөгдөж байна вэ?**

На: Тэр бол одоо маш сонин болсон. Юутай холбоотой вэ гэхээр, хөрөнгөтэй холбоотой. Дээр үед ямар байсан бэ гэхээр яг л тоосго барьж байгаа юм шиг, үзэл бодол адилхан, амьдрал адилхан байсан. Одоо бол яг л шуудайнд хийсэн үхрийн эвэр гэж ярьдаг шүү дээ, тийм болсон.

**Зу: Энэ чөлөөт зах зээлтэй шууд хамааралтай юу?**

На: Одоо ерөөсөө хүний эрх чөлөөтэй хамаатай үүргээ мэдэхгүй хэр нь эрхээ л яриад байдаг.

**Зу: Одоо хүмүүс их ярьдаг болсон. Сүүлийн үеийн хүүхдүүд ахмад настай хүмүүстэй харилцах харьцаа нь тун өөр болсон гэж, энэ талаар?**

На: За, энэ бол яах вэ хүүхдүүдийн хувьд нэг тийм зүйл ажиглагдаж байгаа. Сүүл үед ухаан нь их сайн болж байна. Бие бялдрын хувьд сайн болж байна. Ганцхан сэтгэл зовоосон зүйл бол эрүүл мэнд л байна. Монголын хөрс шороон дээр галав юүлээгүй цаг үед миний үр удам хэдэн үе дамжаад амьдарна. Цусаараа, амиараа хамгаалаад энэ газар нутгийг бидэнд үлдээсэн байгаа юм. Тэгэхээр бид нар, тэд нартаа бүрэн бүтэн байдлаар нь үлдээж өгөх хэрэгтэй. Тийм үүрэгтэй, тэр үүргийг биелүүлэх ёстой.

**Зу: Арга барил, арга ухаан хоёрын яг аль нь вэ?**

На: За энэ болохоор янз янзын юм байдаг юм л даа. Одоо барих, хатгах, ханах янз янзын эмчилгээ байдаг юм. Тэгэхээр би тархи нь хөдөлсөн хүний тархийг нь барьж өгнө, ясны гэмтэлтэй хүний ясыг нь барьж өгнө, за тэгээд зарим хүмүүсийг хатгаж өгнө.

**Зу: Энэ бүх арга ухааныг та хэнээс сурсан бэ?**

На: Би сургуульд сурахаасаа өмнө янз бүрийн юмыг сонирхож явдаг хүүхэд байсан. Жижигхэн хүүхэд байсан үеийн юм маань ой ухаанаас минь гардаггүй. Хүмүүсийн ярьсан зүйл ерөөсөө мартагддаггүй, нэг хэсэг бурхан шашны зүйл оролдсон, нэг хэсэг эмнэлгийн зүйл оролдсон. Сүүлд энийгээ залгамжлуулж өвлүүлэх нь зүйтэй гэж бодоод хэрэгжүүлж эхэлсэн дээ. Бөөрний хагалгаанд орох гээд өдрийн зуун мянган төгрөгийн эмчилгээ хийлгэж байсан ямар ч эмчилгээгүй улсууд над дээр ирээд зүгээр болоод явдаг юм. Зүрхний шигдээс болсон хүн ямар ч эмчилгээгүй гээд ирдэг юм. Би тэгээд зүгээр болгоод л явуулдаг юм.

**Зу: Та ямар эмчилгээний арга хэрэглэж байна вэ? Нууц биш бол яриач?**

На: Өө, ямар нууц байх вэ. Нууц байтугай би сүүл үед Монголын арга ухаанаа хүмүүс мэдэж аваасай гэж бодоод зааж өгдөг. Хөгшин хүн энийг авч явж байгаад өөд болбол, энэ ингээд хаягдана. Тийм учраас “Залуучууд сурч аваасай” гээд л залуучууддаа зааж өгдөг. Зарим талын зүйлийг заагаад өгөхөөр болохгүй зүйл бас байдаг. Энэ чинь ганцхан ургамал биш олон талын юм хэрэглэгдэж байгаа юм. Тэр талын зүйлийг заагаад өгөхөөр их бэлэн зүйл хэрэглэдэг болчихсон болохоор зарим нэг зүйлийг анзаарахгүй буруу хийх аюултай.

**Зу: Та мухар олгойг хатааж байгаа гэсэн. Тэр тал дээр ямар эмчилгээ хийж байгааг хэлж өгвөл?**

На: Мухар олгой ургана гэж ярьдаг юм. Мухар олгой ургаж байгаа зүйл угаасаа биш байхгүй юу. Тэр лүү юм ороод өвддөг юм. Тэрийг нь л хатаадаг юм. Түүнийг хатаахаар өмхий давс гэж юм байдаг. Тэр муухай амттай зүйлийг өгнө. Огт олгой ургаагүй хүн байна. Тэр хүнийг урьдчилан сэргийлээд, тусахаас нь өмнө хатаачихдаг юм.

**Зу: Тэрнээс гадна бөөрний өвчин гэдэг юм уу. Ямар өвчин голдуу байна? Ямар эмчилгээ хийж байна? Эмчилгээний арга ухаанаасаа дэлгэрэнгүй ярьж өгвөл?**

На: Цөсний чулуутай хүмүүс ирнэ. Тэрийг монгол аргаар хайлуулдаг юм. Тэр арга нь нохойн хошууг найруулж бэлдээд, долоо хоног уулгаад очоод үзүүлэхэд цөсний чулуу алга болсон байна гэдэг. Гурваас дөрөв хоног дээр шээсээр элс болоод гарч ирнэ. Бөөрөнд нь чулуу ургасан хүмүүс байдаг. Тэр хүмүүст сонгиныг архинд найруулж бэлдээд өгнө.

**Зу: Та энэ аргуудыг хаанаас сурсан бэ? Туршлага дээрээсээ сурсан уу? Ном судар харав уу эсвэл ахмад настай хүмүүсээс сурсан уу?**

На: Цагаан мах эргэсэн хүмүүс байдаг юм. Цагаан мах эргэнэ гэхээрээ дөрвөн булчин байдаг, тэр булчин сулрахаар цагаан мах эргэдэг. Энэ эмчилгээний аргаар тэрийг тайрдаг. Тайраад ямар ч ажиллагаагүй болно тэгэхээр нь тэр хүнд би юм өгөөд булчинг нь чангалаад өгдөг.

**Зу: Тэрэнд юу өгөх вэ? Ямар хэмжээтэй гээд энэ бүхэн нууц биш бол та хэлээд өгөөч?**

На: Цагаан мах эргэх гэхээр, дээр үед бол хүн чулуу ургамлаар арчдаг байсан, одоо үед нойлын цаас гээд хэт хуурай зүйлээр арчсанаас болж л эргэж байна. Тэр түүсэн ургамал байна. Би хоёр удаа эмчлээд л зүгээр болно.

**Зу: Тэр түүсэн байгаа ургамал ямар ургамал вэ?**

На: Би ордог зүйлүүдийг хүүхэд, багачууддаа зааж өгдөг байхгүй юу. Энэ юмыг “сайн харж ав, сурч ав” гэдэг. Урд жил корона гарахад хүүхдүүддээ тусгачихгүй гээд, олон юм хэрэглүүлээд л туссангүй.

**Зу: Тэр маш сонирхолтой байна л даа. Та хүүхдүүддээ өгч байсан эм тангаасаа нэрийг нь хэлж өгвөл?**

На: Саримс зүүлгэсэн, ганга уулгасан. Корона туссан хүн байсангүй шүү дээ.

**Зу: Жишээлбэл тан дээр ирж байгаа хүмүүсийн өвчин зовлон юу байна, ямар арга хэрэглэж байна?**

На: Бөөр өвдсөн улс сүүлийн үед их байна. Зарим хүнд ажил хийж байгаа хүмүүс бөөр их өвдөж байна. Пүүз өмсөх их аюултай хүнийг бөөргүй болгодог. Би буган гээд ургамал бэлддэг тэрүүгээр ундаалдаг юм.

**Зу: Та тэдгээр зүйлийг хэнээс сурсан бэ?**

На: Зарим нэгийг нь би өөрөө судалж гаргаж ирсэн зүйл, зарим нэгийг нь сурсан. Би юм болгоныг судалдаг. Ганцхан өвчин биш. Өвчин яагаад ихдээд байна вэ гэдэг тал дээр Монгол хүнд захих зүйл байна. Зөв боловсон хооллож чадахгүй байна. Тэрнээс үүдэлтэй, тэрнээс биш урт наслах боломж байна. Янз бүрийн хүнс хэрэглэж байна, түүнийг шингээхгүй байна. Ходоодны өнгөртэй болоод өнгөр нь шарх, тэгээд ходоодны хавдар болж байна. Ходоодоо тайруулж байна. Өвчин тусаж болно гэхдээ тэрийгээ хүндрүүлэхгүй л байх ёстой. Монгол арга ухаанаар эмчлүүлбэл ямар ч зардал гарахгүй.

**Зу: Одоо таны хэрэглэж байгаа арга ухаан монголчуудынх юм уу эсвэл бүс нутаг, угсаатны анагаах ухаан юм уу бүр эсвэл цаашлаад дорнын ард түмэнд нийтэд байдаг арга ухаан юм уу?**

На: Энэ бол ерөнхийдөө монгол хүний л хэрэглэж байсан арга ухаан гэхдээ янз, янзын ургамал зарим бүс нутагт ургадаггүй, мэдэхгүй. Тэгээд би бүсгүйчүүдэд захидаг юм. Та нар ч гэсэн мэдээд ав. Эр, эм хоёр хүн бие өөр. Эмэгтэй хүн яагаач үгүй эрт ясны сийрэгжилт болж кальцийн дутагдал болдог. Та нар ажиглаарай. Тэгээд харахаар ерөөсөө эмэгтэй хүн их доголон. Ясны сийрэгжилтээс хамгаалах нэг арга байдаг юм.



Тэр нь тугаллаж байгаагүй нэг үнээ аваад тэр үнээнээс сүүг нь саагаад тусад нь хувинд аваад нэг шаазан халуун сүү ууна. Долоо хоног уухад кальци 100 хувь нөхөгддөг.

**Зу: Тэгвэл таны бодлоор яг монголчуудын анагаах ухаан аль нь вэ? Бариа засал уу, зүү төөнүүр үү, мал амьтан, ургамлаар анагаах уу?**

На: Ер нь бол энэ хануур төөнүүрийг янз, янзын газар хийж байна. Би судас барихдаа хэлдэг юм. “За миний дүү чиний биед хэчнээн ширхэг судас байгаа вэ” гэж асуудаг. Тэгэхэд нэг л хүн олон байгаа, мянга байгаа байх гэж хэлж байсан. Тэгэхээр хүний биед нарийн бүдүүн нийлээд 84 мянган судас байдаг юм. Ханахын тулд яадаг гэхээр, цусыг нь ялгадаг тан өгөх хэрэгтэй. Сайн мууг ялгана, за тэгээд яг ялгарсан цус ханах хэрэгтэй. Ялгараагүй үед нь ханавал сайн цус гарна гэж байхгүй. За тэгэхээр цус ялгадаг тан бэлдье гэхээр тангийн үрийг Энэтхэгээс авдаг эд. Тэгэхээр манай энд тийм зүйл ор тас байхгүй.

**Зу: Одоо жишээлбэл ханахдаа хэр их хэмжээний цус хүнээс ханадаг юм болоо?**

На: Тэгж хамаагүй их гарахгүй. Тэр цус гэдэг чинь зарим нь их өтгөн, зарим нь их шингэн юм байна. Өтгөнөөсөө шалтгаалаад өөр, өөр. Эрэгтэй хүн бол мэснээс маш их айдаг. Эмэгтэй хүн бол ер тоодоггүй.

**Зу: Дундаж авах ёстой хэмжээ гэж байх уу?**

На: Одоо жишээлбэл тан өгөхгүйгээр ханадаг эмчилгээ гэж байна л даа. Сүүлийн үед энэ компьютер дээр байнга суудаг хүмүүс, ер нь суугаа ажил хийдэг хүмүүс гүйдлийн өвчин гэж юмтай болно. Тэрнээс болж даралт ихэсдэг. Тэрнээс бол халбага хэртэй цус гарна. Одоо энэ эмчилгээний янз, янзын сувилалд ингэж хатгуулаад гээд ярьдаг. “Аль ах нь харъя” гэхээр хаа хамаагүй ханасан байдаг. “Хандан зээрд” гэж байдаг, энэний хоёр талд тэр өвчин татагддаг. Тэгээд ингээд юм өөр байх юм. Элэгний судас, зүрхний судас гээд өөр байгаа. Яг номоороо бол өөр нэг мундаг хүн байна. Хүний зүрхний судас яг энд байдаг юм.

**Зу: Та судасны байрлалыг өөрөө олж мэдсэн үү эсвэл хэн нэгэн хүн зааж өгсөн үү?**

На: Хатгаж барьж байгаа хүн харж л байсан, хар домын судар гэж байдаг шүү дээ, тэрийг судалсан. Янз, янзын юм байна. Жишээлбэл толгойтой үс хагтаад байна, үс уналаа гэж ярьдаг. Тэгэхээр тэр яагаад ингэж байгаа вэ гэхээр, газар тариалантай харьцуулья. Газар тариаланг сайн бордвол л сайн ургана. Тэгэхээр тэр хуйхны чинь бордоо нь дутагдаад хагтаж үс унадаг. Тэгэхээр энийг эргээд бордохоор, хагтахгүй үс унахгүй. Гангаар угаагаад өгөхөөр хагтахгүй, үс унахгүй. Хорголоор бордвол унахгүй.

**Зу: Та түрүүн хэлсэн энэ тан барихад Энэтхэгээс авч байна гээд, зөвхөн Монгол улсад ургадаг эмийн ургамлаар хийж байгаа эм тан байна уу?**

На: Хоолойны мах ургалаа, махыг нь авхуул гэхэд эргээд буцаад ургачихна. Тэгэхээр Монгол арга яадаг вэ гэхээр тэр махыг авахгүй. Тэр цусыг шимэгдүүлэхээр мах эргээд хэвийн байдалд орно.

**Зу: Цусыг шимэгдүүлэхийн тулд ямар эмчилгээ хийх вэ?**

На: Тэр хоолойны цусыг шимэгдүүлэх юм юу байна гэхээр, жамц давс хэрэглэхээр шимэгддэг. Хөл дээр нь янз янзын яс ургасан хүмүүс байдаг. Тэр эмчилгээний арга

яаж байна гэхээр ясыг нь авч хаяж байна. Буцаад л ургана. Монгол аргаар яана гэхээр, тэр ясыг авахгүй, ясыг шимэгдүүлнэ. Шимэгдүүлсэн шүүсийг нь авахаар яс буцаад хэвдээ орно.

**Зу: Тэр тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?**

На: Над дээр нэг хүн ирж байлаа. Хүнд арван хуруу байгаа. Тэгвэл хуруу болгоныхоо хоёр талд бондойчихсон байсан. Тэгээд ясыг нь шимэгдүүлсэн. Тэр нь ямар арга байдаг гэхээр Оросын байхуу цай гэж байгаа, тэрийг задлаад, мөнгөлөг цаасаар хөлд нь бооно. Тэгээд л байхгүй болно. Одоо энэ хамрын гамрит өвчинд ерөөсөө нэг лаа л хэрэгтэй. Лаагаа халуун усанд хийгээд тэр нь хайлаад, хайлсан лаагаа арай нүүр түлчихгүйхэн шиг жаахан жаахнаар хавтгайлан аваад дух, хамар, хацар, хоёр нүдийг нь оруулахгүйгээр ингээд шавдаг байхгүй юу. Шаваад нэлээн байлгаж байгаад авна. Маргааш нь ахиад л халуун усанд хийгээд, хайлуулаад гурван удаа хэрэглэнэ. Тэгэхээр цусны өвчин их байна. Цусны өвчтэй хүүхдүүдийг 7 хоногийн дотор эрүүл болгож чадна гэхээр намайг зөнөсөн өвгөн гэх байх. Хамраас нь цус гараад тогтдоггүй хүмүүс байна, цусны бүлэгнэл болчихсон. Эмнэлгийн хүмүүс бол тэд нарыг тариад л байна өөр зүйл байхгүй. Монгол аргаар эмчлэхэд 2, 3 удаа өгөөд л зүгээр болно. Тэмээн зулын цагаан цэцэг гэж өгнө. Гурван удаа өгөөд цусны бүлэгнэл байх хэмжээндээ болно. Бүлэгнэл байхгүй болно гэдэг чинь цус өтгөрөөгүй, шингэн гэсэн үг шүү дээ. Цус багатай хүн гэж байна. Цус багатай хүн гэж нүүр ам нь цонхийсон тийм байдаг юм. Цус багатай хүний цусыг төлжүүлнэ. Түүнийг бол залуу ямааны халуун цус нэг шаазан уувал цус төлжинө. 200 гр орчим хэрчээд ундааны саванд хийгээд дээрээс нь нэг шил архи хийгээд өдөр болгон сайн сэгсрээд, 21 хонуулаад тэрнээсээ арван дуслыг аяганы тал сүүнд хийгээд ууна.

**Зу: Энэ аргуудыг та бүгдийг нь хүмүүст туршсан гэсэн үг үү?**

На: Тийм. Миний судалж туршсанаар бол эдгэхгүй өвчин гэж байхгүй. Нэг л өвчин байдаг юм. Эр хүнийг охин болгож болохгүй. Охин хүний гэр болгож, сүвийг нь өөрчилж болохгүй. Мөн хүүхэд гаргахгүй төрдөггүй хүмүүс байна. Тэгэхээр эмэгтэй хүнд би юм уулгана. Одоо жишээлбэл жил болгон тугалладаг үнээ байна. Тэгсэн гэнэт тугаллахаа больдог. Яг түүн шиг эмэгтэй хүний савны амсар дээр юм гарчихдаг. Түүнийг нь хайлуулдаг байхгүй юу.

**Зу: Түүнийг хайлуулна гэдэг маань эмийн ургамал тан хэрэглэх үү?**

На: Тан байна. Тэгээд жонш гэж нэг зүйл байна. Тэрийг найруулж өгдөг. Жонш их хатуу эд. Юм болгоны эмчилгээнд ордог. Баас шээс ч гэсэн эмд ордог. Шээс хүний халууныг татдаг, баас бол газрын юм гарсан хүнд түрхэхээр алга болдог байхгүй юу.

**Зу: Энэ номхотгох гэж ярьдаг нь ямар учиртай вэ?**

На: Номхотгоход аюултай нэг ургамал байдаг. Тэр нь “манчин” гээд өвс байгаа. Тэрийг хүн ч бай мал ч бай амслаа л бол үхнэ.

**Зу: Тэр ургамал Монгол улсад байдаг уу тэрийг яаж номхотгох вэ?**

На: Тэрийг түүгээд хатаагаад тавина. Маш бага хэмжээний архинд хийгээд дарна. Хоногоо гүйцээхлээр байшинд бол болохгүй гэрт тооно онгорхой, агаар орж байгаа газар

эмчлүүлж байгаа хүний нүд ам, бас өөрийн гарыг бооно. Тэгээд хөл гар нь өвчтэй хүний тэнд түрхэж бооно. Боолтоо аваад цэвэрлэж, дахиад бооно. Тэр бол хамгийн аюултай хүнд эмчилгээ.

**Зу: Тэр ургамлыг ямар үед хэрэглэж байна вэ?**

На: Тэр бол кальциас болоод хөл мэдээгүй болсон үед л ясны сийрэгжилтийг нөхөх үед хэрэглэнэ.

**Зу: Өөр заавал номхотгож байж хэрэглэх ёстой ямар ургамал байдаг вэ?**

На: Би хүүхдүүдэд захидаг юм. Энэ “хурганы цагаан цэцэг”-ийг түүж болохгүй. Тэр цагаан цэцэг бол яг ижилхэн мөртөө, гол нь өөр, өөр өнгөтэй. Хар голтой, шар голтой, ягаан голтой. Ягаан голтой, шар голтой нь бол зүгээр. “Бугын зуурд” гээд ургамал байдаг. Тэр бол маш аюултай. Мал идвэл нүд улаанаар эргэж, харсан юм болгон дээрээ харайна.

**Зу: Тэрийг эрүүл мэндийн шаардлагаар хэрэглэж болох уу?**

На: Тэрийг гадаад руу гаргадаг юм байна лээ.

**Зу: Зарим сударт энэ арга ухааныг тэмдэглэсэн, тэмдэглэгээгүй олон янз байдаг уу?**

На: Зүгээр бичсэн юмыг хүн хараад бол нарийн ялгаж чадахгүй. Тэгэхээр амьдрал дээр яг хэрэглээд, туршигдаад баталгаажсан юм шүү дээ. Сүүлийн үед боддог юм. Монгол хүний бие организм гэж өөр байна. Энэ сүүл үеийн юм бидний биед таарахгүй, тэгэхээр монгол хүн монгол хүнс хэрэглээд явж байх хэрэгтэй. Одоо энэ эмэгтэйчүүд нүүр амандаа янз бүрийн гоо сайхны юм түрхэж байна. За яах вэ нүүрийг нь өнгө оруулдаг л юм биз дээ. Тэрнээс илүү нөлөөтэй.

**Зу: Одоо таны ярьж байгаа уламжлалт анагаах ухаан болоод орчин үеийн анагаах ухаан хоёрын давуу, сул талууд юу вэ?**

На: Ажиглаж байгаа, би хүмүүст хэлдэг юм. “За миний дүү нар эмнэлэг бараад” гэж. Одоо энэ анагаах ухаанаар сурч байгаа хүмүүс над дээр ирж шавь ордог юм. Тэгээд тэд нарт зааж байгаа гадаадын юмыг би ямар мэдэх биш. Өөрийнхөө талаас асуухаар ер мэдэж байгаа юм байхгүй.

**Зу: Тэгэхээр нь монголчуудын уламжлалт анагаах ухаанд өөрийн гэсэн онол байна уу?**

На: Зүрх болохоо байсан гээд зүрхний хагалгаанд ороод байдаг. Монгол аргаар яадаг вэ гэхээр зүрх байдаг газраа байж л байна. Дотор судасны нарийн шүүрс гэж байдаг тэрийг монгол аргаар тэлж өгдөг. Судсыг нь тэлээд л зүгээр болдог.

**Зу: Та түрүүн ярьж байсан цагаан мах эргэхэд ямар эмчилгээ хийдэг билээ?**

На: Энэ болохоор шар цэвэрлэнэ гээч юм.

**Зу: Энийг хэзээ ямар үед ямар модноос авдаг вэ?**

На: Энэ модон дотор ордог юм. Дээр үед бол үүнийг иддэг байсан. Энэ бол хүний тамир тэнхээг маш их сайжруулж байгаа. Энэнээс хоёр том юм авна. Хоёрыг хийгээд, нэгийг шаазанд хийгээд хоол унданд хэрэглээд, маргааш нь ахиад ийм аяга шөл уугаад зүв зүгээр. Энэ бол ямар ч монгол эмчилгээнд байдаггүй. Энэ яасан гэхээр би цагаан мах

эргэдэг тэгээд янз, янзын юм хэрэглэж байгаад энийг уугаад тэрнээс хойш зүгээр болсон.

**Зу: Энийг бол та олж нээсэн гэж хэлж болох уу?**

На: Болно, тэгэхээр үүнийг хэрэглэж байгаа хүн сайхан болно.

**Зу: Энэ монгол оронд элбэг ургах уу?**

На: Энэ модгүй газар байхгүй шүү дээ, тал газар, модны хаяа газар л байдаг юм. Гэхдээ юмны үндэс байгаа юм. Одоо “боогон” гэж гоё өнгийн цэцэгтэй байдаг. Шар өнгийн цэцэгтэйг бөөрөнд хэрэглэнэ. Хөх өнгийн цэцэгтэйг бамбай булчирхайд хэрэглэнэ.

**Зу: Энэ боогон гээд байгаа цэцэг ургамлыг номхотгохгүйгээр хэрэглэж болох уу?**

На: Болно.

**Зу: Одоо номхотгохгүйгээр хэрэглэдэг, хүний биед хамгийн ач тустай мөртөө хамгийн элбэг ургадаг ургамал юу вэ?**

На: “Дэгдэнэ” гэж байна. Шар дэгдийг шар өвчинд гээд янз, янз. Шарласан хүн нэлээн олон жилийн дараа элгэнд нь өөхлөлт үүсдэг. Одоо энэ В, С вирус гэж яриад байгаа шүү дээ. Ингээд өөрчлөгдөж эхэлдэг. Тэгэхээр шар өвчинд бүрэн буцалгаж хэрэглэнэ. Элэг мөн томордог, урагддаг, цоохорддог. Хүндрээгүй нөхцөлд цусыг цэвэрлэнэ. Болохоо байгаад усан хаван болно. Усан хаванд халуун цус уулгана. Шээлгэнэ, шээсийг нь буцааж уулгана. Тэгэхээр тэр элэгний усыг хөөгөөд гаргана.

**Зу: Уламжлалт анагаах ухаан буддын шашинтай хэр их нийлсэн бэ? Дорнын анагаах ухаантай хосолсон арга ухаан байдаг уу эсвэл дан ганц монголчуудын өөрсдийн эмч нараас бий болсон арга ухаан уу?**

На: Энэ бол дан ганц Монголын арга ухаан гэж хэлж болохгүй. Ер нь бол Энэтхэг орно. Манай Өвөр монголчууд орно гээд янз, янз.

**Зу: Бусад орон ороогүй. Зөвхөн монголчуудын гэж хэлж болох нэг арга хэлж өгөөч?**

На: Ер нь монгол хүн байгалийн юмаар эмчилдэг. Гадаадын янз, янзын юм байгаагүй. Тэр дээр нэмээд хатгах, ханаж эмчлэх барьж эмчлэх бариа засал орно. Дээр үед бариа заслаар сургаж байсан.

**Зу: Бас нэг зүйл байдаг. Барьдаг хүмүүс дээр очихоор гартаа юмтай гэж ярьдаг.**

На: Гартаа юмтай гэдэг нь гарын мэдрэмжтэй гэсэн үг. Ямарваа нэг юмыг сурна гэдэг анхаарлаа сайн хандуулж байж сурна, тэрнээс биш сурахгүй шүү дээ.

**Зу: Та бариа засал сурахдаа өөрөө сурав уу эсвэл гарын мэдрэмжээрээ сураад хөгжүүлсэн үү?**

На: Тэгэхээр янз, янз л байна. Яс хугарах хоёр янз. Тэгшхэн хугарсан байна уу, ташуу байна уу бүр эсвэл үйрээд унасан байна уу гэдгийг мэдэрч байрлуулна, бооно. Нэгэнт хугарсан юм чинь их хэмжээгээр хавдана, тэрэнд нь тааруулж бооно. Хавдар буугаад ирэхээр чангална.

**Зу: Зарим хүн ирээд өвчин зовлонгоо хэлэхэд чадахгүй гэж буцааж байсан тохиолдол бий юу?**

На: Байхгүй, унаж тусдаг хүнд юм бэлдээд өгөхөд ганц удаа ч унаагүй.

**Зу: Тэр нь юу вэ?**

На: Тэр бол их нарийн, энгийн хүн чадахгүй. Эмчилгээ шашин талдаа холбоотой. Дом гэж байдаг шүү дээ.

**Зу: Хүмүүс шууд гэмтэж бэртээд тан дээр ирэх үү эсвэл орчин үеийн анагаахаар явж байгаад ирэх үү?**

На: Зарим нь эмнэлгээр яваад эцсийн шатанд хүрэхээрээ ирэх юм. Тэгэхээр бас их харамсалтай. Тэр хүмүүс чинь бөөн химийн эмчилгээ хийлгэж байгаад ирнэ. Бөөн хор. Монгол аргаар цусыг нь цэвэрлээд л болдог. Жишээ нь дэлүү гэж байгаа. Дэлүү ямар үүрэгтэйг мэдэх үү та нар? Дэлүү бол хүний идсэн уусныг шүүх үүрэгтэй. Тэр бохирдох нөхцөл бүрдэнэ. Тэгээд цус бохирдоно.

**Зу: Одоо та өөрийн сурсан мэдсэнийг цааш хэн нэгэнд өвлүүлэх бодол бий юу?**

На: 2016-2020 оны сонгуулийн хооронд , аймаг ороод Завхан аймгийн бөхийг эмчилж өгөх болов. Бөх эмчлэхээр, аймгаараа эмчлүүлэх болно. Тэгээд надад орон байр хэрэгтэй гээд эмчлэхээр болов. Өвөл аймгийн дарга ирэхэд “би ийм хүн Завханд байгаа, бүх хүнийг эмчлэх юм” гээд хэлсэн. Тэгсэн “өө болно, эмчилгээний бичиг аваар ир” гэв. Надад ямар эмчилгээний бичиг байх вэ дээ, тэгээд больсон.

**Зу: Жишээлбэл та Завхан аймагт ямар өвчин эмчилнэ гэсэн санал тавьсан бэ?**

На: Цусны өвчтэй хүмүүсийг бүгдийг нь эмчилье гэж бодсон.

**Зу: Яагаад бидний уламжлалт анагаах ухаан цусны өвчнийг эмчилж болж байхад орчин үеийн анагаах ухаан тэрийг ашигладаггүй вэ?**

На: Мэдэхгүй, цусны өвчнийг тэгж судлаагүй юм байна гэж боддог.

**Зу: Миний болон таны бодлоор уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулбал их үр дүнд хүрэх юм шиг санагдаж байна.**

На: Хүрнэ, тэгэхээр яг дотроосоо эмчилбэл. Одоо бол дан гадаадын юм дагаж хэрэглэж байна. Хүүхдүүдийн сурч байгаа зүйл дандаа гадаад. Одоо монгол гэдэг зүйл 100% алдагдлаа. Ямар сайндаа би аль орны хүмүүс дунд амьдраад байгаагаа мэдэхээ байсан.

**Зу: Монголчуудын сэтгэлгээний онцлог гэдэг зүйл байх уу?**

На: Байна. Монгол хүний ген гэж байгаа, тэнд хадгалагдана.

**Зу: Тэгвэл Монгол хүний сэтгэлгээний онцлог юу вэ?**

На: Одоо бол ярьж байгаа хэл нь л монгол байх. Тэгэхээр өв уламжлалаа авч үлдмээр байна. Одоо энэ эрэгтэй эмэгтэй хүмүүсийг харьцуулахаар арван насны зөрүү байна гэж байгаа. Нас барж байгаа хугацаа нь. Эрэгтэй хүн яагаад богино наслаад эмэгтэй хүн яагаад арай урт наслаад байна гэхээр хоёр зүйл гарч ирж байна. Эр хүн эхээс төрөөд үхэн үхтлээ ямар ч цус холилдоогүй. Эмэгтэй хүн бол хүүхэд төрүүлнэ, цус холилдоно. Тэгээд эрэгтэй хүн биеэ хайрлах нь бага, хүнд хүчир ажил хийдэг. Эрэгтэй хүн даарч хөрөхөөр түрүү булчирхай өвддөг. Охидууд даарахаар цистит гэдэг өвчин тусна.

**Зу: Энэ хоёр өвчнийг эдгээдэг ардын эмчилгээ байгаа юу? Жишээ хэлбэл?**

На: Янз, янзын ангын талын юм эмчилгээнд их ордог юм. Тийм болохоор нэг их ашигладаггүй. Яагаад гэхээр бас амьтан алж эмчилж болохгүй. Тэгэхээр ямар ч гай үгүй юмаар эмчилье гэж боддог.

**Зу: Та одоо эдгээр арга ухааныг уламжлуулъя гэвэл аль нь хамгийн сурахад хэцүү вэ ?**

На: Ер нь энийг өвлөөд сурсан байхад хүнд их хэрэгтэй. Би заримдаа боддог. Одоо энэ Завхан аймаг гэхэд 24 сумтай. Тэгэхээр сум болгоноос ядахдаа 3 хүн тэгээд 72 хүн болно доо. Сургаад өгчихвөл энэ өв ухааныг хадгалж явахаар байгаа юм. Энэ талаар би судалгаа хийж, жил тойрсон гээд байгаа шүү дээ. Ийм талын мэдлэгтэй хүн байдаггүй юм байна лээ.

**Зу: Тэгэхээр бид энэ анагаах ухааны алийг нь илүү яаралтай судлах хэрэгтэй вэ?**

На: Ер нь бол хэрэггүй зүйл гэж байхгүй. Өвчин болгон хэцүү. Бүгдийг нь хэрэглээсэй гэж боддог. Нэг эмнэлэгт үзүүлэхээр нэг эм уудаг, өвчин тэгж ужгираад хагалгаанд ордог. Тэгэхээр өвчнөө хөнгөн дээр нь л дарах хэрэгтэй, хүндэрсэн хойно нь суучхаад байгаа юм.

**Зу: Урьдчилан сэргийлэхэд хамгийн хэрэгтэй зүйл нь юу вэ?**

На: Ганцхан арга бол зөв боловсон хооллох. Одоо янз, янзын халуун ногоотой хоол ходоодны өнгөр алга болгоно. Өнгөр байхгүй болоход хоолоо шингээх аргагүй. Хоолоо шингээж чадахгүй болохоор ходоод шархалдаг. Шарх нь ходоодны хавдар болоод тайрна.

**Зу: Таны уламжлалт арга ухаанаас хамгийн сайн чаддаг арга ухаан нь аль вэ?**

На: Би ерөөсөө янз бүрийн өвчнийг эмчлэхэд зориулалтаар явдаг. Хануур төөнүүр гэхэд гадаадаас янз бүрийн тангийн материал авах хэрэг гарна. Наашаа зардал их, гадаадын юм өндөр үнэтэй. Би хүнийг эрүүл болгох хүсэлтэй. Тэр хүн эрүүл болбол тэр хүнээс илүү их баярладаг. Тэгэхэд л гар дээр юм дусаах хүн их ховор доо. Би юу хийдэг юм гэхээр, хөдөө гадаа юмаа цуглуулаад байдаг. Тэгээд сүүл үед боддог юм. Нэг хөгшин ингэж цуглуулж байгаад алга болох вий гэж. Аптекаас юм авахад хүн зүгээр авахгүй мөнгөөр л авна шүү дээ. Тийм сэтгэлгээ бол байна. Гаднын улс л тийм сэтгэлтэй, таны юм хэдэн төгрөг үү гэдэг би бол “ах нь тийм юм тогтоодог хүн биш” гэдэг. Боломжтой ч хүн бий, боломжгүй ч хүн бий. Боломжгүй бол тэрнээс авах гээд яах вэ, хүний амьдрал янз, янз. Ер нь эрүүл мэнд дээр л хүн маш их анхаармаар байна. Би их харамсаж байна. Одоо энэ газтай ундаа яс сийрэгжүүлнэ. Архи байна, донтуулна ер нь тэгээд болох юм ховор.

**Зу: Бид танаас асууж чадаагүй ардын уламжлалт анагаах ухааны хэлмээр байгаа зүйл юу байна вэ?**

На: Монголынхоо ард түмэнд зөвлөх ганцхан зүйл байна. Ерөөсөө эрүүл саруул байхын тулд “зөв хооллооч ээ” гэж хүсмээр байна. Монгол хүний биед гадаадын янз бүрийн юм таарахгүй байна. Би тийм янз бүрийн зүйл хэрэглэдэггүй. Монголоороо бай л гэж. Монгол соёлоо үхэн үхтлээ авч явна. Болдоггүй зүйл гэж байдаггүй, байхгүй. Одоо судас бүдүүрэх байна, тэрийг би дор нь зүгээр болгоно.

**Зу: Хүмүүс яагаад уламжлалт анагаах ухаандаа итгэхгүй байна вэ?**

На: Сүүл үед л ийм боллоо. Гэхдээ нэг хэсэг бол эмчилгээ шашин бүх юм хаалттай байлаа. 1990 оноос хойш дэлгэрсэн. Тэгээд гадаад, дотоодын юмыг муу хэлэхгүй. Тэр орны хүмүүсийн бие өөр шүү дээ. Тэр хүмүүстэй таардаг байх. Жишээлбэл энэ газар нутаг

ийм хүйтэн сэрүүнд амьдарч байгаа бидний бие шал өөр. Тэгэхээр Монгол юмаа хэрэглээч. Тэр юмны үнэ ч гүйцэгдэхээ байлаа. Монгол юмаа хэрэглэдэг хүн ч байхаа байлаа. Дан гадаад юм хэрэглэдэг ийм хүмүүс боллоо. Яагаад монголоороо байж болдоггүй юм. Одоо энэ хүүхэд сахлаа приткээр (притка) авч байна. Мань шиг юм бол зулгаана. Хүүхнүүд бас үсээ будаж байна, энэ чинь хор. Би бол хэзээ ч өөр юм бодохгүй би Монголынхоо төлөө л гэж явна.

**Зу: За танд их баярлалаа.**

**Завхан аймаг, Тосонцэнгэл сум, Мөнбаярын Цэвэгжав**

**Зу: Өөрийгөө дэлгэрэнгүй танилцуулж өгнө үү?**

Цэ: Мөнбаярын Цэвэгжав, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын уугуул. Сумандаа ажиллаж байгаа. 2008 онд Тосонцэнгэл сумын 2 дугаар арван жилийг төгсөөд, тэр оныхоо намар Энэтхэг улс руу явсан. Энэтхэгт би 9 дүгээр Богдын дэргэдэх.....2:00 жод лүйжингийн номыг 3 жил үзсэн. Ирээд 2013-2019 оны хооронд “Оточ маарамба” анагаах ухааны сургуулийг “уламжлалтын их эмч” мэргэжлээр төгссөн. 2019 оноос өнөөдрийг хүртэл сумандаа хувиараа үйл ажиллагаа явуулж байна. Ард иргэддээ эмчилгээ үйлчилгээ үзүүлж байна.

**Зу: Таны Энэтхэг явах болсон шалтгаан юу вэ?**

Цэ: Энэтхэг явах болсон шалтгаан бол тухайн үедээ би Төвөдийн уламжлалт анагаах ухаан сурья гэсэн бодолтой байсан. Надад нөлөөлсөн зүйл бол би өөрөө бурхан шашинтай их ойр өссөн. Миний өвөө буюу ээжийн аав манай нутгийнхан их сайн мэднэ. Дашдаваа гэж лам хүн байсан. За тэгээд өвөөгийнхөө хажууд харж өсөх, дараагаар миний төрсөн ах Өлзийбат гэж лам хүн байна. Бас л Тосонцэнгэлийн уугуул. Ахынхаа дэмжлэг зөвлөгөөгөөр Энэтхэгт сурвал ямар вэ гэсэн бодолтой явсан. Очсон хойноо миний бодол өөрчлөгдөөд Монгол хүн бол Монгол уламжлалт анагаах ухаанаараа сурах нь зөв юм байна. Би нэгэнт бурхны шашинтай хүн, бурхны оронд зориод ирсэн шүү дээ. Энд хүрээд ирсэн юм чинь ном үзье гэж шийдсэн.

**Зу: Би нэг ийм зүйл асуумаар байна. Ялангуяа дорнын анагаах ухаан Монгол, Төвд, Энэтхэг, Хятад гээд маш олон зүйлээрээ ижил төстэй байх. Тэр бүхний ялгаа ч гэх юм уу, ялангуяа Энэтхэг, Төвөдийн анагаах ухаанаас юугаараа Монгол анагаах ухаан нь Монголчуудын магадгүй нүүдэлчдийн ч гэдэг юм уу энэ онцлогийн тухай ярьж өгвөл ?**

Цэ: Ерөнхийдөө яах вэ ижил төстэй ялгаатай талууд аягүй олон байгаа. За тэгээд ижил талаараа бол Төвийн анагаах ухаантай их төстэй. Учир нь гэвэл “Анагаах ухааны дөрвөн үндэс” гээд ном маань өөрөө Төвд хэл дээр эхээрээ байж байдаг. Тэгээд монголчууд яаж ялгарах юм бэ гэхээр миний хувьд бол монголчуудын цаг уурын онцлог бол маш нөлөөтэй. Ерөнхийдөө цаг уурын эрс тэс уур амьсгал, дөрвөн улирал, бүсчлэлээр ялгаад байгаа. Монгол улсад амьдарч байгаа Монгол хүн хангайн бүс, говийн бүс гэдгээрээ ч юм уу, өвчний онош, эмчлэгдэх байдал гээд тодорхой хэмжээнд ялгаатай байгаад байдаг. Эндээс болоод тухайн газрын хүмүүстэй илүү зохидог ч юм уу. Би бол эдгээрийг аягүй чухал ялгаа гэж бодож байна. Төвд улстай хамгийн ойр

гэсэн шүү дээ. Төвөдийн ерөнхий нэг жорууд байгаад байдаг. Ходоодонд ийм, ийм эм уншина гээд ерөнхий нэг жор байгаад байдаг. Тэгэнгүүт тухайн эмч сонгож өгнө л дөө. Дотор нь орж байгаа найрлагуудаас, энэ хүнд, энэ өвчний шинжид энэ эм гэсэн үүднээс сонгож өгдөг. Гэтэл монголчууд дан ургамал, амьтны гаралтай түүхий эд аягүй их хэрэглэдэг. Тэд нар нь эмчилгээний өндөр ач холбогдолтой. Яагаад гэхээр би одоо хөдөө орон нутагт ажиллаж байна. Хөдөө орон нутгийнхан маань байгальтайгаа ойр байдаг учраас хүмүүсийн аман яриагаар “миний тэр өвдөөд, би тийм юм уу” эсвэл “би амьтны гаралтай зүйл хэрэглэчихсэн, зовуурь багассан” гэсэн зүйл их ярьдаг. Тэгэхээр өөрөө өөрсдийгөө эмчлэх эсвэл өвөг дээдэс, аав ээжээс уламжилж ирсэн байдлаа бас хадгалсаар л байгаа. Энэ л ер нь уламжлалаа л авч үлдээд байгаа юм.

**Зу: Одоо энд орж байгаа орц дан ганц Монгол улс тухайн бүс нутагтаа ургадаг ургамал байна уу?**

Цэ: Зөвхөн тийм эм тан бол байна. Зөвхөн халуун оронд ургадаг ургамал ч гэж байна. Тэгэхээр ерөнхийдөө сонголтоор тэр бүс нутагт ажиллаж байгаа хүн бол өөрийн гарын жортой л байх хэрэгтэй гэж би боддог. Яг өөрийн нөөцөөр гэсэн үг байхгүй юу. Аль болох байхгүйг эрэлхийлэх биш, байгаагаа хийж чадах юм бол яг л тухайн бүс нутагт амьдарч байгаа хүндээ тохирно л гэсэн үг.

**Зу: Дорнын анагаах ухаан ч гэдэг юм уу төв Азийн анагаах ухаанд монголчуудын оруулсан хувь нэмэр юу байна?**

Цэ: Олон он цагийн уртад олон шалгуур болон засаг төрийн байдлаас болоод өөрсдийн хүчин зүйлээс биш бусдын эрхшээлд алдагдах, өөрчлөгдөх зүйлс бас байна л даа. Энэ бол Төвөдийн анагаах ухаанд маш их яригдаж байна. Хятад улсын бодлогын дагуу “Анагаах ухааны дөрвөн үндэс” дээр гарч байгаа үг болгоныг үгчлэн орчуулах эрх байхгүй. Төвд улс шашны холбогдолтой үгийг өөрчилж орчуулах эсвэл өөр хасах ч байдаг юм уу. Гэтэл монголчууд өндөр хувь заяатай, бүх юм нээлттэй. Тэрнээс гадна өөрсдөө хадгалж авч үлдэх, дамжуулах гэдэг зүйл байна. Нэг айлын авдрын мухраас эмийн ном гараад ирдэг байхгүй юу. Тэгээд тухайн цаг үеийн нөхцөл байдал хэцүү байсан ч, яаж хадгалж ирсэн нь сонин шүү дээ. Тэгэхээр тэгж их сэтгэл зүрх гаргаад ирсэн анагаах ухаан одоо Монголд ахиад хөгжиж эхэлж байна. Хэдий устах тийшээ хандсан ч өнөөдөр сэргэх үе нь ирээд айл айлаас л юм гарч байгаа. Тэгэхээр сэтгэл зүрх байна гэсэн үг. Одоо боломж нь бас байна.

**Зу: Тэгэхээр та яг сургуулийг нь төгссөн, их эмч хүн. Хүн эмчлэх эрхтэй, Монгол улсад байгаа өвлөн уламжлагчид хүмүүс маань хүн эмчлэх эрх байхгүй. Хүнд үзүүлэх баталгаа, нотолгоо байхгүй. Тэгсэн хэдий ч хүн эмчилдэг. Энэ талаар таны бодол?**

Цэ: Ерөнхийдөө бол жинхэнэ эмч хүнийг тэгдэг шүү дээ. Практик дээрээс эмч болдог. Зарим багш “хатуухан хэлэхэд бараг л хүн алчхаад, эсвэл үхсэн хүн харчхаад эмч болдог шүү” гэж хэлдэг. Бид нар бас мэдэхгүй зүйл байгаа шүү дээ. Миний хувьд ч гэсэн би 2019 онд төгсөөд ирэхэд бидний гол эмчилгээ бол судас байсан. Анх би онолын л мэдлэгтэй байсан бол одоо 3 жил гаран хугацаанд 2000 гаруй хүнд



үйлчилсэн байна. Би 2000 гаруй хүний судас барьж үзсэн гэсэн үг. Ингээд арай өөр ойлголт төрдөг. Тэгэхээр эмчлэх эрхгүй ч гэсэн хүн зорьж очоод байдаг хүмүүс чинь ерөөсөө тийм дан практикаар явсан. Яах вэ онол байсан үгүйг нь би мэдэхгүй, ямар ч байсан багш юм уу зааж өгсөн хүндээ “за ингэдэг шүү”, “ийм шүү” гээд шууд бодит байдал дээр хэлээд өгсөн маш том гарын авлага байхгүй юу. Тийм болохоор тэр хүмүүсийг шүүмжлэх үгүйсгэх тийм зүйл бол байхгүй.

**Зу: Өөр нэг асуулт бол та Энэтхэг улсад сурч байсан. Дээрээс нь Төвөдийн анагаах ухаан сонирхож байсан. Одоо бол Монголын анагаах ухаан гээд явж байгаа. Тийм болохоор Монголчуудын анагаах ухаан эсвэл уламжлалт анагаах ухаан гэж юу вэ? Эсвэл одоо угсаатны гэх үү, ардын ухаан гэх үү?**

Цэ: Энэ бол тухайн цаг үеийн л байдал байгаа. Өнөөдрийн байдлаар уламжлалт анагаах ухаан гэж ярьж дийлэнхдээ ойлгож байгаа. Магадгүй 5 жилийн дараа арай өөр болох ч юм уу эсвэл 10 жилийн өмнө ардын эмнэлэг гэдгээр арай илүү хүмүүст хүрдэг байсан. Би бол нэршлийн хувьд онцгой ач холбогдол өгөхгүй байна. Одоогийн миний мэдэж байгаагаар ямар ч байсан тасрахгүй л улбаа.

**Зу: Тэгвэл Монгол анагаах ухааны суурь нь яг хэзээ бий болсон болон гол лавлагдсан бүтээлүүдээс хэлбэл?**

Цэ: Монголын уламжлалт анагаах ухааны тухай яривал их өргөн сэдэв. Зүгээр миний болоод уламжлалт анагаах ухаан сонирхож байгаа хүмүүст бол би хамгийн нэгдүгээрт энэ уламжлалт анагаах ухааныг төлөөлж чадах хүн бол Манба дацан төвийн тэргүүн Нацагдорж хамба багшийгаа хэлмээр байна. Мөн “Оточ маарамба” их сургуулийн сургалтын талаар би дурдмаар байна. Яагаад гэхээр сэтгэл гаргаж сургадаг. Одоо бол юм хөгжөөд техник технологи тал руугаа байдаг бол миний төгссөн сургууль яг л нөгөө уламжлалт аргаар заадаг. Амаараа шалгалт өгдөг, цээжилдэг, ярьдаг, тэгээд яг л уламжлалт аргаараа байдаг учир багштайгаа их ойр. Тэнд бас нэг дамжлага гэж байгааг нэмээд хэлэхэд бурхны шашин ч тэр, анагаах ухаан ч тэр дамжлага гэж чухал зүйл байна. Тэр нь юу гэхээр багшаас шавьд дамжигдаж ирж байгаа зүйл. Оюун ухаант хүн бол энэ ном сурах бичиг мэдээллийн эрин үед тэр номыг ч юм уу хэлийг сурч болох юм байна. Гэтэл бурхны шашны онцлог байна. Заавал амаар багшаас шавьд хэлж “адис жанлав” гэж ярьдаг, тэр нь шим бүтээл гэж ойлгож болохоор. Тэгэхээр тэр дамжлага бол манай сургуульд яг дамжлага болж явагдаж байдаг.

**Зу: Одоо жишээлбэл судас бариа, хануур, төөнүүр, хатгах ханах арга ч гэдэг юм уу дээрээс нь эм ургамал, мал амьтнаар анагаах, гүрэм дом, засал эдгээрээс аль нь монголчуудын соёлыг төлөөлж болох вэ?**

Цэ: Миний бодлоор хануур засал Монголд их дэлгэрч хүмүүс хэрэглэж байсан. Одоо ч гэсэн хэрэглэдэг. Хүмүүс их рашаан усанд явдаг. Тэрний дараа хануур хийлгэх ёстой гээд бүр яг оюун ухаанд нь суусан байдаг. Тэгээд урин дулаан болоод хүмүүс рашаанд яваад ирсэн ханууль гээд их ирдэг. Тэрийг хүн зааж өгсөн юм байхгүй. Манай аав зааж өгдөг байсан. “Рашаанд явсны дараа хануур хийлгэх ёстой” гэдэг байсан ч юм уу. Тийм байдаг учраас би хануур засал их ойр гэж бодож байна.

Хоёрдугаарт монголчууд хэзээнээс бурхны шашинтай хүмүүс байсан, үүнийг дагаад их гүрэм засал хийлгэдэг байсан. Яагаад ийм байсан гэхээр нөгөө “анагаах ухааны дөрвөн үндэс” номд гүрэм заслаар эдгэх өвчин гээд бүр бүлэг байж байдаг.

**Зу: Гүрэм заслын тухай ярьсных та бас энэ заслыг хийдэг гэж сонссон. Энэ тухайгаа дэлгэрүүлж яривал?**

Цэ: Өвөө болоод ахынхаа тухай ярьсан шүү дээ. Би бол ном үзээд сэтгэл шулуудсан. Энэтхэг улсын Дармасала хотод очоод 9 дүгээр Богд багшийн дэргэд би их хувь ерөөлөөр очоод байж байхад Монголоос зорьж очсон оюутнуудыг тусад нь байлгаад ном заадаг. Ер нь би яагаад тийшээ очих болсон гэхээр нэгдүгээрт, Монгол хүн ер нь Богддоо мөргөө гэсэн тийм бодолтой. Хоёрт миний ах л тэр их бодлыг тээж намайг зорьж явуулсан юм байна. Тэгээд багштайгаа уулзсанаараа би ерөөсөө л ном үзье гэж шийдсэн. Надад бол болгоомжлох зүйл байсан л даа. Нэгдүгээрт би жаахан хүүхэд байсан. Хоёрт бол эмэгтэй хүн ном үзэж болдог тухай ойлголтгүй явж байгаа юм. Тэгээд очиход болно, амьтны тус бүтээхийг зорьсон хэн ч бай эр эм, лам ч бай жод лүйжин гэх ном айлдаад, би анх үзэж эхэлсэн. Жод лүйжин гэх номыг анх үзэхэд багшаас үзэж болох эрх гэж байгаа юм. Тэр эрхийг авдаг. Тэрний дагуу үзэж эхлээд, лүйжингийн номтой танилцсан маань энэ. Би бурхны ном заалгаж эхэлсэн маань, ахаараа заалгасан. Миний “А”-ийн багш гэж хэлдэг тэр хүн бол миний ах. Төвд цагаан толгой бол “Га”-гаар эхэлдэг. Тэгэхээр миний “Га”-гийн багш, миний ах. Жод лүйжинг бол би 9 дүгээр богд багшаас дамжлага хүртсэн. Багш маань намайг очиход нас өндөр болсон байсан. Лүйжингийн номыг үзсэн хүн 108 хоногийн жарз гарын авлага болгож, үзсэн номоо хэрэгжүүлж хээрийн бүтээлд гардаг. Лүйжингийн номын тухай ярихад их өргөн ойлголт. Би лүйжингийн номыг анагаах тал руугаа засал яаж анагаадаг юм гээд холбогдуулаад ярихад, сүүл үед их дэлгэрч байгаа арьсны өвчин, үе мөчний өвчин, одоо бол хөл нь өвдөхөд, эсвэл харшилд хэрэглэдэг. Энэ өвчнүүдийг “анагаах ухааны дөрвөн үндэс”-т өвчний холын шалтгааныг номын яриагаар, “лусын шалтгаантай” гэж үзэж байгаа юм. Тэгэхээр уламжлалт анагаах ухааны онцлог бол энэ шалтгааныг эмчилдэг. Тийм өвчний шалтгааныг эмчилдэг нь гүрэм засал болж байгаа юм. Лүйжингийн жод лүүжин гэж байгаа. Жод гэдэг нь таслах гэж байгаа юм. Лүйжин гэдэг маань “биеийн өглөг” гэж байгаа юм. Монголчуудын ярьдгаар заслын дээд ном лүйжин бол номын дээд ном учир нийтэд доторхыг ярих шаардлагагүй. Гэхдээ тэр заслын дээд гээд байгаа учир бүх л засалд уншиж болох нээ.

**Зу: Энэ тан дээр ирж байгаа хүмүүс, үйлчлүүлэгч нарын өвчний шалтгаан зовуурь юунд байна вэ?**

Цэ: Нэгдүгээрт би энэ дээр онцолж хэлмээр байна. Тосонцэнгэл бол Монголын хүйтэн цэг. Энэ хүйтэн цэгээс шалтгаалсан бөөрний өвчтэй хүмүүс их ирдэг. Хоёрт сэтгэл санааны хямралтай хүмүүс ирдэг. Тийм болохоор энэ дээр гүрэм засал хэрэг болоод явчихна. Дараа нь голын хий, савны хий гэж яриад байдаг. Яах вэ онол дээр бол тэгж авч үзэхгүй. Гэхдээ хийн гүйдлийн хямрал гэж байдаг юм. Энэнээс даамжраад удаад ирэхээр сэтгэцийн өвчин болж эхэлдэг. Сэтгэцийн өвчин бол ардын өвчин эргүүлэгт ороод

ирэхээр хорлог чанар андуудтай нөхөрлөөд бүр хүчээ аваад яваад өгдөг гэсэн үг. Тэгэхлээр ийм тохиолдолд заавал гүрэм засал хийх хэрэгтэй. Ер нь нэмж хэлэхэд уламжлалт анагаах ухаанаар, орчин үеийн анагаах ухаанаар ч эмчилгээ хийж байгаа хүмүүст ном уншуулахад гэмгүй гэж хэлдэг байхгүй юу. Мэдээж би шашин шүтлэгийн тухайд нь асуудаг. Хүн бүр эрх чөлөөтэй болсон үед би бүгдэд тулгаад ном уншуул гэж хэлээд байж болохгүй. Хэрвээ та ном уншуулдаг, шүтлэгтэй бол нэг Ганданд ороод манал уншуулаарай гэдэг. Тэгэхээр аливаа өвчний шалтгаан, адын шалтгаан ер нь л байх гээд байдаг. Тэгээд заслаа хийлгээд өгөхөөр эмчилгээ зохино гэсэн үг.

**Зу: Одоо ихэнх ирж байгаа хүмүүс үйлчлүүлэгч маань европ эмчилгээнд хандаад дараа нь ирж байна уу, өмнө нь ирж байна уу? Манайд нэг ажиглагдсан юм нь явж явж байгаад “за за” гээд бөө эсвэл уламжлалт анагаах дээр ирдэг. Энэ талаар таны ажигласан зүйл юу вэ?**

Цэ: Ер нь бол хөдөө орон нутгийн хувьд ам дамжсан яриагаар их явдаг. Их сайн барьдаг хүн гээд очдог гэдэг шиг яг одоо миний ажиллаж амьдарч байгаа орчин яг тийм. Ер нь бол ихэнхдээ бүх газар очоод дуусгачхаад ирдэг хүмүүс байгаа. Ер нь бол урьдчилан сэргийлэх байдлаар ирж байгаа хүмүүс 10-20 хувьтай л байдаг. Зарим хүмүүс шууд ном уншуулья засал хийлгэе гэсэн сэтгэхүйтэй орж ирж байгаа хүмүүс байна. Тэгэхээр яах вэ хөдөө орон нутгийн хувьд аман яриа л их чухал байгаад байна.

**Зу: Бас нэг зүйл нь мэдээж орчин үеийн анагаах ухаан Монголд хөгжөөд нэлээдгүй хугацаа өнгөрсөн, мөн уламжлалт анагаах ухаан хоёрыг хослуулах тал дээр ямар зүйл дээр хамтарвал дээр вэ?**

Цэ: Ер нь бол европ анагаах ухаан уламжлалтыг үгүйсгэдэг байсан. Сүүл үед гайгүй болсон. Уламжлалтын эмчид очоод нэг үзүүлээч гэсэн тийм юм их болсон. Бид сэтгэцийн өвчин гэж ярьдаг, тэр тал дээр уламжлалттайгаа хавсарч эмчилбэл зүгээр. Тийм хүмүүс их өрөвдмөөр л дөө, өөрийн мэдэлгүй зүгээр ямар нэгэн юманд хөтлөгдөөд явж байдаг. Ядаж тэгэхлээр өвчний шалтгааныг арилгах ном засал уншуулна гээд хэлээд өгдөг байгаасай, аль ч эмч нь. Хий хямраад байдаг, хийг нь засах хэрэгтэй гээд мэдээж сэтгэцийн эмчилгээ байгаа шүү дээ. Унтуулга тайвшруулах гээд тэр эмчилгээг хийг л дээ. Хажуугаас нь тэрийг бас хийх хэрэгтэй. Тэгвэл эдгэх бүрэн боломжтой хүмүүс зөндөө байгаа.

**Зу: Жишээлбэл: Энэтхэг улсад суралцахгүйгээр Улаанбаатар хот ч юм уу, хийдэд шавилан суухгүйгээр өвөө, ааваасаа ч юм уу энэ гүрэм заслыг сурах боломж байгаа юу?**

Цэ: Байлгүй яах вэ, миний хувьд хувь заяагаар таарсан боловч би эндээ байсан бол ялгаагүй бурхны шашин судлаад, ахыгаа дагаад ном үзээд явах л байсан.

**Зу: Одоо хөдөө орон нутгаар яваад зарим хүмүүстэй уулзахаар, “тэр хүмүүс гартаа юмтай, мэдрэмж сайтай” гээд ярьдаг. Тэр хүмүүс бол увдис шиг юм яриад байна л даа. Тэр увдисын хувьд бараг нэг өдөр барьдаг болсон гэх юм уу. Тийм биш хүмүүс анагаах ухааны сургуульд сураад өөрөө сайжруулах боломж байна уу? Гарын мэдрэмжтэй хүн, энгийн хүн хоёрын хооронд ялгаа байна уу?**

Цэ: Ер нь манай сургуульд ч тэр гарын мэдрэмж сайжруулах талаар зааж өгдөг бас мэдрэмжээ илүү сайжруулах, хадгалах, гэмтээхгүй байх тэр талаас нь заавар зөвлөгөө өгдөг. Гэхдээ ер нь бол хүний нэгдүгээрт хүсэл сонирхол. Тэгж байж тэрийг сайжруулах арга замаа олоод явна. Тэгэхгүй бол манай төгсөлтөөс ч тэр зургаан жил сурч төгсөөд мундаг оюутан байсан хүмүүс төгсөөд ажлаа хийдэггүй. Энэ чинь хүсэл сонирхол тийшээ биш байна гэсэн үг. Тэгэхээр өөрийн хүсэл уламжлалтын эмч бол нөгөө гартаа мэдээтэй гэдэг шиг авьяастай л хүн сонгодог байх гэж боддог.

**Зу: Танай нутагт Дагва гуай гэж өвлөн уламжлагч хүн байдаг юм байна. Тэр хүн эмийн ургамал, эм тан хийдэг юм байна. Тэр хүнээс бас таныг эм тан аваад хүнд өгч байсан гэж сонссон. Одоо бол эм тангаа сургуулиасаа эсвэл хотоос аваад бэлдэж байгаа. Тэгвэл тэр Дагва гуайн эм тан, тусгайлан үйлдвэр, сүм хийдээс авч байгаа эмийн хооронд зөрүү бий юу?**

Цэ: Дагва гуайтай би их ойр байдаг. Намайг анх энэ ажлаа эхлээд явж байхад тусалж дэмжиж байсан хүн. Тэгэхээр тэр хүний тангийн онцлог бол олон биш цөөхөн нэр төрлөөр хийдэг. Тэрэндээ гаршсан. Уламжлалтынхан мэднэ, тандаа гаршина гэж байдаг. Тэр хүн бөөрний танг сайн хийхийн тулд хэдэн мянган удаа туршсаныг мэдэхгүй шүү дээ. Өнөөдөр бол хамгийн сайныг гаргаж байна. Тэгэхээр тангийн хэмжээ гэж байгаа. Багаар гаргадаг, харин үйлдвэр бол их хэмжээгээр гаргана шүү дээ. Угаасаа өөрөө их гаргах хүсэлгүй. Тан хийх их хэцүү л дээ. Нарийн хийх, бутлах их байдаг. Тийм болохоор их хийдэггүй байж болох юм. Гэхдээ өөрөө сонирхолгүй. Нөгөө жаахан тусмаа нарийн нандин юм байгаад байна. Эмийн үйлдвэр бол яах вэ “Армон”, “Манба дацан” мөн яг одоо тан хийж эхэлж байгаа өөрийн төгсөлтийн найз нөхдөөс авч хэрэглэж байгаа. Ингээд үзэхээр би аль, аль тан дээр итгэлтэй байдаг. Миний хийдэг зүйл бол дээрээс нь тарни шившдэг. Мамба дацан бол бас тийм. Би өөрөө сурч байсан болохоор ийм үйлдвэрт бид нар дадлагад гардаг. Тэр журмаар л явдаг. Тан боож байгаа хүн бол зүгээр чалчаад яриад суухгүй, байнга тарниа тоолж суудаг. Тэгэхээр зөвхөн эмийн ургамалдаа биш тарнийн хүч байна.

**Зу: Одоо бидний явж байгаа гол асуудал бол ЮНЕСКО-д уламжлалт анагаах ухаанаас бүртгүүлэх. Энэ ажил үйлсэд таны зүгээс монголчууд бид энийгээ соёлын өв гээд бүртгүүлэхэд болохгүй зүйл байхгүй гэсэн зүйл хэлбэл?**

Цэ: Ер нь бол одоо уламжлалт анагаах ухааны бусад улсаас ялгагдах онцлог бас дутуу ярьсан байна. Тэр бол монголчууд маань цогцоор нь авч явдаг юм байна. Хятад бол зүү төөнүүр түлхүү хэрэглэдэг. Төвөдүүд бол “тэтгэх засал” гээд рашаан хэрэглэнэ. Монголчууд бол уламжлалтын эмч бүгдийг хийнэ, зүү тавина, төөнүүр хийнэ, бариа, хануур гээд цогцоор нь авч яваад байна. Монголчууд цогцоор нь авч яваад байгаа нь онцлог юм болов уу?

**Зу: Танд маш их баярлалаа.**

**Идээ ундаагаар анагаах**

**Ми:** Надад нэг асуулт байна. Энэ хүн өвдөж байгаа, эдгэж байгаа, урт богино насалж байгаа дээр идээ ундаа, хоол ундтай холбоотой зүйлд хэрхэн яаж анхаарах ёстой байдаг юм бол. Ер нь идэж ууж байгаа зүйл, өвдөх аль эсвэл сайн сайхан явахад хамааралтай байх уу?

**Цэ:** Хамгийн их хамааралтай, хүний түүх ярьж байгаа байхгүй юу. Анх өвчин гэж байдаггүй байсан юм байна. Тэр үед газар орон их сайхан жимс ногоо ургасан байж. Тэр жимснээс хэн ч идэж уудаггүй байхад нэг нөхөр алимыг идмээр санагдсан байгаа юм. Тэр алимыг идмээр санагдаж байгаа зүйл бол шунал байхгүй юу. Өвчний хорлолын шалтгаан нь уур бухимдал, хүсэл тачаал, мунхаг энэ гурав. Өвчний холын шалтгаан тэр. Тэгээд тэр шунал байгаад тэрийг идсэн. Тэгсэн чинь идээгүйг идсэн гээд өвчин үүсэх шалтгаанууд болж байна. Тэнд нэг нь идэж дадаагүйг идэх гэж байгаа юм. Шинээр нэг юм амсаж идэх бас цаггүй идэх гэж байгаа. “Анагаах ухааны дөрвөн үндэс” дээр шашны маягийн хэллэг их байгаа. Манай уламжлалтын эмч нар их мэдлэгтэй, номынхоо юманд баригдаж ярих гээд байдаг. Тэгсэн өмнө идэж байгаагүй алим идээд, эс шингэх гэдэг ходоодны өвчин хамгийн түрүүнд туссан. Тэгэхээр амаараа хоол оруулах уу, хор оруулах уу гэдэг хувь хүний сонголт. Идээ унд, явдал мөр, эм, засал дөрвөн зүйлээр засдаг. Хамгийн эхлээд идээ ундаа, идэх уух зүйлээр засна, дараа ам тан гээд явчхаж байгаа юм. Хамгийн түрүүнд хоол хүнсээр засаж болно.

**Ми:** Ахиад нэг зүйл тодруулъя. Миний судалж байгаа сэдэв бол идээ ундаа. Хүмүүс ер нь идэж ууж байгаа зүйлээ хэрхэн яаж зохицуулж байна. Дөрвөн улирлын зохилдлогоо хэр байдаг юм бол?

**Цэ:** Одоо миний их айж байгаа зүйл бол турна гэдэг бодолтой ус их уух. Зам сайн болсон. Жимс их ирээд, жимс их авдаг болсон. Жимс ногоог идэх цаг, идэхгүй цаг гэж байна. Жишээ нь хаврын улирал жимс нэг их зохимжтой зүйл биш. Ходоод гэдэс бадгантуулдаг. Дулаарахтай зэрэгцээд л баахан түүхий жимс ногоо идээд, дээрээс нь хүйтэн ус уугаад бөөн хаван болдог. Энэ зам тээвэр хөгжинө гэдэг чинь сул талтай байна. Өмнө бол гурил махаа л иддэг байсан. Гэхдээ хоол олон төрөл байх нь зөв. Уламжлалт анагаах ухаанд хэлдэг нэг гоё зүйл бол юу ч битгий хоригло, чухам яг хэмжээнд нь байлга. Жишээ нь гурван цагаан болох давс, чихэр, өөх байна. Тэр гурвыг ч хорихгүй. Өөх гэхэд л үе хоорондын шингэн, элсэн чихэр гэхэд хүнийг хөөрхөн болгоно гэж байгаа юм. Царай зүсэнд нөлөөлдөг. Хамгийн гол нь хэмжээнд нь хэрэглэх хэрэгтэй.

**Зу:** Мацгийн тухай яривал манайх чинь мацаг гээд л монгол мацагтан гэж нэгдээд л том семинар хийгээд чухам бараг дөч хоног ус уугаад амьдарна юм ярьдаг. Энэ тал дээр эмч хүний хувьд хэлбэл?

**Цэ:** Мацаг бас л улиралтаараа зохицуулах нь чухал, одоо тэр галын илч гэдэг зүйл байна. Галын илч гэдэг бол хүний ходоодны шингээх чадварыг нэрлэж байгаа юм. Галын илч хамгийн сайн бадарч байгаа үед бол юу ч идсэн шингэнэ. Юм идэхгүй байсан ч галын элчээр байж болдог. Тэгэхээр өвөл намрын үед бол мацаг болно. Учиргүй 48 цаг гэдэг

бол хэцүү. Зун хүмүүс халуун л гэж үзэж байгаа байх. Гэтэл зун чинь уламжлалт ухаанд сэрүүн улирал гэж явна. Хавраас зуны улирал шилжих үед андашгүй хүмүүс ядраад ирдэг. Тэр үеийг завсрын үе гэж авч үзнэ. Энэ үе дээр хоол ундыг ер тэгж болохгүй. Эсвэл намар, өвөл тэг л дээ.

**Зу: Өвөл сэрүүн болохоор мацаг барьж болохгүй, зуны дэлгэр цагт ч юм уу турах хүсэл сонирхол улам бадраад л мацгаа бариад эхэлдэг дээ?**

Цэ: Тэр бол сэтгэл санааны байдалтай холбоотой. Зуны улирал ирээд, хуйсгануур болоод ирэхээр хий бас ихэсдэг, тэгэнгүүт тэгмээр санагдаад л. Уг нь тэр үед амт шимтэй зүйл идээд хий дарах хэрэгтэй. Уламжлалт анагаах, зүү төөнүүр бол дан хий дарах шүү дээ. Сэтгэлд ийм зохистой эмчилгээ байхгүй юу. Гэтэл бүр сэтгэлээр унасан, “өө энэ надад эмчилгээ болохгүй дээ” гэсэн эсвэл дөнгөж эмчилгээ эхэлж байхад л “өө сайхан боллоо” гэсэн ийм сэтгэлтэй хүмүүс л тэр гүрэм засал хийлгэх хэрэгтэй байдаг. Одоо хийморь гэж ярьдаг шүү дээ. Хийморь гэдэг бол сэтгэлийн жолоодлого. Тэрийг л өөр юм хөтлөөд явчихдаг байхгүй юу. Тэгээд тэр лусын өвчин их байдаг, яр гардаг. Ялангуяа усархаг суурьтай идээт үрэвсэл гарч байгаа бол холын шалтгаан нь лустай холбоотой юм байна гэж ойлгох хэрэгтэй. Мөн үе мөч байна, нурууны суулт ч бас лустай холбоотой. Манай ах бас яр шарх үлээж эмчилдэг.

**Ми: Манай ээжийн гар нь их зовоогоод байдаг байхгүй юу. Шөнө их янгинаад бид хэд эмнэлгээр яваад тусыг олохгүй л байна. Сүүлдээ бүр ээж маань өвчин намдаах дөрөв хувааж ууж бариад мал саах гэхэд гар нь янгинаад болдоггүй. Энэ одоо яадаг өвчин бэ? Ламд үзүүлэхээр лусын хорлол гээд, бид нутаг явж уул ус тахиад тэгээд засагдсан юм уу мэдэхгүй л байна.**

Цэ: Хүмүүс нэг ном уншаад больдог. Лусын хорлол бол газар гэсэх, газар хөлдөх буюу хавар намар заавал очоод байх шаардлагагүй байгаа газраасаа өргөөд сэтгэлээсээ тууштай байх хэрэгтэй. Хоёрт бол хануур засал дээр. Хүний үе мөчний өвчин ч гэсэн цусаар л дамжиж байгаа. Хануур гэдэг чинь өөрөө маш том засал. Урьдчилаад хүнийг ханаж болох болохгүйг үзнэ. Дараа нь цусыг ялгах тан, сайн цус муу цусыг ялгана. Хүний сайн цуснаас нэг дуслыг ч гаргаж болохгүй. Дараа нь ханах өдрөө сонгоно. Хаа хамаагүй өдөр бас сонгохгүй. Ханахаасаа боолт их чухал гэдэг. Зөв хийгдэж байгаа хануур бол өөрөө гарч байгаад зогсдог. Зүгээр нэг шифриз биш нэг удаагийн хутгаар зүсэж байгаа. Тэр бол хануурын гайхамшиг тэр. Тэгээд л сайн цуснууд хурдан төлжилтөд ороод ирдэг.

**Зу: Зарим нэг уламжлалтад маш их цус аваад байгаа явдал байдаг. Би харсан л даа. Энэ ханах заслыг буруу хийж байна гэсэн үг үү?**

Цэ: Яг тийм хэмжээ бол байхгүй. Тухайн хүнийхээ тамир чухал. Зарим хүн их гардаг.

**Зу: Төвөдөд хануур хийдэг хүн байна уу?**

Цэ: Байхгүй тэгэхээр бас би монголчууд илүү юм болов уу гэж бодоод байна. Одоо хавар намрын улирал ханах улирал гэж байгаа юм. Элэгний судас тухайн улиралтай холбоотой дэлгэрдэг судас гэж байна л даа. Тэгэхээр хавар бол элэгний судас. Би хавартаа элэгний судас ханаад, намартаа бусад судсаа ханадаг ч юм уу гэсэн бодолтой

байдаг. Тэгэхэд хаа байсан 6 сард рашаанд явж ирчхээд хануулья гэдэг. Гэтэл одоо огт ханах шаардлагагүй хүмүүс л “би хануулчихмаар байна” гэхээр нь бага зэргийн цус гаргаад явуулахаар, “өө сайхан боллоо” гээд явдаг хүн байна.

**Ми: Намрын улиралд ямар судас байна?**

Цэ: Хүн чинь одоо яг л мал шиг байдаг байхгүй юу. Намар бүх л тарга тэвээрэг орчихсон, тамир тэнхээтэй. Бүх л судас ханаж болдог байхгүй юу.

**Зу: Тэгэхээр бид ханах засал бол монголчуудынх юм гээд бүх өвлөн уламжлагчдаа бөөгнүүлээд бүртгүүлэх боломжтой юу?**

Цэ: Хануур бол болно гэж бодоод байна. Энэтхэгт хийдэг хүн байж магад. Тэр олон хүнд ямар ч ойлголтгүй гудамжинд хийгээд зогсож байж магадгүй. Төвд бол эм тангаа л барьдаг байх. Дарамсала гээд жижигхэн суурин байгаа. Далай багш шашин, төрийн тэргүүн, хэдэн төрийн өндөрлөгүүдээс аваад Хятадаас гарсан. Төвөдийн сургууль байгаа, засаг захиргааны нэгж нь байгаа. Тэгэнгүүт Хятадад байгаа төвд байна шүү дээ. Лаос гээд манай сургуулиас солилцоо гэх мэт байдаг л байсан. Гэхдээ яах вэ учиргүй оюутан солилцоо байгаагүй. Тэгээд ярьж байхдаа “дөрвөн үндэс”-ийг бүтнээр нь “рашааны үндэс” гэж эхэлдэг байхад шууд “рашаан” гэдэг үгийг хас гээд л Төвөдийн анагаах ухааны багш уйлж байсан гэж байгаа юм. Тэгээд та нар азтай юм гэсэн гэж байгаа юм. Төвд хэл яах вэ ном, бичгийн хэл. Хэл гээд ганцхан үг байлаа гэхэд бичигдэхээр өөр болоод номын хэл рүү өөр шашинтай холбогдохоороо нэг өөр болоод салдаг. Төвд бол шашинтай холбоотой юмнуудаа байхгүй болгож байгаа байхгүй юу. Төвд бол оюутнуудад нээлттэй. Намайг байхад төвөдөд сурч байсан нэг хүн одоо “Монос”-т багшилж байгаа. Би одоо өөрөө эмч болоод бодож байхад, тэр хүн онолдоо илүү сайн байгаа байхгүй юу. Эмчилгээндээ сайн уу гэдгийг сайн мэдэхгүй байна. Тэгэхэд Монгол эмч нар бүх юмаа л авч яваад байна. Манай тэр манба дацан сайн сургалттай, сайн хүмүүс бэлдэж байгаа. Гэхдээ яах вэ манай хамба багшийн дутагдалтай тал байдаг. Би гэж их ярьдаг. “Би л ингэсэн шүү” гээд дандаа ярьдаг гэдэг чинь, би гэж байхгүй, бид гэж байгаа шүү дээ. Хамба багшийн эхнэр Одонцэцэг эмч судас оношилгоо, тарни гэж ярьдаг юм. Бид чинь оюутан байхдаа өдөр болгон тарниа тоолно. Миний давуу тал бол өөр тарни давхар уншдаг. Тэгэнгүүт тарниа тоонд нь хүргэсэн хүмүүст судасны чимээ чихэнд нь номын бурхан ирж өвчний онош шивнэдэг гэж байгаа. Тэгэхээр судас оношилгоо бол өргөн ойлголт, хэзээ ч тийм болох юм. Одоо аппаратаар оношилж байгаа шүү дээ. Үүнийг бол европын эмч нар зүрхэнд өөрчлөлт байна гэдэг. Гэтэл одоо судсаар тэгж хардаг хүмүүс байгаа. Зүрхний зүүн ховхлог чинь одоо бараг дурандаж харахыг хэлнэ. Гэхдээ тийм боломж байдаг юм байна гэж бодож байгаа. Тэгээд одоо бол аягүй хэцүү. Зарим нэг хүнд бол тийм юм байж магадгүй, та бататгаарай гээд эход харуулаад шинжилгээ хийлгээд ирээрэй гэхэд зөрөхгүй байх ганц нэг тохиолдол байгаа юм. Тэгэхээр өөрөө л хянамгай байвал орчин үеийн аппарат шиг оношлох боломж байгаа юм байна гэж хараад байгаа.

**Ми:** Хооллолт дээр ахиад нэг зүйл асууя. Хүмүүс өглөөд ус уух хэрэгтэй гэдэг шүү дээ гэх маягтай зарим нэг хүмүүс ярьдаг. Тэгэхээр сэтгэл дагаад ч юм уу миний бие сонин болоод хийдээд сэрүүдээд эхэлдэг. Эсвэл өглөө ус уухаар тэгэв үү эсвэл арай надад цаг агаар таарахгүй тэгэв үү, тэрэнд ямар учир байна?

**Цэ:** Тийм, ер нь бол усны тухай анагаахын ном дээр ус уух сайн гэж байдаггүй юм. Усыг бол найм ангилдаг. Хамгийн эхэнд бол хурын ус буюу борооны ус тэгээд явсаар байгаад усыг “эмээ даруулж уу” л гэж байдаг. Тэрнээс биш дангаар уугаарай гэж байдаггүй юм. Тэгээд хамгийн сайн ундааг бол бор цай, хярам гээд хэлээд өгсөн. Яахав ус таардаг үндэстэн байдаг байж болно шүү дээ. Монголчууд бол ер нь нэг аяга ус ууж болно шүү дээ. Тэгэхгүй нэг дор 640 мл ус тэгээд сав тавиул уугаад байдаг. Яах вэ эрдэс бодис нөхөх дээр тангууд их нөхдөг. Нарийн судалгаа бол байна. Агуулгын дотор агуулагддаг эрдэс бодис гээд яг тэрүүгээр нөлөөлдөг юм уу, чухам тэр нарийн судалгааг би мэдэхгүй байна. Би бол над дээр ирсэн хүмүүсийг илүү дутуу витамин, эмээ болиод тангаа уучих гэж хэлдэг. Тэгэхэд ер нь бол эрдэс их сайн нөхдөг.

**Зу:** За их баярлалаа.

**Цэ:** За баярлалаа.

**Завхан аймаг, Цагаан-Хайрхан сум, Бариац овогтой Жамъянжавын Цэенцогзол**

**Цэ:**Намайг Жамъянжавын Цэенцогзол гэдэг. 1948 онд Төмөртийн голд төрсөн. Сургуульд сурч байгаад 5 дугаар анги төгсөөд аймаг дээр гарсан. Тэгээд аав, ээжийн хамтаар мал маллаж байгаад тэтгэвэрт гарсан.

**Зу:** Та ерөнхийдөө Завхан аймгийн Цагаан-Хайрхан сумын уугуул хүн үү?

**Цэ:** Уугуул.

**Зу:** Хүүхэд насныхаа тухай надад жаахан ярьж өгвөл?

**Цэ:** Хонь хариулаад л, үнээ мал саагаад л явж байлаа.

**Зу:**Таны ургийн овог?

**Цэ:** Бариац.

**Зу:** Би уламжлалт анагаах ухааны талаар судалж яваа хүн юм. Тэгэхээр “Соёлын өвийн үндэсний төв” дээр соёлын биет бус өвлөн уламжлагч гээд таны нэр байдаг юм байна. Энд бүртгэгдсэн талаараа та мэдэж байгаа юу? Мэддэг бол хэзээ бүртгүүлсэн бэ?

**Цэ:** 2017 онд бүртгүүлсэн.

**Зу:** Ямар байдлаар яаж бүртгүүлсэн бэ?

**Цэ:**Музейн эрхлэгч Дэлгэрмаагаар дамжуулж бүртгүүлсэн.

**Зу:** Та ер нь уламжлалт анагаах ухааны ямар төрөл зүйлийг эзэмшсэн хүн бэ?

**Цэ:** Гар хөл нь хугарсан хүн барьдаг.

**Зу:** Та энэ арга ухааныг хэнээс сурсан бэ?

**Цэ:** Хэнээс ч сураагүй. Өөрөө л тэгээд удмаараа явчихдаг юм байлгүй дээ.

**Зу:** Танай аав, ээж барьдаг хүмүүс байсан уу?

**Цэ:** Миний ээж барьдаг хүн байсан.



**Зу: Таны ээж танд зааж сургасан уу?**

Цэ: Үгүй.

**Зу: Та хэдэн настайгаасаа өөрийгөө яг барьдаг юм байна гэж мэдсэн бэ?**

Цэ: 23, 24 наснаас л.

**Зу: Тэр мэдрэмжийн тухай ярьж өгвөл?**

Цэ: Мэдэхгүй, амьтан хүн үзүүлэх гээд байхаар л үзье гээд үзсэн. Тэрнээс хойш үзүүлж харуулаад болоод байна л гээд байдаг юм. Болдог л юм байлгүй.

**Зу: Тан дээр ихэвчлэн ямар өвчин зовуурьтай хүмүүс ирж байна?**

Цэ: Толгой тархи хөдөлсөн, хөл гар хугарсан, сав суулганы асуудалтай.

**Зу: Та тэгэхээр зөвхөн бариа гэхээс илүү яс барьдаг гэж ойлгож болох уу?**

Цэ: Барьдаг, ясыг бол их барьсан.

**Зу: Залуу байхдаа юу?**

Цэ: Тийм.

**Зу: Одоо та бариа хийж байгаа юу?**

Цэ: Одоо ямар юм хийх вэ дээ.

**Зу: Та сумын эмнэлэгтэй хэр харилцаа, холбоотой байдаг вэ?**

Цэ: Байхгүй, урд малчин доктор гэж л байдаг байсан. Одоо мэдэхгүй.

**Зу: Тэгэхээр уламжлалт анагаах ухааны сургууль болоод хэн нэгэн өвлөн уламжлагч танд зааж сургаагүй гэсэн үг үү?**

Цэ: Тийм. Өөрийнхөөрөө л.

**Зу: Өөрийнхөөрөө гэдэг нь та тэр бүгдийг хийх явцдаа сайжруулаад байсан гэсэн үг үү эсвэл угаасаа л гартаа юмтай байсан уу?**

Цэ: Тийм. Тэгээд мэдрээд л.

**Зу: Таны үр хүүхдүүдэд тань шиг гартаа юмтай, мэдрдэг юмтай хүн байна уу?**

Цэ: Одоо манай тэр охин л барьдаг юм.

**Зу: Охиндоо энэ аргыг өвлөн уламжлуулах ямар нэгэн арга хэмжээ авсан уу?**

Цэ: Үгүй.

**Зу: Яагаад та боддоггүй вэ ? Энэ тэгэхээр цаанаа нэг учир байна уу?**

Цэ: Харин тийм учир байна.

**Зу: Тэгэхээр зааж болдоггүй гэсэн үг үү?**

Цэ: Тийм, өөрийнхөө мэдрэмжээр хийдэг.

**Зу: Та хүн барихдаа хугарсан яс барьдаг онцгой арга технологи байгаа юу?**

Цэ: Байхгүй.

**Зу: Та хэчнээн хүнийг барьсан бэ?**

Цэ: Мэдэхгүй, ёстой хэлж мэдэхгүй байна.

**Зу: Тэр дундаа та өөрөөрөө бахархаад би ийм хүнийг ингэж эдгээж байсан гэсэн түүх яривал?**

Цэ: Цагаанчулуутын нэг самган чааваас мориноос уначхаад хэцүүдээд байсан. Тэгээд дараад л байсан. Тэрнээс хойш манай гадаа буугаад эдгээд, саяхан л өнгөрлөө.

**Зу: Хүүхэд залуучуудын яс хугарах, тархи толгой хөдлөх үед танай нутгийнхан хамгийн түрүүнд эмнэлэг орох уу, тан дээр ирж байна уу?**

Цэ: Над дээр ирдэг юм.

**Зу: Та яагаад тан дээр ирдэг гэж боддог вэ?**

Цэ: Эмнэлэг дээр очоод болдоггүй юм.

**Зу: Тэгэхээр тан дээр ирэх нь илүү хурдан түргэн байна гэж ойлгож болох уу?**

Цэ: Тийм л байх, тан дээр л гээд байдаг юм.

**Зу: Зарим нэг тан дээр үзүүлье, эмчлүүлье гээд ирсэн хүнийг хараад “би энэ өвчнийг эдгээж чадахгүй” гээд буцааж байсан тохиолдол бий юу?**

Цэ: Байхгүй, тэгээд эдгэдэг л байлгүй. Бариад явуулдаг. Тэр чинь хугараад мурийгаад явж чадах уу, байлаа гэдэггүй л юм.

**Зу: Ямар нэгэн гомдол ирсэн удаа байгаа юу?**

Цэ: Байхгүй.

**Зу: Одоо энэ бариа засал гэдэг чинь мэдээж өөрийн хүч хөдөлмөр цаг завьг зарцуулж байгаа учир тэр хүмүүс танд ямар нэгэн үнэ тариф төлдөг үү?**

Цэ: Байхгүй, за сайхан боллоо гээд яваад өгдөг.

**Зу: Та хамгийн сүүлд хэзээ ямар хүн барьсан бэ?**

Цэ: Мэдэхгүй, санахгүй байна. Хэзээ барьсан юм болдоо.

**Зу: Ерөөсөө энэ жил бариа хийгээгүй гэсэн үг үү?**

Цэ: Сүүлийн хэдэн жил бариагүй.

**Зу: Та энийг увдис гэж хэлж болох уу?**

Цэ: Мэдэхгүй тэгээд болох юм уу, болохгүй юм уу хэлж мэдэхгүй юм. Өөрөө өөрийнхөө биеэ мэдэж байхад болдог.

**Зу: Одоо жишээлбэл, нэг хүний тархи толгой хөдөлсөн эсвэл хугарсан яс барьсаны дараа таны биед нөлөөлдөг үү?**

Цэ: Гайгүй, жаахан ядарна тэгээд нөгөө муу хүн маань яаж байгаа бол босоод ирж байгаа болов уу гэж бодоод л.

**Зу: Тэр мэдрэмж буурна гэж байдаг уу?**

Цэ: Байхгүй.

**Зу: Одоо ч гэсэн та хэн нэгний хугарсан хөлийг барихад залуу шиг ээ мэдэрч чадах уу?**

Цэ: Чадахгүй.

**Зу: Тэгэхээр тэр мэдрэмж буурдаг юм биш үү?**

Цэ: Харин тийм. Тэр үедээ буурдаг юм уу яадаг юм.

**Зу: Залуу байхад бол тийм зүйл байдаггүй байсан уу?**

Цэ: Байдаггүй байсан.

**Зу: Та хугарсан ясыг барьчхаад боодог уу? Боох талаар та надад жаахан ярьж өгвөл?**

Цэ: Боодог, доор нь чиг барьж байгаад эвлүүлээд боодог.

**Зу: Тэр зүйлийг та ер нь заалгаагүй юу?**

Цэ: Үгүй.

**Зу: Та ээжийнхээ тухай ярьж өгвөл ?**

Цэ: Миний ээж бас л барьдаг хүн байсан. Тэгээд “миний хүү ингэж байгаарай” гэж надад ер хэлдэггүй байсан.

**Зу: Та ч өөрөө заалгая гэдэггүй байсан уу?**

Цэ: Бодоогүй, ерөөсөө.

**Зу: Нэг өдөр ч юм уу гэнэт л бариа хийдэг болсон гэж ойлгож болох уу?**

Цэ: Одоо болох л юм уу даа, мэдэхгүй. Улсууд чинь би удамтай, угсаатай гээд суулгадаггүй шүү дээ. Тэгээд яах вэ дээ гээд л би үздэг юм.

**Зу: Та ер нь хэд дэх үеийн бариач юм бэ?**

Цэ: Дөрөв.

**Зу: Одоо та өөрийн арга ухааныг хэн нэгэнд өвлөн уламжлуулахгүй бол танай удмын арга ухаан тасрахгүй юу?**

Цэ: Тасрахгүй.

**Зу: Тэрэнд та итгэлтэй байна уу?**

Цэ: Итгэлтэй байна.

**Зу: Яагаад?**

Цэ: Яах вэ дээ, тасрахгүй байх гэж бодоод итгэж л байна.

**Зу: Одоо та өөр шигээ бариа хийгээд явчих байх гэж бодсон үр хүүхэд, ач зээг мэдэрч чадах уу?**

Цэ: Чадна. Манай энэ охин л гэж бодож байна.

**Зу: Одоо танай охин барьж байна уу?**

Цэ: Барьдаг байх аа, надад нуугаад хэлэхгүй шүү дээ. Намайг аашлан гээд.

**Зу: Та яагаад охиноо хүн барихаар аашлан гэж?**

Цэ: Үгүй яах вэ дээ, чадахгүй байж гээд л.

**Зу: Тэгэхээр та бас итгэхгүй байна гэсэн үг үү?**

Цэ: Манай энэ битгий хэл, би ээжээс айдаг байсан.

**Зу: Яагаад гэвэл энэ маань цаашлаад хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой учраас уу? Тэгвэл хэзээнээс яг өөртөө итгэлтэй болж ирдэг вэ? Би яг энэ арга ухааныг эзэмшихсэн юм байна гээд?**

Цэ: Ээдээ ер нь итгэлтэй болдог юм болов уу даа. Би чадах юм болов уу гээд л.

**Зу: Та залуу байхаасаа л өөртөө их итгэлгүй байсан гэсэн үг үү?**

Цэ: Ёстой л, хүмүүс сэтгэл дүүрэн сайхан болчихлоо л гэдэг юм.

**Зу: Гэхдээ тэр хүмүүсийн хэн ч гомдол мэдүүлээгүй бүгд сайхан эдгэсэн гэж байна шүү дээ.**

Цэ: Тийм, зарим нь хөл нь бүр хоёр хугарчихсан л байдаг юм.

**Зу: Тэр чинь одоо бас их хэцүү шүү дээ. Гадуур нь булчин байна шөрмөс байна, тэр ясыг хоёр хугарсныг мэдээд эвлүүлнэ гэдэг маш онцгой чадвар гэж миний хувьд үзэж байгаа. Тийм учраас тэр чадварыг яаж сурдаг вэ гэдэг их сонирхолтой байна?**

Цэ: Тэгээд увдис байдаг юм уу, тийм байна.

**Зу: Тэр гарт байгаа мэдрэмжийг байна гэдгийг анх яг хэзээ мэдсэн бэ?**

Цэ: Өө ёстой мэдэхгүй байна.

**Зу: Хүмүүс таны удам судрыг их мэддэг болоод тэр үү?**

Цэ: Тийм л байх, түрүүгээрээ л, та үзээд хараадах гэдэг.

**Зу: Та судас барьдаг уу?**

Цэ: Судас барихгүй ээ, нэг их барьдаггүй юм.

**Зу: Та түрүүн хэлсэн шүү дээ хугарсан яс байна, толгой хөдөлсөн мөн сав гээд. Савны барианы тухай надад жаахан дэлгэрүүлээд яриад өгөөч?**

Цэ: Тэгж гажаад, ингэж гажаад, хүүхэд гажаад гээд ороод ирдэг юм. Тэгэхээр тэрийг нь боож бариад явуулчихдаг юм. Аа сайхан боллоо гэдэг, үнэн юм уу худлаа юм уу мэдэхгүй.

**Зу: Би бас нэг ийм юм хайж яваа юм аа, монголчуудын уламжлалт анагаах ухааны арга нь яг аль нь юм бэ? Таны бодлоор эрт цагаас хойш өөрсдийгөө яаж эмчилдэг байсан бэ ?**

Цэ: Тэгээд л уудаг барьдаг юм байдаг байлгүй дээ.

**Зу: Та яс барихдаа давхар хажуугаар нь эмийн ургамал ч юм уу, өөр зүйлс хэрэглүүлдэг үү?**

Цэ: Үгүй. Тийм юм уугаарай гэдэг ч үгүй.

**Зу: Та 2017 онд өвлөн уламжлагчид бүртгүүлсэн тэрнээс хойш тан дээр ирэх хүмүүсийн тоо ихэссэн үү?**

Цэ: Үгүй. Нэг их ихсээд байсан зүйл байхгүй.

**Зу: Хол аймаг сумдаас тан дээр ирж хүмүүс бариулж байсан уу?**

Цэ: Бариулж байсан. Алтайгаас хүртэл ирээд бариулж байсан. Ховдоос хүртэл. Би дургүйцэж л байсан. Таныг би мэдээд л ирж байна гэдэг байсан. Би бүр угаасаа дургүйцдэг байсан.

**Зу: Танд болгоомж байдаг юм байна тийм үү?**

Цэ: Би ерөөсөө алив за би гээд тэгдэггүй байсан.

**Зу: Зарим нэг сумын эмнэлэг хугарсан яс эмчлэхгүй бол тан руу л явуулах уу?**

Цэ: Их явуулаад байх нь гайгүй ээ, өөрсдөө л ирнэ үү гэхээс.

**Зу: Одоо хүрээд ирвэл та яах уу?**

Цэ: Үгүй л гэнэ.

**Зу: Та “би чадахгүй ээ, манай охин барьж магадгүй” гэж хэлэхгүй юу?**

Цэ: Чадах юм уу, яах юм тэгээд мэдэхгүй.

**Зу: Та өөрийнхөө байгалиас өгөгдсөн өгөгдлийг хөгжүүлээд, ном судар эсвэл эжий ааваасаа шавь ороод бүр сайн сурья гэсэн бодол байгаагүй юу?**

Цэ: Байсан бол дээр байсан байх. Байгаагүй. Судар ном үзээд “ээжээ ингэдэг юм уу” гээд асууж байгаагүй. Тэгээд манай муу ээж өнгөрсөн.

**Зу: Таны ээж дээр бас олон хүн ирдэг байсан уу?**

Цэ: Олон хүн ирдэг байсан гэсэн.

**Зу: Та бол Цэенцогзол гуайн том охин. Тэгэхээр та бас өөрийгөө надад танилцуулаач?**

**Завхан аймаг Яруу сум өвлөн суралцагч Т. Ууганбаяр**

У: Намайг Түвшин овогтой Ууганбаяр гэдэг. Би том охин нь байгаа юм. 1967 онд Цагаанхайрханд төрсөн.

**Зу: Тэгэхээр Цэенцогзол гуай зарим нэг зүйлийг надад дэлгэрүүлж ярихгүй байх шиг байна. Та бол энэ насандаа ээжийнхээ хажууд байсан учраас ирж байсан хүмүүс, эмчлүүлж байсан хүмүүсийн тухай надад дэлгэрүүлж ярьж өгөх боломж бий юу? Өөрийн харсан үзсэн хүүхэд насны дурсамж, сүүлийн хэдэн жил ч бас ирсэн л байх.**

У: Сүүлийн 2 жилээс ээжийн гарын чадал буурдаг юм уу, ээж бас дургүй байгаа. Ер нь одоо би хүч хүрэхгүй байх гээд татгалздаг болсон. Тэрнээс өмнө бол ирсэн хүн болгон бариулдаг л байсан.

Цэ: Цус нөж нь гоожоод хугараад, яс нь гараад ирсэн хүн барьдаг л байсан.

**Зу: Таны ээж сая бас хэллээ шүү дээ. “Миний том охин гартаа юмтай байж магадгүй” гээд. Та одоо бариа засал хийж байгаа юу?**

У: Үгүй, би нэг их албан ёсны хийгээд байгаа юм бол алга. Яах вэ өөрийнхөө хүүхэд морь малаас унах үед толгойг нь хаа нэг бариад л байдаг юм. Хүмүүс тэгээд өөрсдөө танайх удамтай юм чинь гэдэг. Найз нөхөд ч бай таньж мэддэг хүмүүс тэгж л байдаг юм.

**Зу: Та тэрийг цаашид хөгжүүлье гэж боддог уу?**

У: Одоо тэгээд удам залгаад байх байлгүй л гэж бодож байна.

**Зу: Та яс барих уу ?**

У: Би ясыг дангаараа барихгүй хамгийн сүүлд ээжтэйгээ хүүхэд машины өндөрлөгөөнд гараа хугалсан байхад барьж байсан.

**Зу: Та ер нь ээжээсээ энэ арга ухааныг өвлөж авъя цаашаа уламжилъя гэж боддог уу?**

У: Бодно, ийм удамтай юм бол надад гарын мэдрэмж байвал аваад явах юм сан гэж бодож л байдаг юм.

**Зу: Зарим нэг хүн хэлдэг шүү дээ манай гэр бол сумын эмнэлэг шиг байдаг гэдэг ч юм уу. Энэ үед жаахан төвөгшөөх ч юм уу, эсвэл хүндрэлтэй талууд байдаг уу?**

У: Манай аавынд бол хүн бараг өвөлждөг байсан. Хүн ерөөсөө тасардаггүй байсан. Гэхдээ манай аав ээж хоёр “хүн ирлээ, тэглээ” гэж эсэргүүцэж байгаагүй ээ. Зарим нэг нь машинаасаа бууж чадахгүй, хөл гар нь хугарсан хүнийг машинд ч гэсэн хөл гарыг нь манай ээж боож өгөөд явуулж л байсан.

**Зу: Бид нар болохоор ЮНЕСКО буюу дэлхийн соёлын өвд монголчуудын гэх соёлын өвийг бүртгүүлэх гэж байгаа. Тийм учраас монголчуудын уламжлалт анагаах ухаан маань бариа засал юм аа гээд бүртгүүлбэл энэ тал дээр Цэенцогзол гуайн болон таны бодол юу байгаа бол би сонсохыг хүсэж байна?**

Цэ: Хэн мэдэх үү.

**Зу: Монголчуудаас өөр бариа засал хийдэг улс орон ховор шүү дээ. Тийм учраас энэ бариа нь монголчуудын ганц өв юм гээд бүртгүүлэх боломж байгаа болов уу?**

Цэ: Байх байлгүй дээ.

**Зу:** Би одоо таныг өвлөн уламжлагч гэхээр ээжээсээ маш олон зүйл сурсан гэж найдаж байна. Ардын эмнэлэг эм, дом шившлэгийн тухай болон яс хугарсан хүнийг бариад ч юм уу дом шившлэг хийж байсан уу, тийм юм байдаг уу?

Цэ: Тийм юм байхгүй.

**Зу:** Барихад хамгийн хүндрэлтэй яс юм уу бэртэл юу байдаг вэ?

Цэ: Үе дагаж ойрхон хугарсан юм л хэцүү байдаг юм. Тэгээд энэ булчинтай газар.

**Зу:** Тархи толгой доргих бол маш түгээмэл байдаг. Та ивдэг үү, барьдаг уу, баздаг юм уу? Зарим нэг нь бүр цохидог гэх юм. Олон зүйлийн арга байх шиг байна. Тархи хөдөлсөн хүнийг ер нь яаж мэдэх вэ?

Цэ: Бариад л үзнэ, хөдөлсөн байна аа гээд л боож өгнө.

**Зу:** Тэрийг харин би бол мэдэхгүй шүү дээ. Хүний тархи хөдөлсөн байна, хөдлөөгүй байна гэдгийг. Тийм учраас танаас, гартай юмтай гэдэг юм уу эсвэл цаанаасаа өгөгдөлгүй хүн тэрийг гаднаас нь хараад мэдэх боломжгүй гэсэн үг үү?

Цэ: Боломжгүй.

**Зу:** Та ер нь бол охиноо бариа засал хийж байвал аашлан гэж байсан шүү дээ. Хүний амь настай холбоотой учраас уу?

У: Манай хөгшин бид хоёр, манай аав бас ярьж байсан юм. Удам гэдэг бол өмнөх нь заавал дуусаж байж дараагийн удам залгах ёстой. Тиймдээ бас нэг нууж бариад ээж бас за чи нэг тэгэх гээд яах вэ гэдэг.

**Зу:** Та жишээлбэл, энэ увдисыг өөртөө байгаа гэдэгт итгэж байна уу?

У: Нэг их тэгж учиргүй өөртөө бардаагүй, гэхдээ яах вэ хөл гар нь өвдлөө гэвэл учиргүй хугарч бариагүй хүн над дээр ирж л байсан л даа. Зарим нэг нь тоглоом наадам хийгээд үзээдэх гэж д байсан. Гэхдээ би баараагүй гэж барддаггүй.

**Зу:** Таны сум орон нутагт танаас өөр барьдаг хүн байсан уу?

Цэ: Мэдэхгүй. Удам угсаа байдаг байх өө хүү минь.

**Зу:** Одоо сүүл үед энэ ардын уламжлалт анагаах ухааны маш олон сургууль байна тийм ээ. Бариа заслын олон курсүүд байдаг. Энд хүн сураад хүмүүсийг бариад байгаа шүү дээ энэ талаар та юу гэж бодож байгаа вэ?

Цэ: Болдог л юм байлгүй гэж боддог юм. Өөрт байгаад болдог юм байлгүй.

**Зу:** Та мал маллаж байсан уу ?

Цэ: Маллаж байсан. Насаараа малласан.

**Зу:** Мал маллах арга ухаан одоо хэр өөрчлөгдөж байгаа вэ?

Цэ: Өөрчлөгдөж байна, мань мэтийг мал маллаж байсныг бодоход сайхан байна.

**Зу:** Та хэдэн нас хүртлээ мал малласан бэ?

Цэ: 60-н хэд хүртлээ.

**Зу:** Та бас мал дээр байна уу?

У: Тийм.

**Зу:** Мал маллахад тулгамдаж байгаа асуудал байна уу?

У:Тулгамдсан асуудал байна. Одоо энэ ихэнх хөрс үнэгүйдэж байна, юмны үнэ нэмэгдэж байна, мануус одоо аав ээж дээрээ байгаа хүүхдүүд бол яах вэ.Гэхдээ залуучууд амьдрахад

их хэцүү болж байна. Хүүхдээ өсгөхөд янз бүрээр дутагдаж байна, мал ахуй нь үнэд орж зарагдаж борлогдохгүй байна. Тиймдээ хөдөө залуу малчид их ховордож байна. Тэгээд бас энэ залуучуудын амьдрах орчинд төр засгаас туслалцаа, дэмжлэгээ тиймэрхүү зүйл байвал нутагтаа малаа маллах залуучууд бас байна л даа.

**Зу: Энэ уламжлалт мал аж ахуй одоо байна уу?**

У: Яг дээр үеийнх шиг бол байж чадахгүй байна, айл болгон машинтай нүүдэг болсон. Дээр үед чинь айлууд хөсгөөр нүүдэг байсан, одоо бараг малаа хүртэл дандаа техник технологиор нүүнэ.

**Зу: Одоо энэ уламжлалт нүүдлийн соёлыг авч үлдэхийн тулд бид яах ёстой вэ?**

У: Одоо ер нь малтайгаа зөв харьцаад малчин хүн ямар байх ёстой тэр болгоныгоо зөв боловсон авч явбал зүгээр юм уу л гэж бодож байна.

**Зу: Одоо энэ нүүдлийн соёл уламжлалыг хамгаалах хэрэгтэй гээд ярьдаг, бид хэнээс яаж хамгаалах ёстой юм бэ? Энэ нутаг усыг хамгаалахад хүндрэлтэй тал байгаа юу?**

У: Хүндрэлтэй тал байгаа. Одоо энэ бэлчээр усыг энэ дээдчүүл чинь аваад л, зарим нэг газрыг хагалаад л, тэрнээс хамгаалах учир зүйгээ малчид олохгүй байна. Явал бид нар энэ нутаг усаа авч үлдэх үү, явал хагалуулахгүй хөндүүлэхгүй байх вэ гэдэг учраа бас хүмүүс мэдэхгүй байна. Засаг гэхэд л дээшээ засаг захиргаандаа хэлнэ, малчид цаашаагаа хэндээ хэлэхээ мэдэхгүй шүү дээ. Тэгэхээр засаг захиргаа тэрийг хүлээж аваад “яг тэр тэгэх ёстой”, “малчид ингэмээр байна аа” гээд засаг захиргаа мануусыг төлөөлсөн хүн бол байхгүй байна шүү дээ. Тийм болохоор нэг удаа, хоёр удаа хэллээ малчид өөр яах юм, тийм л болчхоод байна.

**Зу: Одоо хүүхэд залуучууд сургууль соёл яваад эргэж ирэхгүй байна. Залуучууд бага болсон байна гэж ярьж байна, тийм үү ?**

У: Тийм.

**Зу: Танай нутагт өөр нутаг орны малчид ирж маргаан үүсдэг үү?**

У: Зөндөө шүү дээ. Ойрын сумдын малчид бол зөндөө ирнэ.

**Зу: Тэгээд тэнд бас бэлчээрийн асуудал гарах уу?**

У: Өө, гаралгүй яах вэ.

**Зу: Танай нутаг орноос цаг уур өөр болж байгаа үед, өөр нутаг руу шилжиж байгаа малчид байна уу?**

У: Байгаа ер нь голдуу төв рүү л явчхаад байна.

**Зу: Ерөнхийдөө хүмүүс мал маллахад тулгамдаж байгаа асуудал бол цаг уур бэлчээр гэж ойлгож болох уу?**

У: Болно.

**Зу: Залуучуудыг явал цаашдаа мал маллахад түлхэц болох бол?**

У: Залуучууд сум дээр ирээд ажиллахад залуучуудын хангамж их муу байна. Боловсролтой болох гээд залуучууд төв яваад байна. Манай сумын тухайд бол тийм байна. Өөр сумд янз бүрийн бэрхшээл байдаг байх. Тийм болохоор залуучууд суманд ирээд ажиллах сонирхол их муутай байна. Тэгээд ерөнхийдөө намын барьцаанд орчихсон.

**Зу: Нам бас байна уу?**

У: Байна, нэг залуу хүрээд ирнэ. Тэгэнгүүт нь тэр намынх гээд бараг л барьж аваад харьцахгүй, тийм зүйл зөндөө шүү дээ. Тэгээд тэр хүүхдүүдийн боловсролын асуудал маш хүнд. Сургуульд байрлах бололцоотой дотуур байр байна гэхдээ сургалт нь муу.

**Зу: Та сая ярилаа шүү дээ, хүн хоорондын харилцаа гээд. Хүмүүсийн хоорондын харилцаанд юу нөлөөлж байна вэ?**

У: Нам шууд нөлөөлж байна. Одоо жишээ нь авгай нөхөр хоёр байлаа гэхэд сонгууль болоод хоорондоо харьцахгүй юм болоод байна шүү. Тэгээд л энэ гайгүй багш юм гэхэд л намынхаа юмаар хална гээд л дайраад байна. Өөрийгөө хүрээлсэн ах дүү, намын улсуудын наймаалцаан бол энд маш их байна.

**Зу: Тэрнээс гадна хүүхэд залуучууд хөгшидтэй харьцах харьцаанд ямар өөрчлөлт байна?**

У: Өөрчлөлтүүд байна. Одоо энэ залуучууд бүр настай хүнийг хүндлэхээ байсан шүү дээ. Миний үед настай хүн, багш, гудмаар явж байгаа хөгшин хүнийг хүртэл хүндлээд зам ч болтугай, сандал ч болтугай тавиад өгдөг байсан. Одоо бол хүний эрх гээд л хүүхдүүдэд юм хэлэх эрхгүй болсон. Жишээ нь манай энэ өвгөн явж байхад хажуугаар нь нэг хүүхэд мод чулуугаар цохиод хаяхад “чи намайг цохилоо” гэж хэлэх хүртэл эрхгүй болоод байна шүү дээ. Тийм болчихоод байна. Дээр бол чи хөгшин хүнийг хүндлэхгүй яасан юм гэж хүүхдээ загнадаг байсан, одоо бол тэгэхгүй. Өө чи хүүхэд загнасан байна, хүүхдийн эрх хөндсөн байна гээд л.

**Зу: Энэ хэзээнээс ийм болчхов оо?**

У: Өө тэгээд тэр хууль журам нь гараад тийм болсон юм байлгүй дээ. Хүүхдийн эрхийг л их барьдаг юм шиг байна. Хүний эрхийг хөнддөг бол хүн бүр л эрхээ хамгаалмаар байна шүү дээ. Манай сум орон нутагт бол хүний эрхийг хамгаалж байгаа юм бол алга. Үнэндээ хүн чөлөөтэй эрхээ хамгаалж чадахгүй л байна.

**Зу: Мэдээж сонгуулийн үед хүмүүс хоёр тийшээ болдог л байх, хэзээд нь нэгдэн нийлж байна вэ?**

У: Ерөнхийдөө нэгдэхгүй дээ. Одоо тэр нам гарсан. Жишээ нь: Ардчилсан нам гарсан, манайх ардын намдаа энэ намын хүнийг авахгүй гээд л, ерөнхийдөө тийм байна. Намынхаа хүнийг ажилд авна гэх жишээтэй. “Сайн боловсон хүчин, нам хамаагүй ээ” гээд ажилд авдаг хүн бараг байхгүй байна.

**Зу: Улс төрийн болоод намын эрх ашгийн дор ард иргэд хохирч байна шүү дээ. Ялангуяа хүүхдийн боловсролоор тийм үү?**

У: Тийм, тэр бол ёстой үнэн. Одоо энэ манай Цагаанхайрхан сум дээр үед улсын тэргүүний сургууль болж байсан. Энэ жил овоо төрөлтөөрөө ч юм уу хорин хүүхэд байх шиг байна. Тэгээд л ер нь гурав, дөрөв, тав зургаан хүүхэдтэй. Тэгээд тийм хүүхдүүдтэй энэ багш нар хүрэлцэж ажиллаж чадахгүй байна гэж байхгүй шүү дээ. Дээхэн үед бол хоёр, гурван бүлэг байлаа. Тэгэхэд тийм цөөхөн хүүхдэд яагаад харьцаж чадахгүй байна. Өдрийн хоёр, гурав хүүхэд дээрээ явж очоод харьцчих тэр хугацаатай л байна. Тэгэхэд дээр үед багш нар тэр олон хүүхдэд бүгдтэй нь харьцаад, дэвтэр номоо засаад л хичээл



заадаг байлаа. Тэгэхэд одоо манай сумын сургалт маш муу. Сая сумын сургуулийн захирал болох ажиллагаа маш их яригдлаа шүү дээ. Тэгээд л одоо намын шугамаар сандал суудлаар намайлцъя болоод л, заавал найз нөхдөө урих ёстой гээд л, түмэн юм болсоор байгаад л захирал нь солигдлоо.

**Зу: Одоо танай сумд уул уурхай байна уу? Хайгуулын лиценз зэрэг тийм юм байна уу?**

У: Ер нь лицензтэй юм байна лээ гээд тэгж байгаа юм бол байна. Гэхдээ учиргүй ирээд ухаад байсан юм бол алга л байна.

**Зу: Ирээд ухвал асуудал үүсэх үү?**

У: Тэгээд нутаг орныхоо төлөө тэмцэх л байлгүй дээ.

**Зу: Уул уурхай ирвэл хүнд машин, газар ус гээд л.**

У: Тийм шүү дээ. Бэлчээр уснаас эхлээд л хэцүү шүү дээ.

**Зу: Тэгэхээр бид нар энэ бэлчээр ус, мал аж ахуйг уул уурхайгаас хамгаалах юм уу?**

У: Уул уурхайгаас хамгаалах бол бүр нэгдүгээр зэрэгт.

**Зу: Нутаг орны ан амьтад танай нутагт их үү?**

У: Их байлгүй яах вэ, зөндөө.

**Зу: Хулгайн ан гэдэг юм уу эсвэл танай нутгийг их сайхан арцтай гэж сонслоо энд маш ихээр түүх тийм зүйл байна уу?**

У: Байна. Би энэ жил багийн хурлын даргаар сонгогдсон юм. Тэгээд би дотор нь ороод ярьж хөөрөх юм их л бодогдож байлаа. Тэгээд хурлын даргын орон тоог ерөнхийд нь цомхотгосон байгаа. Гэхдээ би бол хурал дээр хэлэх юмаа хэлдэг. Энэ арцны хулгай бол их байдаг, маш их. Хавар, намар гээд жаахан айл хөндийрөөд нүүгээд ирмэгц энд бүгд л ирээд ухна. Чухам энэ дээр ямар арга хэмжээ авдаг юм, үзсэн харсан, арц түүгээд байгаа тэдэн машин гээд ярьж л байдаг юм. Чухам энэ дээр арга хэмжээ авдаг юм уу, тохирчихдог юм уу бүү мэд.

**Зу: Энэ арцыг авах бас хугацаа цаг нар гэж байдаг юм уу, их хэмжээгээр аваад явбал дахиж ургахгүй гэсэн асуудал байх уу?**

У: Тийм шүү дээ. Ерөнхийдөө дээд талыг нь тайраад аваад явсан газрууд бол ургахгүй болсон байна. Манай энэ ард тал руу зөндөө байна. Тэр чинь их хэмжээгээр авч байна. Урд жил манай нэг найз хотоос ирээд бид нар доошоогоо газар үзэх гээд явлаа. Тэгээд явахад л нэг машин 17, 18 шуудай тавьсан авч байна. Тэгээд бид нар шаардлага тавьсан. Өө, ёстой ингээд явлаа бид нар ахиад ингэхгүй л гэсэн. Би зураг хөргийг нь аваад, “ийм хүмүүс явж байна” гээд цагдаа, засаг дарга нарт хэлсэн. Тэгээд ямар арга хэмжээ авсан юм гэхээр “өө тэгээд торгосон л” гэдэг юм байна лээ.

**Зу: Одоо жишээлбэл: Танай нутаг орон нутагт зарим нэг газрыг хамгаалалтад авъя гэвэл аль газрыг хамгаалуулах вэ?**

У: Ан амьтнаа авах хэрэгтэй. Арц, модоо авах хэрэгтэй. Хэрэв одоо модоо аваад байвал усны ундарга муудна.

**Зу: Бид яг энэ уламжлалт анагаах ухаан судлахаас гадна нүүдлийн соёлд тулгамдаж байгаа асуудал, мал аж ахуй эрхэлж байгаа малчдынхаа санал сэтгэгдлийг сонсоод энийг цааш нь хүргэх ажлаар яваа. Одоогоор энэ тулгамдаж байгаа асуудал, гэхээр**

**зөвхөн бэлчээр мал биш хүний асуудал. Жишээ нь таны ярьдаг нам хоорондын асуудал байна, хүүхдийн эрхийн асуудал байна. Мөн энэ арц ховорддогийг бол яагаад улсаас ирээд хамгаалж болохгүй гэж?**

У: Тийм, түүдэг нэг хугацаатай. Тийм үед нь хүн амьтанд хоол, цалинг нь өгөөд болж л байгаа шүү дээ. Сум орон нутаг тэрийгээ хамгаалж чадахгүй байна.

**Зу: Сум орон нутаг өөрөө дотроо түүгээд эндээсээ нийлүүлээд санхүү төсвөө бүрдүүлдэг юм уу тэ?**

У: Тэгээд яах вэ, учиргүй их авагдаад байна гэвэл пост гаргаад суулгачихдаг тийм ээ, цалин хөлс өгөөд хамгаалчхаж бас болно шүү дээ.

**Зу: Одоо энэ мал маллахад их тохиромжтой байна уу?**

У: Үгүй яах вэ бүх өмч хувьд очсон болохоор улсын юм гээд зүтгээд байхгүй, өөрийн юм чинь нэг, хоёр мал үхсэн ч гэсэн за яах вэ өөрийн юм гээд ерөнхийдөө тийм болчхоод байна шүү дээ.

**Зу: Гэхдээ хүмүүс ярьж байна л даа. Хувьд очсон болохоор хонь саахгүй байна, цагаан идээ маань хэцүү боллоо гэж байна. Танай нутаг сумын хувьд тэр асуудал хэр байна?**

У: Өө, байна яг л адилхан. Одоо энэ сайхан сургууль төгсөөд ирсэн хүүхдүүд аав ээж дээрээ байя гэхээр гарсан намын хүн биш бол аймагт ажиллаж чадахгүй ажилгүй, болно. Тэгээд хэн ингээд байхыг хүсэх вэ, ажилтай газар луу явна шүү дээ.

**Зу: Гэхдээ танайх бас аймагтайгаа ойрхон байна. Тэгэхээр зарим нэгэн зүйл нөлөөлж байна уу?**

У: Нөлөөлнө, одоо яах вэ дээ хөөрхий амьтад хүүхдүүдээ боловсролоор дутаачихгүй, гайгүй сургачих юм сан гээд эцэг хүн хүүхдээ аймагт өгч байна. Авгай нь аймагт очоод эхнэр нөхөр тус тусдаа сууж байгаа байхгүй юу. Хөдөө нөхөр нь ганцаараа мал маллаад тэрнээсээ болоод өвчин болж байна. Хонь малдаа явж ирээд хоол ундаа хийх, хийхгүй хүйтэн нойтон хоол идсэнээсээ болоод өвчтэй болж байна. Хэрвээ сум тийм найдвартай байх юм бол хүүхдээ байранд өгчихнө. Хагас бүтэн сайн ойрхон давхиад хүрээд ирнэ. Хүүхдээ санах ажил байхгүй. Нөгөө эхнэр нөхөр хоёр чинь хоёулаа ажлаа хийгээд яваад байна шүү дээ.

Цэ: Аймаг дээр сурсан хүүхэд илүү сурлага сайтай болно тийм учраас би хүүхдээ аймаг дээр сургасан. Манай сум бол аймгийн хүүхдүүдээс хоцорчихно, үнэндээ л бас муу.

**Зу: Дээрээс нь мал чанар муу байна тийм ээ?**

У: Тийм, хэрэв энэ мал аж ахуй дээр үеийн нүүдлийн уламжлалаараа байсан бол бид нарын эрүүл мэнд, наслалтад маш их хэрэгтэй байсан юм. Одоо айлын авгай үхэр тэргээ хөтлөөд алхдаг байсан бол машиндаа суугаад яваад өгч байна. Тийм юм дээрээс таргалалт хүртэл их болж байна.

Цэ: Араг үүрээд, аргал түүдэг чинь бас их учиртай байсан юм байна. Одоо тэр насны хүмүүс чинь их насалж байгаа. Бид нар шиг хүмүүс бол тэгж наслах уу үгүй юу. Ааруул гэдэг чинь хүүхдийн бэхжилтэд их хэрэгтэй байсан юм байна. Бид бол зун мах

иддэггүй байсан шүү дээ. Дандаа цагаан идээ, ээзгий, өрөм. Ерөөсөө тийм л хоол иддэг байсан шүү дээ. Тийм учраас өвчин гээч юм их бага байсан.

**Зу: Одоо Монгол хүний онцлогийг гаргаж ирвэл, их олон онцлог байна шүү дээ. Энэ зүйлс одоо өөрчлөгдөж байна уу?**

У: Одоо энэ малаа саахгүй байна. Цагаан идээ асар үнэтэй болсон тул авч хэрэглэж чадахгүй байна шүү дээ.

**Зу: Уг нь өөрсдөө хийдгээрээ хийгээд байж болно шүү дээ.**

У: Одоо хүүхдээ морь мал дээр мордуулдаг айл алга. Одоо манай аав ээж хоёр бол хоёрхон эмэгтэй хүүхэдтэй морь унуулж сургах банди байхгүй. Манай аав миний хүү морд гээд би мордоод л эмнэгээ сургаад л, ялгаагүй энэ айл унаа морьтой байдаг байсан бол манайх тийм л байсан. Өөрсдөө хүүхдээ морь унуулахгүй, тэгсэн хэр нь айлын хүүхдийг морь унуулах гээд. Хүний хүүхдийг тэгж болохгүй шүү дээ. Бүх хүүхдийг ялгаа байхгүй дасгалжуулаад л, Монгол ёсондоо эмэгтэйгээрээ үнээ мал саалгадаг эрэгтэйгээр нь унуулдаг байх хэрэгтэй байхгүй юу.

**Зу: Тэгэхээр энэ чинь одоо манай нүүдлийн соёл иргэншилд асуудалтай л зүйл юм. Нүүж суухад хол ойр зай хэр өөрчлөгдөв?**

У: Манайх бол хол шүү дээ. Сумаасаа доошоо яваад говь руу 40 гаран км явж өвөлжөөндөө гарч байна. Хамгийн цаад талдаа бол бүр 50 км хол нүүнэ шүү дээ. Сайхан нүүдэлтэй. Айл болгон чинь одоо 2, 3 машинтай. Нэг машинаараа хонь малаа дагаад яваад байна. Мориор хариулдаг хүн алга. Уг нь малаа малаараа хариулдаг байсан бол.

**Зу: Харин тийм, адууг адуулахгүй байна, эдлэхгүй байна гэдэг чинь дагаад соёлууд нь алга болоод байна.**

Цэ: Адуулахаас гадна одоо суртай айл бүр алга, дандаа эрмээн. Тэр болгон чинь бүгд хаягдаж байна. Эрт үед чинь идшинд хадгалсан үхрийн ширээр сур хийдэг байсан. Одоо бол дэрийгтэл хаяж байна шүү дээ.

**Зу: Хүмүүсийн хоорондын харилцаа ихээхэн өөрчлөгдсөн гэж бид харж байгаа.**

У: Хүмүүсийн хоорондын харилцаанд намаас үүссэн хүн хоорондын харилцаа маш их байна. Одоо би таньдаг хүнтэйгээ таараад, бараг ярьж чадахгүй шүү дээ. Энэ чинь тэр нам, энэ нам гээд. Багын найзууд битгий хэл төрсөн ах, дүү хоорондоо харьцахгүй байна.

**Зу: Одоо тэгэхээр хүүхдүүдийн сэтгэлгээ их өөр болсон. Тэр хүүхдүүдийн харилцаан дээр асуудал байна уу?**

У: Байлгүй яах вэ, аав ээж нь нам байна гэдэг чинь тэр хүүхдийн үзэл бодол өөр болоод явчхаж байна шүү дээ. Гэхдээ тэр хүүхдүүд чинь хэцүү. Хүмүүсийг бараадаж “ахаа, эгчээ” гэж байгаад ажилд орохоо бодно.

**Зу: Хүн малаа саахгүй байна тэгэхээр хүн мал хоорондын харилцаа их холдсон байх.**

У: Холдолгүй яах вэ айлаас нэг хонь авах гээд очиход л хүнд баригдахгүй, адуу шиг болчихсон. Адуу уургалдаг байсан бол хонь уургалдаг болсон байна. Тэрнээс хонь малаа саадаг байхад юу гэж тийм байх вэ.

**Зу: Хүн байгалийн харилцаа бас их өөрчлөгдөж байна.**

У: Тийм, өвсөө идэж байхад нь ганц мотоцикл яваад л цочооно. Тэр мал уг нь байгальтайгаа харьцаж байна шүү дээ.

**Зу: Тэгвэл энэ нүүдэлчин Монголчуудын үнэт зүйл нь юу вэ?**

У: Ер нь тэгээд малгүй бол дуусаа шүү дээ. Манайх чинь нүүдэлчдийн соёлтой ард түмэн, мал аж ахуйгаа устгавал тэгээд л болохгүй.

**Зу: Мал аж ахуй бол бидний үнэт зүйл үү?**

У: Тийм, ёстой үнэт зүйл. Энэ дээр л монголчууд ганц гар дээр зогсож байгаа зүйл шүү дээ. Манай энэ алслагдсан нутаг чинь ийм юмаа ярьж чадахгүй. Зарим нэг хотод дээлтэй лайв хийж байгаа хүмүүсийг хараад манай сумдаар хүрээд ирээсэй. Сургууль дотор нэг лайв хийгээсэй гээд тэгж л байлаа. Тэгээд энэ хөдөө газар ирээд, дарга нартай л уулзаад явна. Тэр цаана ажиллаж байгаа ажилчин юу бодож байгаа бол ямар юм хийх гэж сэтгэж суугаа, тэр ерөөсөө асуудал байхгүй. Тийм болсон.

**Зу: Тэгэхээр яах вэ мал аж ахуй, нүүдэлчдийн тухай ярихад угаасаа сумын засаг дарга мэдээж мал дээр байхгүй. Малчин хүн байсан байж болж байгаа юм. Тэгэхээр мал дээр байгаа малынхаа хотонд байгаа хүмүүстэй уулзаад явахад илүү үр дүнтэй биз?**

У: Засаг дарга хөдөө малчдаар нэг жилд хоёр удаа албан шахалтаар явж байх шиг байна. Малчин өрөөнд нь ороод юм ярина, тэр хүнд ерөөсөө хөдөөгийн мэдэгдэхүүн байхгүй, юу яриад байгаа юм бол гээд бүр хүлээж авах ч үгүй. Уг нь бидний гүүр болж явах чинь сумын засаг захиргаа байх ёстой доо. Тэгэхээр ерөөсөө хүлээж авахгүй байна. Тэгэхээр тэр хүн тэрэнд хариулах толгойных нь потенциал хүрэхгүй байна уу эсвэл ард иргэдээ үгүйсгэж үзээд байна уу, тийм тохиолдол байна.

**Зу: Уг нь тэр хүн сум орон нутгийн төлөөлөл дуу хоолойг өөр газар хүргэж байх ёстой хүн биз дээ?**

У: Тэгэхэд чинь тэр хүн хүлээж авахгүй байж цаашаа юу ярьж явдаг юм бол доо. Өөрийнхөө бодлыг ярьдаг юм байгаа биз.

Цэ: Ерөөсөө өөрсдөө л сандал суудал дээр суух, авгай хүүхдээ суулгах, тэрний төлөө л ажиллаж байна. Бас боловсролгүй, боловсролтой хүн бас байх ёстой юм байна. Тэгэхээр энэ дээр бас бодлого хэрэгтэй байгаа байхгүй юу.

**Зу: Тэгэхээр нэг эрүүл систем хэрэгтэй байна, тийм үү?**

У: Харин тийм. Тэр бол ёстой хэрэгтэй байна. Үнэн ялзарч байна. Одоо тэгэхээр надад ч гэсэн ганцаараа байгаа хүнд хэцүү байна 180 000 төгрөгөөр 2 өрөө хөлслөөд хүүхдээ байлгаад сургуульд нь сургаж байна. Гүнзгийрүүлсэн сургалттай байхаар жилд 192 000 төгрөг гэхээр, эдийн засгийн хямралтай байдалд нөлөөлж байгаа байхгүй юу. Зүгээр сургууль нь чанартай шахаж шаарддаг байвал би энгийн сургуульд нь л сургамаар байна. Тийм л байгаа байхгүй юу.

**Зу: За баярлалаа.**

**Завхан аймаг, Яруу сум, Гүртэн овогтой Дэмчиг**

**Зу: Та өөрийгөө надад дэлгэрэнгүй танилцуулаач?**

Дэ: Лувсангийн Дэмчиг гэдэг хүн байна. 1943 онд Яруу сумын Өргөн багт төрсөн.

**Зу: Та уламжлалт анагаах ухааны ямар ухааныг эзэмшсэн хүн бэ?**

Дэ: Би эм тан л барьдаг хүн. Анх эхлээд ааваас сурсан. Ааваас сурахдаа бага байсан. Тэрнээс хойш он цаг солигдоод өөр болжээ. Тэр үед уламжлалыг ер нь болохгүй гэдэг байсан. Тэгэхэд би айдаг байлаа. Одоо бол дэлгэр сайхан байна.

**Зу: Анх эм тан барьдаг аргыг хэдэн настайдаа сурч байсан бэ?**

Дэ: Би 18, 20 настай байсан байх. Аав, авга ах эм тан барьдаг байсан. Тэрнээс хойш аав, ахтайгаа эм тан барьдаг болсон. Засаг бас тэр үед эм тан бариулдаггүй байсан. Уул нь сурсан юм болохоор барьдаг байсан даа.

**Зу: Та хэд дэх үеийн өвлөн уламжлагч вэ?**

Дэ: Аав, авга ах, хөгшин аав гээд 4, 5 дугаар үе дээрээ явж байна.

**Зу: Та эм тан барих аргаа өвлүүлж байна уу? Хэзээнээс өвлүүлж байна вэ?**

Дэ: Өвлүүлж байна. Ойрын хэдэн жил өвлүүлж байна. Би одоо 80 гарсан хүн болохоор дороо ядраад байх юм. Боовол боогоод, боохгүй бол хэвтэж байх. Тийм л байна даа.

**Зу: Эм тан боох арга дээр та дэлгэрүүлж ярих боломж байна уу?**

Дэ: Тэр хүүхэд л илүү ярина даа, одоо их ядраад байна. Би ингээд хэвтэж байдаг хүн болчихоод байна.

**Зу: Би одоо хэдэн зүйл асуугаад тэгээд хоёулаа дуусгая.**

Дэ: За

**Зу: Хэр их хүн үзүүлж эм тан авдаг байсан бэ?**

Дэ: Өө, зөндөө Хэнтийгээс ирж авдаг байсан, Улаанбаатараас жаал жуулхан аваад байсан. Энэ аймагтаа бол ургамал, сонгино цант авч байсан.

**Зу: Эмийн ургамал номхотгох гэж яг яадаг юм бэ?**

Дэ: Эм номхотгох нь нүүрсэнд яаж байгаад заримыг нь номхотгодог. Заримыг нь ч яах вэ номхотгох юу байх вэ хийгээд л бариад л.

**Зу: Та ааваасаа сурсан бүх зүйлээ охиндоо зааж сургасан уу?**

Дэ: Охиндоо хэлээд л, “за одоо би 80 гарлаа, одоо аав нь байя” гээд тэрнээс хойш дан энэ охин барьж байгаа.

**Зу: Та ааваасаа сурсан зүйл дээрээ ном судраар ч юм уу баяжуулж сурсан уу?**

Дэ: Худлаа хэлэх юм байхгүй ээ. Ер нь байхгүй, байхгүй.

**Зу: Эм тан барих нь монголчуудын уламжлалт анагаах ухаан мөн үү?**

Дэ: Уг нь мөн. Засаг бас заримдаа болохгүй гээд байсан. Тэгж байгаад одоогоос л хөгжүүлэх арга ухаан хийж байгаа юм билээ.

**Зу: Орчин үед анагаах ухааны их сургуулиуд бий болсон. Та тэр тал дээр ямар бодолтой байдаг вэ?**

Дэ: Хөгжүүлэх барих ажил одоо ёстой зөв явж байгаа. Дээр үед анагаахыг үздэггүй байсан.

**Зу: Уламжлалт анагаах ухаан, орчин үеийн анагаах ухаанаас ямар давуу тал, онцлогтой вэ?**

Дэ: Эм тан барьж байгаа, хийж байгаа улс сайн сурвал улам хөгжинө дөө.

**Зу: Та соёлын биет бусын өвлөн уламжлагчид хэзээ бүртгүүлсэн бэ?**

Дэ: Дээр үед манай аав барьж байсан. Авга ах, өвөө барьж байсан. Тийм болохоор энийг бариад хүнд өгөөд судас ч барьдаг тэрийгээ эд нартаа зааж өгдөг тийм л байна даа.

**Зу: За одоо эгч хоёулаа ярилцах уу?**

Дэ: За тэгье.

**Зу: Та надад өөрийгөө их сайн дэлгэрэнгүй танилцуулж өгөөрэй**

Су: Намайг Дэмчигийн Сувдаа гэдэг, 1978 онд төрсөн. Нөхөр хүүхдийн хамт амьдардаг. Нөхөр хүүхдүүдтэйгээ хөдөө мал малладаг. Би аймагт хүүхдүүдтэйгээ байдаг. Дээр үед Галав туурай гэж байхад манай өвөг эцэг Галуутын хүрээнд маарамба байсан юм. Одоо дөрөв дэх үе дээрээ явж байна. Манай аав одоо нас өндөр гарсан учраас надад уламжилж байгаа. Манай аав өөрөө судас барьдаг тэгээд аав маань “миний хүү одоо энэ хүнд тийм эм өг”, “ийм эм өг”, “энэ хүний зүрх тийм байна” гээд надад ярьдаг. Би тэрийг байнга хийж өгдөг. Манай аав өндөр нас наслаад бие нь ядруу. Шаралгаа, ком болдог шүү дээ. Тийм юманд манай аав их сайн байсан. Манай өвөг дээдэс ч бас сайн байсан. Цусны өвчтэй хүмүүс ч гэсэн эдгэлээ гээд баяртай ирдэг. Тийм л уламжлалтай. Одоо намайг уламжлуулж байна. Би бол тав дахь үе дээр явах юм байна лээ. Бид нар цэцэг навчаа өөрсдөө түүнэ, үрийн юмыг гаднаас авна. Эрээнээс авдаг, гаднаас болохоор их үнэтэй. Гэхдээ бид нар аргалаад л авдаг. Тэр хүнд захъя гээд.

**Зу: Та яг хэзээнээс голчилж ажиллаж байна вэ?**

Су: Би одоо 3 дахь жилдээ явж байна. “За одоо миний хүү, би одоо боллоо хийгээрэй” гээд надад уламжилж байгаа.

**Зу: Тэгэхээр одоо та энэ бүгдийг ааваасаа л сурч байна уу?**

Су: Тийм, манай аав бол бүгдийг зааж өгдөг.

**Зу: Одоо танай аав дээр болоод тан дээр зорьж ирж байгаа хүмүүс бол байна уу?**

Су: Байгаа, манай аав “миний хүү ороод ирээрэй”, “тийм хүн ороод ирлээ”, “аав нь судас бариад өгнө”, “миний хүү тийм юм өгөөрэй” гэдэг. Тэр хүмүүс “миний бие их сайхан боллоо” гээд их баярлаж ирдэг. Манай аав бол удмаараа маарамба хүн байгаа юм. Одоо сүүл үед бол энэ Монгол эмийг уламжлах хэрэгтэй. Тэгээд энэ анагаах ухаан бол бүр дэлгэрэнгүй байх хэрэгтэй гэж бодож байна.

**Зу: Та аавынхаа хэлж зааснаас өөр сургууль ном үзэж байгаа юу?**

Су: Би харин сургаал ном авъя гээд боддог юм. Би өөрөө 5 дугаар анги л төгссөн. Тэгэхээр би бол аавынхаа юмыг уламжилъя гэж боддог. Гэхдээ манай ээж, аав бол “чамайг нэг явуулаад судас бариулаад сургачих юм сан” гэж ярьдаг байхгүй юу. Тэгэхээр нь би “за яах вэ танаас л өвлөхөөр болно шүү дээ” гэдэг.

**Зу: Гол нь судсаа барьж онош тогтооно шүү дээ. Тэгэхээр танай аав судас бариад та эм боож байгаа гэсэн үг үү? Эм бооход юуг анхаарах ёстой вэ?**

Су: Эм бооход бол “энэ хүний бөөр өвдөж байна”, “элэг өвдөж байна”, “цөс нь тийм байна”, “нойр булчирхай, түрий булчирхай” гээд яг анагаах шиг ярина. Элгэнд бол тийм тан өгнө, нойр булчирхай гээд бас л нэг өөр тан өгнө.

**Зу: Эм тан хоёр юугаараа ялгаатай вэ?**

Су: Орцоороо ялгаатай. Нэг орц нь зарим нь нэгнээсээ арай их. Зарим нь арай багахан шиг ордог.

**Зу: Ер нь дан Монголд ургадаг ургамлаар бүтдэг эм тан гэж байна уу?**

Су: Байна, цэцэг навчаар бүтдэг. “Дэгэржав” гээд цөсний эм, “дэгд” гэж хийнэ, “хунилан” гэж хийнэ, “зад”, “ар үр” гээд л явчихна. Үрүүд бол дан гаднаас авна. Цэцэг навчаа бол өөрсдөө түүнэ.

**Зу: Та голчлон түүж байна уу?**

Су: Тийм, манай хүүхдүүд хүртэл түүнэ. Манайх том бандитай тэрийгээ “за миний хүү, тийм ургамал түүгээд ир” гэвэл түүгээд л ирнэ.

**Зу: Ургамлыг таниулах ажлыг аав нь зааж өгсөн үү?**

Су: Тийм, би багаасаа мэднэ. Манай аав 1990 хэдэн оноос бүр нууцаар барьдаг байсан. Манай ааваас нууцаар мэддэг хүмүүс нь ирж авдаг байсан. Хэрэгтэй машин бол ард ирнэ, хэрэггүй машин бол урд ирнэ. Тэгээд энэ “араас машин ирж байна шүү, хэрэгтэй л машин ирж юм авах гэж ирж байгаа шүү” гэж хэлнэ. Бид нарыг бага байхад аав маань бүгдэд нь зааж өгдөг байсан юм. Аавын юманд ордог юм чинь гээд түүгээд явдаг байсан.

**Зу: Одоо бол зарим нэг бүтээгдэхүүнээ заавал гаднаас авах хэрэгтэй байна уу?**

Су: Шаардлагатай бүтээгдэхүүнээ авдаг. Гаднаас авдаг юмнуудаа нийлүүлээд хийнэ. Нэг зүйл дутвал битгий хийгээрэй гэж өвөө аавд хэлдэг байсан. Манай аав надад одоо тэгж хэлдэг. Нэг зүйл дутвал битгий хий гэж.

**Зу: Эм бооход хамгийн хэцүү зүйл юу вэ?**

Су: Нэг өвчинд гэхэд долоо найман юм бооно. Манай дүү нар тусална, би бооно. Бүгдээрээ зэрэг, зэрэг бооно. Тэгээд “тэр, тэр эмийг уугаарай” гэж хэлж өгнө. Тан бол аяганд хийгээд аяганы тал болгож ширгээж ууна. Эмийг бол 30 гр бүлээн усанд зуурч ууна. Тайлбар бүгдийг бичиж өгнө. Энэ тал дээр хүндрэлтэй.

**Зу: Аавтай нь түрүүн ярьсан, “эм номхотгох” талаар аавын заасан зүйл байна уу?**

Су: Манай аав эм тан номхотгоход “дүлэлж хийж аргал түлж хийж байгаарай” гэж хэлж байсан.

**Зу: Дүлэлнэ гэдэг нь юу гэж байгаа юм бол?**

Су: Номхотгоно гэсэн үг нэг ёсны бүх юмыг номхотгож байгаа л гэсэн үг. Манай өвөө байхдаа их сургадаг л байсан. Манай өвч өөрөө их бүдүүлэг хүн байсан. Ийм засагтай байхад би яаж чадах юм гээд хийхгүй гэдэг байсан. Одоо бол зааж байх үед нь би сурч байхгүй гээд амаа барьдаг. Гэхдээ бол өвлөсөн юм зөндөө бий.

**Зу: Та сайн бичиж тэмдэглэсэн гэсэн үг үү?**

Су: Тийм, тийм. Тэднийгээ өвлөнө л гэж бодож байгаа.

**Зу: Одоо ирж байгаа хүмүүсийн өвчин ч гэдэг юм уу зовуурь ямархуу хүмүүс ирдэг вэ?**

Су: “Энэ өвчин, тийм өвчин” гээд эсвэл дуугай байж байгаад орж ирээд судсаа бариулдаг. Аав үзээд “ийм байх шүү, миний хүү” гээд “тэр эмийг өг” гэж хэлдэг.

**Зу: Тэр хүмүүсийн ихэнх нь ямар өвчин зовуурь их байна?**

Су:Одоо бол голчилж янз бүрийн хавдар их гарч байна. Бөөрний хавдар, зүрхний хавдар, элэг цөс, ходоодны хавдар гэж бас их үүсэж байна. Тэрэнд бол эм өгнө. Саяхан энэ манай Эрдэнэхайрхан сумын хүн ходоодны хавдар гээд эм тан аваад явсан. Саяхан ирээд “миний хавдар сайхан болсон байна”, “одоо ахиад уумаар байна” гээд сая ахиад аваад явсан л даа. Тэр хүн бол байнга ярьдаг. “Миний бие их сайхан болж байна, дээрдэж байна” гэж ярьдаг. Манай аав бол шарласан хүнийг ком болох гэж байна гэхэд “за чи энийг гурав хоног уугаад ирээрэй” гэнгүүт “за таны юмыг уугаад арай дээр болоод ирлээ” гэдэг.

**Зу: Шарласан юм уу ком болох гэж байгаа хүнд ямар эм тан боож өгч байна?**

Су: Тэр бол ком болох гэж байгаа хүнд халуун, бүлээн юм өгнө.

**Зу:Тэрний нэрийг нь хэлбэл? ямар эм та бэ?**

Су: Халуун эмийг нь “лонлон сэмбэрүү” гэдэг. Бас “ар жүтэн”, “дугаржав”хоёр өгдөг. “Цагаан тан”, “ман шагдан” гэж өгдөг.

**Зу: Энэ ургамлын ихэнх нь Монголд ургадаг уу, гаднаас авдаг гэхээр Энэтхэг төвөдийн анагаах ухаантай хольсон гэж ойлгож болох уу?**

Су: Болно.

**Зу: Дан Монголд бүтдэг эм гэж бас бий тийм ээ?**

Су: Бий. Монголд ургадаг эмээр бол хийнэ. Зарим нь бол заавал үрийн эм ордог.

**Зу: Таны одоо боож байгаа эм тан орчин үеийн эм тангаас ялгаатай тал болон давуу, сул тал нь юу вэ?**

Су: Эм бол яах вэ наана байгаа үрэвслийг дарна. Цаад юмыг нь дардаггүй байхгүй юу. Монгол эм бол бүүр цаанаасаа угаар нь дардаг. Одоо бид ханиад хүрээд доктор эм уугаад яваад байдаг шүү дээ. Тийм зүйл монгол эмд байхгүй. Хэд хоног уушгины тан уугаад ахиад үзүүлэхэд, “чи юу уугаад ийм болсон юм бэ” гэж ярьдаг байхгүй юу. Тэгээд доктор эм уугаад дараа нь монгол эм уугаад зүгээр болсон гээд ярина.

**Зу: Та сая ярьсан, ковид эсвэл ханиад хатгааны үед эм боож өгч байна уу?**

Су: Боолгүй яах вэ. Манайхан ханиад хүрчихлээ гэхэд өөрсдийн хүүхдүүдэд “мана шагдан”, “мана дөрөв” өгөх хэрэгтэй. Манай дунд банди дээр үед хоёр сартай хатгаа авчихдаг байхгүй юу. Тэгсэн түргэн дуудлаа, хоёр хоноод ирдэггүй. Тэгэхээр нь өөрөө “мана шагдан”-гаар ороолт хийгээд нөгөөдхөө буцалгаж байгаад ар нуруун дээр нь тавьж байгаад боолт хийчхэж байгаа юм. Гурав хоног ороолт хийгээд, түргэний машин ирсэн. Түргэний машин ирээд та хатгаа авсан гэсэн худлаа ярьсан юм биш үү гэж байгаа байхгүй юу. Тэгээд “хатгаа авсан гэдгийг нь би мэдсэн”, “наад чинь хүржигнээд байсан” гэсэн. Мээмээ бүр хөхөхгүй. Тэгээд би манай аав ингэдэг байсан гэж хэлсэн. Тэгээд 3 хоног орооход тэр хатгаа нь зүгээр болсон.

**Зу: Та энэ арга ухааныг суралцаж байгаа хэн нэгэнд өвлүүлж байгаа юу?**

Су: Одоохондоо арай уламжлаагүй байна, алс ирээдүйдээ уламжлуулна даа.

**Зу:Анагаах ухааныг уламжлуулах цаанаасаа дур сонирхолтой байхаас гадна мэдрэмж байх хэрэгтэй юу, энэ талаар та надад дэлгэрэнгүй ярьж өгөөч?**



Су: Анагаахад сурч болно эсвэл “би энэ хүнийг эдгээе” гэсэн тийм сэтгэл байвал өгч уламжлуулж болно.

**Зу: Эм танг бооход тусгайлсан арга уламжлал гэж байгаа юу?**

Су: Байгаа, манайх бол гараараа хийдэг юм.

**Зу: Та надад нэг харуулбал?**

Су: Энэ байна. Уур нүдүүр.

**Зу: Та надад нэг өргөөд харуулаач?**

Су: Энүүгээр нүднэ, тангаа бас энүүгээр хийнэ тэгээд гараараа л хийнэ дээ.

**Зу: Энэ дотор ургамлуудаа хийж байгаад уу?**

Су: Тийм. Ургамал, цэцэг навчаа хийж байгаад л нүднэ. Өөрсдийнхөө гараар л уламжилна.

**Зу: Энэнээс өөр хийдэг технологи бий юу?**

Су: Энэ нүдүүрээрээ хийсээр байгаад л дуусна. Зарим нэг гурил шиг зүйлийг шигшүүрээр хийнэ. Энэ дотор эмээ хийгээд ууранд хийж байгаад л нүднэ.

**Зу: Аан, ингээд нарийн ширхэгтэй нь доошоо унаж байна уу?**

Су: Аан, тэгээд энүүгээр хийнэ. Гараараа л хийх уламжлалтай. Зарим хүмүүс цахилгаанаар хийдэг гээд байгаа юм. Манайх бол гараараа л хийдэг. Тэгээд энүүгээрээ шигшээд гурил шиг нарийхан гартал хийнэ.

**Зу: Гаднаас оруулж ирдэг үрт ургамлуудын олноо хэр байдаг вэ? Үнэтэй юу?**

Су: Ховор их үнэтэй. Тэр “сэмбэрүү”, “анардал” гээд жимсний үр, хальс нь гадаадад ургана. Манай энд ургах биш. Тэрийг нь л авахад, дал наян мянгаар авна.

**Зу: Тэгэхээр тэрийг боловсруулахад мөнгө, цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулж байгаа. Тэрийг хүмүүстээ өгөхдөө бас зохих хэмжээний мөнгөөр өгдөг үү?**

Су: Өгдөг ширхгийг нь 500 гээд л өгчихдөг юм.

**Зу: Одоо хамгийн урт хугацаанд хэрэглэдэг ямар эм тан байна вэ?**

Су: Ядаргаанд уудаг эмүүд бол “мана шагдан”-гаас эхлээд “шижид лонлон” гээд л, хүн ядраад бүр болохоо байлаа гэхэд ууна даа.

**Зу: Монгол эм тан гэж хэлж болох уу? Тэр Монгол эм танг хэрэглэхдээ барих гам гэж байгаа юу?**

Су: Одоо ийм тангаа ууж байгаа үедээ янз бүрийн архи дарс уухгүй, янз бүрийн усанд ордоггүй. Тэгж байж л эм тангаа ууна даа. Будаа, адууны мах, ямааны мах зэргийг идэж болдоггүй. Тарвага идэж болохгүй. Хонь, үхрийн мах идэж болно. Манай өвөө бид нарыг жаахан байхад тэгдэг л байсан. “миний хүү ийм өнгийн ургамал түүгээд ир”, тэрийг нь бариад гүйгээд ирэнгүүт өөрөө “мөн байна” гэнэ.

**Зу: Таныг хүүхэд байхад ургадаг байсан ургамал одоо бий юу?**

Су: Одоо бас их ховордоод байна. Бид нар зун газар сайгүй явж ургамлаа түүнэ.

**Зу: Одоо хамгийн элбэг байдаг мөртөө анагаах шид нь хамгийн сайн ургамал юу вэ? Хэр элбэг байдаг вэ?**

Су: Зарим ургамал талбайгаар их ургадаг. Тэгээд энэ хяраар цэцэг навч их ургадаг.

**Зу: Одоо гялгар уутанд жижиг, жижиг ургамал хийгээд буцалгаж хэдэн удаа ууна гэсэн нэг ийм үзэгдэл байна. Энэ ер нь зөв үү?**

Су: Уг нь тэгж ургамлыг дангаар нь уудаггүй. Заавал хольж уудаг.

**Зу: Холихдоо заавал буталж номхотгож уух уу? Номхотгохгүйгээр уухаар хүний амь насанд аюултай зүйл гэж байх уу?**

Су: Номхотгож ууна. Тийм зүйл байж болно. Бид нар тэр ургамлыг дангаар нь уухгүй. Заавал тэр юманд ордог орцоор нь хийж ууна.

**Зу: Одоо жишээлбэл, нэг өвчин зовуурьтай хүн судсаа бариулах гээд ирэхэд “үнэхээр эдгэх боломжгүй юм байна” гээд буцааж байсан тохиолдол бий юу?**

Су: Байгаа, бүр аргаа барахаараа ирдэг хүмүүс байгаа. Хавдар нь бүр эцэстээ тулаад ирдэг хүмүүс бий.

**Зу: Хүмүүс ихэвчлэн анхан шатан дээр ирж байна уу эсвэл бүр эцсийн шат хүргэж ирж байна уу?**

Су: Зарим хүмүүс бол бүүр эцсийн шатанд болгоод ирнэ. Анхан шатандаа ирсэн хүнийг бол эдгээдэг юм. Эцсийн шатанд хүрвэл, хүн эдгэдэггүй юм байна лээ.

**Зу: Одоо та хүнд эм тан боогоод өгч байна. Үүнд баталгаа гэж бий юу? Хоёр хүний хоорондын итгэлцлийн зүйл байх уу?**

Су: Зарим хүн нь итгэж уугаад эдгэдэг юм. Зарим нь тэгээд хаячихдаг юм. Тэгж болохгүй тэрийгээ эцэстээ тултал уух хэрэгтэй.

**Зу: Зарим нэг зүйл дээр эм тан харшлаад сөрөг тал үзүүлж байсан тохиолдол байгаа юу?**

Су: Монголын эм бараг тийм зүйл гардаггүй, хор бага.

**Зу: Танд сурахад хамгийн хэцүү зүйл нь юу байсан бэ?**

Су: Надад бол судас барих чухал. Ааваараа заалгаад л байгаа даа.

**Зу: Та судас бариад сурчихвал өөрөө оношлоод, эм тан мэдэж байгаа юм чинь цаашид бариад явахад боломжтой юу?**

Су: Боломжтой.

**Зу: Тэгэхээр одоо танд үзүүлдэг хүмүүс хэр их вэ?**

Су: Одоо бол аав дээр л хүмүүс их ирдэг юм. Над дээр зарим хүмүүс бариульа гээд бариулдаг. Тэгээд чиний юм их таарч байна гээд тэгдэг юм.

**Зу: Зарим хүмүүс орчин үеийн анагаах ухаанаар оношоо мэдчихээд бариулдаг уу?**

Су: Тийм.

**Зу: Одоо орчин үеийн хэллэгээр байнгын үйлчлүүлэгч хүмүүс байх уу?**

Су: Байна, энэ Яруугийнхан байнга авна. Нутгийнхан маань байнга уламжилдаг байсан.

**Зу: Судас барихад хүний өвчин зовлон бүгд арилах уу?**

Су: Арилна, судас л барьж чадвал бүх юм гарна.

**Зу: Одоо танд бол сурах шаардлагатай зүйл чинь бол судас барихад юм байна. Бусдаар бол эм тан барих, боох зэргийг бүгдийг сурчихсан гэж бодож болох уу?**

Су: Болно.

**Зу: Би өөр танаас асуугаагүй монгол эм эмнэлгийн чухал зүйл юу вэ?**

Су: Уг нь энэ уламжлалаа байнгын уламжилж л баймаар байна.

**Зу: Яруу суманд ингэж эм барьдаг, та нартай адилхан тийм хүн бий юу?**

Су: Манай яруу суманд бол байхгүй байх. Манай хөгшин л байдаг байсан юм.  
Манай Ярууд бол Замба гээд барьдаг хөгшин л явуулдаг байсан.

**Зу: Уламжлалт анагаах, орчин үеийн анагаах зарим зүйлээрээ хоршиж болж байна, тийм үү?**

Су: Тийм, болдог.

**Зу: Таны сурсан зүйлээс асууж тодруулаагүй зүйлүүд байна уу?**

Су: Манай аав зуны дунд сард цэцэг навч ид ургахаар түүдэг.

**Зу: Тэр түүсэн цэцэг навч, ургамал чанараа алдана гэж байх уу?**

Су: Байхгүй. Жил тойртлоо чанараа алддаггүй байхгүй юу. Битүү ийм ийм саванд хийгээд хадгална.

**Зу: Жишээлбэл түүх хориотой ургамал гэж байх уу?**

Су: Янз бүрийн хориотой ургамал байдаг юм билээ. Би бол түүхгүй. Яг өөрсдийн юманд орох ургамлаа тэрнээс түүнэ. Тэрнээс биш хориотой зүйл түүхгүй.

**Зу: Хэрвээ тэр хориотой ургамал янз бүрийн эмд ордог бол түүх шаардлага бий юу?**

Су: Байна л даа. Хориотой эмээс монгол эмд ордог бол түүнэ.

**Зу: Жишээлбэл эмд маш шаардлагатай ургамал байдаг, засгаас түүхийг хориглосон байдаг, ийм асуудал байгаа гэж ойлгож болох уу?**

Су: Болно.

**Зу: Тийм ургамлын нэр хэлбэл ?**

Су: Энүүхэнд л байдаг юм гэсэн. Дархан цаазтай “Рээгомбо” гэж ургамал бий. Тэр уг нь ордог юм. Дархан цаазтай болохоор хүмүүс явж түүдэггүй байхгүй юу. Тэгээд бид хүнд захидаг юм. Уг нь өөрсдөө түүдэг бол. Бид энэ өөдөө явахгүй мэддэг хүмүүст нь захичихдаг.

**Зу: Тэгээд та нар мэддэг болохоор Яруу сумандаа очиж л түүдэг үү?**

Су: Сумуудаар ургаж байвал сумуудаар очиж түүнэ.

**Зу: Баярлалаа, танд их баярлалаа.**

Су: Зүгээр, их баярлалаа.

**Зу: Бид нар ийм их ажилтай л явна.**

Су: Өмнө жил корона гарсан үед мана 4 норов 7 л ууж байлаа.

**Зу: Өөрсдөө найруулах уу, худалдаж авах уу?**

Су: Өөрсдөө найруулна.

**Зу: Хүмүүс худалдаж авч байсан уу?**

Су: Авч байсан, авалгүй яах вэ. Тэгээд хүмүүс “аптекаас авсан чинь тийм байна” гээд орж ирдэг байсан.

**Зу: Тэгэхээр бас нөгөө эмийн том, том уламжлалт ухааны үйлдвэр зарим талаараа чанар жаахан муу байж болох уу?**

Су: Муу байна, зарим хүмүүс “танай энэ “шижид” их гоё байх юм тэгэхэд зарим газраас авахад сонин шорвог байх юм” гэж ярьдаг байхгүй юу.

**Зу: За баярлалаа.**

Увс аймаг Завхан сум Цоозол

**Зу: Та Европоор эмч байсан хүн зарим уламжлалт анагаах ухааныг ашиглаж байв уу ?**

Цо: Уламжлалт анагаах ухаан гэхээр бариа засал хэлээд байх шиг байна тийм үү ?

**Зу: Бариа засал, зүү, төөнүүр, дом шившлэг зэрэг ардын уламжлалт анагаах болон хүүхэд ширэглэх, ам гэмтэх,горьдох гэх мэт иймэрхүү зүйл хэрэглэж байсан талаар орчин үеийн анагаах ухаан эсвэл уламжлалт анагаах ухааны давуу талаар бидэнд ярьж өгөөч.**

Цо: Уламжлалт анагаах ухаан гэдэг дээр дээр үеэс бол хүмүүс голдуу ер нь тэр 1920,1930,1940 оны үед чинь 1925 онд манай эмнэлгийн анхны суурь тэр өвгөн сайр айраг нуур гэж Гомбожав гэдэг хүн анх суурийг нь тавьж байсан гэнэлээ тэр үед чинь яадаг гэхээр шинжлэх ухааны анагаах ухаан гэж байдаггүй байсан. Тэгэхлээр тэр үеийн шинжлэх ухаан 1925 онд орос эмч ирж 2 сар сургалт явуулаад тэр сургалтад суусан хүн юм байна лээ. Тэрнээс өмнө тэр хүн яадаг байсан гэхээр судас барих голдуу тийм байсан. Лам нар их байсан лам нарын үнэмшлээр хэрэглэдэг эмчилж байсан гэж би өөрийн эмнэлгийн товч танилцуулга дээр үед олж уншиж байсан юм. Тэр дээр тэр хүн болохоор хүмүүсийн уламжлалт гэж хэлдэггүй байсан хүнийг бариагаар арц хүжээр гэдэг юм уу эмчилдэг байсан. Хүмүүс чинь тэр үед халдварт өвчин их гарч байсан тэмбүү өвчин гэдэг юм уу тиймэрхүү тийм өвчин нэлээн байсан түүнийг шинжлэх ухааны аргаар нэлээн голдуу Пагмасүрэн билүү тийм хүнтэй суурийг нь тавьж эхэлсэн. Тэр хүнд болохоор бариа хийдэг ханадаг төөнүүр хийдэг тийм дээр үеийн эм дандаа нунтаг эм байсан. Тэрийг дандаа шившлэгтэй боож өгдөг тийм хүн байсан тэгж байгаад шинжлэх ухааны анагаах ухааныг 2 сар сураад тэрнээсээ үндэслээд гэр барьж эхлээд 1939 онд 2 гэр болгоод 2 ажилчинтай болоод тэгээд Шар булаг төв дээр ирж эмнэлэг байгуулах анхны суурь болсон. 1800 төгрөгөөр эмнэлэг барих төсөв эмнэлгийн суурь тавигдаж эхэлсэн танилцуулга байдаг. Анх бол Айраг нуурын тэнд байсан Буурийн сайр гэдэг газар 1 гэр барьж байсан гэнэлээ. 1939 онд бол ард түмнээсээ хандив авч 2 гэртэй болж 1948 онд тэр үеийн 1800 төгрөгийн төсөвтэй байшин бариулж 5 ажилчинтай анхны шинжлэх ухааны гараа эхэлсэн.

**Зу: Шинжлэх ухааны эмнэлэг анх тэгж байгуулагдсан тэрнээс өмнө тэрийг ардын эмнэлэг гэдэг байсан уу ?**

Цо: Дээр үед оточ гэдэг байлаа шүү дээ миний ээжийн нагац ах болох оточ Доёд гэдэг хүн байсан бариа хийдэг. Хүүхэд эх барьж авдаг, ээжүүд төрөх болдог ер нь тэр үед гэрт төрдөг байсан тэгээд тэр хүнийг дуудаж төрдөг тийм байсан. Тэр хүн хугарал бэртэл юу л байна бүгдийг нь барьдаг тийм байсан. Намайг хэлд орсноос хойно өнгөрч байсан би санаж байна. Тэр уламжлалаараа би өөрөө эх баригчаар төгссөн хүн би аав ярьдаг байсан юм тэр хүн мундаг бариач байсан төрсөн эхийн эхээс гардаггүй тэр хүн дийлж гаргадаг байлаа. Тэр хүн домнож гаргадаг байсан. Хоёрт бол өрхний оосор оруулж ирээд аманд нь хийж огиулдаг юм байна. Огихоор тэр булчин агшиж сунаж

тэр сав жаахан ширгэдэг гэсэн би тэгж бодож байна. Намайг эмч болсны дараа аав тийм дом байдаг янз бүрийн хүн гэрээр таарвал гэж хэлж байсан. Би 1982 онд төгсөж байсан эмнэлэгт л байсан 1980 онд бол гэртээ төрж байсан. Тэгээд би яг аавын хэлж байсныг санаж байгаа байхгүй юу яг тэгдэг юм байна лээ гээд. Гэрт нь ах дүү нар нь бүгд л байна шүү дээ эх төрж байгаа юм чинь араг түшээд л одоо яана гээд би гэрийнхэнд нь хэлж байсан ийм дом байдаг гэсэн гэрийнх нь өрхний оосрыг тотгоор оруулж ирээд тэгээд аманд нь хийж огиод эхэс гардаг гээд тэгж хэлсэн тэгье гээд оруулж ирээд тэр хүндээ ёстой л огьдог юм байна лээ тэгээд гарч байсан тэр оргүй ч биш юм байна даа гээд бодож байсан. Манай нагац ах их мундаг хүн байсан байна лээ. Тэр эмч Гомбожав гээд бас их мундаг хүн байсан байна лээ. Тэр хүнийг 1939 онд юм уу хэдэн онд билээ БНМАУ-ын эрүүлийг хамгаалах жуух гэсэн юмаар шагнуулж байсан байна лээ. Би бүр тэрийг үзэж байсан мундаг хүн байжээ. Манайхаар бас лаборант байсан хориод жил ажиллаад хот руу шилжээд явсан байгаа тэр залуу тэрний буурал аав.

**Зу: Одоо бол та шинжлэх ухааныг төгссөн хүн ардын анагаах ухааныг хэрэглэж байна шүү дээ тэр эхэс гаргах ч юм уу тэрнээс өөр сонирхолтой хэрэглэж байсан арга байна уу ?**

Цо: Тэр аргыг би нэг хэрэглэж байсан. Өөр нэг их байхгүй байх.

**Зу: Эсвэл та сонсож байсан ч юм уу тийм зүйл байсан уу зарим хүмүүс чинь сонин шүү дээ шинжлэх ухааны анагаах очихоосоо өмнө ардын анагаах ухаанаар явдаг ч юм уу, эсвэл дараа нь ханддаг ч юм уу ?**

Цо: Яах вэ хүн хүний сэтгэхүй өөр ялангуяа бэртэл гэмтэл дээр тийм юм их байдаг. Нярай хүүхэд дээр их байдаг. Яагаад гэхээр хүүхэд халуураад гэдэс өвдөхөөр тархи нь доргичхож гэнэ эмнэлэгт үзүүлнэ эмч үзээд наршсан байна гэдэг юм уу хоол нь болоогүй байна гэдэг юм уу эм бичиж өгнө зөвлөгөө өгөөд л тэр хүн гарч яваад толгой барьдаг хүн хайгаад явдаг байхгүй юу. Тэгээд хавсарч яваад байдаг иргэд их тэгж явдаг одоо ч гэсэн тэгж явдаг. Над дээр ч гэсэн их ирнэ юуг нь нуух вэ эмнэлэгт үзүүллээ ханиадтай байна гэнэ манай хүүхэд өчигдөр орноос унасан ч гэдэг юм уу юм мөргөсөн ч гэдэг юм уу ингээд ирдэг байхгүй юу. Би эмч хүн юм чинь тэнд үзсэн эмчийг үгүйсгэхгүй үгүйсгэх ч арга байхгүй. Тэр хүн бол анатоми эмнэл зүй мэдэж байгаа болохоор хэлж байгаа. Энэ хүн бол өөрийн сэтгэл зүйгээр миний хүү нэг тэгчхэв үү дээ гээд тэр хүн дээр очвол болчих байхаа гэж сэтгэлээрээ ирнэ нэг ёсны. Яах вэ нэгэнтээ хүн зориод ирж байхад үгүй би чамайг үзэхгүй эмчдээ үзүүл гэж бас болдоггүй юм. Үзээд л аргагүй хугарсан барьсан юм байвал тусална. Хөл гар нь хугарсан мултарсан байвал одоо харин гар хөл хүчирхээ байсан. Анагаах ухааны ч эмчилгээ их байдаг байсан хөл гарын бариа их барина мөрний мултрал оруулна зөндөө тийм юм хийж байсан. Одоо харин хүч хүрэхгүй байна лээ ялангуяа насанд хүрсэн хүн бол бүр хүүхэд бол яах вэ. Тийм хүүхэд ирэхээр яах вэ дээ ээжийн сэтгэл зүй тосож байгаа юм толгойг нь илж өгнө гэдэг чинь нэг ёсондоо би судсыг нь тэлж өгч байгаа байхгүй юу. Тэр хүүхэд гүйлгээд халуураад судас нарийссан байгаа. тэрийг

нь тэлж өгөөд тэгээд сайхан тайвшруулах юмыг нь өгнө. Одоо сүүл үед хөгжиж байгаа анагаах ухааныг би зөв гэж үздэг тийм буруу юм биш.

**Зу: Яг үнэнээсээ адуу малаас унаад тархи нь доргисон ч юм уу тийм байлаа гэхэд шинжлэх ухааны анагаах ухаан тэрийг яаж эмчлэх вэ ?**

Цо: Яг шинжлэх ухааны анагаах ухаанаар тэр хүнийг хөдөлгөөнгүй л байлгах ёстой. Хамгийн гол юм хөдөлгөөнгүй байлгах. Хөдөлгөх л юм бол тэр хүн хүндрэл өгнө. хүндрэл өгөхөөс нь л өмнө тэр ялангуяа тархи хөдөллөө гэдгийг хэн ч гаднаас нь хараад мэдэхгүй тэрийг эмч үзээд нуруу нугасны хөшингө байна уу үзээд хөшингө байх л юм бол хөдөлгөөнгүй л байх хэрэгтэй.

**Зу: Тэр үед шинжлэх ухааны эмч бариачаар бариул гэж хэлж болно биз дээ ?**

Цо: Яг тархи доргисон үед би нар бол тэгдэг байсан одоо сайн мэдэхгүй байна. Дөнгөж л хүн ирэхэд эхлээд шинжлэх ухааны юмаа л хийнэ. Бариа засал бол илаарьшсан үед хэрэглэх. 3-5 хоног шинжлэх ухааны юм хэрэглээд хурц үе намжсан үед гэсэн үг. Хэрвээ шууд бариа засал хийвэл 5-10 хоногийн дараа хүндрэх магадлалтай.

**Зу: Бариа засал байж болж байна, гоёо гоёхон гээд танай нутаг орны онцлогтой ургамал байна. Эмийн ургамлын чанартай зүйл хэрэглэх тал дээр эм болоод эмийн ургамлын зөрүү ялгаа бий юу. Та жишээ нь эмийн ургамал хэрэглэж байна уу ?**

Цо: Эмийн ургамал гэхээр манайх Монголын аль ч нутагт ургаж байгаа яг шинжиж ямар эмийн ямар найрлага вэ гэдгийг бүрэн төгс үнэхээрийн яг судлагдаагүй. Би хувьдаа тэгж боддог. Тухайлбал манайд тарваган шийр гэж ургаж байна хулангийн ундаа ургаж байна. Тэд нар дотор ямар найрлага байгаа хар тамхины хольц ч байгааг ч бид нар мэдэхгүй шүү дээ. Энийг хэн ч судлаагүй. Гэтэл хөдөө орон нутагт тэр их сайн юм гээд хэрэглэж байгаа шүү дээ. Хэрэглэхгүй биш хэрэглэж байгаа. Цөсөнд их сайн нойр булчирхайнд их сайн гээд хэрэглэж байна. Бөөрөнд ёстой баараагүй баталгаатай гээд уусан хүмүүс хэлж байгаа. Шинжлэх ухаанаас юугаараа ялгаатай юм гэхээр ямар ч химийн найрлага байхгүй гэж үзэж байгаа шүү дээ. Тэр үүднээсээ хэрэглэж байна гэтэл яг шинжлээд үзэхэд юу юу ямар найрлага байгааг мэдэхгүй шүү дээ. Манайх чинь жинхэнэ элсэн газар элс аваачаад шинжлүүлэхэд юу юу байгааг мэдэхгүй шүү дээ. Ойшоодоггүй юм байна лээ би бас энэ элсийг шинжлүүлж үзсэн сайндаа ч биш бөөрний сувилал нэг эмчтэй хийж үзвэл ямар юм болдоо гээд шинжлүүлсэн шинжилдэг юм байна лээ 80000 гаран төгрөг аваад шинжилж байсан санагдаад байна.

**Зу: Үр дүн нь ямар гарсан бэ ? Хүний биед ямар байсан бэ ?**

Цо: Тэгээд би боддог юм манай энэ элсийг Ховд аймгийн нэг бөөрний сувилал хийлэг эмч энд нэг манай элсэн дээр бөөрний сувилал ажиллуулж байсан. Тэгээд би бас нэг бөөрний сувилал ажиллуулбал ямар юм болдоо гэж бодож байсан байхгүй юу. Гэтэл тэр яасан гэхээр нөгөө эмч маань сураад явсан тэгээд чадаагүй.

**Зу: Хэрвээ үнэхээр энэ нуурын шавар элс химийн зүйлсийг нь судлаад хүний биед хэрэгтэй байвал ач тусаа өгнө тийм үү ?**

Цо: Өгнө бас л нэг ардын эмчилгээ.

**Зу: Одоо жишээлбэл ардын болон шинжлэх ухааны эмчилгээ хавсарч болж байна уу ?**

Цо: Болно шүү дээ. Жинхэнэ хавсарч болно манайх бол алс хол тэр үед бид тэр эмч бид хоёр ярьж байсан хаана ямар тохиолдолд яах вэ гэхээр энэ нэг голын захад ямар ч унаа хүрэхгүй мосттой машин хүрнэ үү гэхээс өөр машин хүрэхгүй шүү дээ. За нэг нүүдлийн гэр байшин зөөвөрлөөд явъя нөгөө эмч наашаа цаашаа явъя гэхээр хэцүү юм байна. Хоёулаа хэцүү хадны ойролцоо очъё урагшаа 20 км байгаа газар очоод байя гэхээр бүр эндээс ямар ч хүн очихгүй юм шиг тэгээд хаясан юм л даа. Одоо жишээлбэл хослуулаад тэр хонин зээргэнэ, тарваган шийр, гоёо л гэнэ бүгдийг нь сайхан судлаад химийн найрлага тодорхойлоод шинжлэх ухаантайгаа хавсрахад их л гоё юм болно. Гоёог бол элэг цөсөнд сайн гэж уудаг юм. Одоо бол хөөрхий ховордоод байх шиг байна. Тэрнээс шарласан бол элэг томорсон бол гоёохой уудаг байсан. Одоо ховордоод үндсийг нь оргүй хийчхээд байна. Бас одоо гоёо чинь ямар ч учиртай юм ноднин шүүх цагдаагаар яваад бөөн л юм боллоо. Нуурын хаялгаас түүсэн гээд хэлсэн юм уу даа тэр хүн нуур чинь гэтэл тусгай хамгаалалттай газар.

**Зу: Гоёохой нуурын тэр хавиар л ургах уу ?**

Цо: Үгүй элстэй газар сангийн далай гэж ургадаг юм манай Сэдэс гэж гол бий манхан тохой гэж газар ургана.

**Зу: Та бол гоёохойг хүүхэд байхаасаа л хэрэглэж байв уу ?**

Цо: Тэгдэг байсан хүүхэд байхаасаа л хэрэглэлээ. Одоо ховордоод байна бид 10 гаруй км өдөр яваад л орой нар жаргахын алдад нэг уутны тал гоёохой үүрээд л янцаглаад л явдаг байлаа тэрийг чинь 2,3 өдөр машиндаж өгнө сүү гарчихсан. Тэр суль бол нэг ёсондоо элэг цөсөнд сайн нөгөө талдаа дархлаа сэргээх гэж хэрэглэнэ. Бүр ядарсан хүнд цай чанаж өгнө хөлс гарна.

**Зу: Гоёохой гээд танай нутгийн онцлог зүйл байна шүү дээ тийм ээ ?**

Цо: Манай жимс тэр гоёо суль хармаг.

**Зу: Хармагийг юунд хэрэглэж байна вэ ?**

Цо: Намар л гардаг юм зүгээр тэгээд ирнэ. Яг үхрийн нүд шиг амт ч их төстэй. Чихэр өвс гэдэг чинь амьсгалын замын өвчинд их сайн.

**Зу: Одоо ер нь өмнө байснаасаа ховордож байна уу ?**

Цо: Чихэр өвс ч гэсэн ховордож байна гэсэн элсэн дотор газар дагаж ургадаг.

**Зу: Сонирхолтой энэ байгалийн онцлогоос хамаарч.**

Цо: Тийм элс ихтэй чийг сайтай газар ургадаг гэсэн үг. Энэ суль 8-10 сарын хооронд л ургана. 7 сараас хойш сайн бороо ороод байвал 10 сар хүртэл л ургана тэгээд түүж авна.

**Зу: За баярлалаа.**

Увс аймаг Улаангом Ш. Бадамсамбуу

**Зу: Та өөрийгөө дэлгэрэнгүй танилцуулаач.**

Ца: За, намайг одоо Шагжийн Бадамсамбуу гэдэг хүн байгаа юм би, одоо 63 настай. Одоо ингээд эцэг өвгөдөөсөө уламжилж ирсэн энэ цахиач гэдэг юмыг цахидаг одоо анагаах хэллэгээр бол могойн яр гээд түүнийг нэг цахиж эдгээдэг эмнэлгийн эмчилгээгээр ямар ч эмчлэх арга байхгүй тэгээд зөвхөн хар домын аргаар л эдгээдэг өвчин. Тэр өвчнийг одоо би ангааж эмчилдэг хүн.

**Зу: Та энэ арга ухааныг анх хэнээс өвлөж авсан бэ ?**

Ца: Би энэ арга ухааныг анх ааваасаа өвлөж авсан, удам залгасан.

**Зу: Та одоо яг энэ арга ухааныг өвлөсөн хэд дахь үеийн өвлөн уламжлагч бэ?**

Ца: Би одоо юу л даа, 4 дахь үе. Манай аавын хөгшин аав нь, аавын аав нь, манай аав би, би дөрөв дахь үе нь болж байна. Тэгээд тэр залгамжилж анагааж хүн амьтны бас эрүүл мэндэд ингэж бас ач холбогдол өгч ирсэн хүмүүс бид нар. Хүнийг бас яах бэ, Эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд гээд байдаг шүү дээ бурхны тэр шиг одоо бид нар хар домоор хүмүүсийг өвчнөөс салгадаг хүмүүсийг өвчин зовлонгоос нь ангижруулдаг бас авьяастай хүмүүс бид нар. Тэгээд бид нарын авьяасыг хүмүүст зааж өгөхөөр хүн сурчхаад яваад сурчихна гэж бараг байхгүй. Зөвхөн тэр удмын хүмүүс цагаан ястай цорос тайж удмын хүмүүс цахидаг. Тэр удмын хүмүүс их ховор.

**Зу: Цахих гэж ярьж байна уу ?**

Ца: Цахих гэж ярьж байна. Хэт цахиур чулуу хоёроор арчдаг. Тэгэхдээ тэнгэртэй харьцдаг гээд одоо нэг бөө байдаг шүүдээ бид нар бас нэг тиймэрхүү бас өвөг дээдэстэй тэнгэрт байгаа өвөг дээдсийн удам судар одоо заана дөрөв таван үеэрээ ингэж дуудаж цахидаг тийм тангарагтай хүмүүс. Цас шиг цагаан ясанд толбо үлдээхгүй гэсэн тангарагтай тэр тангаргийн дагуу тэр хүний өвчнийг илаарьшуулж байдаг. Хүн амьтны эрүүл мэндэд тус болж ирдэг хүмүүс.

**Зу: Та одоо яг хэдэн настайгаасаа хойш цахих арга ухааныг хэрэглэж байна.**

Ца: Би одоо 95 он гэхээс одоо 27 жил болж байна уу? 27 жил одоо миний эцэг өнгөрсөн миний эцэг өнгөрснөөс хойш л тэгээд л уламжлаад цахиад явж байгаа. Миний эцэг одоо надыг бас би аав нь ингээд нас өндөр гарлаа 90 хүрээд миний аав өнгөрсөн юм тэгээд ингээд өндөр боллоо надаас сурч ав гээд надад ингэдэг тэгдэг гээд зааж зөвлөсөн би тэрний дагуу уламжлаад явж байгаа

**Зу: Та ээж ааваасаа хэдүүлээ вэ?**

Ца: Би ээж ааваасаа наймуулаа байсан одоо дээрээ 2 эгч 2 ах ингээд 5 уулаа байна

**Зу: Таны аав таны ах эгч нарт бас энэ арга ухааныгаа өвлүүлэв үү? Эсвэл таныг сонгон танд өвлүүлж уламжлуулсан уу?**

Ца: Ер нь надыг бол бараг сонгосон би айлын отгон хүүхэд хамгийн бага нь. Тэгээд хамгийн бага хүүхэдээ нөгөө голомт залгаж төрсөн гэхээр надад уламжлуулж заасан. Гэхдээ нөгөөдүүл бас л цахиналдаа бас гэхдээ надад уламжлуулах юмаа зааж өгсөн.

**Зу: Та одоо энэ цахих гэдэг арга ухааныг илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгвөл одоо энийг мэддэггүй тэ? Энэ зүйлийг одоо сонсож байгаагүй хүмүүс бас байгаа тэ? Энэ одоо өвчин могойн яр гэдэг зүйлээр олон хүмүүс зовж шаналж байж магадгүй. Тэгвэл энэ цахих гэдэг арга ухааныг хар домийн энэ аргыг илүү ойлгомжтойгоор тэ? Хүмүүст түгээх байдлаар одоо энэхүү бичлэгт тэгээд дэлгэрэнгүй ярьж өгвөл.**

Ца: Харин тийм. Би тэгээд энийг бол хүмүүст нэг хүн ч болтугай энэ өвчнөөс салж байвал бас дээр. Би бол өөрийгөө сурталчлах, реклам маягийн өөрийгөө нэг гадагшаа гаргадаггүй хүн зүгээр ингээд байж л байдаг надад хүмүүс ирээд цахиулдаг энэ нутгийн хөдөө сумын, надад бүр Польшоос хүртэл тэнд амьдарч байсан хүн энд аавындаа тэр ангаахын аптекийн эм тос бүх юм бүрхээд тэгээд ядаад тэгээд бушуулаад тэр нэг 3-4 настай хүүхдийг энд авчирч надаар эмчлүүлээд буцаад явсан тохиолдол байгаа. Улаанбаатараас ч гэсэн ганц нэг хүн ирдэг юм.



Хүүхдээ авчраад эмчлүүлээд явдаг хүмүүс байгаа. Тэгээд энэ Анагаахын дээд төгссөн хүмүүс их эмч нар надаар ирж цахиулна. Тэгээд намайг их гайхдаг юм. Бид нар анагаахын сургуулийг 4 жил сураад бид нар энэ өвчнийг дийлэхгүй байгаа. Та ямар сонин хүн бэ гээд тэгдэг юм тэгээд би тэд нарыг эмчлээд л. Намайг тэр хамар хоолойн эмч нар эмчилгээтэй би ганцхан цахиад явуулсан. Маргааш нь хүүшээ та ямар сонин юм бид нар Анагаахын дээд 4 жил сураад төгссөн таныг цахиад би 15 минутад өвчин намдлаа. Би унтаж чадаагүй урд шөнө гэртээ очоод нам унтлаа. Одоо нэг цахиулчихъя гээд гурав цахиулаад нөгөө хувилж байсан юм нь хатаад.

**Зу: Энэ могойн яр гэдэг өвчин нь ямар өвчин юм бэ ?**

Ца: Анагаахын хэллэгээр могойн яр гэж байгаа юм. Бидний хар домын хэллэгээр бол бузартсан байгаа. Бузартлаа гээд ламаар ном уншуулаад хийморийн сан уншуулаад байдаг. Зөвхөн энэ хар домын шившлэгтээ аргаар.

**Зу: Хар домын судар ном гэдэг юм уу тэр уншлага шившлэгийг амаар эсвэл бичгийн хэлбэрээр дамжуулж байна уу ?**

Ца: Амнаас ам дамжсан тухайн удмын хүнд л заавал дамжуулна. Тэр хүн дараа үедээ заавал залгуулж хэлж өгнө. Өөр хүнд хэлж өгөхөд тэр биелэл олохгүй. Зөвхөн өөрийн удам залгасан хүндээ хэлж өгнө.

**Зу: Одоо таны энэ цахих аргыг могойн ярнаас гадна өөр өвчин зовлонд хэрэглэх үү ?**

Ца: Бас боломжтой одоо жишээлбэл би зөвхөн могойн ярыг эмчилдэг үү гэж судалсан хүүхдийн ам тойрч гарч байгаа яр байна шүү дээ устай түүхий гардаг тэр мэрийг бол бас алга хийнэ. Хүний энэ могойн ярнаас гадна энэ тэндхийн бузартсан хүрэн суурьтай шарх байдаг байхгүй юу. Тэд нарыг бас цахиад алга хийнэ. Тэгээд ер нь бүх төрлийн устай шархыг эмчилнэ. Би нэг удаа 9 дүгээр ангийн охин нүүрээр нь дүүрэн шарх гарсан битүү идээ гоожоод тэр хүүхдийг би 14 удаа цахиад тэр ярууд мултарч унаад цав цагаан цэвэрхэн нүүртэй болсон. Тэр бол цахиад хийхээр тийм л шарх байсан. Тэр хүмүүс одоо манай суманд байж л байна л даа баярлаж л байдаг юм. Устай төрлийн ямар ч шархыг эдгээнэ. Би сүүл үед манай энд нэг Батсүх гээд хөгшин байдаг байхгүй юу тэр хүн толгой нь битүү яр шарх байсан. Тэгээд би цахиад байсан толгойных нь шарх бүрэн унаад энэ хүзүүн дэх яр шарх нь багасаад одоо эдгээд одоо надаар нэг цахиулж авмаар байна гээд утсаар ярьж л байна. Тэр бол олон жил эмнэлгээр нарны харшил гэж яваад эмнэлэгт хэвтээд артерийн тос авч түрхээд тэр тоснууд нь дийлэхээ байгаад тэр шарх нь дийлэхээ байгаад надаар цахиулаад одоо толгой нь гоё цэвэрхэн болсон. Одоо энд байгаа л даа.

**Зу: Тэр шарх гараад байгаа нь цаанаа бас бузрын асуудал байна уу ?**

Ца: Тийм бузартай холбоотой бүх шархыг эдгээнэ гэсэн үг. Цахиад бол устай шүү дээ зарим нь бүр гоожиж байдаг шүү дээ. Далаар гарсан шарх бүр далнаас гоожоод орой нь цохчиход маргааш нь хувь хуурай болдог. Хатаад л шархнууд нь мултраад унадаг байхгүй юу. Тийм бас ид шидтэй л дээ бүх устай шарх. Одоо анагаахын янз бүрийн тос түрхдэг. Батсүх гэдэг хүн бол тос түрхээд бүр дийлэхээ байсан. Манай Оюун гэж Оюуны ээж нь гэж хүн байгаа тэр хүн бүр толгой нь үс нь дотор чих гээд бүр хоолой нь хавдчихсан тийм аймар шарх хоолой нь боогдож байсан. Тэр хүнийг эмнэлэгт хэвтүүлэе гэсэн гэтэл тэр хүн намайг сонгосон эм дом хийлгэнэ гээд. Би тэр хүнд 3 хоног эм дом хийгээд тэр хүний хавдар нь хариад тэр хүн анх хавдартай яаж хавдартай болсон гэхээр гал тахидаг хүнээр аваачаад үлээлгэсэн байгаа юм. Тэгээд нөгөөх нь хавдаад

хоолой нь боогдоод тэгээд зөвхөн миний хар домоор эдгээдэг юмыг өөр хүн хэрэглэж болохгүй байхгүй юу. Тэр эмнэлгийн тос чернил түрхэж болдоггүй байхгүй юу. Би тэр хүнийг 3 хоног цахиад үргэлжлүүлээд 14 хоног цахисан тэр хүний шарх нь хонины ноос шиг хөвөрсөн нэг ёсондоо шархнууд нь мултраад мултраад тийм хүчтэй үйлчилдэг.

**Зу: Ерөнхийдөө шархнаасаа хамаараад цахих тоо нь их бага байх уу ?**

Ца: Тийм, дөнгөж эхэлж байгаа бол ганцхан цахихад болно. Эмнэлгийн тос түрхээд сэдрээчихсэн тийм бол 14 хоног цахиж болно 3 хоног цахиж болно. Тэгээд ер нь наадах чинь өвчин хэр байсан гээд тааруулж цахина ойрхон зайтай цахиж болно өдөрт хоёр цахиж болно. Нэг дээхэн үед айлд шөнө бас очсон тэр хүн дөрвөн мөчөөрөө тэрийгээд хэвтсэн ах нь үхлээ гээд өвчин зовлонгоо тэсэж ядаж байсан. Тэр айл хоол цай хийж байсан би нөгөө хүнийг эдэргүүлж байгаад эмгэн нь салтаанд нь гарч байсан би тэр хүнийг цахиад гараа угаагаад хоол унд идэх гэж байсан нөгөө хүн чинь юун хоол унд мантай үхэх гэж байсан байхгүй юу. Тэгсэн 10 минутын дараа босож ирээд цай уугаад хоол идсэн. Чи ахынхаа аминд орлоо ах нь үхэн шахаж байсан гээд. Тэгээд тэр хүн ирж цахиулах байсан. Би өөрөө хийж байгаа юмаа мэднэ шүү дээ тэр хүнийг бол ганц цахиад болох байсан. Би тэгээд хөдөө байсан машин тэрэгтэй айл амьтнаар явж байхад л намайг дуудаад л чи нэг ахынхаа аминд ороод гээд их л баярладаг.

**Зу: Одоо таны аав бол энэ ажлыг их хийдэг байсан та харж байсан уу ? Тухайн үед бас цаг их хэцүү байсан энэ талаар ?**

Ца: Манай аав хүмүүсийн тэр өвчнийг эдгээж их тус болж байсан. Дээр үед тийм янз бүрийн юм болохгүй л гэдэг байсан. Манай аав бол 1906 онд төрсөн дээхэн үеийн хүн л дээ 90 нас хүртлээ нутагтаа байсан. Хүн амьтан мэднэ тэгээд хүмүүс нууцаар ирж цахиулаад л явдаг байсан.

**Зу: Одоо та энэ арга ухааныг өөрийн удмын хүмүүст өвлүүлэх үү ?**

Ца: Би одоо манай 35 хүрэх гэж байгаа залуу байна энд л өвлүүлэх гээд бодсон байна. Тэр маань тэгээд жаахан хүүхдэдээ өвлүүлэх байх нэг иймэрхүү маягаар явна.

**Зу: Энэ хар домын аргыг өөр орны хүмүүс хэрэглэдэг юм болов уу энэ хар домын аргын язгуурыг яаж мэдэх вэ ?**

Ца: Ер нь монголчуудаас өөр байхгүй л дээ бөөгийн шашин гэж ярьдаг шүү дээ тэр нь шиг энэ хар дом бол монголчуудын дом. Бид чинь язгууртан улс шүү дээ тэнгэрээс гаралтай. Язгууртан улс гэхээр дээр гарсан юм байна тэд нараас бид нар харьцаж тэд нараас авч л үйлчилгээ үзүүлдэг улс шүү дээ бид.

**Зу: Та яг Улаангомын хүн үү ?**

Ца: Би Увс аймгийн Тэс сумын хүн. Одоо манай энүүхэн энд нэг овоо байдаг юм. Хош Тэргийн гол гээд тэнд төрсөн хүн. Тэр миний нутгийн овоо. Миний аавын босгосон овоо. Хоёр овоо байдаг Булган Өндөрийн овоо миний аав, миний аавын аав хөгшин аав тэд босгосон. Тэгээд үндсэндээ янз бүрийн хүнээс юм уншиж судлахаар тэр хооронд манай өвөг дээдэс биднийг эргэж тойрч байдаг.

**Зу: Та ямар мэргэжилтэй хүн бэ ?**

Ца: Би бол малын мэргэжилтэй хүн л дээ.

**Зу: Ерөнхийдөө хэдийнээс энэ цахихыг илүүтэй хэрэглэж байна. Аавыгаа өөд болсноос хойш хэрэглэж байна уу ?**

**Ца:** Би энэ аавыг өнгөрснөөс хойш хэрэглэж л байсан. Харин сүүл үед нэлээн хийж байна. Би ч бас төрийн алба хашиж байсан хүн л дээ тэгээд хүмүүс бас нэлээн таньдаг. Тийм болохоор хүмүүс энэ хүн ийм юм хийдэг гээд мэддэг болсон. Хүмүүс таньдаг мэддэг болохоор нэг нэгнээсээ мэдээд л нөгөө багийн дарга байсан хүн ийм юм хийдэг юм байна шүү дээ гээд. Ийм хүн эдгэсэн байна гээд. Эдгэсэн хүмүүс өө тэр хүн дээр оч гээд тэгдэг юм байна лээ.

**Зу:** Мэдээч өвчин зовлонтой хүмүүс шууд анх гарахад нь ирж байна уу эсвэл бүр эмнэлгээр яваад л болохоо больсон хойно нь ирж байна уу ?

**Ца:** Зарим нь энэ хар домын л аргаар эдгэдэг гээд мэддэг хүмүүс шууд гараад л бол ирдэг. Ирээд л нэг цахиулаад эдгээд явлаг хүмүүс байна. Зарим нэг эмнэлгээр яваад хүндрүүлээд ирдэг хүмүүс байна тэр хүмүүс бол олон цахиулна. Тэрнээс биш тэр эхэндээ их амархан.

**Зу:** Одоо энэ танай удмын хувьд өвлөн уламжилж байгаа чухал зүйл. Харин энийг өвлөн уламжлахад танд яг ямар мэдрэмж төрж байсан бэ ? Зарим нэг хүний хувьд бол айж сандрах чадах болов уу гэсэн эмээлт байсан уу мөн дээрээс нь мэдээж хүний шархтай харьцана тэр үед ямар нэг асуудлууд байдаг уу ?

**Ца:** Ер нь энийг миний аав ер нь бол айж сандрах юм байхгүй ингэх болов уу тэгэх болов уу ядах болов уу гэж айх юм байхгүй энийг бол нэлээн ширүүн зориг зүрхтэй өөртөө итгэлтэй дээрээс тусалдаг тангарагтай хүмүүс цасан цагаан ясан дээр байгаа ярыг цасан цагаан толбо үлдээхгүй гэсэн тийм тангарагтай. Тэр тангаргийн дагуу өөртөө итгэлтэй байх ёстой миний аав тэгж зааж өгсөн өөртөө итгэлтэй шившлэгээ хийгээд дууддаг юмаа дуудаад тэнгэр язгууртай өвөг дээдсээ дуудаад тэгэх ёстой.

**Зу:** Нэг яр шарх цахихад ямар хугацаа шаардагдаж зан үйл хийх вэ ?

**Ца:** Одоо нэг шархыг цахихад захаас нь үзүүлье одоо энд ингээд ийм хэт байна ийм цахиурын чулуу байна энэ хоёроор л зан үйл үйлдэнэ.

**Зу:** Энэ хоёр зүйлээр цахидаг ?

**Ца:** Тийм энэ хоёр зүйлээр цахидаг тэгээд шившлэг байна дээдсийн тангараг байна тэнгэрээс өвөг дээдсээ дуудна нэг ёсондоо сүнс дуудна гээд байдаг шүү дээ түүн шиг.

**Зу:** Энэ хэт цахиурууд яг 4 дүгээр үе дээрээ өвлөн уламглагдаж байгаа эд үү ? Та хүүдээ өвлүүлэхдээ өөрчилдөг ч юм уу эсвэл яг энэ хэвээр нь өвлүүлэх үү ?

**Ца:** Тэр өөрчилнө үү хамаагүй хамгийн гол нь энэ шившлэг онгод дууддаг тэнгэрээс дээдсээ дууддаг тэрийг заагаад өгчихөөр тэгээд болчихно өөр хүн заавал болохгүй. Зөвхөн тайж цагаан ястай тайж хүн.

**Зу:** Тэгэхээр ер нь ховор ?

**Ца:** Ховор одоо энэ янз бүрийн бурхан шашны ном заагаад тэр хүн уншаад явдаг шүү дээ. Энд бол тийм зүйл байхгүй энэ бол зөвхөн яс дагаж явна.

**Зу:** Одоо яг ингэж хийдэг хүн өөр бий юу танай ах дүү нараас өөр ?

**Ца:** Ер нь ховор манай аймагт бол Зүүн гол сумын нэг хүн ганц нэг хүн байдаг л юм байна лээ нэг л хүний сураг гардаг юм. Тэгэхдээ яг одоогоор бол би үндсэндээ дагнаж байна. Одоо хүмүүс цахиулна гээд цахилаа барилаа гээд тэгдэг юм. Тэгэхээр өөр үндэс ястай тийм хүн байхгүй. Өөр хүн дээр очиж цахиулаад хүндрээд над дээр ирдэг тийм тохиолдол байна.

**Зу: Одоо халх хүн цахиж байна гэвэл итгэж болохгүй юм байна буриад хүн цахиж байна гэвэл бас итгэхгүй юм байна.**

Ца: Тийм дөрвөд тайж язгуурт цагаан ястай тайж байхгүй баядын сумуудад бол ганц нэг байсан ч тайж дотроо өөр язгууртан тайж гэж байдаг шүү дээ тэрнээс биш зүгээр нэг тайж биш.

**Зу: Энэ маань их нарийн их хязгаарлагдмал их цөөн тооны одоо жишээлбэл та өвлөн уламжлахгүй үлдээвэл тасрах аюултай ?**

Ца: Одоо жишээ нь би хүүхдэдээ юу ч зааж өгөхгүй байвал тасраад явах магадлалтай байхгүй юу.

**Зу: Та хүүдээ өвлөн уламжлуулах талаар ярихад нэг их төвөгшөөхгүй юу ?**

Ца: Би хэлэхэд л болно л доо. Цаашдаа дараа дараачийн үйл ажиллагаа явахад нэг хүүхэд гараад ирчихсэн л байна л даа.

**Зу: Би одоо нэг зөвхөн Баяд угсаатнууд хийдэг хар домын арга гэж хэлж болно ?**

Ца: Тийм, болно.

**Зу: Баяд угсаатнууд хийдэг хамгийн том анагаах ухааны үйл баруун аймагт ер нь бөө гэж байдаг уу мөн хутагт хувилгаад их цөөтэй тэгэхээр миний хувьд бол би ийм хүнтэй анх удаа уулзаж байна. Бариац нартай үзмэрч нартай засал ном хийдэг олон хүнтэй уулзаж байна надад бол их сонирхолтой санагдаж байна. Тэгэхээр та сая нэг могойн яртай хүн ирсэн гэж хэлсэн тэр хүний шархыг бүгдээрээ хараад та домоо хийж үзүүлэх үү ?**

Ца: Үзүүлье энэ могойн яр бол өвчин нь их сонин байхгүй юу. Дотогшоо цахина гадагшаа цахина гэж байдаг. Янз бүрийн буруу үйлдэл хийгээд буруу хүнд очиж цахиулаад ламаар яваад эсвэл эм түрхээд ч юм уу дотогшоо цахина тэгэхээр 2,3 сар жилээр цахих асуудал гарна. Одоо болохоор энэ хүн бол эмнэлэгт хэвтсэн дотогшоо цахисан дотогшоо өвдөөд байгаа тийм хүн байхгүй юу. Тэгээд би энэ хүнийг дотогшоо цахиж байгааг эдгээхийн тулд одоо өнөөдөр нэг цахиад маргааш нөгөөдөр нэг цахиад дотогшоо хатгасан цахиа нь алга болно. Тийм болохоор энэ хүнийг авчирсан хоёрдугаарт шарх нь ийм гэж та нарт тийм зүйл үзүүлэх гэж тэгсэн юм.

**Зу: Одоо эхлээд ахтай танилцаад өвчнийх нь тухай асууя. Та өөрийгөө танилцуулбал ?**

Лха: Би Увс аймгийн Улаангом сумын 11 дүгээр багийн иргэн Лхагва гэдэг хүн байна. Одоо бол энэ 20-оод хоногийн өмнөөс гэнэт миний энэ талаас хатгаж өвдөөд тэгээд би бэртэл юм байна гэж анхандаа оношлоод бэртэл гээд бариачид ч очиж үзүүлээд тэгээд сүүлдээ цахиа болж хувираад цахиа гэдгийг мэдчихээд цахиулахгүй бол болдоггүй өвчин гээд эмнэлгээр яваад эмнэлэг бол цахиачаар цахиулахгүй бол эмнэлэг талаас эмчилгээ бага үрэвсэл талаасаа дарна эмчилгээ хийгдэхээс биш энийг бүрэн эдгээх юм байхгүй. Тэгээд одоо Цахиа гэдэг хүнээр цахиулаад ерөнхийдөө эдгэх тийшээ хандаад явж байгаа байдал энэ. Хүний бие тойрч гардаг эндээс эхэлсэн. Ингээд бүтэн тойроод эхэлсэн газраа ирээд нийлбэл амь насанд аюултай. Таны хувьд бараг 50 хувь тойрчихсон гэсэн үг үү ?

**Зу: Таны хувьд бараг 50 хувь тойрчихсон гэсэн үг үү ?**

Лха: Тийм 50 хувь тойрсон.

**Зу: Танд одоо ямар өвчний зовуурь байна ?**

Лха: Эхлээд энэ гарахаасаа устай тийм шарх маягийн товруутай юм эргээд гараад дотор өвдөлт бол маш өвдөнө. Устай шарх цахиулсны дараа хатаад хар хар юм унаад одоо уначхаад байгаа нь энэ. Бүгд ийм хар тав тогтоод унаад ингэж эдгэдэг юм байна.

**Зу: Анагаах бол таны энэ өвчнийг оношилж чадаж байна, эмчилж чадахгүй байна гэсэн үг үү ?**

Лха: Үрэвсэл өвчин л намдаадаг юм байна эм ууна диклоденк тариагаар хийдэг юм байна. Тэгээд эмч нар хэлдэг юм байна цахиулахгүй бол болохгүй гээд энэ бол домын өвчин. Анагаах талаасаа бол энийг ингээд эмчилчихнэ гэсэн юм байхгүй. Домнохоос нааш бол энэ бүтэхгүй.

Ца: Одоо дом хийж үзүүлэх үү ?

**Зу: Энийг ерөнхийдөө харуй бүрийд хийдэг үү ?**

Ца: Тийм харуй бүрийд.

**Зу: Лхагва ахын хувьд өөр хүнээр цахиулсан уу ?**

Лха: Өөр хүнээр цахиулаад одоо энэ хүн дээр ирж байна даа.

**Зу: Та өөрөө энэ өвчин гарах болсон шалтгааныг юу гэж бодож байна ?**

Лха: Би бол энийг хэлж мэдэхгүй байгаа юм. Эмч нар бол дархлаа муудахаар гардаг л гэж хэлсэн.

Ца: Хөшгөө хаачих. За одоо байна шүү дээ шарх нь бол ийм байна эндээс эхэлж гарсан гэж байгаа шүү дээ. Одоо энэ төгсгөлөөс нь сөргөн цахина. Дахиад буцаагаад ийшээ цахина. За боллоо иймэрхүү маягаар цахидаг.

**Зу: Таны үзэж байгаагаар Лхагва ах хэдэн улаа цахиулж эдгэх вэ ?**

Ца: Лхагва одоо өнөө маргааш цахиулаад эдгэнэ.

**Зу: Энэ шархны байдал эдгэх хугацаа хэдий вэ ?**

Ца: Энэ ингээд өвдөхөө болино тэгээд тэрнээс хойш шарх хатна усгүй болоод хатаад нэг долоо хоног арав хоногт шарх нь ховхорч унаад бүрэн эдгэнэ гэсэн үг.

**Зу: Одоо жишээлбэл бариачдын хувьд засдаг барьдаг ядардаг хүний өвчнийг авдаг. Цахих зан үйлийн хувьд тийм зүйл байгаа юу ?**

Ца: Тийм зүйл байхгүй эрт үед биедээ бардаад тэр чадахгүй бол би чадна гэсэн би энэ өвчнийг устгахгүй бол тэр устгахгүй гэсэн байртай өөртөө итгэлтэй тийм сэтгэл зүйтэй.

**Зу: Шившлэгийн хувьд өөр зүйл байна уу эсвэл нэг тогтсон зүйл байна уу ? Нууц биш бол хэлдэг ч юм уу дууддаг дуудлага хэлж болох уу ?**

Ца: Тэр өөрийн гэсэн хэллэгүүд байна өөр хүнд зааж болохгүй өв залгамжилсан болохоор тэр хүмүүс л мэдээд тэрүүгээр хэлдэг болохоор тэр дээдсээ дуудаж харьцана.

**Зу: Тэр шившлэг мэдэж байгаа ч гэсэн дээр өвөг дээдэс байхгүй бол болохгүй юм байна тийм үү ?**

Ца: Тийм би одоо ингээд цахиж байгаад байхгүй боллоо гэхэд надаас цаашаа надаас хойших хүүхдүүд надаар заалгалгүй үлдвэл тэгээд өнгөрч байгаа юм.

**Зу: Заалгаад таны хүү уучлаарай таныг өнгөрснөөс хойш таны хүү таныг онгод буулгаад таныг дуудаж болно гэсэн үг үү ?**

Ца: Тийм би 4,5 үеэ дуудаад миний хүү бол 5,6 үеэ дуудаж болно.

**Зу: Одоо төсөөллөөр ач хүү чинь 6,7 үеэ дуудаад цахихад тэр их хүчтэй болно гэсэн үг үү ?**

Ца: Тийм илүү хүчтэй болно.

**Зу: Магадгүй таны мэдэж байгаа үе чинь л 4 үе байгаа байх тэрнээс дээш маш олон үе байгаа байх тэд нарыг мэдэж байгаад тэд нарын сүнс ч гэдэг юм уу онгодтой холбогдоод цахихад илүү хүчирхэгжинэ гэсэн үг үү ?**

Ца: Тэгвэл илүү хүчирхэгжинэ гэсэн үг би одоо ингэсэн шүү дээ дуудаж цахидаг хүн. Чи намайг хэлсэн шүү дээ хэдэн үеэс эхэлж цахив гэж 1995 оноос эхлээд жаахан жаахан цахисан тэгээд одоо 2005 оноос илүү идэвхтэй хүмүүс намайг мэддэг болсон. Олон хүн намайг мэддэг болсон тул ирж цахиулдаг болсон. Идэвхжихээр улам хүчирхэгжинэ дуудахгүй байсан хүн нэг дуудаад хоёр дуудаад тэр хүмүүс чинь надад улам ойртоно тэр битгий хэл шууд эндээс харьцсан тохиолдол байгаа. 2016 оны намрын шинийн 15 тооноор бас тэгж мэдэгдсэн. Тэнгэрээс юм буусан жишээ би энд сууж байсан манай хүнд тэнд сууж байсан хонх дугарч байгаа юм шиг орж ирсэн би харсан тэгээд миний чих рүү орсон би яахаа мэдээгүй гэнэт ийшээ орсон энэ чихээр орсон энэ талын чихээр гарсан. Тэгээд би хүнд үзүүлсэн л дээ тэгсэн өвөг дээдэс таныг эргэж байдаг юм байна дуудахаар ойртдог юм байна гэсэн.

**Зу: Мэдээж энэ хүмүүс буян үйлдэж байгаа ч гэсэн зарим нэг талаар энэ хүмүүсийг өвчнөөс салгаж байгаа юм чинь зарим нэг сүсгээр ч гэдэг юм уу үнэ хөлс өгөх тохиолдол байдаг уу ?**

Ца: Тэр байна хүмүүс өөрсдийн сүсгээр л өгнө бага гэхгүй тариф тогтоохгүй. Би нэг жишээ ярья энэ буянт хорооллын нэг ядарсан ганц бие эмэгтэй хүн байлаа 50н хэдэн настай тэр хүн миний утсыг хүнээс олж авсан юм шиг байна лээ. Тэр надад цахиач гарлаа бие муудлаа гэсэн байхгүй юу тэгээд л одоо яах вэ ийшээ явах боломж байна уу эсвэл чи хүрээд ирэх үү гэсэн тэр хүн та хүрээд ирээч гээд ямар хүн байдаг юм болоо гэж бодоод би өөрийн машинаар өвөл цаг байсан очлоо хашаа заалгаад очлоо. Очсон нэг хөнжил нөмөрсөн хүн байна жижиг муу хар гэртэй тэр хүнийг би юу хийдэг юм гэсэн группэд байдаг гэсэн. Тэгээд харваас ядарсан би хувцсаа тайл шархаа харуул гээд үзээд цахиж өгсөн. Тэгээд би гараад явах гэсэн би танд групп буухаар мөнгө өгье гэсэн. Тэгээд би зүгээр гэсэн хэд хоногоос дахиад цахиж өгье надад чиний өвчин л эдгэж байвал болно гэсэн.

**Зу: Энэ зүйлийг бид зөвхөн энэ монголчуудын зүйл юмаа гээд бүртгүүлэх боломжтой юу ?**

Ца: Боломжтой энэ өөр хаана ч байхгүй Монгол дотроо ховор ховордсон мал амьтан л гэдэг шиг. Тийм учраас би энийг цаашаа өвлүүлэе гэсэн бодолтой байна.

**Зу: Та соёлын өвийн үндэсний төвд хэдэн онд бүртгүүлсэн бэ ?**

Ца: Би ер нь өнөө жил бүртгүүлсэн судалгаа ирээд.

**Зу: Соёлын өвийн өвлөн уламжлагч бол таны хэлснээр үе дамжаад явдаг тэр хүн шүү гээд ам дамжаад явдаг. Сүүл үед бол бөө бариац сошиалаар өөрсдийгөө рекламдаад байдаг болсон та энэ тухай юу гэж боддог вэ ?**

Ца: Чи бол энэ тухай зөв ярилаа би бол ингэж бодож байна тийм их хүмүүсийн өргөл барьц аваад тариф тогтоох бодол надад алга хүмүүсийг өвчин зовлонгоос нь салгая ажил амьдралд нь тус больё гэсэн үүднээс л байдаг хүн л дээ. Би нэг юм байгуулаад өөртөө хэргэм зэрэг өгөөд тамга тэмдэг аваад тийм зүйл надад хэрэггүй. Би зөвхөн хүмүүст тусалъя гэсэн бодолтой. Би бол реклам гэхээс илүү надад итгээд анхан шатанд нь хүмүүсийг эдгээе гэсэн бодолтой би бас өөрийгөө рекламдаад тийм хүн биш. Хүмүүс яах вэ буруу хүнд цахиулаад тос түрхээд сэдэрээгээд хүндрүүлээд янз янзын хүндрэл учруулахаас өмнө надад ирж өвчнөөс салаасай гэж хүсдэг. Тэгээд яах вэ тэр ажлын байр гэж би одоо өндөр настай хүн залуу байсан бол би бас боддог байсан байхгүй юу эмнэлгийн харшлын тасагт тийм орон тоо гаргаад тэнд би очоод

цагаар ажиллаад шарх үзүүлэхээр ирсэн хүнийг буруу хүн дээр очиж байхаар чаддаг мэддэг хүн байгаад боломжтой юм болов уу л гэж боддог.

**Зу: Нөгөө хүний хувьд ч тэр хүний хувьд ч байх юм бол илүү амар тэгэхээр ер нь уламжлалт анагаах ухаан болоод орчин үеийн анагаах ухаан зарим нэг зүйл дээр хосолбол ?**

Ца: Тийм зарим нэг зүйл дээр хослуулбал зүгээр тэр түрээс би ч юм уу нэг хүн төрийн үйлчилгээний хөөрхөн цалин аваад тэр хүнээс барьц авахгүй тийм ээ. Би бол одоо тэдэн төгрөг гээд барьц шахахгүй хүмүүс сэтгэлээсээ 5, 3 төгрөг өгөхөөр тэрийг авна. Тэрнээс биш би их байна бага байна гээд хэлэхгүй шүү дээ.

**Зу: Сүүл үед ийм хандлага байна орчин үеийн анагаах ухаанд эмч үнэмлэхтэй эрхтэй байна л даа гэтэл үзмэрч бариач дом засалч гэдэг юм уу зүү төөнүүр өөрсдөө хийдэг ийм сүрхий хүмүүс байдаг. Энэ хүмүүс өөрсдийгөө яаж батлах юм ч гэдэг юм уу ийм зүйл гараад байдаг.**

Ца: Би бол олон жил ажиллаж байна тэгээд хэргэм зэрэг авах хүсэлгүй хүнд тусалъя л гэж боддог.

**Зу: Зөвхөн одоо цахихаас гадна танай нутаг орны онцлогтой домын аргууд байна уу ?**

Ца: Одоо жишээлбэл энэ зэс аяга халбага айргийн тос зэсийг ногооруулж бага зэргийн тарни хэлнэ. Би бол номтой хүн биш ойр зуурын тарни мэддэг хүн. Энэ бол одоо үлд гэж байдаг үлдэнд их сайн энийг ногооруулаад энэ үхрийн айргийн шар тос.

**Зу: Энэ аргыг та яаж сурсан бэ ?**

Ца: Судалж хуучны хүмүүсээс авсан ном аймаг аймгаар янз бүрийн хүмүүс байдаг шүү дээ хуучны том бичгээр бичсэн зүйл байдаг тэрнээс судалсан. Жил болж байна усан шарх эдгээнэ хуурай шарх эдгээхгүй гэж байснаас туршиж байна.

**Зу: Зарим нэг зүйлийг хөгжүүлж байна ? Үр дүн хэр вэ ?**

Ца: Тийм хөгжүүлж байна энэ хоёр хоёулаа сайн.

**Зу: Цахих бол яахав угаасаа таны удам угсаанд байна. Нөгөөдөх маань бол та өөрөө судалсан ?**

Ца: Тийм судалж байна зарим хүмүүст шилэн саванд хийгээд хүмүүст төлбөр байхгүй өгөөд явуулдаг юм энийг аваачаад хүүхдэдээ түрэхээрээ гээд. Ноднин намар нэг хөгшин над дээр ирж цахиулсан байхгүй юу эдгээж байсан чинь хүүхэд дагуулсан хүн орж ирлээ энэ шарх цахиж болдог юм уу гээд үзүүлсэн чинь идээтэй. Тэгээд би намайг хүргэж өгсөн машинд шилэнд энэнээс хийгээд очоод түрх гэсэн эдгэсэн байна лээ.

**Зу: Хар домын энэ аргыг та хаанаас үүсэлтэй гэж бодож байна бөөгөөс үүсэлтэй мэдээж өөр байна шарын шашнаас мэдээж хол байна. Танай тайж угсаатны хүмүүс бол энэ зүйлээр мэргэшсэн хүмүүс байсан юм болов уу энэ тухай би жаахан дэлгэрүүлж асуумаар байна ?**

Ца: Энэ бол зөвхөн тайж удмын хүмүүс мэргэшсэн цагаан ястай зөвхөн цасан цагаан толбо тогтооно гэсэн тангарагтай тэр тангарагтай холбоотой бид нарын өвөг дээдэс бол бид нарыг хар махгал бурхантай холбоотой тэр бурханд даатгадаг.

**Зу: Тэр тангараг чухал зүйл байх нь байна шүү дээ ?**

Ца: Хамгийн чухал зүйл энэ устай шархыг хаа явсан газраа дарна гэсэн тангарагтай.

**Зу: Энэ 1995 онд энэ өвчин хэр их байв сүүл үед энэ өвчин олширч байна уу цөөрч байна уу гэдэг нэг асуудал байна ?**

Ца: Тэр үед арай гайгүй байсан. Сүүлийн үед бас ихдэж байна.

**Зу: Ихдэж байгаагийн шалтгааныг та юу гэж бодож байна ?**

Ца: Тэр үеийнхийг бодоход хүмүүс одоо их хүнтэй уулздаг болсон хөлийн газар их явдаг янз бүрийн юм идэж уудаг бузартана аливаа юмнаас 3, 4 сараас ихдэн. Одоо бас янз бүрийн халдварт өвчин их гарч байна энийг дагаж гарч байна. Ер нь миний өвөг дээдэс л тангараг өргөсөн байгаа тэр тангараг л яваад байгаа.

**Зу: Тангаргаас няцах боломжгүй ?**

Ца: Боломжгүй.

**Зу: Одоо жишээ нь бөөгийн онгод гээд онгодтой хүн авахгүй бол бөөгийн хорлол шиг зүйл ирдэг тэгтэл одоо ийм тангарагтай хүн байж ийм арга зүйг мэдэхгүйгээс болоод мэдсэн ч гэсэндээ өвлөж авахыг хүсэхгүй бол өөр нэгэн сөрөг зүйл байдаг болов уу ?**

Ца: Энд бол сөрөг зүйл байхгүй ер нь цагаан ясны хүн бол заавал энийг өвлөж залгамжлуулж өгдөг нэгэндээ. Бид нар их сонин хүмүүс нар марандаа залбирч байдаг гэтэл манай аав бол шөнө залбирдаг байсан. Од яраагаад гарсан байдаг тэр үед залбирдаг байсан.

**Зу: Тэр юутай холбоотой бол ?**

Ца: Тэр тэнгэр язгууртай болохоор од мичдэд залбирдаг дээр хүмүүс байгаа болохоор тэгж байна. Одоо бид нарт янз бүрийн юм байж л байсан юм л даа одоо тэр манай нэг ах 25 настай өнгөрсөн тэгэхэд бас хүнд үзүүлээд бид нарыг тэнгэр язгуурт улс гэж үздэг. Бид нарын төрөл их сонин би одоо өөд болбол буцаад тийшээ явна гэж ойлгодог. Тэгээд энэ хүн 25 настай өнгөрөөд яасан гээд тэгсэн үзүүлсэн чинь энэ хүн тэнгэрийн зүүд байж гэсэн. Бид нар тэр дээр байгаа хүмүүстэй харьцдаг тэгсэн тэр хүн болохоор тэнгэрээс зүүдэлсэн зүүд байсан тэгээд буцсан 25 настайдаа ингэж буусан. Одоо ер нь бид нар тэнгэрт л залбирдаг. Од гараад яраагаад ирэхээр залбирдаг.

**Зу: Миний хувьд энэ хар домын аргаар эмчилгээ хийж байгаа хүнтэй анх удаа уулзлаа мэдэхгүй зүйл маш олон байна. Бусад зүйлүүд бол нэлээн сайн уншиж судалсан болохоор гайгүй асуусан байх гэж бодож байна. Магадгүй би танаас асууж чадаагүй чухал зүйл байгаа бол тэрийг та ярьж өгвөл ?**

Ца: Энэ цахиулж байгаа хүн барьдаг дэглэм байгаа. Сонгино саримстай хоол идэхгүй байх ёстой. Тэгсэн зарим хүн цагаан сар болж байна гээд бууз идээд тэр нь сэдрээд дахиад цахиулдаг байхгүй юу. Цахиж байгаа үед артерийн чернилийн ягаан тэрийг түрхэж болохгүй химийн гаралтай юм түрхэж болохгүй. Анагаахын хүмүүс ч өөрсдөө мэдэхгүй манай талаас байхгүй гэж ярьж байгаа биз дээ.

**Зу: Одоохондоо бол орчин үеийн анагаах ухаан энийг эмчилж чадахгүй гээд хүлээн зөвшөөрсөн ?**

Ца: Зөвшөөрсөн зөвхөн домоор эдгэдэг гээд. Ер нь сүүл үед хар домын аргыг хослуулдаг болсон эмнэлэгт очихоор хэлж байгаа шүү дээ дом хийлгэхгүй бол болдоггүй юм өө манайхаас бол яахав өвчин намдаах ч гэдэг юм уу тийм болсон байгаа.

**Зу: Мэдээж Лхагва ахын хувьд эмнэлэгт хэвтэхэд мэдээж төлбөр гарна эм антибиотик гээд энэний оронд эртхэн дээр нь ирээд цахиулах юм бол цаг хугацаа мөнгө санхүү гээд олон зүйлийг хэмнээд найдвартай эмчлэх боломж байсан байна.**

Ца: Тийм.

**Зу: Тэгэхээр одоо бид нар уламжлалт анагаах ухааны аргыг таниулах цаг нь болсон уу ?**



Ца: Цаг нь болсон.

**Зу: Мэдэхгүйдээ өвчинд шаналаад байгаа хүмүүс байгаа шүү дээ ?**

Ца: Зарим хүмүүс бүр амь насанд хүрч байгаа ч хүн байна. Нэг хүн цахиац гараад тос түрхээд бүх биеэр нь түгчихсэн хүүхдүүд нь аваачаад рашаанаар шавраар эмчилнэ гээд тэгээд хүндрээд тэр хүн нас барчихлаа шүү дээ. Тэр хүн над дээр ирээд уулзсан бол тэр хүнийг амархан эдгээчих боломж байсан. Би нэг өөрийгөө рекламдаж байгаа биш хүмүүс нэг их хүндрүүлэлгүй над дээр ирээд цаг алдалгүй юмаа хийлгээд аваасай л гэж бодож байдаг хүндээ.

**Зу: Дахиад нэг зүйл энэ өвчин маань зөвхөн хэвлий тойрч гардаг уу эсвэл гарын бугуй тойроод гарах боломжтой юу ?**

Ца: Чи маш зөв асуулт тавилаа одоо энэ хүний гэдсээр гарсан байгаа биз зарим хүний суга тойрч зарим хүний толгой тойрч гарна ам тойрч гарна.

**Зу: Одоо жишээ нь миний бугуйг тойрвол энэ маш богино хугацаа шүү дээ. Богино тойрвол аюултай ?**

Ца: Тийм гэхдээ хэвлий тойроод гарахад хугацаа удаж магадгүй ч зүрх тойрвол аюултай хүмүүс зүрх өвдөж байна гээд буруу эмчилгээ хийдэг байхгүй юу. Тэгээд зарим эмч нар мэднэ зарим нь мэдэхгүй. Зарим нь тэгж байна зүрхний эмчилгээ хийлгэх үү гэдэг би тос түрхэж болохгүй цахиулсны дараа зүрх чинь өвдөхөө болино гэж хэлдэг юм. Тийм учраас зүрх байна уу цахиулаад л алга болно тийм учир санаа зовох хэрэггүй.

**Зу: Таны цахиж байсан эвгүй гэдэг юм уу хэцүү газар ямар газар ямар газар байсан бэ ?**

Ца: Чи маш гоё оновчтой ярилаа би тэрийг нэг залуу байдаг цагаан махан дээр нь тойроод гарсан тэр хүн босож чадахгүй хэвтчихсэн тийм байсан тэгээд би гурав цахиад юу ч үгүй болсон. Ээж нь бөгсийг нь татаад би цахисан тийм тохиолдол гарсан. 20 хэдтэй ээжтэйгээ байдаг тийм залуу. Эмэгтэй хүний эрхтний дотор гарсан тэр хүн орон дээр зогсоогоороо сууж чаддаггүй хэвтэж чаддаггүй тийм байсан. Тэр хүн тэгээд хот руу эмчилгээнд явна гээд энэ бараг эмэгтэйчүүдийн юм гээд тэгчихсэн байсан би тэгээд цахиад наа чинь цагаач байна гээд би гурав цахиад эдгээж өгсөн. Одоо надад их сайн намайг эдгээж өгсөн гээд нөхөр нь өөрөө их сайн. Тийм айхтар газар гарна хүний нүд ам тойрч гарна.

**Зу: Энэ цахиац гэдэг өвчнийг мэдэх ямар арга байна хамгийн түрүүнд андуурахгүйгээр ?**

Ца: Хамгийн эхлээд мэддэг арга шарх туурч гарч ирнэ тэгэнгүүт барзгар устай юм гардаг байхгүй юу энэ хүнийх тийм байсан л даа.

**Зу: Лхагва ах анх энийг юу гэж бодсон бэ ?**

Лха: Анх энийг би хавирга гэмтчихлээ гэж бодсон байхгүй юу. Гараагүй байхдаа өвдөөд тэгээд хавирга гэмтчихлээ гээд бариачид очсон бариач тэгээд хэд бариулж байтал өөрөө гараад ирж байгаа юм. Тэгсэн ангийн найз хараад цахиац байна гэж хэлсэн.

Ца: Гарахаас өмнө өвдөлт мэдэрнэ. Бид нарт бол гардаггүй өвдөлт мэдэрнэ эхлээд шүүрүүлдэж байгаа юм шиг өвдөнө тэгтэл гараад ирнэ. Туураагүй үед бол бэртэл гэмтэл байна гэж боддог.

**Зу: Туураагүй байхад нь цахиж болох уу ?**

Ца: Болно. Гэхдээ туураагүй байхад нь мэдэхгүй байгаа юм чинь одоо жишээлбэл энэ хүний хамаатан садан өвдлөө гэхэд энэ хүн тэгж өвдөж байна уу гэж асуугаад аваад ирж болно. Туураагүй байхад нь цахихаар гараад ирдэг гадагшилж байна цахиад биед нь хүргэж домноно

шившлэгтээ тэгээд цахиад ирэхээр тэр гадагшлаад ирдэг байхгүй юу. Хүний арьс ийм зузаан байна гэж бодъё тэгээд гадна талд туурсан байна тэгээд энэ янз бүрийн буруу үйлдэл хийгээд сэдрээвэл дотогшоо энэ талдаа гарна. Нэг ёсондоо хананы хоёр талд тэгээд энэ чинь яс руу бие рүү хатгаж өвддөг байхгүй юу. Их аюултай.

**Зу: Их сонирхолтой байлаа.**

Ца: Чи бас их сонирхолтой асуулт асуулаа миний мартсан зүйлсийг сануулж яриуллаа.

**Зу: Та энэ жил хэдэн нас хүрч байгаа билээ.**

Ца: 63 нас хүрч байна.

**Зу: Ер нь ингээд соёлын өвийн уламжлагчид хамгийн бага байдаг нь тэгээд заримдаа их байна гээд бүртгүүлсэн байдаг бид зориод очихоор заримдаа хулхи байна үнэндээ тэр нутаг оронд байхгүй бол байхгүй чигээр нь бичихгүй заавал байлгах гээд жаахан барьдаг гартаа юмтай гэдэг ийм хүмүүс дээр оруулчихаар яах вэ зарим сайн хүн байна хугарсан яс барьдаг хүмүүс байна заримдаа бол хэцүү.**

Ца: Миний энийг ч бас хулхи хүмүүс байна. Би өөрийгөө рекламдахгүй л тэгээд байна гэтэл заримдаа урагшаа гараад хүмүүст үнэн шударгаар үйлчлэх хэрэг байна шүү дээ. Би тэр талаасаа сүүл үед би халтуур хийж мөнгө олох гол биш үнэн голоосоо хүмүүст тус больё л гэж боддог.

**Зу: Миний анзаарсан нэг зүйл бол угаасаа эрдэм чадалтай хүн бол даруухан байх юм. Зарим хүн бол таны хэлсэн тангараг зүйлс байх нь байх юм байна зарим хүмүүс бол энэ насандаа элбэг сайхан амьдарсан ч дараа хойчдоо хэцүү байдаг юм гэсэн зүйл олон хүн ярьсан. Угаасаа хүний өвчин зовлонгоор мөнгө төгрөг хийнэ гэж байдаггүй юмаа л гэж ярьсан. Би хүн судлаач мэргэжилтэй 21 аймгийн бүх л сонин содон хүмүүстэй ярилаа тэгэхэд энэ ярилцлага их сонирхолтой боллоо. Би одоо энийг бичээд хүмүүс унших ёстой энэ бол зүгээр нэг мэдээ биш пост биш. Энэ бол цэвэр эрдэм шинжилгээ 100 хувь үнэн тэгэхээр би энэ ярилцлагаас авч ашиглах бол заавал таны нэр усыг дурдана.**

Ца: Намайг тавьж болно, жишээ нь Улаанбаатарт нэг зовлон туссан хүн байж болно шүү дээ тэр хүн намайг дуудаж болно. Би Польшоос хүн ирээд эдгэсэн гэж хэлсэн байх. Би бас энэ хүмүүст хэрэг болог өөрийгөө бас сорьё. Чи бас их зөв хүн дээр ирсэн. Батбаатар гээд хүн байна шүү дээ тэр хүн өөрөө над дээр эмчилгээ хийлгээд эдгэсэн хүн. Тэр хүн өөрөө тийм хүн тул намайг онцолж хэлсэн байхгүй юу. Би саяхнаас ингэж судалгаанд орж байгаа юм. Би урд нь ингэж судалгаанд орж байгаагүй бидний энэ уламжлал бол урд нь хүн судалж байгаагүй хүн ирж ярилцаж байгаагүй байхгүй юу. Чи их зөв хүн дээр ирлээ. Та худал хүнтэй таарсан бол тэгээд худлаа үнэн юм ярина шүү дээ.

Ца: Зөв зөв ахтайгаа хийсэн ярилцлага их таалагдав уу ?

**Зу: Их таалагдлаа, сайхан боллоо бараг 1 цаг 20 минут боллоо.**

Увс аймаг Ховд сум Назгүл

На: Назгүл гэдэг би Увс аймгийн эрүүл мэндийн даргаар 15 дахь жилээ ажиллаж байна би төгссөн мэргэжил гэвэл Анагаах ухааны их сургуулийн эмчилгээний ангийг 1994 онд хүний их эмч мэргэжлээр төгссөн. Түүнээс хойш би олон жил Улаанбаатар хотын өрхийн эмнэлгүүдээр мөн Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт мөн

Баян-Өлгий аймгийн Сансар клиникт зүүний их эмчээр 10 жил гаруй ажилласан. Сүүлийн 15 жил бол Увс аймгийн эрүүл мэндийн төвийн даргаар ажиллаж байна. Энэ ажилласан хугацаанд дан ганц эрүүл мэндийн дарга хийхээс гадна манайд гарцаагүй шаардлагатай байгаа захын мэдрэлийн саа саажилт мэдрэлийн гаралтай өвчинд өөрийн мэдсэнийг европын эмчилгээтэй хослуулаад уламжлалт анагаах ухааны аргыг хослуулж хэрэглэж нэлээн их үр дүнд хүрч байгаа. Энэ юу вэ гэхээр би өөрөө 1994 онд Анагаах ухааны дээд сургуулийн эмчилгээний ангиар төгсөж ирчхээд 1995 онд БНХАУ-ын ӨМӨЗО-д зүү төөнүүрийн чиглэлээр нарийн мэргэшээд ирсэн байгаа. Тэр мэргэжлээ бас европ эмчилгээтэй хослуулаад нэлээд үр дүнд хүрч байна гэж үзэж байна. За манай суманд гэхэд тэр баргийн өвчтөнүүдээ аймаг явуулахгүйгээр эндээ шаардлагатай захын мэдрэлийн үрэвсэлтэй зарим нэг саа саажилт өгсөн харвалт өгсөн ийм хүмүүсийгээ ч бас европ эмчилгээтэй хослуулаад эмийн эмчилгээний аргатайгаа уламжлалт анагаах ухааны аргатай хослуулж хэрэглэхэд маш их үр дүн өгч байна. Эмчилгээний дараах нөхөн сэргээлтийн арга маань маш их хурдан явагдаж байна. Яагаад гэхээр зүү гэдэг эмчилгээ нь дорнын анагаах ухаан Хятадаас гаралтай ч гэсэн энийг бас бид Монголд түгээн дэлгэрүүлээд энэнийхээ бас үр шимийг сумынхаа ард түмэнд түгээж байгаа явдлыг би бас их сайшааж үзэж байгаа. Гарч байгаа үр дүн ч бас их сайн байгаа. Ардын эмчилгээ эхлэхээр дараа нь дууссаных нь дараа зүү эмчилгээ рүү аймаг руу явуулаад эмчлүүлэх шаардлагатай хүмүүс байдаг байсан бол цаг хугацаа алдахгүйгээр сумандаа бас маш том ололт амжилт гэж бодож байна. Энэ хугацаанд нэлээдгүй сурсан мэдсэнээ ааваасаа уламжилж авсан зүү төөнүүр зарим нэг ардын эмчилгээний аргууд хануур төөнүүр гэх ийм заслүүдыг бас хамтатгаж хийх энэ бол манай Монголын эртнээс уламжилж ирсэн ийм эмчилгээний аргууд гэж боддог. Зөвхөн хануур төөнө хийхээс гадна бас судас судлаар хануур хийх аргууд бас байдаг тэд нарыгаа ч бас тэгэхээр яг өвчин өвчиндөө тааруулаад бас ийм эмчилгээнүүдийг хийж байгаа. Би ер нь ирснээс хойш харвалтаар өнгөрсөн хүн манай суманд бараг байхгүй гэж хэлж болно. Яг харвалт өгчхөөд эмийн эмчилгээ 10 хоног хийгээд яг тэрэндээ зэрэгцүүлээд хануур төөнүүр хийгээд уламжлалт анагаах ухаантайгаа зэрэгцүүлээд гарч байгаа үр дүн бол маш сайн. Ерөөсөө 2 курс эмчилгээ яваад л тэр хүн маш сайн сэргээд л босоод ирдэг. Дан ганц зүгээр зүү тавихгүй зүүтэй хослуулна яагаад гэхээр зүү эмчилгээтэй хамт бариа заслыг нь хамт 3 сарын курс сурсан яг манай уламжлалт анагаах ухаанд Монголын хийж байгаа бариа засал Хятадын бариа заслын эмчилгээ бас маш ойролцоо байдаг. Би яагаад ингэж бодож байна вэ гэхээр 3 сарын бариа заслын курст сурч байхдаа тан эмчилгээ хэрэглэж үзсэн. Тэр Хятадын эмч нараас бас суралцсан. Тэр бас маш үр дүнтэй байдаг юм байна лээ манайх энэ хий бадган шар гээд Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглээд байгаа энэ тангууд чинь европ эмүүдтэй хослуулж хэрэглээд байхад ямар ч харшлаад байх зүйл байхгүй. Харин ч бүр манай анагаах ухааны шинжлэх ухаанд ер нь эмийн эмчилгээ гаргахдаа европ эмийн эмчилгээний аргыг хослуулаад хэрэглэвэл илүү их үр дүнд хүрдэг гэдэг нь яг батлагдаж байна. Одоо өөрөө ч гэсэн амьдралдаа хэрэглэж үзсэн ариун

туршлагаас хараад үзэхэд маш олон хүнийг эмчилсэн. Би одоо 2473 хүн байсан би яг өөрийнхөө бүх эмчилгээ хийсэн хүмүүстээ судалгаа хийж үзэхэд дан ганц манай Ховд сумаас хүн эмчлүүлдэггүй манай 18 сумаас гэхэд л зарим нь ингээд судалж ирээд өөрсдөө ийм эмчилгээ хийлгэх гэсэн би танаар эмчлүүлье гээд хүмүүс ирдэг тийм учраас би аль болох өөрийн сурсан чадсан мэдсэн бүхнээ өөрөөсөө хүн болгонд хийж жаахан ч гэсэн буян үйлдэх юм сан гэсэн бодолтой байгаа. Тийм учраас бид эмийн эмчилгээтэйгээ европ эмчилгээ уламжлалт Монголынхоо анагаах ухааныг хослуульж хэрэглэвэл илүү их үр дүнд хүрч байна гэдгийг үүгээр баталж байна. Ковидын үед бас бид баахан эмийн эмчилгээ хийсэн. Тэгэхэд бол бид уламжлалт анагаах ухааны маш олон тангууд хэрэглээд байна тэр тангууд маш их үр дүнтэй байна. Энэ бас ор үндэсгүй биш бид шинжлэх ухаанаар батлагдсан зүйлээ хослуульж хэрэглээд яваад байвал маш их үр дүнтэй юм байна гэдгийг би ойлгосон.

**Зу: Таны хувьд бас анагаах ухааны сургуулийг төгссөн дээрээс нь бас БНХАУ-д уламжлалт дорнын анагаах ухааныг сураад бас мэргэжил дээшлүүлсэн тийм учраас танаас асуух нэг зүйл нь Монголчуудын уламжлалт арга ухаан энэ дундаас аль нь байх боломжтой вэ ? Ургамлаар анагаах мал, амьтнаар анагаах, зүү төөнүүр, хануур юм уу Монгол хүнд тохирсон гэдэг юм уу яг монголчуудынх байх боломжтой гэж таны үзэж байгаа тэр анагаах ухааны арга ухаан нь ямар арга ухаан бэ ?**

На: Ханах төөнөх талын юм л ер нь манай Монголын талын юм бусдаас түрүүлж хэрэглэж байсан юм болов уу гэж боддог. Ер нь тэгээд хараад байхад дээр үед ч гэсэн манай монголчууд энэ ханах төөнөх шившлэг дом засал хэрэглэгдэж л байсан байна лээ. Ер нь манай Монголын уламжлалт анагаах ухаан байсан юм болов уу гэж би бол тэгж бодож үзэж байгаа. Тийм учраас хэрэглээд ч гэсэн үр дүн гардаг маш их боломжийн арга ер нь бид цаашдаа энэ өв соёл уламжлалаа цаашаа гээхгүй ингээд нэг мэдсэн сурсан юмаа цаашаа түгээн дэлгэрүүлээд байвал цаашаа олон хүнд үр өгөөжөө өгөх болов уу гэж бодож байна.

**Зу: Бид нар өвлөн уламжлагч гээд хүмүүстээ уулзаад явахад бариач гээд хүмүүс байдаг тийм үү, бас хүн амьтанд ач буянаа өгч байгаа хүмүүс байдаг. Таны хувьд бол бас бариач заслаар сураад ирсэн тэр сурах явцад ямар ямар арга барил заадаг вэ ? Манай бариач гэдэг хүмүүс болохоор хэн нэгнээр заалгаагүй ч гэсэндээ гэрийг аргаар сурсан эсвэл удам дамжсан байдаг. Тэгээд тэр хүмүүсээс асуухаар би бол мэдэхгүй гэхдээ гартаа юмтай ч гэдэг юм уу гэсэн зүйл ярьдаг. Тэгэхээр бариач заслын курс ч юм уу юу зааж сургасан бэ ?**

На: Тэр бол бид нарт онолын талаас зааж сургадаг болохоор суваг судал гэж юм байдаг тэр болохоор бид тэр чиглэлийн дагуу суваг судал л барина гэсэн үг. Яг тэр одоо зарим нэг хувиас би сурсан ч гэдэг юм уу тийм хүмүүсийг би мэдэхгүй л даа. Миний зүгээс бол яг л тэр суваг судал 5 махбодын онолоор л тэгж тайлбарлаж тэр утгаар л сурсан болохоор ямарваа нэг өвчин чинь яг л яг суваг судлыг нь дарж барьж үзэх үү яг тэр

талаараа л явагддаг. Тэрнээс биш би энд нь барихаар зүгээр болдог гэсэн тийм ухаанаар арай болохгүй байх гэж бодож байна.

**Зу: Зарим нэг тийм хүмүүс байдаг шүү дээ тэгээд харахаар яг болгоод байдаг бас яс барьдаг толгой тархи барьдаг бөөр нуруу барьдаг хүмүүс байгаад байна энэ хүмүүсийн талаар таны бодол ?**

На: Би боддог юм хүний бие махбодыг анатомийн үүднээс авч үзлээ ч гэсэн тэр тодорхой хэмжээний цэг байршил суваг судал гэдэг юмыг эрдэмтэд судалж гаргасан юм л арай илүү дөхөм юм болов уу гэж боддог зүгээр нэг хар ухаанаар ч юм уу одоо энд нь бариад танд нь бариад одоо өө яаж гэнэ барьсан юм нь буруу бороолоод буруу эдгэх дахиад хагалгаанд орж байгаа хүмүүсийг үгүйсгэхгүй шүү дээ. Одоо тийм зарим нэг хүмүүс байгаа өвөөгөөсөө уламжилсан би ааваасаа уламжилсан гэдэг юм уу яг тэр маягаар цаашаа хийгээд өчнөөн олон хүмүүс цаашаа чирэгдэл хийгээд эрүүл мэндээрээ бие махбодоороо хохироод байгаа явдал бол байгаа. Зарим нэг хүмүүс түүгээрээ ашиг хонжоо олохын тулд ч юм уу тийм хүмүүс байгаа. Шинжлэх ухаан гэдэг зүйл угаасаа л үндэслэлтэй учраас яг л сурсан боловсорсон яг л мэргэжлийн хүмүүс илүү хийвэл илүү үр дүнд хүрэх болов уу гэсэн бодол байдаг.

**Зу: Тэгэхээр орчин үеийн анагаах ухаанд ч гэдэг юм уу тархи доргисон үед ямар арга хэмжээ авч байгаа вэ ?**

На: Тархи доргисон үед бас л бариа хийнэ манай монголчууд эрт дээр үеэсээ тэгж тархины доргилтыг гаргаж байсан аргууд бол бас байгаа. Бид нарт анагаахын ангид ч гэсэн бас энэ уламжлалтын бас хичээл ордог байсан. Яг одоо анх бид нарыг 1994 онд төгсөж байхад эмчилгээний ангид салаалаад уламжлалтын анги салаалаад яг нэг жил тэд нар бас суралцаад тэрнээс хойш 1995 оноос хойш уламжлалт анагаах ухааны анги гэж тусдаа гарч байсан юм. Бид нар бол зүгээр эмчилгээний ангиар төгсөөд л төгссөн хойноо уламжлалтын чиглэлээр зүү төөнүүр 1995 онд би Хятад руу явж байсан. Тэгэхээр одоо энэ манайхаас гараад Швейцар хүртэл гараад яг уламжлалтын чиглэлээр мундаг мундаг явж байгаа залуус бол байгаа. Яг энэ малын эд эрхтнээр ясан эврээр хүртэл бумба хийгээд бүр тэр Швейцар улсад бүр хөөрхөн музей гаргаад уламжлалтын аргаар хануур төөнүүр яг энэ Монголын уламжлалт анагаах ухаанаар дагнаад явсан алдартай эмч нар бол зөндөө байгаа. Тэгээд бодохоор ер нь их боломжийн арга гэж боддог яагаад гэхээр яагаад уламжлалт анагаах ухааныг европ эмчилгээтэй холиод хэрэглэж болохгүй гэж маш их үр дүнтэй болохоор болно шүү дээ. Харин ч одоо манай эрүүл мэндийн яамны баримталж байгаа бодлого бол эмийн эмчилгээ нэг талдаа эмчилж байгаа ч нөгөө талдаа хор ихээр хэрэглээд байх буруу гэж үзээд байгаа. Яагаад уламжлалт аргыг хэрэглээд байна гэхээр эмийн бус эмчилгээ гарах үр дүн маш хурдан байдаг. Тэгэхээр яагаад заавал эмийн эмчилгээ гээд байхгүйгээр уламжлалт анагаах ухаанаа маш сайн хөгжүүлбэл нэлээд амжилтад хүрнэ.

**Зу: Таны хувьд бол уламжлалт анагаах ухаанаар сурсан болохоор маш олон давуу тал байна л даа. Зарим газар ийм зүйл байхгүй тэгэхээр толгой доргих яс хугарсан үед сумын эмнэлгүүд ийм зохих арга хэмжээ авахгүй байгаа. Аймаг руу явуулдаг**

тэгэхээр зарим талаараа нөгөө бариач гэсэн хүмүүс хэрэг болдог. Тэгэхээр та түрүүн их сонирхолтой зүйл ярилаа суваг судал гэхээр тархи доргисон хүмүүсийг гартаа юмтай ч юм уу хүмүүс барьж мэдээд эмчлээд байдаг тэр тухай та юу гэж боддог вэ ? Тухайн хүмүүсээс асуухаар сайн тайлбарлаж чаддаггүй. Энэ гарт юм байна би мэдэхгүй ингээд аргалаад болдог гээд тийм юм ярьдаг. Тэгэхээр энэ ямар байдлаас тархи доргиод тэрийг яаж бариад хэвд нь оруулдаг тухай та мэргэжлийн хүний хувьд ярьж өгвөл ?

На: Тэр бол угаасаа хүний тархинд байгаа шингэн зүйл цалгиад хүний тархи байх ёстой хэмжээнээс хазайгаад тийм зүйл байгаа байхгүй юу тэгэхээр уламжлалт анагаах ухаан яг онолоор тайлбарлахаар бас нэг талдаа тэр хазайсан хэмжилтийг нь хийж байгаад яг аль талдаа хазайсан байна уу тэрүүгээр нь хазайлтыг нь засаж байна. Харын аргаар өөрсдөө бариад болдог юмаа гээд байгаа хүмүүс ямар аргаар бариад байгааг тайлбарлаж мэдэхгүй. Анагаах ухаанд чинь өөрөө тэр тал руугаа хазайсан байна энэ тал руугаа уртассан учраас ингэж хазайсан байна гээд яг тэр хэмжээсээр хэмжиж байж л тэр алт талдаа доргилт үүссэн байна гэдгээр хэмжиж гаргах боломжтой байгаа байхгүй юу.

**Зу: Одоо тэгээд хэмжчихлээ зүүн тийшээ баруун тийшээ гээд тэгэхэд тэр хүүхэд бөөлждөг ч юм уу гүйлгэдэг ч юм уу ингээд онош тогтоогоод ирлээ. Барих үйл явц нь яах вэ ?**

На: Ер нь тэр хаашаа хазайсан байна түүнийг нь ингэж доргилтыг нь засдаг юмаа гэж үзүүлбэл арай бас дөхөмтэй байх. Тэр чинь бол яг саяныхаа хэмжилтээ хийчхээд одоо аль тал руу цохиж байж хэвийн хазайсан юмаа хэвийн байдалд оруулах уу гэдэг байгаа л даа. Тэрнээс биш зүгээр ингээд цохичихлоор болдог юм гэж бас ярьж болохгүй.

**Зу: Та эрүүл мэндийн байгууллагад олон жил ажиллаж байгаа тэгэхээр хүндрэлтэй тал маш олон байгаа. Хүмүүс гэрийн хар бор домын арга ч гэдэг юм уу олон зүйлээр өөрийгөө эмчлэх гэж оролдчихоод болохоо байгаад ирвэл эмнэлэгт ханддаг. Тийм хүндрэлтэй талууд юу байдаг вэ ? Ирээд шууд арга хэмжээ авах байсныг ямар нэгэн арга хэрэглэхээд ирэх байдал байдаг уу ?**

На: Байдаг тийм тохиолдол зөндөө гардаг. Ард иргэд тийм лам сайн гэнэ гээд эмч рүү явахаасаа түрүүлээд өөрсдийн чиний хэлдгээр явчихаар хэзээ хойно хүндэрсэн үед эмч рүү явах үе зөндөө байдаг. Ер нь энийг би буруу гэж үздэг яагаад гэхээр шинжлэх ухаан хөгжихсөн одоо хэддүгээр зуун билээ тээ ? Хөгжилтэйгөө хөл нийлүүлээд алхах байтал ерөөсөө хуучин сэтгэлгээнээсээ салж чаддаггүй зүгээр нэг ламд очоод үлээлгэх юм уу эсвэл нэг засал хийлгэхэд болчихдог гэдэг байдлаар аргаар хүмүүс яваад байдаг. Одоо тийм биш тэгж явж болохгүй. Жишээ нь хөл нь хугарлаа гэхэд дор хаяж нэг рентгенд зураг авхуулаад тэгж байж л би лам руу явах уу эмч рүү явах уу гэдгээ шийднэ үү гэхээс түрүүлээд л хугарсныг нь мэдэхгүй цуурсныг нь ч мэдэхгүй булчих мах булгарсан байхыг ч мэдэхгүй шууд тэгээд л бариач дээр очоод явна гэдэг ерөөсөө байж болохгүй асуудал.

**Зу: Яг тэгэхээр үүний эсрэгээр орчин үеийн анагаах ухаан эмчлэхэд хүндрэлтэй зарим үе дээр аргыг нь олоогүй байхад зарим нэг зүйлийг хуучны тэр аргаар эмчилж байгаа тохиолдол бас байна тэрийг та юу гэж үзэж байгаа вэ ?**

На: Ер нь түүнийг бол аль болох шинжлэх ухаантай хослуулах нь зөв л гэж хэлэх гээд байна огт мэдэхгүй хүн хүнийхээ ч бараг бие мах бодийг сайн мэдэхгүй байж ер нь зүгээр хар бүдүүлгээр байна гэдгийг байж болохгүй л гэж үзэж байна. Тийм учраас аливаа зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй яг одоо анатоми шинжлэх ухааны үндэслэлтэй яг тэр юунд нь тааруулж эмчилгээ хийнэ үү гэхээс зүгээр нэг хийгээд байдаг юм байж болохгүй шүү дээ.

**Зу: Дорнын анагаах ухаанаас та зүү төөнүүр бариа гээд хослуулж байна эдгээр аргуудын Монгол хүнд тохирдог эсвэл хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь аль вэ ?**

На: Хануур төөнүүр л хамгийн их хэрэглэгдэж байна.

**Зу: Хануур төөнүүрийг ямар үед голчилж ашиглаж байна ?**

На: Ерөнхийдөө манайд болохоор маш их даралт ихсэлт цус их өтгөрч байна. Зарим нэг зүрх судасны эмгэгтэй хүмүүс байна. Венын судасны өргөлийн үед ч бид хануур төөнүүр хэрэглэж байна энэ бол илүү үр дүн гарч байгаа. Захын мэдрэлийн өвчнүүдэд бас ир хэрэглэдэг. Энэ бол их сайн үр дүн өгнө.

**Зу: Хануур төөнүүрийн хувьд та дэлгэрэнгүй шинжлэх ухааны талаас нь ярьж өгвөл ?**

На: Эрт дээр үеэс хэрэглэж ирсэн болохоор энэ бол маш их олон жилийн түүхтэй маш их үр дүн өгдөг. Цус шингэлэх эмчилгээ хийж байгаад цус ханахад бол тэр цус ерөөсөө дээшээ өгсөнө гэж огт байдаггүй. Тэр хануур бол тийм учраас бол зүү төөнүүрийг эмийн эмчилгээтэй дан ганц даралтын эм уугаад байх биш тийм ээ байнга цусаа шингэлж байгаад хануур төөнүүр хийлгэхэд илүүдэхгүй. Яагаад гэвэл нэгт цус даралтыг буулгаж өгнө хоёрт бол бүлэгнээд байгаа зүйлийг шингэрүүлж өгөх үйлчилгээтэй. Тэгэхээр хүний биед аль болох шингэн эргэлдээд байвал заавал харвалт өгөх шаардлагагүй гэж үздэг. Тийм учраас энэ хануур төөнүүрийн асуудал байнга хэрэглэхэд муу арга биш гэж үзээд байгаа би.

**Зу: Ханах бол нэг өөр төөнөх бол нэг өөр арга. Төөнөх аргын хувьд ч гэдэг юм уу ямар аргыг голчилж байна ?**

На: Төөнөх аргыг бол бид нар голдуу сахартай захын мэдрэлийн үрэвслүүдийн үед хэрэглэж байгаа. Тэр үед хэрэглээд байхад маш сайн үр дүн өгч байна. Захын мэдрэлийн саа саажилт нүүрний саа саажилт нуруу ууц бөөр өвддөггүй хүн гэж байхгүй одоо үед хөгшин залуу гэлтгүй 30-аас дээш насны хүмүүс ер нь даарч хөрсөнтэй холбоотой гэдэг юм уу маш их байгаа суудлын мэдрэлийн үрэвслүүдээс эхлүүлээд. Тийм эмчилгээний үед бол бид зүүтэйгээ хослуулаад хэрэглэнэ. Тэнд бол бид нэг их хүн мөнгө санхүү зарцуулаад байх шаардлагагүй төөнүүр бол. Тэгээд зүүтэй хослуулж хэрэглэхэд энэ маш үр дүнтэй арга. Тэгэхээр энэ аргыг хэрэглэхэд нэг их буруутахгүй болов уу гэж бодоод байгаа. Тэгээд ч ер нь үйлчилгээ нь ч гэсэн хурдан илэрч гардаг тэр хүндээ. Тэр утгаараа бол хамгийн боломжтой арга гэж үзээд байгаа.

**Зу: Одоо таны өвөө аав ч гэдэг юм уу тэр аргуудаас хэрэглэж байсан болов уу та тэр талаас хэлж өгөөч ?**

На: Байсан манай өвөө бол дандаа эмийн ургамал тангын аргаар эмчилдэг байсан. Өөрөө бол дандаа тийм харын аргаар хэрэглэдэг байсан. Яагаад би Монгол анагаах ухаан хануур төөнүүр монголын анагаах ухаан гэж бодоод байна вэ гэхээр одоо манай өвөөгийн үед гэхэд л харвалтаар хүн өөд болдоггүй байсан гэж ярьдаг байсан. Тэгэхээр дандаа бумба тавиад л хануураа хийгээд л энэ тэндээс нь хэлэн доороос нь цус ханадаг ч юм уу одоо бүр ингээд даралт нь 200 хүрсэн хүнийг толгойг нь боож аваад л шууд цус ханаад л бууруулдаг байсан гэсэн. Биднийг хүүхэд байхад аав ч гэсэн зүү төөнүүр бариа заслаар дагнадаг байсан. Тэр хүмүүсийн арга барил маш үр дүнтэй байсан болохоор би хүүхэд байхдаа эмч болохыг маш их хүсдэг байсан. Тухайн үед бол аав тэрийг өвөөгөөс сурчхаад миний ер нь бол энэ уламжлалт анагаах хэтийн маш сайн үр дүнд хүрнэ энэ бол шинээр дэлгэрч байгаа маш сайн үр дүнтэй аргууд одоо л манай Монголд нэвтэрч байгаа шүү гээд тэгээд л би яг тэрнээс сэдэл аваад анх 1996 онд анх 10 дугаар ангиа төгсөөд ерөөсөө л би эмч больё гэсэн бодол орж ирсэн тэгээд л эмч болсондоо. Анагаахын дээдээр төгсөөд Хятад улсад зүү төөнүүр заслаар сурья гээд зүүний талыг хослуулж хэрэглэсэн байгаа. Одоо би эмчилгээний анги төгсөөд дандаа европ аргаар эмчлээд байх биш уламжлалтын талын аргыг хослуул хэрэглээд байх үед үр дүн нь илүү нүдэнд харагдаад байгаа учраас би бас болбол эмчилгээний аргатай хослуулаад илүү үр дүнтэй гэдгийг туршиж үзээд үр дүн гарч байгаа учраас тэгж хандаж хэлмээр байна. Эмийн одоо байнга өдөр тутмын хэрэглээ шиг хэрэглэхээ болиод эмийн бус эмчилгээг илүү түлхүү хэрэглэвэл хүний биед ч гэсэн учруулах хор хөнөөл илүү бага ийм л зүйл хандаж хэлмээр байна.

**Зу: Та бол орчин үеийн анагаах ухаан хөгжсөн үед сурсан таны өвөөгийн хувьд бол нарийн аргуудыг хаанаас яаж сурав гэдэг сонирхолтой байна л даа.**

На: Өвөө маань бол Хятадын Шинжаан мужаас анх наашаа дөрвөөд орж ирсэн тийм хүн байна лээ. Тэр үедээ ч гэсэн Хятадын Шар ямар сүмбэ гээд байл уу тийм нутагт амьдарч байсан тэгээд 1939 оны үймээнээр анх Монгол руу наашаа дүрвэж орж ирсэн тийм хүн байсан. Өөрөө бол Орос хэлтэй тэр үед Хятадтай Оросууд их наймаа хийж тэмээгээр таваар зөөж наймаа хийдэг байсан. Тэгээд тэр үед өөрөө бас нээлттэй чөлөөтэй европ руу ч гардаг юм үзэж нүд тайлсан гэх үү дээ тийм хүн байсан байна лээ. Тэр үед их хаалттай байсан гэж аав маань ярьдаг. Хийж байсан ардын эмчилгээний аргаа ер нь нууцаар хийдэг байсан тэр үед ер нь тэгж ил хийж баригдвал их л төлбөр тавьдаг юм уу эсвэл яадаг ч байсан юм тэрийг нь мэдэхгүй байна. Тэгээд л аавд уламжлаад тэрийг нь ингэж хий тэгж хий гээд илүү үр дүнтэй гээд тэр арга барилыг зааж өгсөн юм шиг байна лээ. Би болохоор ааваасаа л тэр юмнуудыг эзэмшсэн. Манайд ч гэсэн заримдаа ходоодны хий хуралдах тийм зүйл байдаг. Түүнийг бол бид нар зүгээр нэг одоо татлага гэж хэлдэг тийм татлага хийхээр ходоод өвдөөд ходоодны хийтэй тавгүй байсан хүүхдүүд дорхноо зүгээр болдог тэгээд бодохлоор уламжлалт эмчилгээний арга маш сайн хүүхэд бол нүдэн дээр л сайжраад гурван өдөр л татаад



өгчихөд тэгээд сайжраад тэгдэг намайг энэ Ховд сумд ирээд ажиллахад би одоо 15 жил ажиллаж байна тэгэхэд тархины даралттай гэнэ чих нь өвдөж байна гэж хэлсэн гээд чихэнд нь тос тусаагаад байдаг ч юм уу тийм аргууд байгаад байдаг байсан одоо бол ерөөсөө больсон яагаад гэхээр уламжлалтын аргаар нөгөө хүүхдээ барьж өгөөд татлага хийгээд явуулна. Ерөөсөө гурван өдөр барихад л дорхноо нүдэн дээр засал аваад л ирдэг. Тэгэхлээр ер нь манайхан бүгд л мэдэж байгаа.

**Зу: Би сая буруу сонссон уу та сая савардах гэж арга ярьсан уу тэр одоо ямар арга болоод юунд ашигладаг арга вэ ?**

На: Одоо энэ савардах гэдэг чинь хүмүүс мээм нь ирлээ гээд тэгдэг шүү дээ Матриц өгөөд байдаг манай энэ шинжлэх ухааны нэршлээр тэрэнд бас дом хийж баавгайн савраар дом хийж байдаг тийм засал тэрийг бас манай өвөө хэрэглэдэг байсан гэж сонссон тухайн үед. Тэр чинь бас л нэг дом засал юм даа манай монголчуудын дунд хэрэглэгдэж байсан дом шившлэг анагаах ухааны талын л зүйл байсан байх.

**Зу: Би ер нь нэг зүйл сонирхож байна та бол Казак хүн би одоо олон угсаатны хүмүүстэй уулзаад явж байна тухайн газар орны байдал онцлогоос хамаараад тухайн газрын дом шившлэг арга өөр өөр байгаад байдаг. Тэгэхээр би хэдийгээр Баян- Өлгий аймагт очих ч гэсэн танаас нэг зүйл асуумаар байна Казак хүмүүсийн дунд түгээмэл хэрэглэгддэг ямар аргууд байдаг вэ ? Хэрхэн яаж одоо ?**

На: Хэрэглэдэг байсан бэ гэж үү?

**Зу: Тийм**

На: Тийм, Одоо манай Казак уламжлалтын эмчилгээнд Чиббэ гэж юм хэрэглэдэг. Одоо манай Монголд ширгэ гэж хэлээд байдаг байхгүй юу. Тийм, тэр арга нь болохоор одоо би бас л ааваасаа уламжлан авсан арга тэр чинь бол манай яг казахын уламжлалт юунд бас хэрэглэдэг ардын уламжлалт арга ухаанд.

**Зу: Тэрийг та дэлгэрүүлээд өгөөч ?**

На: Тэгээд тэр одоо саяны нөгөө миний хэлээд байдаг ходоодны хий гэдэг ч юм уу яг одоо энэ тархины даралттай хүүхдүүдэд болбол тэр ширгэ нөгөө юуг болохоор татлага

маягаар хэрэглэдэг нэг тийм хачин арга байдаг. Тийм одоо түүнийг болохоор дээр үед болохоороо хэдэн настай хүмүүс түүнийг хийдэг байсан гэж ярьдаг байсан аав маань. Тэгээд хэн гэлээ бас нэг тийм нэртэй хүнээс нууцаар өөрөө сурч авсан юм билээ аав маань тэгээд түүнийгээ болохоороо надад зааж өгсөн. Тэгээд би түүнийгээ хятадаас сурсан бариа засалтайгаа түүнийгээ бас хамт хэрэглэдэг.

**Зу: Тэрийг нууц биш бол та ямархуу зан үйл үйлдэх гэх үү ямархуу арга технологи хэрэглэж тэр ширгийг хийдэг бэ?**

На: Тэр нь болохоор бас их сонин хараад байхад бариа засалтай ойролцоо юм шиг мөртөө бас нэг өөр аргатай тэгээд тийм. Би ер нь боддог юм тэгээд тэр суваг судлалаас хойш хаашаа ч юм бас тийм юутай арга байдаг байхгүй юу хэрэглэдэг. Ер бол бариа заслын бас нэг төрөл юм болов уу гэж боддог тэгээд яг ямар арга механизмаар үйлчлээд эдгэрээд байгааг би гайхдаг тэгээд ерөөсөө л нэг гурван удаа

татахад маш дорхноо засал авчихдаг. Ямар ч гэдэс нь дүүрээд цардайгаад байгаа ходоодны хийтэй хүүхдүүд ёстой дорхноо зүгээр гурван удаа засал хийгээд яахад бол шууд эдгэрдэг.

**Зу: Тухайн заслыг яаж хийдэг вэ ?**

На: Тухайн заслыг харин би хэлээд байна шүү дээ яг бариа засал шиг тийм юутай.

**Зу: Би яг сайн мэдэхгүй учраас танаас яг, одоо жишээлбэл ширгийг бол харуй бүрий болсон цагт давс хэрэглэдэг ч юм уу ?**

На: Тэр болохоор ийм юутай. Би боддог юм зүгээр ингээд шинжлэх ухааны талаас нь бодоод үзэхээр ч гэсэн би одоо тэр ходоодны тэр хийг нь гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулж байж л тэгээд хийж байгаа тэр арга юм уу гэж бодоод байгаа юм.

Зу: Тэгэхээр гэдэс дээр нь бариа засал шиг юм хийгээд?

На: Тийм, бариа засал шиг юм хийчхээд тэгээд нуруу дээр нь татлага хийгээд байгаа байхгүй юу.

**Зу: Татлага хийхдээ нурууг яаж татах вэ гэдгийг би сонирхоод байгаа байхгүй юу?**

На: Тэр нь болохоор одоо яаж яамаар нь одоо яг хүн дээрээ хийж үзүүлбэл илүү бас дөхөмтэй гэхдээ би бас түүнийг нь одоо ингээд үгээр хэлэхэд бас яг тайлбарлаж чадахгүй байна л даа. Яг хийж байгаа арга барил нь болохоор яг л нэг бариа заслын аргатай яг адилхан юм шиг юутай. Тэгээд ингээд яг цагийн зүүний дагуу ингээд нөгөө нэг ёсондоо гэдэсний чинь одоо гүрвэлзэх хөдөлгөөнөөр бариагаа хийчхээд тэгчхээд татахаараа нуруу талаас нь татаад байгаа байхгүй юу хүнийг одоо ингээд доош нь харуулж хэвтүүлээд түрүүлгэ нь харуулж хэвтүүлчхээд тэгэхээрээ одоо тэр ямар онолоор яаж явагдаад байгаа юуг нь би сайн мэдэхгүй байна л даа. Яг би өөрөө нөгөө зүгээр одоо яг ингэж бариад ингэж одоо татаад гээд яг тэр аргаар нь заалгасан болохоос

тэр нь одоо ямар онолоор яаж хийгдсэнийг нь сайн мэдэхгүй байна тэгсэн мөртөө маш их үр дүнтэй арга. Тэр бол ерөөсөө

**Зу: Тэгэхээр яг таны энэ хэлсэн шиг яг ямар онол ямар үндсэн дээр суурилж үүссэн нь мэдэгдэхгүй ч үр дүн өгөөд байгаа энэ аргуудын би сонирхож явна.**

Тэгэхээрээ Казах түмний дунд дахиад энэ шиг ийм өөр арга байдаг ч юм уу эсвэл бид одоо өвдөг гарахаар өвдгөөрөө домноод зүгээр болгочихдог гэж үздэг бас мэдээж одоо түрүүний таны хэлсэн шиг савраар горьдоог нь гаргахын тулд ингээд олон янзаар домнодог шүү дээ. Одоо жишээлбэл, Казак хүн мэдээж одоо тэр горьдоог ч гэдэг юм уу шинжлэх ухааны хэллэгээр хөх нь хавдчихдаг энийг ямар байдлаар дом одоо үйлддэг бэ?

На: Харин саяных шиг би одоо хэлээд байна шүү дээ, баавгайн савраар ингээд самнаас хийж хэрэглэдэг юм тийм, тэгээд манай яг Казак үндэстний хувьд болохоор

**Зу: Баавгайн савар тэгэхээр бас хүн бүрд байна гэсэн үг үү эсвэл айл амьтнаас гуйж байна уу ?**

На: Үгүй, айл амьтнаас гуйж л байна тэгээд тэр чинь яг нөгөө тэр нөгөө дом хийдэг хүн нь л тэгж хэрэглэдэг юм байна лээ. Тэрнээс яг түгээмэл тэгж яахгүй. Тэгээд зарим эмчилгээнүүдийг хараад байхад ингээд тэмээний бүүр хуучин хөх хомоолоор эмчилдэг арга байна. Тэр чинь одоо манай Монголд ч гэсэн байдаг шүү дээ уламжлалт ангаах ухаанд бүр эрт дээр үеэс домносон. Одоо энэ нөгөө нэг мэдрэлийн суудлын өвчнүүдийн үед хэрэглэж болж байна захын мэдрэлийн өрөвслийн үед хэрэглэж болж байна. Би бүр тэр хятадад явж байхад бүр одоо би яг тэрийг өөрөө бүр яг нэг хүн дээр хэрэглэж үзсэн. Тэгсэн чинь бүр ингээд 10 хэдэн жил хэвтэрт орсон. Зүгээр ингээд явж байсан хүн шууд ингээд хэвтэрт орчлоо гээд. Тэгээд тэр хятадын бүр настай нэг бариа засалч хүн байсан л даа миний тэр суралцсан багш маань. Тэгээд тэр хүн өөрөө бүр нэг 5 жил оролдож байж энэ хүнийг би хөл дээр нь босгосон гээд. Бүр хятадын нэг ямар мужид билээ дээ очиж би нэг тэр хүмүүстэй бүр сургалт нь дуусаад тэд нар яасны дараагаар яг одоо би энэ хүнтэй ингэж 5 жил би уйгагүй явж байж энэ хүнийг хөл дээр нь босгосон гэсэн хүн дээр бүр тэр тэмээний бүүр тэр хуучин тэр хөх хомоолоор утаж одоо бүр ялз болгоод яг ингээд малын сэвс шиг болгоод бүр юу яадаг юм билээ. Тэр тогоонд ус нь ширгэтэл ингээд ус хийгээд чанаад байна чанаад байж хөх хомоолыг чинь бүүр ингээд ялз болгоод. Тэгээд тэр юунд нь ингээд бүтэн ингээд 24 цаг нөгөө хүнээ юу яачихдаг юм билээ. Тийм арга бол манай Монголд ч бас байдаг шүү дээ. Би бас түүнийг эхлээд гайхаж байсан байхгүй юу. Үгүй ээ зүгээр ингээд хомоолоор энэ хүн ингээд босчихлоо гэж үү гэж бодоод тэгсэн чинь тэр хүн ингээд бүр ингээд мэдрэлийн нуруу нугас нь суулт өгөөд ерөөсөө ингээд явж чадахаа байгаад бүр сүүлдээ

ингээд хэвтэрт орсон хүнийг одоо тэр багш маань эмчилсэн байгаа байхгүй юу. Зөвхөн тэр хүний хэрэглэсэн арга нь болохоороо ерөөсөө л хомоол ялз ингээд яагаад тэгээд бүтэн тэр хүнийгээ сэвсээр ороогоод бүтэн 24 цаг ерөөсөө тэгэхэд тэр хүний ясных нь хөлс гартал юу яадаг. Тэгж байж тэр хүний биед хуралдсан хүйтнийг нь тэгж хөөж байна гэж хэлж байсан байхгүй юу тэр үед тэр багш. Тэгээд би гайхаад одоо яах лээрээ тэгж босдог юм болоо гээд. Тэгээд тэр аргыг би сурч ирчхээд энд Монгол ирсний дараа Баян-Өлгийд Сансар клиник сувилалд ажиллаж байсан гэсэн шүү дээ яг тэр үедээ би ингээд бас нэг фригматизмээсээ болоод бүр яг ингээд хөлийн суулт өгөөд босож чадахаа байсан суумгаа хүн дээр хэрэглэж үзсэн байхгүй юу. Тэгсэн чинь тэр хүнийг яг 24 цаг сэвсэнд ороогоогүй л дээ. Яг 2 хөлийг нь ерөөсөө ийм кушетка бэлдээд л яг орны тэр шүршин дээр нь гялгар цаас тавьж байгаад түүн дээрээ сэвсээ тавиад 2 өвдгийг нь битүү ингээд хөнжлөөр ороогоод яг нэг 12 цаг болгоод босоход тэр

хүн ёстой бүр нэг аймар хөлрөөд бүр ёстой нэг жинхэнэ тэр ясны хөлс гэдэг нь яг тэгэхэд гарсан байх гэж боддог юм. Тэгээд ерөөсөө нөгөө араас нь шөл мөл бас их уулгадаг юм байна лээ. Тэр нөгөө манай багш хэлэхдээ яг тэгж хэлж байсан байхгүй юу яг шинэ гаргасан малын шөл яг тэр орноос нь босоогүй дээр нь өгвөл илүү үр

дүнтэй байдаг шүү гэж байсан тэгээд би яг тэр хүн дээр тэгж хэрэглэж үзэж байсан. Тэгэхэд бол маш сайн үр дүн өгсөн. Хүн тэгээд суугаа байснаа юм түшиж босдог болоод сүүлдээ таяг тулаад босож явдаг болсон. Тэр хүн маань хөл дээрээ боссон. Тэгээд яг сайн арга юм байна гэж бодсон тэгээд яг хөдөө гадаагаар явж байхдаа би боддог байхгүй юу одоо байгальд ямар ч хэрэгцээгүй хэвтэж байгаа биднээс ямар ч төсөв мөнгө шаардахгүй гарын доорх ийм юмыг яагаад ашиглаж болохгүй гэж одоо энэ хужир ч гэсэн хэрэглээд үе мөч нь өвддөг хүн хэрэглэдэг манай уламжлалт анагаах ухааны арга байна шүү дээ. Эсгийг хужиртай тогоонд бүтэн хийгээд халуун усанд дүрж аваад л эргээд тэр эсгийн хужраа хөлийг нь хучиж өгөөд тэр чинь бас халуун бигнүүр шиг болоод үений өвдөлтүүд нь намддаг тийм арга бас байна.

**Зу: Энэ бол цаад учиртаа төөнөх арга гэсэн үг ?**

На: Тийм, халуун жингээр төөнөж байгаа юм чинь тэгэхээр төөнө засал хануур эдгээр бүгд л ерөөсөө манай Монголд байсан л аргууд.

**Зу: Монголын төөнөх болон Хятадын төөнөх аргын ялгаа юу вэ ?**

На: Би бол тэр Улаанбаатар рашаанд тэндээ би Монголын багш нараар заалгаж байсан уламжлалтын арга тавьж байсан зүү төөнүүрийн арга нь Хятадын юунаас шал өөр байдаг юм байна лээ. Тэгээд би сүүлд хэзээ хойно зүүний эмчилгээ төгсөж ирсний дараа Солонгосын зүү төөнүүрийг бас судалж үзсэн байхгүй юу номоос тэгсэн чинь ер нь ингээд л хараад байхад жаахан жаахан ялгаа байдаг юм байна лээ. Уушгины цэгүүд дээр ханах төөнөх аргууд байдаг шүү дээ тэр Хятадад заалгасан тэгэхэд одоо манай Монголд хийж байгаа уушгины цэгүүд дээрх хануур төөнүүр шал өөр. Тэгээд би яг бодоод байсан байхгүй юу Хятадын тэр уламжлалт анагаах ухаанаас Монголын маань хануур төөнүүр өөр байдаг юм байна шүү гээд. Яагаад гэхээр тэр яваад байгаа суваг судал ерөнхийдөө нэг байхгүй юу тэгэхэд л ерөнхийдөө тэр арга нь түрүүгээрээ бас өөр юм байна лээ.

**Зу: Хятадын хувьд бол тэр цэг дээр төөнөөд байгаа юм шиг санагддаг надад. Монголчуудын хувьд арай нэг нийтэд нь ч юм уу би тэгж ойлгоод байгаа.**

На: Яг зөв, тэр хоёрыг зэрэгцүүлж харахаар суваг судал нь нэг л мөртөө яг тавиад байгаа чиний хэлдгээр цэгүүд нь өөр байгаад байгаа байхгүй юу тэгэхээр л цаанаа суваг судлууд нь нэг л байгаа байхгүй юу. Тэгэхэд бол тэр төөнөөд байгаа арга нь өөр түрүүгээрээ л ялгаатай гэж би ойлгоод байгаа.

**Зу: Дорнын гэж байгаа ч тухайн газар орны онцлог байгаад байна. Тэгэхээр төөнүүрийг дан ганц орон эзэмших нь учир дутагдалтай ?**

На: Учир дутагдалтай.

**Зу: Ханахад хамгийн их анхаарах зүйлс нь юу байдаг вэ ? Сошиал медиагаар маш их явж байна энэ хүнийг ханаж байгаа гэсэн маш их хэмжээний цус аваад хийсэнтэй их таарсан л даа. Үнэхээр тэгж их цус авч хийдэг юм уу үгүй юм уу ?**

На: Тэр бас хэмжээ дамжаатай л даа. Их гарах тусам сайн гэсэн ойлголт байхгүй. Хятадад байх үед бол ерөөсөө уур гаргах төдий байхад болно л гэж үздэг. Яагаад гэхээр зарим нэг цэгүүдээс 10 дусал юм уу 6 дусал гарлаа гэхэд тэр чинь тэгээд болчхож байна гэсэн

үг байхгүй юу. Яагаад гэхээр боогдоод байгаа суваг судлыг л чөлөөлж өгч байна гэсэн үг. Зарим нэг даралтын цэгүүд дээр бид нар болохоор зарим хүмүүс дээр бүр олгойдож хүртэл гардаг. Зарим хүнийг хоолойны ангин дээр хэлэн доороос гаргадаг. Тэгэхлээр бол тэр хар хүрэн цус гарч дуусаад шингэн цус гарна шүү дээ тэгэнгүүт нь зогсоочихно тэр чинь бас хэмжээ дамжаатай. Зүгээр нэг гараад байхдаа гол нь биш ерөөсөө аливаа суваг судал дээр гарах хэмжээ нь шал өөр өөрийн гэсэн онцлогтой тэр нь.

**Зу: Нэг сонирхолтой зүйл байна, хар хүрэн цус нь гараад дуусчхаад больж болох юм уу ? Тэр том суваг судлыг нээхээд цус гарахаа болино гэхээр бас сонин байгаа юм л даа.**

На: Болно, хүний өөрийн судас судал гэдэг чинь агшиж томрох онцлогтой учраас энэ ч гэсэн өөрөө 5-7 минутын хооронд л бүлэгнэх учиртай байдаг байхгүй юу. Түүрүүгээрээ л тэр чинь автоматаар зогсоно. Үргэлжийн тэгж гоожоод байна гэж байхгүй л дээ. Олгойдож гарсан ч гэсэндээ тэр өөрөө наалдаад л зогсоно.

**Зу: Миний харсан шиг тэр одоо маш их хэмжээний 300-500 мг орчим гаргаад байдаг нь ямар учиртай вэ ?**

На: Яг аль цэгээс вэ гэдгээс л шалтгаална. Тэгэхдээ бол яг тэр 500 болтол авах нь буруу гэж бодож байна. Миний сурч байсан Хятад улсад ч гэсэн 500 болтол нь авдаггүй байсан. Одоо бид нар зүгээр харвалт өгсөн хүнд ч гэсэн Оросын анагаах ухаанд ч гэсэн байсан. Куробосканы гэж цус ханах арга гэхдээ Оросууд бол ялгаатай арга. Анагаахын эмчилгээний арга дээр ч гэсэн заадаг юм. Цус бол ер нь дээшээгээ л хөөрөөд байдаг байхгүй юу. Хүний тархи толгой руу харвуулахгүйн тулд захын эрхтэн рүү урсгалыг нь багасгаж өгөхийн тулд тэгэхээр хоёр судаснаас нь боож 40,40 80 гр аваад л болчхог. Нөгөө тархи толгой руу чинь цус хөөрөхгүй гэсэн үг. Тэгэхлээр харвасан ч зүгээр л явна гэсэн үг.

**Зу: Бас нэг асуулт байна. Захын мэдрэлийн өвчин гэж ярьсан тэгэхээр европ арга хүрч үйлчилж чадахгүй байна уу ? Захын мэдрэлийн өвчин гэдэг маань яг ямар өвчин бэ ?**

На: Тэр бол одоо хүний захын мэдрэлийн үрэвсэл гэхээр суудлын үрэвсэл орно одоо зарим нэг нуруунд нь юм орчихлоо гэж яриад байдаг шүү дээ тэр байж болно. Ерөөсөө захад л тохиолдоод байгаа мэдрэлийн өвчнүүд бүгд л орно гэсэн үг. Ясны ургалттай гэж хэлээд л олон жил суумгай болоод юм өргөж байснаа гэнэт нуруунд юм орчлоо гээд л яриад байдаг ерөөсөө бүгд тэрэнд орно. Захын мэдрэлийн саа саажилт гээд хүний бүх эрхтэн эс чинь ерөөсөө л цус нян бактери мэдрэлжүүлээд явж байгаа болохоор бүх юм орно одоо таны гарыг хүртэл мэдрэлцүүлж байгаа суваг судал мэдрэлийн сувгаар дамжиж байгаа болохоор тэд нарын чинь л захын мэдрэлийн судал гэж нэрлэнэ.

**Зу: Тэгэхээр нуруунд суулт өгдөг юм ордог энэ үед бол эм уугаад эмчлэх арга байхгүй. Тийм үү тэгэхээр зэрэг ханах төөнөх ?**

На: Тийм тэгэхээр зүү тавьдаг ч юм уу тэгвэл үр дүнтэй.

**Зу:** Монголчуудын хувьд бол яах вэ өвчин тийм олон төрөл байгаагүй байх. Мэдээж бэртэл гэмтэл халуун хүйтэнтэй холбоотой өвчин байсан байх би бас бодож байна. Ингээд яг асуучихад Монголчуудын уламжлалт анагаах ухаан бол хануур төөнүүр болж байна та тэгж бодож байна уу ?

На: Тийм хануур төөнүүр тэгж л бодож байна.

**Зу:** Домоор засаад эдгэдэг зүйлс байдаг. Хамгийн сүүлд сонин санагдаад байгаа зүйл нь могойн яр гээд өвчин байдаг энэ өвчнийг яг үнэндээ орчин үеийн шинжлэх ухаан эмчилж дийлж байгаа юу ? Та бол эмч хүн гэтэл түүнийг зарим нэг хүн дом заслаар эмчилж байгаа. Бас энийг юу гэж бодож байгаа вэ ?

На: Шинжлэх ухаанд бол энийг вирусээр халдварлаж байгаа гэж үзэж байгаа тэгээд маш их дахилт өгдөг. Дандаа нэг мэдрэлийн суваг судлыг дагасан. Ерөөсөө бүсэлж гардаг болохоор бүслүүр яр гэж нэрлээд байгаа. Энэ өөрөө болохоор мэдрэлийн гаралтай өвчин. Сэдрэх хандлагатай олон удаагийн дахилт өгдөг эдгэрэх магадлал бага. Тэгэхлээр чиний хэлдгээр ардын аргаар эмчлээд байна гэдэг маань сайн л байна үнэхээр. Надад бол ганц хоёр тохиолдож л байсан гэхдээ бүрэн гүйцэт эдгэсэн тохиолдол бараг байхгүй.

**Зу:** Би нэг хүнтэй уулзсан таныг эмч болохоор хэлж байгаа юм. Увсын Улаангомд Цахиац гэж нэрлэдэг тэр хүн эдгээдэг тэр өвчнийг бас тэр хүнээр нэрлэдэг хүмүүс нь ч бас итгэдэг эдгээдэг гэж хэлдэг. Таны сая хэлдэг урдаасаа бараг хойно хүртлээ бүслүүрийн яр гарсан тийм хүнийг эмчилсэн зан үйл хүртэл хийж үзүүлсэн л дээ. Тэр хүн бол маш итгэлтэй энэ чинь зөвхөн бүслүүрээр гардаггүй нүд хүртэл тойрч гардаг хүний эмзэг эрхтэн дээр хүртэл гардаг гэж тэр хүн надад хэлсэн. Энийг эмчилдэг хар домын эмчилгээний талаар надад хэлсэн л дээ. Нэг сонирхолтой зүйл байгаа тэр хүн эмнэлэгт хэвтэж байгаад ирсэн л дээ. Энэ бол мэдээж таны хэлснээр мэдрэлийн ядаргаа зэргээс үүссэн өвдөлт маш ихтэй. Тэгээд сүүлдээ өвчний шок болоод тэрийг тэгэхэд тэр хүн домын аргаар эхэлж байхад нь гурав нэлээн болсныг нь 12 удаа цохиод эмчилдэг гээд ярьсан. Маш сонирхолтой санагдаад байгаа юм. Ийм монголчуудын арга ухааны ид шид гэх юм уу хар домын аргууд байж болох уу гэж асуух гээд байна л даа.

На: Байж болно, яагаад байж болохгүй гэж. Шинжлэх ухааны талаас нь эмч хүний хувьд харахад үнэхээр эдгээхэд тэр бол маш хэцүү. Тэр ч бас над дээр ганц хоёр тохиолдож л байсан. Үүнийг эмчлүүлж бол үнэхээр бараагүй. Эмчилгээ хийлээ дахиад намдлаа дархлаа нь сулардаг ч юм уу тийм үед дахиад л сэдэрнэ. Тэгэхлээр эмчлүүлэхэд үнэхээр хэцүү. Энэ чинь маш их хэцүү стресстэй өөрийгөө шаналаад л сэтгэл гутралд ордог иймэрхүү явдал маш их гардаг.

**Зу:** Өөр чухал зүйл юу байдаг юм гам уу сэтгэл санаа юу эсвэл уламжлалт анагаах ухаанд ч гэсэн ямар нэг арга чарга хэрэглэж байгаа. Орчин үеийн анагаах ухаанд зүрх өвдлөө гэхэд зүрхний эмээ уухад зүгээр болдог. Үүнээс гадна тухайн хүн эрүүл мэндээ анхаарахад хамгийн чухал зүйл нь юу вэ ? Монгол хүн ийм байх ёстой шүү ийм зүйлийг анхаарч байгаарай ч гэдэг юм уу тийм зүйл ?

На: Одоо европ ч бай уламжлалт анагаах ухаан ч бай хүн нэгэнт л эм зааж байгаа бол заавал ч үгүй хувь хүн өөрийнхөө талаас хоёрт гэвэл хэрэглэж байгаа зан заншил одоо хүний дадал хэвшил өөрчлөх шаардлагатай гэж үздэг миний хувьд. Гуравт гэвэл гам байлгүй яах вэ европ ч бай уламжлалт анагаах ухаан ч бай тодорхой хэмжээний гам барих ёстой л гэж үздэг. Бид нар бас гам барих гэж байна. Ус цасанд ордоггүй ч юм уу зүү төөнүүр хийлгэж байхдаа хүйтэн усанд гараа дүрдэггүй ч гэдэг юм уу төмөр металл эдлэл байлгаж болдоггүй ч гэдэг юм уу. Тэр хүн арьсандаа ямар нэг яр шарх байх ёсгүй ч гэдэг юм уу. Арьсны бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх ч гэдэг юм уу. Тэгээгүй үед зүү эмчилгээ хийхгүй ч гэдэг юм уу. Таарсан барих ёстой гам хувь хүний онцлогт таарсан байдал одоо европ эмчилгээнд ч гэсэн байгаа эм тан хэрэглэж байсан үедээ ийм ийм юм хэрэглэнэ ч гэдэг юм уу. Аливаа юманд хэрэглэх нэг заалт хэрэглэхгүй нэг заалт байна. Тийм учраас хувь хүмүүс аль болох өвдөхөөсөө өмнө өөрсдийгөө сэргийлэх. Өвдсөн хойноо эмчлэх биш өөрийгөө түрүүлж сэргийлэх боломж нь байна гэж үзэж байгаа. Ер нь голдуу буруу дадал хэвшлээс болдог. Юуг би амандаа хийж болох уу юуг амандаа хийхгүй байх уу гэдгээ хувь хүн өөрөө ялгаад сурчихвал заавал нэг их өвдөөд эмнэлэг рүү гүйгээд байх шаардлагагүй гэж үзэж байна.

**Зу: Миний ойлгосноор нэг зүйл байна та бол орчин үеийн анагаахаар сурсан ч гэсэн уламжлалтыг их сайн сурсан учраас танай сумын хувьд маш их давуу талтай болчихож байгаа юм. Зарим сумд бол тийм зүйл байхгүй. Зөвхөн эмийн эмчилгээ хийдэг зарим нэг зүйл дээр уламжлагчийг орхидог ч юм уу энэ зүйлийг хавсарсан хослуулсан эмчилгээ хийдэг ч юм уу их сайн уламжлалтын эмч байхад нэг сайн европ эмч байх жишээний зүгээр юм шиг надад санагдлаа ?**

На: Үнэхээр бас уламжлалтын талаар олон зүйл хийе гэсэн олон бодол байдаг ч гэсэн би энд удирдах ажил хийж байхад байнга түрээгээрээ тууштай явж болохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр манайд нэг давуу тал байгаа нь уламжлалтын сувилагч байгаа. Түүн дээр би зааж зөвлөөд чи одоо энэ цэг дээр ингэ тэг гээд ханаж төөнөх тийм асуудал гарахад би өөрөө тавиад өгдөг болохоор манай сумын хувьд энэ бол давуу тал. Хоёрт нь гэвэл би өөртөө бардамнаад байгаа ч юм биш хүн болгоны хийгээд байдаггүй палкад гэж байдаг хүний мэдрэлийн цэг дээр энийг бол би бардам өөрөө хийж чаддаг. Үүгээр бол би ямар ч байсан өөрийгөө Монголдоо номер 1 гэж бодож байна. Энэ нь бол миний Хятадад сурсны ач гавьяа гэж бодож байна. Яагаад гэхээр өчнөөн шаналаад нуруу нь өвддөг хөл нь өвдөөд суулт өгөөд байгаа хүмүүсийг дээрээс нь оношлуулаад суулт өгөөд үений завсар багасаад суулт өгөөд эхэлчхэж гэсэн хүмүүст би өөрөө плакат хийгээд өгдөг шууд эндээ.

**Зу: Плакат гэдэг нь юу вэ ?**

На: Хориг гэж хэлнэ монголоор яг л одоо чиний саяны хэлж байгаагаар төгсгөл хэсэгт очиж хийгээд байгаа эмчилгээ.

**Зу: Хатгаж байна уу яаж байна ?**

На: Тэрийг бол эм хийгээд яг тэр цэг дээр нь тавьж өгөх арга.

**Зу: Европ зүү хоёрыг хослуулж байна гэсэн үг байна ?**

На: Тийм, манай сумын иргэд азтай байна гэж би боддог хэрвээ тэрийг хот руу явж хийлгэдэг байсан бол гэтэл би энэ дээ эмчилдэг. Өөр газраас ирсэн хүмүүсийг би эмчлээд эдгээгээд явуулж байсан. Хотод манай нэг өвчтөн байсан л даа. Тэр бүр олон эмчилгээг хийлгээд сумандаа ингэж байсан гээд суманд тийм эмч байсан гэж үү гээд гайхаад бүр тэгж хэлээд магтаад дахиж өвдөж намайг зовоогоогүй ээ гээд тэгэхлээр ер нь нэг хүнд ч гэсэн буян үйлдээд өөрийн сурсан мэдсэнийг түгээж явж байгаадаа баярлаж байна.

**Зу: Энэ плакат хориг гээд байгаа ?**

На: Яг тэр мэдрэлийн төгсгөл хэсэг дээр хийгдэж байгаа эмчилгээний арга тарилга гэж ойлго ерөөсөө.

**Зу: Танд маш их баярлалаа, миний танаас асуугаагүй зүйлс байна уу би өөрөө мэргэжлийн хүн биш болохоор таны ярихыг хүссэн уламжлалт болон европ анагаах ухааны орхигдуулсан зүйл байвал та нэмж хэлж болно ?**

На: Орхигдуулсан ч гэж өөр юм нэг их байхгүй ер нь эмийн эмчилгээ түлхүү хэрэглэснээс илүүтэй уламжлалт анагаах ухааны аргыг илүү түлхүү хэрэглэвэл хүний бие организмд учруулах хор хөнөөл нь бага үр дүн ч гэсэн сайн. Аль болох л ийм арга хэрэглэж уламжлалт аргаа хослуулж хэрэглээд байгаасай л гэж ард иргэддээ хэлмээр байна.

**Зу: Та эмчилгээ хийлгэхээр ирсэн хүмүүст уламжлалт анагаах ухааны арга зөвлөхөд хүмүүс хэрхэн хүлээж авдаг вэ ?**

На: Маш сайн хүлээж авдаг гэхдээ надад зав зай их бага болохоор аль болох чөлөөт зав зайтай үедээ ч юм уу эсвэл ээлжийн амралт авсан үедээ эсвэл үдээс хойш ажлын ачаалал бага үед тэгж л хүмүүст үйлчлэхийг хүсдэг.



Хавсралт 6. Өвлөн уламжлагч нарын зураг

